

ГАРЧИГ

УИХ-ЫН 2010 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

ӨМНӨХ ҮГ

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ДАРГА Ц.НОРОВДОНДОГ

1. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ

- 1.1 НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨРГӨН БАРЬСАН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДЛУУД
/Харьцуулсан судалгаа/

Р.Хатанбаатар, А.Пагма/МА/, Г.Чулуун, Ш.Хишигсүрэн/LLM/, Ө.Мөнхтунгалаг, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа, Ц.Батбаяр

- 1.2 НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТАЛААРХИ ШҮҮМЖ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА */Харьцуулсан судалгаа/*

Р.Хатанбаатар, Ө.Мөнхтунгалаг, Ш.Хишигсүрэн/LLM/, Г.Чулуун

- 1.3 СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ЗОХИСТОЙ ХУВИЛБАРУУДЫГ СОНГОХ ЗАРЧИМ */Харьцуулсан судалгаа/*

Ц.Товуусүрэн

- 1.4 ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙГ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААРХИ
/Павлагаа, мэдээлэл/

Р.Хатанбаатар

- 1.5 УЛС ТӨРИЙН СОНГУУЛИЙН НӨЛӨӨГӨӨР ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ ӨӨРЧЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ АСУУДАЛ, ХАНДЛАГА */Харьцуулсан судалгаа/*

С.Дорждагва

- 1.6 ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ */Павлагаа, мэдээлэл/*

К.Пүрэвсүрэн, Б.Хатантуул/LLM/, Ш.Хишигсүрэн/LLM/

- 1.7 ЯПОН БОЛОН ИХ БРИТАНИ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ */Мэдээлэл, лавлагаа/*

Б.Хатантуул/LLM/, Ш.Хишигсүрэн/LLM/

1.8 ЦААЗААР АВАХ ЯЛЫН БАЙДАЛ, ХАНДЛАГА, БАЙР СУУРЬ /Лавлагаа, мэдээлэл/*Б.Хатантуул/LLM/ , Ш.Хишигсүрэн/LLM/***2. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ****2.1 ТӨРИЙН АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД НИЙГМИЙН АУДИТЫН ҮҮРЭГ** /Харьцуулсан судалгаа/*А.Пагма/МА/***2.2 ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АСУУДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАНДЛАГА** /Харьцуулсан судалгаа/*А.Пагма/МА/, Б.Ариунжаргал/МА/, О.Нарантуяа, Т.Мягмаржав***2.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН***Ц.Товуусүрэн, А.Пагма/МА/***2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР ХИЙГДСЭН СУДАЛГААНУУДЫН ҮР ДҮНД ХИЙСЭН** /Харьцуулсан мэдээлэл/*Ц.Товуусүрэн, А.Пагма/МА/, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав,
Б.Ариунжаргал/МА/, Б.Хатантуул/LLM/***2.5 МОНГОЛ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ** /Лавлагаа/*Р.Хатанбаатар***2.6 ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ** /Лавлагаа/*Б.Буяндэлгэр*

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨРГӨН БАРЬСАН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДЛУУД

(Харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ)

Ц.Норовдондог (Ph.D), Р.Хатанбаатар, А.Пагма/МА/, Г.Чулуун,
Ш.Хишигсүрэн/LL.M/, Ө.Мөнхтунгалаг, Г.Билгээ, Ч.Онончимэг,
Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа, Ц.Батбаяр

Агуулга

Удиртгал

Судалгааны дүгнэлт

Нэгдүгээр бүлэг. Нийслэл хотын статус, эрх зүйн зохицуулалтын талаархи онол, практикийн зарим асуудал

1.1 Нийслэл, түүний онцлог чиг үүрэг, удирдлага, үйл ажиллагааны зарчим

1.2 Нийслэл хотын эрх зүйн зохицуулалт, статус, нутгийн захиргаа болон нутгийн удирдлагын эрх зүйн орчны талаархи бусад орнуудын туршлага

Хоёрдугаар бүлэг. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хийсэн дүн шинжилгээ

2.1 Нийслэл, дүүрэг хорооны удирдлага болон шат шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх, үүрэг, хоорондын холбоо, харилцан хамаарал, нийслэлийн асуудлаархи Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрх, тэдгээрийг хуульчилсан байдал

2.2 Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг

2.3 Нийслэлийн эдийн засгийн эрх мэдэл, өнөөгийн байдал, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх

2.3.1. Нийслэлийн эдийн засгийн эрх зүйн үндэс, өнөөгийн байдал боломж

2.3.2. Нийслэлийн буюу орон нутгийн татвар

2.3.3. Нийслэлийн өмчийн эрх зүйн зохицуулалтын талаар

2.3.4. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын талаар

2.3.5. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын талаар

2.4 Нийслэлийн удирдлагаас иргэд, аж ахуйн нэгж болон төрийн захиргааны төв байгууллагатай харьцах асуудал

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар нарын хүсэлтээр “Нийслэлийн эрх зүйн зохицуулалтын асуудлууд, өргөн барьсан хуулийн төсөлд хийсэн дүн шинжилгээ,

боловсронгуй болгох асуудлууд” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, Үндсэн хуулийн (1992) зарчимд нийцүүлэн нийслэл хотын статус, онцлох чиг үүрэг, түүний удирдлага, үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, зарим улс орны туршлагыг харьцуулан судалж, санал, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

Судалгааны зорилтууд:

- Нийслэл, түүний онцлог чиг үүрэг, удирдлага, үйл ажиллагааны зарчим
- Нийслэл хотын эрх зүйн зохицуулалт, статус, нутгийн захиргаа болон нутгийн удирдлагын эрх зүйн орчны талаархи бусад орнуудын туршлага
- Нийслэл, дүүрэг хорооны удирдлага болон шат шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх, үүрэг, хоорондын холбоо, харилцан хамаарал, нийслэлийн асуудлаархи Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрх, тэдгээрийг хуульчилсан байдал
- Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг
- Нийслэлийн эдийн засгийн эрх мэдэл, өнөөгийн байдал, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломж */төсөө, татвар, өмч, газрын харилцаа, чөлөөт бүс/*
- Нийслэлийн удирдлагаас иргэд, аж ахуйн нэгж болон төрийн захиргааны төв байгууллагатай харьцах асуудал

Судалгааны аргачлал:

- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн агуулга, мөн чанар, онцлогын харьцуулалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх
- Бичиг баримтын судалгаа

Энэ хүрээнд:

- Нутгийн удирдлагын асуудалтай холбоотой ном, материал, судалгааны тайлангуудад анализ хийсэн
- Бусад орнуудын туршлага, цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны дүгнэлт:

- Гадаад орнуудын нийслэлийн эрх зүйн зохицуулалтаас үзэхэд зарим улс оронд **“Нийслэлийн статусын тухай хууль”** тусгайлан үйлчилж байна, зарим орнуудад нутгийн удирдлагын тухай хуулиар нийслэлийн эрх зүйн зохицуулалтын гол үндсийг нь тогтоогоод, тухайн нийслэл хотын **Дүрмээр** нарийвчлан зохицуулснаар нийслэлийн статус тодорхойлогдож байна. Хуулийн төслийн зарим заалтуудыг хотын дүрмээр зохицуулах боломжтой.
- Мөн бусад улсын туршлагаас үзэхэд тухайн хот зөвхөн хот гэдэг утгаараа биш нийслэл хотын хувьд чиг үүргээ гүйцэтгэхэд нь **засгийн газар, нийслэлийн хоорондын харилцааг** хуулиар эсхүл **“хамтын ажиллагааны талаархи хоёр талын гэрээ”**-ээр зохицуулдаг ба эдгээр нь нийслэлд эдийн засгийн баталгааг бий болгож нийслэлийг хөгжүүлэхэд болон нийслэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд гарсан зардлыг нөхөн олгох боломжийг бүрдүүлдэг байна.
- Зарим орнууд нийслэл хотын Дүрэмдээ Нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналт, шалгалтын эрх, үүргийг маш тодорхой заасан байна. Тухайлбал, хяналт, шалгалт хийх

комиссийг ямар тохиолдолд байгуулах, бүрэлдэхүүн нь ямар байх, бүрэлдэхүүнд нь хэн орох болон орж болохгүй байх, хэрхэн шийдвэр гаргах зэргийг тусгажээ.

- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд хотын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шалгалтын комисс байгуулж болох талаар зааж өгөх
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Улсын Их Хурал нийслэлийн талаар хэрэгжүүлэхээр заасан бүрэн эрхийн тухайд Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад хамаарч байгаа бөгөөд томъёоллын хувьд зөрүүтэй байна гэж үзэхийн зэрэгцээ хууль хоорондын давхардлыг бий болгох шаардлагагүй гэж үзэж байна.

Мөн түүнчлэн

- Хуулийн төслийн 8 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрх /8.1.1.нийслэлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 8.1.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх; 8.1.1, 8.1.3 дугаар заалт Засгийн газрын тухай хуулиар зохицуулагддаг учир дахин хуульд тусгах шаардлагагүй,
- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн /9.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно/ 9.2 дүгээр заалт Үндсэн хуулийн 59.2, Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23.1 дүгээр заалтын үндэслэн хасах,
- Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрхийн /11.4. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно/ 11.4-ийг Үндсэн хуулийн 57.1, 60.2-ийг үндэслэн хасах
- Нийслэлийн оршин суугчийн эрхийн талаар нийслэлийн асуудлыг шийдвэрлэх үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн иргэд нийслэлийн засаг, захиргааны зүгээс ямар үйлчилгээг хэрхэн хүртэх эрхтэй болох талаар асуудлыг тусгах нь зүйтэй юм. Мөн нийслэлийн оршин суугчийн татварын хувьд иргэний “оршин суугаа газрын байрлал” нь тухайн иргэнд татвар ногдуулах үндэслэл болохгүй гэж үзэж байгаа бөгөөд энэ талаар тухайн асуудлаархи хэсэгт тодорхой өгүүлсэн болно.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг төвлөрсөн төсөвт тусгах, хөрөнгө оруулалтын шийдвэрийг төвлөрсөн байдлаар батлах зэрэг хязгаарлалт тогтоосон нь орон нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй болсон. Иймд Төв, орон нутгийн засаг захиргааны бүх түвшинд төсвийн харилцаа, төвлөрлийг хэрхэн сааруулах талаас нь нийслэлийн эдийн засаг, өмч, төсөв санхүүгийн асуудалд хандах шаардлагатай байна.
- Хуулийн төсөлд техникийн шинжтэй алдаа мадаг нэлээдгүй байгааг нягтлах, тухайлбал, “Нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах” гэсэн 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйлд Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах асуудлыг тусгасан байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийслэл хотын статус, эрх зүйн зохицуулалтын талаархи онол, практикийн зарим асуудал

1.1. Нийслэл, түүний онцлог чиг үүрэг, удирдлага, үйл ажиллагааны зарчим

Аливаа улсын нийслэл хот нь улс орныхоо амьдралд чухал үүрэг гүйцэтгэж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын төв болж байдаг билээ.

Улсын нийслэл нь тухайн улсын төрийн дээд байгууллагууд: төрийн тэргүүний өргөө, парламент, засгийн газар болон гадаадын дипломат төлөөлөгчийн газрууд байрлах албан ёсны гол хот юм.

Ихэнхи улс орнуудад Үндсэн хуулиар нийслэл хотын статусыг хуульчилсан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн” хэмээн нийслэл хотын статусыг хуульчилсан. Нийслэлийн статус гэдэг ойлголт нь тухайн хот улсын нийслэлийн үүргээ гүйцэтгэхтэй холбоотой эрх зүйн байдлыг тодорхойлдог ба энэ нь Үндсэн хуулийн дагуу тусгай хууль болон дүрмээр зохицуулагддаг байна.

Өнөөгийн байдлаар тодорхой улс орны нийслэлийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, түүх, геополитикийн үүрэгтэй холбоотой асуудал өргөн хүрээтэй, цогц судалгаа шинжилгээний объект болж, гүн гүнзгий судлагдаагүй боловч орчин үеийн нийгмийн хөгжлийн шууд үр дагавар болж шинэ маягийн нийслэл хотууд бий болсон, олон оронд уламжлалт нийслэлийн шинж чанар өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаас үүдэн энэ асуудалд хандах судлаачдын сонирхол идэвхижиж байна гэж үздэг¹. Тухайлбал, урьд нь буурай хөгжилтэйд тооцогдож байсан улс орнуудад хөгжилтэй дэд бүтэцтэй том нийслэл хотууд бий болсон, нийслэл хотуудын шинж чанар өөрчлөгдөн нийгмийн том нийтлэг бүхий хот-улсууд болох хандлага бий болсон, эдгээр нийслэлүүд бусад улсуудын нийслэлийн хамтлагт идэвхитэй нэгдэх болсон зэрэг шинэлэг үзэгдлүүд судлаачид, ажиглагчдын анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Ерөнхийдөө нийслэлийг үзэгдлийнх нь хувьд судлахад шинжлэх ухааны судлагдахуун хувьд нэг талаас бага судлагдсан байдал, нөгөө талаас маш олон талтай судлагдахуун болохыг онцолжээ².

Судлаачдын үзэж байгаагаар олон орны нийслэлийн түүх, үйл ажиллагааны анализ судалгаагаар улсын нийслэл хотын түүхэн хувь заяа, улс төр, эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг дараахь гурван уялдаа холбоо бүхий хүчин зүйлээр тодорхойлдог байна. Үүнд:

1. Орон зай, цаг хугацааны хүчин зүйл өөрөөр хэлбэл, тухайн нийслэлийн байгуулагдсан цаг хугацаа, газар зүйн байршлын хүчин зүйл,
2. Нийслэлд соёл, зан суртахуун, шашин, оюун санааны амьдралын төвлөрсөн байдал,
3. Нийслэлд улс орны улс төрийн амьдрал төвлөрсөн хүчин зүйл эдгээр болно.

Түүнчлэн нийслэлийг бүс хоорондын харилцааны үүднээс хоёр категори болгон авч үздэг. Үүнд:

- Улс төр, захиргааны статустай нийслэл-энэ нь улс төрийн төв бөгөөд тухайн улсын төрийн дээд байгууллагууд оршдог, албан ёсны нийслэл болно.
- Албан бус нийслэл- энэ нь том хотууд, улс, бүс нутгийн олон чиг үүрэгт төвүүд юм. Эдгээр нь хууль ёсны статусгүй боловч ерөнхий утгаараа нийслэлийн чухал чиг үүргийг үндэсний болон олон улсын түвшинд гүйцэтгэдэг. Жишээ нь, Нью-Йорк хот АНУ-ын санхүү-эдийн засгийн төв, Дюссельдорф хот Рур мужийн төв гэх мэт.

Нийслэлийн гүйцэтгэх чиг үүргийн хувьд онцлох хоёр бүлэг чиг үүргийг тодорхойлж болно. Үүнд:

1. **Нийслэлийн тэргүүлэх байр суурийг тодорхойлох чиг үүргүүд:** Юуны өмнө нийслэлийн чадамж нь тэргүүлэгч болохын хувьд хотын үйлчилгээний чиг үүргүүдээр илэрдэг гэж үздэг. Энэ нь шинжлэх ухаан, боловсрол, төрийн бус байгууллага, санхүүгийн ба олон улсын байгууллагуудын төвлөрөл, соёлын болон нийтийн үйлчилгээ бөгөөд эдгээрийн харилцан

¹ Эдийн засгийн газар зүй, нийгмийн газар зүйн шинжлэх ухаанд харин нэлээн судлагдсан байна.

² T.I. Jaskova Capital region and capital position: ratio of concerts. www.belchas.by

үйлчлэл нь шинэ чанарыг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг. **Нийслэлийн хүн амд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж нь нийслэл хотын нүүр царайг илтгэж байдаг.**

2. **Дээд түвшний гол чиг үүрэг:** Энэ чиг үүрэгт нийслэл нь тухайн улсын улс төрийн төв болохынхоо хувьд гүйцэтгэдэг чиг үүргүүд хамаардаг. Өөрөөр хэлбэл, төрийн дээд байгууллагууд байрлан, үйл ажиллагаагаа явуулах, гадаадын дипломат төлөөлөгчийн газрууд байрлах, үндэсний болон олон улсын чанартай арга хэмжээ зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Нийслэл хот бол зөвхөн төрийн дээд байгууллагууд оршин байдаг газар бус улсынхаа эдийн засаг, соёлын төв байж, үндсэний нийтлэгийг тээгч болж байдаг учраас нийт улсын хөгжлийн хурдасгагч мотор болдог гэж үздэг. Иймд улс орны өрсөлдөх чадвар нь нийслэлийнх нь өрсөлдөх чадвараар тодорхойлогдоно ч гэж үздэг билээ.

Нийслэл хот нийслэлийн чиг үүргээ гүйцэтгэхэд тодорхой нөхцөлүүд зайлшгүй шаардлагатай нь ойлгомжтой. Үүнд, нийт хотын хөгжлийн тогтвортой байдал, экологийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчны хамгаалал, онцгой байдал болон иргэний хамгаалалтын шаардлагыг тооцох, нийтийн тээвэр, инженерийн, нийгмийн дэд бүтцийн иж бүрэн, цогц хөгжил, нийслэлийн хүн ам, зочид гийчдэд үзүүлэх үйлчилгээний иж бүрэн тогтолцоо зэрэг юм. Иймд нийслэлд түүний урт хугацааны томоохон зорилтуудыг гүйцэтгэхэд нь зориулж эдийн засгийн боломжийг нь олгох, нийслэлийн хөрөнгө, санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх явдал чухал байдаг.

Мөн бусад улсын туршлагаас үзэхэд нийслэл хот нийслэлийн чиг үүргээ гүйцэтгэхэд нь **төр, нийслэлийн хоорондын харилцааг** хууль эсхүл хамтын ажиллагааны талаархи хоёр талын гэрээгээр зохицуулдаг ба эдгээр нь нийслэлд эдийн засгийн баталгааг бий болгож нийслэлийг хөгжүүлэхэд болон нийслэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд гарсан зардлыг нөхөн олгох боломжийг бүрдүүлдэг байна.

Европын Холбооны шинэ нийслэлүүдийн хувьд ч, посткоммунист улсуудын нийслэлийн хувьд ч **өмчийн асуудал, хотын болон улсын төсвийн хоорондын харилцааны** асуудалтай холбоотой нийтлэг бэрхшээл байдаг. Эдгээр нь нэгдүгээрт, дээрхи улсуудад засгийн эрх мэдэл маш их төвлөрсөн, хоёрдугаарт, нийслэл хот, төр хоорондын харилцааг зохицуулсан хууль, гэрээ, эрх зүйн баримт бичиг байхгүй, гуравдугаарт, нийслэл хотын хөгжлийн асуудал нь төв засгийн газрын өөрчлөгдөн солигдох гэх мэт улс төрийн аяс, салхинаас хамааралтай байдал зэргээс болж байна гэж дүгнэжээ³.

Нийслэл хотын удирдлага, үйл ажиллагааны зарчмын асуудал чухал бөгөөд дараахь үндсэн зармуудыг дурьдаж болно. Үүнд:

- Төрийн эрх мэдэл, нутгийн өөрийн удирдлага нь хуулийн үндсэн дээр хэрэгжинэ. Эрх мэдлийг хэрэгжүүлэх гол зорилго нь нийслэлийн иргэдийн эрх ашгийн үүднээс хүний ба иргэний эрх, эрх чөлөө, хотын эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг хангах явдал болно,
- Нийслэл хотын төрийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд, тэдгээрийн удирдах албан тушаалтнуудын эрх мэдэл, хариуцах асуудал, гүйцэтгэх үүргийг ялган зааглах үндсэн дээр үйл ажиллагаа явагдана,
- Нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд нийслэлийн төрийн удирдлагын тогтолцооноос ангид бие даасан байх,

³ Декларация конференции Объединения столиц Европейского Союза 2007. www.stolitsa.tallinn.ee/

- Нийслэлийн төрийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд нь чиг үүргээ хэрэгжүүлэх эд материалын ба санхүүгийн боломжоор хангагдсан байх,
- Нийслэлийн төрийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагууд нь өөрсдийн эрх хэмжээний хүрээнд бие даан шийдвэр гаргаж, түүнийхээ төлөө хариуцлага хүлээх зэрэг болно.

1.2. Нийслэл хотын эрх зүйн зохицуулалт, статус, нутгийн захиргаа болон нутгийн удирдлагын эрх зүйн орчны талаархи бусад орнуудын туршлага

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор гадаадын хэд хэдэн орны туршлагыг судлан үзэхэд эрх зүйн зохицуулалтыг янз бүрээр хийсэн байна.

Тухайлбал, ОХУ болон ТУХН-ийн орнуудад “Нийслэлийн статусын хууль” тусгайлан байгаа бөгөөд уг хуулиудаар нийслэлийн эрх зүйн зохицуулалтын гол үндсийг нь тогтоогоод, тухайн нийслэл хотын Дүрмээр нарийвчлан зохицуулснаар нийслэлийн статус тодорхойлогдож байна. Харин Нийслэлийн дүрмийг зарим улс нь хотын парламентаараа баталсан байхад зарим улс нь Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан байх зэрэг ялгаа байна.

Европын улсуудын хувьд бол “Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль”(Act on local self-government) нь нийслэлийн эрх зүйн байдлыг тодорхойлж байгаа бөгөөд эдгээр хуулиудаар нийслэлийг мужтай адилтган үздэг байна. Эдгээр хууль нь тухайн хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Нийслэлийн дүрэм (The Statute of the capital city)-тэй хамтраад нийслэлийн статусыг тодорхойлох гол эрх зүйн баримт болж байна. Харин зарим орны хувьд, жишээлбэл, Польшид “Нийслэл хот Варшавын бүтцийн хууль” (Act on the structure of the capital city of Warsaw), Туркт улсын хэмжээний хотын эрх зүйн байдлыг тодорхойлсон “Их хотын захиргааны хууль” зэрэг хуулиуд байна.

Харьцуулан үзвээс манай хуулийн шинэчилсэн найруулгад дээр дурдсан улсуудын хуулийн болон дүрмийн заалтуудтай төстэй заалтууд аль аль нь байна. Гэхдээ манай төсөлд огт тусгагдаагүй юмуу бүрхэг тусгагдсан санаа авууштай зарим санаа байгаагаас дурдвал:

- Казахстаны хуульд нийслэл болон дагуул бүсийн хилийн цэсийг тогтоох буюу өөрчлөхдөө санал авах, саналыг нь харгалзах, шийдэх субъектуудийг маш тодорхой заасан байна.
- Варшав хотын дүрэмд Хотын зөвлөл (ИТХ)-ийн хяналт, шалгалтын эрх, үүргийг маш тодорхой заасан, тухайлбал, хяналт, шалгалт хийх комиссийг ямар тохиолдолд байгуулах, бүрэлдэхүүн нь ямар байх, бүрэлдэхүүнд нь хэн орох болон орж болохгүй байх, хэрхэн шийдвэр гаргах зэргийг тусгажээ.
- Нийслэлийн өмчид чухам юу юу багтах, хотын дэд бүтэц гэж юуг хэлэхийг маш тодорхой заадаг байна.
- Нийслэл дэхь архитектур, хот байгуулалт, барилгын үйл ажиллагаатай холбоотой харилцааг нарийвчлан заасан бүлэг Казахстаны хуульд байна.
- Нийслэлийн нутаг дэвсгэрт зориулалтын бусаар ашиглагдаж байгаа газрыг албадан хурааж авахын тулд шүүхэд хандах асуудал

- Нийслэл дэх газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын нэг онцлог болох улсын хэрэгцээнд зориулж газар авахдаа өмчлөгч болон газар ашиглагчтай харилцах харилцаа, худалдан авахад үнэ тогтоох, нөхөн олговор олгох зэрэг асуудал.
- Төслийн 28.1 заалтыг “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлтэй уялдуулах

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хийсэн дүн шинжилгээ

2.1. *Нийслэл, дүүрэг, хорооны удирдлага болон шат шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх, үүрэг, хоорондын холбоо, харилцан хамаарал, нийслэлийн асуудлаархи Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрх, тэдгээрийг хуульчилсан байдал*

Улсын Их Хурлын бүрэн эрх

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай 1994 оны өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нийслэлийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхийн тухай аливаа нэг зохицуулалт оруулаагүй бөгөөд Засгийн газраас өргөн барьсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд нийслэлийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхийг тусгайлан зохицуулсан байна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “төсөл” гэх/-ийн 7 дугаар зүйлд Улсын Их Хурал нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

Д/д	7 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх	Тайлбар
1.	7.1.1.нийслэлийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох	Энэхүү 7.1.1 дэх зохицуулалт нь агуулгын хувьд Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад хамаарч байгаа бөгөөд томъёоллын хувьд зөрүүтэй байна гэж үзэж байна. Учир нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг зохицуулсан бөгөөд Улсын Их Хурал нь төрийн дотоод бодлогын үндсийг тодорхойлохоор зохицуулсан бол төсөлд нийслэлийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохоор заасан байна. Үүнээс үзэхэд Улсын Их Хурал нийслэлийн талаархи бодлогын үндсийг тодорхойлж, харин Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд заасан нутгийн өөрөө удирдах ёс, төрийн удирдлагыг хослуулах зарчмын дагуу нийслэлийн хөгжлийн асуудлаар баримтлах бодлогыг тодорхойлох субъект нь Нийслэлийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудал гэж үзэж байна.
2.	7.1.2.хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах	Нэгэнт Хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5-т “нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах”-ыг Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамааруулсан байхад дахин төсөлд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах гэж заах хууль хоорондын давхардсан зохицуулалтыг бий болгож байна. Нөгөө талаас ерөнхий төлөвлөгөөнд яг юу хамаарах вэ гэдгийг нарийвчлан тодруулах шаардлагатай бөгөөд уг асуудал нь төрийн удирдлагын асуудал уу, эсхүл нутгийн өөрөө удирдах ёсны асуудал уу гэдгийг

		тогтоох нь зүйтэй болов уу.
3.	7.1.3.нийслэлийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Уг зохицуулалт нь нэг талыг барьсан агуулгатай зохицуулалт гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хурал Монгол Улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах онцгой бүрэн эрхтэй болохыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д тодорхой заасан бөгөөд төсөлд тусгаснаар Улсын Их Хурал төсөв, түүний гүйцэтгэлээс гадуур, эсхүл дан нийслэлд зориулж нийслэлийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор шийдвэр гаргах нь хэр оновчтой асуудал вэ гэдэг асуулт гарч байна. Нийслэлийн санхүүгийн асуудлыг нутгийн өөрөө удирдах ёсны дагуу өөрөө шийдвэрлэх асуудал бөгөөд Улсын Их Хурал харин нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжих боломжийг нь хангах л шаардлагатай юм.
4.	7.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.	Төслийн 7.1.4-т заасан зохицуулалт нь Улсын Их Хурлын 4 дүгээр зүйлд “Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой болон хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэнтэй утга ижил бөгөөд хууль хоорондын давхардлыг бий болгож байна. Иймд бусад хуулиар зохицуулсан асуудлыг дахин өөр хуулиар зохицуулах шаардлагагүй юм.

Төсөлд тусгасан Улсын Их Хурлын бүрэн эрх нь бусад хууль тогтоомжид нэгэнт зохицуулсан бүрэн эрх тул дахин хуульд нэмж зохицуулж хууль хоорондын давхардлыг бий болгох шаардлагагүй гэж үзэж байна.

Засгийн газрын бүрэн эрх

1994 оны Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нийслэлийн талаархи Засгийн газрын бүрэн эрхийн тухай аливаа нэг зохицуулалт байдаггүй бөгөөд төслийн 8 дугаар зүйлд нийслэлийн талаархи Засгийн газрын бүрэн эрхийг тусгайлан зохицуулсан байна.

Төслийн 8 дугаар зүйлд Засгийн газар нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

Д/д	8 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх	Тайлбар
1.	8.1.1.нийслэлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд Засгийн газрын нийтлэг үндсэн бүрэн эрхийг тусгайлан зохицуулсан бөгөөд хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж хангах нь Засгийн газрын үндсэн бүрэн эрх юм. Нийслэлийн хувьд нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх нь Засгийн газрын бүрэн эрх бөгөөд төслийн 8.1.1-т заасан зохицуулалт нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйл болон Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйл, 12 дугаар зүйлд тус тус нарийвчлан зохицуулсан зохицуулалттай агуулгын хувьд давхардаж байна гэж үзэж байна.

2.	8.1.2. нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллагад мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөгөө үзүүлэх;	Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон аргачилсан туслалцаа үзүүлж, тэдгээрийн бие даасан ажиллагааг хангах арга хэмжээ авна" гэж заасан бөгөөд төслийн 8.1.2 дахь зохицуулалт нь Засгийн газрын тухай зохицуулалттай агуулгын хувьд адил боловч томъёолол нь Засгийн газрын хуулийг явцуу агуулга руу чиглүүлсэн байна. Тухайлбал, Засгийн газар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангах арга хэмжээг авах бүрэн эрхтэй байхад төсөл мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх гэж тухайн арга хэмжээний нэгийг тодорхойлон заасан байгаа нь Засгийн газрын тухай хуулийг явцуу агуулга руу чиглүүлж байна.
3.	8.1.3. нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;	Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т "Төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын болон тэдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулна" гэж заасан нь төслийн 8.1.3-тай агуулгын хувьд адил бөгөөд нэгэнт хуулиар зохицуулсан асуудлыг дахин хуульд тусгах шаардлагагүй гэж үзэж байна.

Иймд төсөлд заасан Засгийн газрын бүрэн эрхийг Засгийн газрын тухай хууль болон бусад хуультай нийцүүлэн томъёолох нь зүйтэй болов уу.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаас гадна 1994 оны Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд хэрэгжүүлэхээр заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зохицуулсан. 1994 оны Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, одоогийн Улсын Их Хуралд өргөн баригдсан нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хоёрыг харьцуулахад нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 5 байсныг өргөтгөн 13 болгосон байна.

Нөгөө талаас нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно гэж тусгасан бөгөөд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.1-т нийслэлийн Хурлыг ээлжилт хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулахаар зохицуулсан. Мөн Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь заалтад "Нутгийн өөрөө удирдах байгууллага бол ..., тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн" гэж заасан байдаг. Тэргүүлэгчид Хурлын чөлөөт цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр Үндсэн хуульд заасан. Иймд Нийсл элийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болохгүй учир нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байх Үндсэн хууль болон түүний үзэл баримтлалыг зөрчсөн заалт юм.

Дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрх

1994 оны Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрхийн талаар аливаа нэг тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрхийн талаар шинэлэг зохицуулалт тусгасан байна. /Төслийн 11 дүгээр зүйл/

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4-т “Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно” гэж заасан байна. Нөгөө талаас Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, 60 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэж зааснаас үзэхэд хэрэв дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн Засаг даргын албан тушаалтай адилтган үзвэл түүний томилох нь хүртэл адил байх тул энэхүү заалт нь Үндсэн хууль зөрчсөн заалт гэж үзэж байна.

2.2. Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн III бүлэг дотроо 3 зүйл 20 заалтай. Хуулийн төслийн энэ бүлэг заалт [одоо үйлчилж байгаа] хуучин хуульд байгаагүй. Шинэчилсэн найруулгын төсөл бүхэлдээ 32 зүйлтэй [гэвэл] түүний нийт агуулгын 10 хувь нь “нийслэлийн оршин суугчийн эрх үүргийг тодорхойлоход” чиглэгджээ. Нийслэлийн оршин суугчийг тодорхойлсон тусгай [энэ бүлэг] зүйл-заалт бүхэлдээ цоо шинэ учраас ярих хэлэх юм ихтэй ... хэлэлцүүлгийн үед маргаантай байх магадлал ихтэй байгаа юм.

Нийслэлийн оршин суугчийн, ялангуяа, үүрэгтэй нь холбогдож гарч ирж байгаа том асуудал бол “нийслэлийн оршин суугчийн татвар” юм. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн “эдийн засгийн агуулгатай” бүлэг дээр оршин суугчийн татварын асуудал туссан, түүн дээр ч бид холбогдох анализыг үүнтэй зэрэгцээ байдлаар хийсэн болно. Харин энд бид, “оршин суугчийн татвар”-ыг иргэний эрх, үндсэн хуулийн агуулгын үүднээс “өөр өнцөгөөс” харахыг эрмэлзэв.

A. “... Оршин суугчийн эрх үүрэг”-ийг Үндсэн хуультай холбож үзэхүйд

Энд бид, нийслэлийн оршин суугчийн [төсөлд туссан] эрх үүргийг “Үндсэн хууль”-ийн “байр суурь”-наас харж зарим зүйлийг нэмж өгүүлэх болно. Үүнд:

1. Үндсэн хуулийн 1.1-т “төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг “... ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх ...” явдал мөн гэж заасан. Тийн атал, иргэн [хүн] нийслэлд оршин суудаасаа болж, жишээ нь, [бусдын төлдөггүй] **олон төрлийн татвар төлөх болж** байгаа нь шударга ёсны болоод тэгш байдлын талаасаа ихээхэн эргэлзээтэй санагдав.

Хожим нийслэлийн оршин суугч дотроос татвараа төлж чадахгүй хүмүүс олноор гараад ирнэ. Тэгэхээр тэднийг яах вэ ... гэдэгт эхлээд хариулт өгч байж нийслэлийн оршин суугчийн татварын асуудлыг шийдэх ёстой мэт. Татвар төлж чадахгүй байгаа оршин суугч торгууль төлж чадах болов уу. Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, **тодорхой эрх**, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаардаг. Энд байгаа “тодорхой эрх” бол Монгол Улсын иргэний чухам хаана оршин суухад хамаарахгүй. Учир нь, Монгол Улсын иргэний “... түр буюу байнга орших суух газраа сонгох эрх”-тэй, энэ эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан **нийтлэг эрх** юм.

Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулснаас татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна.

1. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ... зориулж, өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газраа чөлөөлсөний төлөө зохих журмын дагуу нөхөн төлбөр авах тухай заасан **нийслэлийн оршин суугчийн эрх** бол, иргэний эрхийнхээ дагуу Үндсэн хуулиар зохицуулагдчихсан асуудал юм.

Үндсэн хуулийн 6.4-т “... улсын тусгай хэрэгцээг үндэслэн ... иргэний **өмчлөлд** байгаа газрыг нөхөх олговортойгоор солих ба эргүүлэн авч болно”, 16.3-т “хувийн өмчийг хууль бусаар хураахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг авбал нөхөх олговор, үнийг төлнө; гэжээ. Хотын ерөнхий төлөвлөгөө бол “нийгмийн хэрэгцээ мөн”. Харин иргэний **эзэмшил ба ашиглалтад** байгаа газрыг нөхөн төлбөртэйгээр улсын хэрэгцээнд авах нь ... хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх гэж байгаа талд ашиггүй ч байж болох юм. Заалт, зарим хэсгээрээ ... үндсэн хуулийг зөрчсөн шинжтэй байж мэдэхээр байна.

2. Амьдарч буй орчноо тохижуулах, мод бут тарьж ургуулаад урамшуулал, хөнгөлөлт, эрх эдлэх эрх бол нийслэлийн оршин суугчийн их сонирхолтой эрх юм. **Тарьсан тохижуулсан тохиолдол болгонд** “үнэ хөлсийг нь өгч чадах уу” ...гэдэг ч эргэлзээтэй. Үнэ хөлсийг нь өгч чадахгүй учраас уг арга ажиллагааны хүртээмжийг зориуд хумиж, өөрөөр хэлбэл, түүнийг “үзүүлэх сургууль, уралдаан” маягийн хэлбэрт оруулан...мэдээлэлд ойр байдаг, мэргэжил дадалтай, хөрөнгө чинээтэй, цөөн хүмүүсийн эрхэлдэг ажил болгочих эрсдэл үүсэхээр байна.

Хот тохижуулах чиглэлийн үйл ажиллагаа өрнүүлэхдээ [хэн нэгэн] хөнгөлөлт эдлээд, урамшуулал шагнал аваад ... дээр нь нэмж [тусгай] **эрх эдлэдэг** тийм оршин суугч олон байх бололцоогүй. Нийтэд хүртээмжгүй, явцуу эрх ашгийг яаран хуульчлах хэрэггүй юм.

3. Байгаль орчныг бохирдуулж буй үйлдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд цаг хугацаанд нь мэдээлж, таслан зогсоох боломж олгох; Нийслэлийн оршин суугчид ийм [нэмэлт] эрх хэрэггүй. Тэрний оронд байгаль орчны байцаагчийн орон тоог нэмсэн нь дээр. Нэг зөрчлийг түмэн хүн ирж мэдээлнэ ... тэгээд хэн нь эхэлж ирсэн нь ч ойлгомжгүй болж хувирна. Тэгээд ч, асуудал нь өөрөө “хүний мөн чанарын эсрэг” шинжтэй юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 17.2-т, “... байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэсэн тул иргэний эрх үүргийн дотор нэгэнт багтдаг тийм зүйлийг ... зөвхөн оршин суугчийн үүрэг мэтээр зааж өгөх нь оновчтой бус санагдана.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-т “Монгол Улсын иргэн ... орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй ... энэ бол түүний үндсэн эрхийн нэг мөн” гэсэн заалт бий. Засаг төр өөрийнхөө хийх ёстой иргэний өмнө хүлээсэн үүргээ [хэнтэй ч хуваалцалгүй] өөрөө хариуцах нь илүү зөв болов уу.

Б. Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэгтэй холбогдох бодомжууд

Нийслэлийн оршин суугч гэж хэнийг хэлэх вэ? Нийслэлийн иргэн гэвэл [тэр] ойлгомжтой. Засаг захиргааны тухайн нэгжийн харъяат, нийслэлд хаягийн бүртгэлтэй Монгол Улсын иргэн ... гэж [шууд] бууж байна. Харин “... оршин суугч” гэхээр нэг тийм барьцгүй ... Монгол Улсын хэд хэдэн хуульд харилцан адилгүй, өөр өөрөөр тодорхойлогдсон нэр томъёо болж хувирчихаад байгаа юм.

Нийслэлийн оршин суугчийн эрх үүргийг гэнэт яагаад “сөхөөд” гаргаад ирэв гэхээр ... “гол нэг үндэслэл” нь “оршин суугчийн татвар цуглуулж авах хүрээгээ өргөтгөн тодорхойлж авах” гэсэн зорилттой холбоотой. Өөр зорилтууд ч байгааг үүгээр үгүйсгэхгүй.

1. Нийслэлийн иргэн гээд явахаар татвар төлөгчийн хүрээ хумигдана, татварын орлого багасна, харин “... оршин суугч”-аар нь тооцож бодвол хавьгүй ашигтай тусна.

2. Нийслэлийн иргэн гээд хуульчлахаар татвар төлдөг тэр хэсэг нь ачаа үүрээд ... татвар төлдөггүй үлдсэн хэсэг нь “завшаад үлдэх” нэг тийм шударга бус байдал үүсэх гээд байдаг.

Оршин суугч, түр оршин суугч, байнгын оршин суугч, гадаадын оршин суугч ... гэх мэтчилэнгийн ижил төстэй олон нэр томъёо бий. Эдгээр нэр томъёо “татвар авах”-ын тулд бус, ерөнхийдөө, хувь хүний эрхийг хангах, түүний улстөрийн эрхийг нээх сэдлээр хууль тогтоомжид суулгасан байна. Тиймээс, татвар төлөх үүрэг бүхий “нийслэлийн оршин суугч”-ийн хувьд “чиг баримжаа” төдий юм.

Дүгнэлт:

1. Засаг захиргааны [нэг] нэгжид харъяалалтай иргэний эрх үүргийг, тухайн нэгжид [байнга] оршин суугчийн эрх үүргээс зааглан салгах боломжгүй, бас шаардлагагүй юм. Тэгэх нь харин, эсрэгээр, Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгогдсон “нийтлэг эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй” байна. Тиймээс, НЭЗБТХ –ийн төсөл дэх “нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг”-ийн багц асуудлыг, “нийслэлийн иргэний эрх үүрэг”-тэй холбон авч үзэх шаардлага үүссэн байна.
2. Хэдийгээр Монгол Улсын иргэн “хуулиар ногдуулсан албан татварыг төлөх” үүрэгтэй ч, төлөх тэр татвар нь “татварын [хуулиар тогтоосон төрөл] зүйлс”-ийн хамрах хүрээний гадна оршиж таарахгүй. Өөрөөр хэлбэл, иргэний “оршин суугаа газрын байрлал” нь тухайн иргэнд татвар ногдуулах үндэслэл болж чадахааргүй байна. Тиймээс, “нийслэлийн оршин суугчийн...” гэх аливаа тодотголтой ямар ч татварт үүсэн бий болох орон зай [одоогоор] алга байна. Асуудлыг шийдэхийн тулд эхлээд Татварын ерөнхий хуульд зарим өөрчлөлтийг оруулж болох юм.

ГАДААДЫН ОРШИН СУУГЧ ГЭЖ ХЭН БЭ?

/Монголд суугаа гадаадын иргэний жишээн дээр хийсэн холбогдох зарим тодруулга, лавлагаа/

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох бүлэг заалтаар “Нийслэлийн оршин суугчийн эрх үүргийг зарим байдлаар тодорхойлж, нийслэлд “оршин суугчийн татвар” бий болгон, улмаар, түүнийг төлөх үүргийг “нийслэлийн оршин суугч”-д ногдуулахаар байна. Төсөлд ингэж туссан.

“Нийслэлийн оршин суугчийн татвар”. Энэ нь чухамдаа, «хэн нэгэн хаа нэгтээ [тухайн тохиолдолд нийслэлд] оршин сууж байна» гэсэн үндэслэлээр ногдох болж байгаа сонин татвар юм. Татварын нэр нь ч агуулгаа шууд илэрхийлж байна. Гэвч асуудлын цаана олон зүйл оршин байж болохоор байна. Монголын иргэн монголдоо оршин сууж таарна. “Тухайн (частный) тохиолдол” энд хамаагүй. Харин, монголд суугаа гадаадын иргэн “оршин суугчийн татвар хураамж”-аа хэрхэн төлдөгийг [эхлээд] нэг сонирхъё. Гадаад дотоод хоёр “оршин суугч”-ийг харьцуулж үзэх үүднээс үүнд холбогдох анхдагч мэдээллийг бид дор гаргав.

1. **Цагаач** [монголд ирсэн]
 - Хувийн хэргээр Монгол Улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг цагаач гэнэ.
 - Цагаачлах зөвшөөрлийг 5 жилээр, оршин суух зөвшөөрлийг 90 хоногоос дээш хугацаагаар тус тус олгоно.
 - Монгол Улсад оршин сууж буй цагаач, байнга оршин суугч, харъяалалгүй хүн нь нэг жилд 120 хоног хүртэл хугацаагаар өөр улсад [бас] байж болно.
 - [Цагаачид] оршин суух зөвшөөрлийг эхний удаад 43000₮ -өөр олгох ба сунгалтыг 2 жилд нэг удаа 15000₮-өөр хийнэ. (Энд нэрлэсэн үнэ төлбөр үйлчилгээний хөлс гэхээсээ илүү ... монголд оршин суугаагийнх нь төлөөнөө гадаадын иргэнээс авч

байгаа “оршин суугчийн татвар” шинжтэй юм. Нэр нь ч “оршин суух зөвшөөрлийн үнэ төлбөр” гэдгээр явж байгаа бололтой юм)

2. **Албан хэргээр [монголд] удаан хугацаагаар оршин суугч** [гадаадын иргэн]

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу, хүчин төгөлдөр паспорт ... баримт бичигтэй гадаадын иргэн Монгол улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, энэ хуульд заасан үндэслэлийн дагуу Монгол улсад **зорчиж, оршин сууж** болно.
- Засгийн газар хоорондын гэрээгээр Монгол Улсад суралцах, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон тэдэнтэй адилтгах албан тушаал эрхлэн 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнийг албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ.
- Албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэний “оршин суух зөвшөөрөл”-30000 төг, түүний сунгалт нь 2 жилд-15000 төг.

3. [Монгол Улсад] **түр оршин суугч гадаадын иргэн**

- Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсад 30 хоног хүртэл албан болон хувийн хэргээр ирсэн гадаадын иргэнийг **зорчигч** гэнэ. Зорчигч гадаадын иргэн **бүртгүүлэхгүй**.
- Монгол Улсад хувийн хэргээр 90 хүртэл хоногийн хугацаагаар байгаа гадаадын иргэнийг **түр ирэгч** гэнэ.
- Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 168 дугаар тогтоолоор баталсан “... виз олгох журам”-д заасны дагуу, Монгол Улсад **түр ирэгч гадаадын иргэнийг** хүлээн авсан, урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн түүнийг зохих ёсоор бүртгүүлнэ.

4. **Монгол Улсад оршин сууж байгаа** [харъяалалгүй] хүн

- Ямар нэг улсын гэх хууль ёсны бичиг баримтгүй Монгол улсад оршин сууж байгаа иргэнийг харъяалалгүй хүн гэнэ.
- Оршин суух зөвшөөрлийг эхний удаад 43000 ₮, сунгалт нь 2 жилд 15000 ₮
- Зорчих үнэмлэх нэг удаа-10100 ₮, олон удаагийн зорчих үнэмлэх-11500 ₮

5. **Хувийн хэрэгээр удаан хугацаагаар оршин суугч** [гадаадын иргэн]

- Монгол улсад хувийн хэргээр 90 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч гэнэ.

6. **Монгол улсад байнга оршин суугч гадаадын иргэн**

- Монгол улсын харьяат иргэнтэй гэр бүл болсон бөгөөд 90 хоногоос дээш хугацаагаар Монгол улсад оршин суугаа гадаадын иргэнийг байнга оршин суугч гэнэ.

7. **Суралцагч** [гадаадын]

- Суралцагч бол удаан хугацаагаар оршин суугч мөн. Монгол Улсын их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалтын төвд суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага хийх гадаадын иргэнд зохих журмын дагуу тусгай зөвшөөрөл авдаг.

Дүгнэлтийн бус [зарим] санаа

Нийслэлийн оршин суугч, нийслэлийн оршин суугчийн үүрэг, нийслэлийн оршин суугчийн (олон төрлийн) татвар ... эд бүгд хоорондоо учир шалтгааны холбоотой ойлголтууд юм. Татварыг [бол] иргэн мэдээж төлнө. Тэгэх ч үүрэгтэй. Татвар төлөх нь Монгол Улсын иргэний ёсчлон биелүүлэх нэг үүрэг гэж Үндсэн хуулийн 17.1-д заасан нь бий.

Гэхдээ, Монголд байгаа монголын иргэн, монголын нийслэлийн оршин суугч хүн, “оршин суугчийн татвар”-ын хүрээний хожим гарч ирэх энэ асуудал дээр, монголд байгаа, жишээ нь, “цагаач” статустай гадаадын иргэнээс ч “дорд үзэгдэж” болзошгүй нөхцөл байдал үүсч болох эрсдэл байгаа юм. Товчоор хэлбэл, **монголд ирсэн гадаадын оршин суугч, [энд] оршин суусныхаа төлөө 2 жилд 15000 төг. төлж байхад, монгол хүн монголынхоо нийслэлд оршин суусны төлөө 1 жилд зөвхөн 1 татварт 21600 төг төлөх шинжтэй** болж ирж байна. Ийм байдал үүсгэхгүйгээр хууль тогтоомжоо өөрчилж зохицуулах нь мэдээж. Гэхдээ л...хуулийг бол хүмүүс, мэргэжилтнүүд олон янзаар ойлгож тайлбарладаг. Гэхдээ, тухайн асуудал дээр Үндсэн хууль гол хөтөчийн үүрэг гүйцэтгэх нь гарцаагүй. Монгол Улсын Үндсэн хуулийн

- 14.1-д “Монгол Улсад хууль ёсоор **оршин суугаа хүн** бүр хуулийн өмнө ... өмнө эрх тэгш”;
- 15.2-д болон 16.18-д “Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, **түр буюу байнга орших суух газраа сонгох** ... эрхтэй, энэ эрхийг баталгаатай эдэлнэ, Монгол Улсын иргэнийг эх орноосоо хөөх ...-ийг хориглоно”; гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 18.1.3-т,

- Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг [мөн] иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно;
- Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно;
- Монгол Улс ... гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо [мөн] **иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим** баримтална; гэж заасан.

Энд дурдагдсан “... иргэний эрхийн харилцан адил байх зарчим” бол зөвхөн монголд хамаатай зүйл биш. Үүнтэй холбон авч үзвэл, монголд оршин суугчаас “оршин суугчийн [бүр хэд хэдэн төрлийн] татвар авч эхэлбэл, гадаадад [эргээд] монголын иргэдээс “оршин суугчийн татвар” нэхэж ч болох талтай мэт. Хэн хүнд хаа нэгтээ “оршин суусан”-ны төлөө татвар ногдуулна гэдгийг тал талдаа сайн бодож нухацтай хэлэлцэж шийдэхгүй бол, сүүлдээ, эрхзүйн казус⁴ гээчийг байнга үүсгэдэг “аюул” болж хувирах вий. Жишээ нь, эх орныхоо нийслэл рүү ирж очдог монгол хүнийг “байнга зорчигч” уу, “байнга оршин суугч” уу, эсвэл “оршин суугч” уу гэдгийг үнэнээр нь тодруулах “бүтэшгүй” зүйл болж хувирах магадлалтай. Монголд түр оршин суугаа “зорчигч” статустай гадаадын иргэн бүртгүүлдэггүйг давтан дурдъя.

2.3. Нийслэлийн эдийн засгийн эрх мэдэл, өнөөгийн байдал, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломж

2.3.1. Нийслэлийн эдийн засгийн эрх зүйн үндэс, өнөөгийн байдал:

⁴ Казус (лат. casus); Олон улсын эрхзүйн холбогдолтой ном товхимолд, үүнийг, “невиновное причинение вреда” гэж хэлж бичсэн нь таардаг.

“Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана” гэж Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 1-д заасан бөгөөд 57 дугаар зүйлийн 2-д “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж нийслэлийн эрх зүйн үндэсийг үндсэн хуульд тусгаж өгсөн байна.

Үндсэн хуулийн дээрх заалтууд болон бусад зүйл, заалтад тусгагдасны үндсэн дээр Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” (2006), “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль” (1993), “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль” (1994), “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль” (2003), “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль” (1996), зэрэг “орон нутгаар” дагнасан хуулиуд түүнчлэн Төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай, Албан татварын хууль мөн бусад холбогдох хуулиуд батлагдан гарсан.

“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэлийн /цаашид “нийслэл” гэх/ чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх **эдийн засгийн үндэс**, удирдлагын эрх хэмжээ, онцлог, нийслэлээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлж, энэ явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино. Мөн 3 дугаар зүйлд “Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн” гэж тодорхойлж эдийн засгийн эрх үүргийг олгосон байна.

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс түүнд хамаарах бүрдэл хэсгүүдэд **Нийслэлийн өмч, Нийслэл хотын төсөв, Нийслэл хотын татвар** зэргийг оруулсан байна.

Нийслэлийн эдийн засгийн эрх мэдэл, бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломжийг судлахтай холбогдуулан нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг төсөв, санхүүгийн талаас нь илүү тодруулан авч үзье. Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3.2.2-д Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, аймаг, **нийслэл**, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг орон нутгийн төсөв гэнэ гэж тодорхойлсон.

“Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай” /ТБУСТ/ хуульд “орон нутгийн төсөв” гэж орон нутгийн орлого, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бүтээгдэхүүний санхүүжилтийн нийлбэрийг гэж тодотгон өгчээ. Орон нутгийн төсөв түүнтэй холбоотой нийслэлийн харилцааг нарийвчлан авч үзье. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлд “нийслэл хот нь өөрийн гэсэн төсөвтэй байна” гэж зааснаас өөрөөр төсвийн бусад эрх үүргийн талаар тусгаж өгөөгүй.

Орон нутгийн төсвийн харилцааг зохицуулж буй өнөөгийн голлох эрх зүйн актуудад Монгол улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-иар зохицуулагддаг. 2006 онд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль” боловсруулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс, төсөв, ИТХ, Засаг даргын бүрэн эрх, баг хорооны Засаг даргын цалин, бусад зардлын эх үүсвэрийг тодорхойлж өгсөн байна.

Төсвийн тухай хуулийг 1993 онд батлан гаргасан. Уг хуулийн дагуу төв ба орон нутгийн төсөв гэж зааглан тогтоосон бөгөөд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын нэр төрөл, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын зүйлүүдийг тогтоож өгсөн.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн дагуу *боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ, нийгмийн дээжурмыг сахиулах цагдаагийн байгууллагын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, байгаль*

орчныг хамгаалах зэрэг байгууллагуудын орон нутаг дахь салбар нэгжийн үйл ажиллагааг улсын төвлөрсөн төсвөөс эрхэлсэн сайдын төсвөөр дамжуулан санхүүжүүлэх тогтолцоог бий болгосон. УИХ-аас 2002 онд батлан гаргасан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар салбарын санхүүжилтийн тогтолцоог баталгаажуулсан, түүний эзлэх байр суурийг бэхжүүлсэн тогтолцоог бий болгосон.

Төсөв санхүүгийн хэт төвлөрөл нь орон нутгийн ард иргэдийг бухимдалд хүргэх, нутгийн удирдлагын байгууллагуудаас төрийн захиргааны төв байгууллагуудтай харилцах харилцааг зөрчилдүүлэхэд хүргэж байгаа учраас сүүлийн үед төвлөрлийг сааруулахад чиглэсэн зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Боловсон хүчний босоо тогтолцоог өөрчлөн аймаг, нийслэлд ажиллаж буй цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, онцгой байдлын газар, мэргэжлийн хяналтын агентлагаас бусад агентлагийн дарга нарыг томилох эрхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт олгосноор боловсон хүчнийг томилж, чөлөөлөх эрх үндсэндээ орон нутагт шилжсэн.

ТБУСТ хууль нь санхүүгийн хэт төвлөрөл үүсгэж, орон нутгийн бие даасан байдлыг хангах, эдийн засгийн бие даах санхүүгийн хөшүүргийг бүрдүүлж чадахгүй байна. Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд санхүү, эдийн засгийн арга хэмжээ хамгийн чухал ач холбогдолтой болохыг гадаадын олон орны практик туршлагаас үзэж болох юм.

- Төсвийг хэт төвлөрүүлсэн нь төрийн болон орон нутгийн санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хааж, иргэдийн оролцоог хаасан.
- Тухайн нутаг дэвсгэрт салбарын яамдаас явуулж буй үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс хяналт тавих боломжгүй болсон.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг төвлөрсөн төсөвт тусгах, хөрөнгө оруулалтын шийдвэрийг төвлөрсөн байдлаар батлах зэрэг хязгаарлалт тогтоосон нь орон нутгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй болсон.
- Орон нутагт өөрийн орлогоо нэмэгдүүлэх сонирхол, идэвхийг урамшуулдаггүй, тухайн орон нутгийн газар зүйн байршил, эдийн засгийн бааз сууриас шалтгаалсан орлого, зарлага, хөгжлийн ялгаатай байдалтай хамааралгүй хуваарилагддаг.
- Орон нутгийн засаг захиргааны шийдвэр гаргах эрх, оролцоо багатай, шийдвэрийг төв Засгийн газарт гаргаж байна.
- Нутгийн удирдлагын төсвийн талаархи эрх мэдэл эрс багассан олон тооны сөрөг үзэгдлүүд ажиглагдаж байна.

Судалгааны үр дүн:

- Эрх зүйн орчны хувьд цаашид орон нутгийн засаг захиргааны түвшинд шийдвэр гаргах орчин, нөхцлийг урьдчилан бүрдүүлэх;
- Төв, орон нутгийн засаг захиргааны бүх түвшинд төсвийн харилцаа, төвлөрлийг хэрхэн сааруулах талаархи ойлголтоо эрс сайжруулах, нэгдсэн нэг ойлголтод хүрэх.
- Төв, орон нутгийн төсвийн харилцааг ямар ч арга хэлбэрээр өөрчилсөн гэсэн хөрөнгийн хуваарилалт, эрх мэдлийн хамт иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай, хүртээмжтэй хүргэх үүрэг, хариуцлага хамт очих болно гэдгийг бүх шатандаа анхаарах.
- Орон нутгийн төсөв боловсруулах үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэх мэт.

2.3.2. Нийслэлийн буюу орон нутгийн татвар

Монгол Улсад татварын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдэд тусгайлан нийслэлийн татвар байхгүй, харин орон нутгийн татвар гэсэн ерөнхий нэр томъёонд аймаг, нийслэл ба сум, дүүргийг хамруулсан байдаг. Олон улсын туршлагаар орон нутгийн засаг захиргааны байгууллага нь өөрийн гэсэн төсөв санхүүтэй, түүнийг бүрдүүлэгч татвартай байх хандлага хэдийнээ

тогтсон бөгөөд зарим улс орон энэхүү харилцааны суурь үндэсийг нь Үндсэн хуулиараа тогтоож өгсөн байна.

Дэлхийн олон оронд орон нутгийн төсвийн орлого нь 1) орон нутгийн татварын орлого; 2) төлбөр, хураамж; 3) улсын төсвөөс олгох шилжүүлэг (татаас, тусламж); 4) хуваалцах орлого зэрэг эх үүсвэрүүдээс бүрддэг.

Орон нутгийн татвар бол нутгийн удирдлагын байгууллагын өөрийнх нь бүрдүүлсэн орлого. Энэ бол хамгийн энгийн ойлголт. Онолын хувьд *орон нутгийн татвар* нь орон нутгийн удирдлагын байгууллагаас 1) ногдуулдаг, 2) хувь хэмжээг нь тогтоодог, 3) өөрсдөө хураадаг, 4) орлого нь орон нутгийн төсөвт хуримтлагддаг байх ёстой.⁵

Яагаад орон нутгийн засаг захиргаа өөрийн орлоготой байх ёстой вэ?

- төвлөрлийг сааруулах,
- хариуцлагыг дээшлүүлэх,
- орон нутгийн бие даасан байдлыг хангах, төсвийн гадуурх орлогыг бууруулах.

Гэхдээ улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг орон нутгийн татварын орлоготой андуурч болохгүй. Эдгээр татваруудыг ногдуулах, хувь хэмжээг нь тогтоох, хураалт зэргийг төв засгийн газар хариуцдаг байна. Харин орон нутгийн төсвийн орлогын нэг бүрэлдэхүүн болдог хуваагдах орлого буюу улсын төсвийн орлогоос тодорхой хэсгийг орон нутагт шилжүүлэх хэлбэр нь дэлхийн олон оронд түгээмэл байдаг.

Хүснэгт 1. Татварын төвлөрсөн болон төвлөрсөн бус системд илрэх зэрэг, сөрөг нөхцөл байдал⁶

Төвлөрсөн		Төвлөрсөн бус	
Зэрэг	Сөрөг	Зэрэг	Сөрөг
Эдийн засгийн нэгдсэн бодлого, зохицуулалт	Орон нутгийн нөөц бүрэн дүүрэн ашиглагдахгүй байх	Орон нутгийн нөөцийн ашиглалт	Макро зохицуулалт сулрах
Орон нутгаа хянах	Орон нутгийн санаачлага буурах, бэлэнчлэх	Идэвхи санаачлага өрсөлдөөн	Засгийн газрын хяналт
Татварын ачаалал орон нутагт жигд	Орлогын дахин хуваарилалтаас үүсэх хүнд суртал, зардал	Уян хатан	Татвар төлөгчид харилцан адилгүй татвар төлөх
	Орон нутгийн чанартай бодлого, зохицуулалт	Орлогоо төлөвлөх боломж	Бүс нутаг хоорондын тэгш бус байдал
	Зардлын хариуцлага сул	Зардлын хариуцлага өндөр	Шилжилт

⁵ Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг зохистой хангах нь. Судалгааны тайлан. **Нээлттэй нийгэм форум**. 2009 он. 11 дэх тал.

⁶ Татварын бодлогын "ндсэн асуудал. "Мянганы хөгжлийн зорилт–9: Төсвийн "йл явц дахь иргэний нийгмийн оролцоо" сэдэвт сургалт. МХЗ-9 төслийн баг, Удирдлагын академи. 2009.03.23.

	Үүрэг, хариуцлагын зөрчил	Орон нутгийн захиргааны шуурхай ажиллагааг нэмэгдүүлэх замаар үр ашгийг дээшлүүлэх	
	Тодорхой бус байдал	Иргэдийн оролцоо, ил тод байдал	

Монгол Улсын орон нутгийн татварын эрх зүйн орчны өнөөгийн байдал.

Төсвийн тухай хуулинд (2002) төсвийн бүрдэл хэсгүүдийг тодорхой заасан байдаг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах орон нутгийн төсөвтэй байна. Орон нутгийн төсвийн орлогыг аймаг, нийслэл болон сум, дүүрэг гэсэн хоёр хэсэгт хуваадаг. Баг, хороо нь бие даасан төсөвгүй сум, дүүргийн төсвөөс санхүүждэг.

Татварын ерөнхий хуульд (2008) зааснаар тогтоосон төрөлд нь орон нутгийн албан татвар, хураамж, төлбөрүүд багтсан бөгөөд эдгээр нь зөвхөн тухайн засаг захиргааны нэгжийн төсөвт орж түүнээс санхүүжигдэх үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан. Татварын ерөнхий хуулийн 7.4-т зааснаар орон нутгийн 16 төрлийн албан татвар байх бөгөөд тэдгээрийн хувь хэмжээг УИХ-аас тогтооно. Засгийн газар болон аймаг, нийслэлийн ИТХ нь УИХ-аас баталсан хязгаарт багтаан зарим төрлийн татварын хувь хэмжээг тогтооно. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Орон нутгийн татварын төрөл, хувь, хэмжээ, тэдгээрийг тогтоох субъект

УИХ-аас хувь хэмжээг тогтоодог орон нутгийн татваруудын төрөл	Хувь хэмжээг Засгийн газар тогтоодог	Хувь хэмжээг Аймаг, нийслэлийн ИТХ тогтоодог	Орон нутгийн татварын орлого	
			Аймаг, нийслэл	Сум дүүрэг
Татварын ерөнхий хуулийн 7-8-р зүйлүүд				
Албан татвар:				
1. хувь хүний орлогын				✓
2. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын				✓
3. бууны				✓
4. үл хөдлөх эд хөрөнгийн			✓	
5. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн			✓	
6. нийслэл хотын			✓	
7. нохойны				
8. өв залгамжлал, бэлэглэлийн				

төлбөр:				
9. газрын	✓		✓	
10. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	✓			✓
11. ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны	✓			✓
12. ус, рашааны нөөц ашигласны	✓	✓		✓
13. байгалийн ургамал ашигласны		✓		✓
14. түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны				✓
хураамж:				
15. ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн				✓
16. улсын тэмдэгтийн хураамж				✓
Нэгдсэн төсвийн хуулийн 10-р зүйлийн 10.1, 10.3 дахь заалт				
17. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 20%			20%	10%
18. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25%			25%	25%
19. цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар			✓	

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан татварын харилцаа. Нийслэл хотын албан татварыг хуулиар тогтооно, мөн цаашлаад хотын оршин суугчийн ба хот төлөвлөлтийн албан татвараас нийслэлийн татвар бүрдэнэ гэж байгаа нь тодорхойгүй байна. Албан татварын төрлүүдийн суурь, хувь хэмжээ гэх мэт олон харилцааг ямар хуулиар зохицуулахыг тодорхой заах: бие даасан хууль байх, эсвэл одоогийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Зарим тодорхой санал. Энэ хаврын чуулганаар орон нутгийн төсөв болон татварын бие даасан хууль санаачлан боловсруулагдаж эхлээд байгаа. Боловсруулалтын шатанд хангалттай, урьдчилан тооцох боломжтой, ил тод орлоготой болгох асуудлыг маш тодорхой болгох нь чухал юм. Хуулийг боловсруулахдаа орон нутгийн засаг захиргааны "цэвэр орон нутгийн чиг үүрэг"-ийг

хэрэгжүүлэхэд шаардлагатай орлогын хэрэгцээг тооцож үзэх шаардлагатай⁷ бөгөөд тэрхүү чиг үүрэгтэй нь нягт уялдуулж орон нутгийн өөрийн орлогыг болон төв засгийн газартай хуваалцах татварын нэр төрлийг тодорхой зааж, бүх төрлийн зорилтот болон ерөнхий тэтгэлгийн шинж чанар, тэтгэлгийн нийт хэмжээ, түүнийг хуваарилахад ашиглах томъёо зэргийг нарийн тодорхойлох хэрэгтэй.

Шинэ төрлийн татвар:

- Хуулийн төсөлд тусгасан татваруудаас гадна дархан цаазат бүс нутагт оршин суугчдаас авах тусгай төрлийн татварыг бий болгох.
- Мөн хотод тулгамдаад байгаа хогны асуудлыг татвар, хураамж эсвэл төлбөр зэрэг хэлбэрийн аль нэгээр илүү нарийвчилсан зохицуулалтаар нийслэлийн татварын харилцааг зохицуулах хуульд тусгах.

Орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэхийн тулд дараах асуудалд анхаарах хэрэгтэй:

- бодлогын баримт бичгийг иж бүрэн болгох,
- зарим бодлогын асуудлыг тогтвортой байлгах, хөрвөх чадвартай байлгах,
- орон нутгийн эрх мэдэлд татварын ямар төрлүүдийг төвлөрүүлж байхыг тодорхой болгох,
- татварын хувь хэмжээг орон нутгийн эдийн засгийн үндэслэлтэй, нийгмийн хамгааллын зардалыг уялдуулж тогтоох,
- мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох.

2.3.3. Нийслэлийн өмчийн эрх зүйн зохицуулалтын талаар

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 5 дугаар заалтаар Нийслэлийн өмчийн эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байна.

Хуулийн төсөлд саналыг гаргахдаа бусад хууль тогтоомжид тухайн заалтын талаар хэрхэн зохицуулсан болон хуулийн төсөлд тусгагдсан зарим тодорхойгүй заалтын талаар заалт тус бүр дээр дараахь саналыг гаргалаа. Үүнд:

Хуулийн төслийн заалт	Санал
18.1. Нийслэл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан өмчтэй байх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77-р зүйлд Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн 77.1-т Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна гэж хуульчилсан байна. Мөн хуульд төрийн болон орон нутгийн өмчийн талаар нарийвчлан хуульчилсан байх бөгөөд төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжүүлэх журам, төрийн болон орон нутгийн өмчийг ангилсан байдаг. Иймд тодорхой саналгүй.
18.2. Нийслэлийн өмч нь хуульд заасан үндэслэлээр	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 74-р зүйлд орон нутгийн өмчийн талаархи ойлголтийг хуульчилсан байдаг.

⁷ Монгол Улсын төв орон нутгийн харилцааг шинэчлэн тодорхойлох нь: орон нутгийн удирдлагын шинэтгэлийг хэрэгжүүлэх боломжит чиглэлд. Хэлэлцүүлэгт зориулсан төсөл. *НБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газар*. 2008.10-р сар.

<p>олж авсан нийслэлийн өөрийн эд хөрөнгө болон нийслэлийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгөөс бүрдэнэ.</p>	<p>74.1-д Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ.</p> <p>74.2-т Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарна гэж заасан байдаг.</p> <p>Тодорхой саналгүй.</p>
<p>18.3.Нийслэлийн өмчийг захиран зарцуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн 77.2.2-т Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх гэж хуульчилсан байдаг.</p> <p>Гэвч хуулийн төслийн 18.3-т нийслэлийн өмчийг захиран зарцуулах эрхийг Засаг дарга өргөн мэдүүлж, иргэдийн Төлөөлөгчийн хурал шийдвэрлэхээр тусгасан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар ИТХ-ийн тэргүүлэгчдийн хувьд тухайн орон нутгийн өмчийг захиран зарцуулах эрхтэй бус харин энэ чиглэлээр зохиогдсон ажлын үр дүнг хэлэлцэж чиглэл өгөх үүрэгтэйгээр хуульчилсан байна.</p> <p>Иймд хууль хоорондын хамаарал, зүйл заалтын хоорондын зөрчигдсөн заалтыг анхаарах шаардлагатай байна.</p>
<p>18.4.Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх, ашиглуулах, бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн 77.3-т Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ гэж хуульчилсан байдаг.</p> <p>Орон нутгийн өмчийн хөрөнгийн хувьд бусдын өмчлөлд шилжүүлэх, шинээр олж авах зэрэг асуудлын талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар хуульчилсан байдаг.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид төрийн өмчийг барьцаалах асуудлыг ямар журмаар хэрхэн зохицуулах талаар нарийвчилсан зохицуулалт нь тодорхойгүй байна. Зөвхөн тухайн хуульд 77.3-т заалт л байдаг.</p> <p>Хэрэв төрийн өмч, орон нутгийн өмчийг /үүнд нийслэлийн өмч хамраана/ барьцаалах тохиолдолд ямар журмаар барьцаалах вэ?</p> <p>-Бонд /үнэт цаас/ гаргах журмаар: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2. Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, аймаг, нийслэлийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлөөр нийтэд санал болгон үнэт цаас гаргаж болно. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргасан үнэт цаас нь бусад үнэт цаасны нэгэн адил Хороо болон Хөрөнгийн биржид бүртгэлтэй байна гэж хуульчилсан байдаг.</p> <p>- Төр орон нутгийн өмчийн бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг барьцаалах тухай тохиолдолд энэ хуулийн заалтыг нарийвчлан хуульчлах эсхүл ямар журмаар үл хөдлөх хөрөнгийг барьцаалах талаар бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулан тодорхой</p>

	болгох шаардлагатай болно.
18.5.Нийслэл нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу хууль тогтоомжид нийцүүлэн гадаад улс болон аймаг, сумын нутаг дэвсгэрт нийслэлийн төлөөлөгчийн газар байгуулж болно.	<p>“Нийслэлийн төлөөлөгчийн газар” гэдэг ойлголт нь тодорхойгүй байна. Манай улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийн хувьд нийслэлийн төлөөлөгчийн газрыг хэрхэн байгуулах, эрх бүхий байгууллагаас /эрх бүхий байгууллага гэдэгт нийслэлийн хувьд ямар субъект байх вэ?/ ямар зөвшөөрлийг авч байгуулах талаар ямар ч эрх зүйн зохицуулалтгүй болно.</p> <p>Хуулийн этгээдийн хувьд төлөөлөгчийн газраа байгуулах талаар хуульчлагдан зохицуулагдаж байгаа бөгөөд харин Нийслэл хотын хувьд нь энэ талаархи эрх зүйн зохицуулалт байхгүй болно.</p> <p>Мөн түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.” гэж заасаг байдаг.</p> <p>Иймд хуулийн төслийн 18.5 заалтыг хасах саналтай байна.</p>

2.3.4.Нийслэлийн эрх зүйн байдлын байдлын тухай хуулийн төсөлд газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын талаар

Хуулийн төсөлд газар, газрын харилцаатай нарийвчилсан зүйл, заалт байхгүй бөгөөд газрын харилцаатай холбогдох нарийвчилсан зохицуулалтыг Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай зэрэг хуулиар зохицуулсан байдаг.

Хуулийн төслийн заалт	Санал
10 дугаар зүйл Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрх	
10.7.8-д газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах	<p>Газрын тухай хуулийн 20.2 дугаар зүйлд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг нарийвчлан тодорхой тусгасан байдаг.</p> <p>20.2.1. нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах;</p> <p>20.2.2. газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>Тодорхой саналгүй</p>
10.7.9. Газрын тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;	<p>Газрын тухай хуулийн 21.2.3-т нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу хотын суурьшилын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг</p>

	<p>шийдвэрлэхэд холбогдох дүүргийн Засаг даргын саналыг авсан байна;</p> <p>Тодорхой саналгүй</p>
10.7.10. холбогдох хуулийн дагуу нийслэлийн оршин суугч, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх;	<p>Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн 12.1.3-т аймгийн төвийн сумын Засаг дарга болон нийслэлийн дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэний газар өмчлүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах эрхийг хуульчилсан байна.</p> <p>Гэвч хуулийн төсөлд “нийслэлийн оршин суугч” гэдэг нэрийг тодотгосон байх тул уг нэр томъёог хасч “холбогдох хуулийн дагуу Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэх” гэж оруулах.</p>
11 дүгээр зүйл. Дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрх	
11.5.3.энэ хуулийн 10.7.10-д зааснаас бусад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;	<p>Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд Газар эзэмшүүлэх шийдвэр гаргах талаар тусгайлан заасан байдаг. Үүнд:</p> <p>33.1. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг дараахь журмыг баримтлан шийдвэрлэнэ:</p> <p>33.1.1. энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;</p> <p>33.1.2. энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.</p> <p>Иймд Газрын тухай хуулиар газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар нарийвчлан тодорхой заасан байх тул хуулийн төслийн энэ заалтад “Монгол улсын иргэнд өмчлүүлсэнээс бусад газрыг хуульд заасан журмын дагуу эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах” гэж өөрчлөх</p>
12 дугаар зүйл. Хороо, түүний удирдлагын бүрэн эрх	
12.3.1. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн өөрийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, барилга байгууламж барих зэрэг	<p>Газрын тухай хуулийн 22.2-т Баг, хорооны Засаг дарга газрын харилцааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>✓ 22.2.1. газрын тухай хууль тогтоомж, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаархи нийтлэг</p>

асуудлыг хэлэлцэн саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлэх	шаардлагын биелэлтийг хангуулах;
12.4. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь газар эзэмшүүлэх, ашиглуулах, барилга байгууламж барих зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа энэ хуулийн 12.3.1-д заасан саналыг заавал үндэслэнэ.	<p>✓ 22.2.2. дээд шатны байгууллага болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас газрын ашиглалт, хамгаалалтын талаар гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах;</p> <p>✓ 22.2.3. нутаг дэвсгэртээ нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хариуцах.</p> <p>Иймд хуулийн төсөлд заасан Хороо, түүний удирдлагын бүрэн эрхийн газартай холбоотой энэхүү заалтыг Газрын тухай хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай болно.</p>

Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай зэрэг газрын харилцаатай холбогдох хуулиудад газрын харилцаанд төрийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг дарга ямар эрх, үүрэгтэйгээр оролцохыг нарийвчлан зохицуулсан байдаг.

Иргэн хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх харилцаанд захиргааны байгууллага дараахь төрлийн оролцоо байхаар хуулиар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Зөвшөөрлийн тогтолцоо;
 - Газар эзэмших, ашиглах, өмчлөхөд тухайн шатны Засаг даргаас зөвшөөрөл авах;
 - Газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэхэд тухайн шатны Засаг даргаас зөвшөөрөл авах;
 - Газар эзэмшигч газраа бусдад ашиглуулахад тухайн шатны Засаг даргаас зөвшөөрөл авах;
 - Газар өмчлөгч нь өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулахад тухайн шатны Засаг даргаас зөвшөөрөл авдаг байна.
2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө;
3. Өмчлөлд байгаа болон гэрээгээр эзэмшиж байгаа газрыг хугацаа дуусахаас өмнө газрын нөхөн олговортойгоор эргүүлэх авах;
4. Газар эзэмших эрх дуусгавар болоход газар чөлөөлөх;
5. Иргэдийн эзэмшил, ашиглалтанд байгаа газрыг нийтийн эдэлбэр болон тусгай хэрэгцээнд ашиглах зэрэг болно.

2.3.5. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын талаар:

20 дугаар зүйл. Нийслэлийн чөлөөт бүс байгуулах

Хуулийн төслийн 20.1. Нийслэлийн чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна.

Уг хуулийн төслийн танилцуулга /6-Г/-д дурьдсанаар нийслэлийн эдийн засаг, аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулан ажиллуулах журмыг холбогдох хуулиар тогтоож өгөхөөр тусгалаа хэмээн заасан бөгөөд хуулийн төсөлд уг санаа ерөнхий утга агуулгаар тусгагдаж орсон.

Нийслэлд аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулах нь хэр тохиромжтой эсэхийг тооцоо судалгаагаар судалсны үндсэн дээр оруулсан эсэхийг анхааран авч үзэх, харин нийслэлийн тодорхой бүс нутагт эдийн засгийн /Чөлөөт бүсийн тухай хуулийн 3.3-3.6/ чиглэлийн дагуу чөлөөт бүс байгуулах нь илүү зохимжтой юм.

2.4. Нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудал

Нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгжтэй харилцах асуудал нь маш өргөн агуулгатай бөгөөд бүх шатны нутгийн удирдлагын хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд зохицуулагддаг харилцаа юм.

Монгол Улсын Үндсэн Хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Засаг захиргааны нэгжийн түвшингээс үл хамааран аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарын нийтлэг бүрэн эрхийн тухай зохицуулсан байдаг. Нийтлэг бүрэн эрхэд тухайн нэгжийн хөгжлийн төлөвлөлтийг удирдан зохион байгуулах, төсөв санхүү, татварын бодлогыг хэрэгжүүлэх хүн амд ерөнхий боловсрол олгох, эрүүл мэндийг сахин хамгаалах, соёл урлаг, шинжлэх ухааныг хөгжүүлэх, байгаль хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, хууль ёс, дэг журмыг сахиулах, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах зэрэг бараг бүх салбар чиглэлээр тодорхой үүрэг хүлээж, эрх эдэлж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд **Аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн захиргааны төв байгууллагатай харилцахдаа** төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, харьяалах нутаг дэвсгэрийн салбарын болон салбар хоорондын бодлогыг хэрэгжүүлэхдээ харьяалах нутаг дэвсгэртээ төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан шийдвэр гаргаж биелэлтийг зохион байгуулах; нэгдсэн бодлогын талаар Ерөнхий сайдтай шууд харилцах; Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагад саналаа уламжлах, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн удирдлагын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэхээр зохицуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ Хурал, түүний Тэргүүлэгчидтэй харилцахдаа Хурал, түүний Тэргүүлэгчдээс хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж дүнг тайлагнах; хууль тогтоомж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, түүний үр дүнг жил тутам Хуралд тайлагнах; сум, дүүргийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргатай зөвшилцөн, аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргын хооронд үүссэн маргааныг нутгийн удирдлагын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус шийдвэрлэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын хамтын ажиллагаа нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийг цогцолбороор хөгжүүлэх, хөрөнгө хүч төвлөрүүлэх томоохон асуудлыг Хурал, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга нар хамтран хэлэлцэж шийдвэрлэх буюу саналаа холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны явцад сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын хооронд үүссэн маргааныг харьяалах дээд шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Ерөнхий сайд тус тус шийдвэрлэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль нь нутгийн удирдлагуудын төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй харилцах,

хамтран ажиллах эрх хэмжээг ерөнхий байдлаар зохицуулсан байна. Нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон 140 гаруй хуулинд нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг хуульчилж өгсөн. Эдгээр ажил хэрэгтэй байнга мөрдөн ажилладаг хуулинд нийслэлийн эрх зүйн байдлын шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудлыг нэр бүхий 137 хуулинд нийслэлийн бүх шатны удирдлагын эрх, үүргийн нарийвчилан зохицуулсан байна.⁸

Ялган тодорхойлсон эдгээр хуулиудаас гадна хуульд заагаагүй бусад эрх зүйн актаар зохицуулагддаг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын эрхийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжтэй харилцахдаа дараах эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:

- НИТХ-ын 2007 оны 71 дүгээр тогтоолоор *“Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл”*-ийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д зааснаар 2 жил,
- НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 55 дугаар тогтоолоор *“Улсын Нийслэлд хөшөө дурсгал хүндэтгэлийн самбар байршуулах журам”*
- Нийслэлийн Засаг Даргын 2001 оны 333 дугаар захирамжаар *“Орон сууцны нэгдүгээр давхарын зориулалтыг өөрчлөх зөвшөөрөл”*
- НИТХ-ын 2006 оны “Журмыг шинэчлэн батлах тухай” 145 дүгээр тогтоолоор *“Реклам мэдээллийн байгууламж байрлуулах зөвшөөрөл”*
- НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1998 оны 29, 2005 оны 147 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт байгалийн баялаг ашиглах зөвшөөрөл”
- НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 155 дугаар тогтоолоор *“Нийслэлийн хэмжээнд соёл урлагийн төлбөрт үйлчилгээ эрхлэх”*⁹

Эндээс судалгааны сэдвийн хүрээнд зохицуулж буй асуудал нь нийслэлийн эрх зүйн байдлын тухай шинэчилсэн төсөлд тусгагдсан зохицуулалтыг одоо үйлчилж буй хууль эрх зүйн орчин, эрх зүйн актуудтай нь харьцуулан авч үзье.

Шинэчилсэн найруулгын төслийн **21 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах** 21.2. *Нийслэлийн удирдлага нь төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр нийслэлийн эрх ашгийг зөрчиж байна гэж үзвэл дүгнэлт, саналаа Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад гаргана.*

Нийслэлийн удирдлагаас төрийн захиргааны төв байгууллагатай харилцахдаа шинэчилсэн төслийн дээрхи заалтын агуулга нь ерөнхийдөө Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн ерөнхий зохицуулалтад тусгагдсан, нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг нарийвчилан тодотгосон боловч энэ заалт нь нийслэлийн удирдлагын хуулиар олгосон нийтлэг бүрэн эрх, бусад хуулийн зохицуулалтаар ч энэ эрх нь нээлттэй учир заавал хуулинд тусгах шаардлагагүй болов уу гэж үзэж байна. Хуулийн төслийн 5 дугаар бүлгийн нэр нь нийслэлийн удирдлагаас төрийн захиргааны төв байгууллагатай харилцах. Гэтэл 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйл буюу **Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах** заалтууд хуулийн бүтцийн хувьд 2 дугаар бүлгийн 7 дугаар зүйлд байрших боломжтой.

⁸ Нийслэлийн Засаг Даргын эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудын жагсаалт, НЗДТГ-аас судалгааны ажлын хэсэгт ирүүлсэн мэдээлэл, 56 хуудас

⁹ Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудаас хуульд заагаагүй бусад эрх зүйн актаар зохицуулагддаг эрхүүд, НЗДТГ-аас судалгааны ажлын хэсэгт ирүүлсэн мэдээлэл, 2 хуудас

21.5.Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нийслэлийн нутаг дэвсгэрт газар ашиглуулах тухай шийдвэр гаргахдаа Нийслэлийн Засаг даргын саналд үндэслэнэ.

Тус заалтын хувьд шинээр нэмж оруулсан зохицуулалт бөгөөд нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах тусгай хамгаалалттай газар нутагт БОАЖЯ-ны сайд эрхлэх асуудлын хүрээнд тусгай хамгаалттай тус бүсэд аялал жуулчлалын чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших зөвшөөрөл олгодог байсан нь дэд бүтцийг барьж байгуулах асуудал нь газар олголтоос салж, цогц байдлаар шийдэгдэж чадахгүй, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мөрдөхөд хүндрэл бий болж байгаа тул дүүргийн Засаг дарга бус нийслэлийн Засаг дарга санал өгдөг байх нь зүйтэй гэж төслийн танилцуулгад дурьджээ.

Үүнтэй холбогдуулан тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан *“Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон, сум дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана”* гэсэн заалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга гэж өөрчлөх. Мөн тус хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтуудын дүүргийн Засаг дарга гэснийг нийслэлийн Засаг дарга гэж өөрчлөхөөр тусгагдсан нь хуулийн төсөл хэлэлцэх үед маргаантай асуудлын нэг байх гэж үзэж байна. Учир нь энэ асуудал нь тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулаад зохицуулагдах асуудал биш бөгөөд эргээд нийслэлийн удирдлага, БОАЖЯ-ны сайд нарын дунд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан дэгдээх эрсдэл харагдаж байна. Иймд тус асуудлаар нарийвчилан судлах хэрэгтэй болов уу.

Нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгжтэй, байгууллагатай харилцах асуудал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон 140 орчим хуульд нарийвчлан зохицуулсан харилцаа бөгөөд төсөлд тусгагдсан зохицуулалт нь хуулиар зохицуулах шаардлагагүй байж болох юм. *“Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн шүүмж, бусад орны туршлага” /1-р хэсэг/* харьцуулсан судалгаанд тус харилцааг бусад оронд */Турк, Казахстан, Унгар/* тусгайлан хуулиар зохицуулалт хийгддэггүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Хууль

- Монгол Улсын Үндсэн Хууль /1992/.
- Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /2006/.
- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль /2002/.
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль /1994/.
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /1993/.
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай /2003/.
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль /2002/.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/.
- Татварын ерөнхий хууль /2008/.
- Хот байгуулалтын тухай хууль /2008/.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /

Монгол хэл дээрх бусад материал

- “Төвлөрлийг сааруулахад нутгийн өөрийн удирдлагын санхүүгийн үндсийг бэхжүүлэхийн ач холбогдол” илтгэл. *Монгол Улсын Ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид*. 2008-12-20. Чингис хаан зочид буудал.
- Орон нутгийн төсвийн орлогын хуваарилалтыг зохистой хангах нь. Судалгааны тайлан. **Нээлттэй нийгэм форум**. 2009 он. 11 дэх тал.
- Монгол Улсын төв орон нутгийн харилцааг шинэчлэн тодорхойлох нь: орон нутгийн удирдлагын шинэтгэлийг хэрэгжүүлэх боломжит чиглэлүүд. Хэлэлцүүлэгт зориулсан төсөл. *НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газар*. 2008.10-р сар.
- Монгол Улсын төв орон нутгийн харилцааг шинэчлэн тодорхойлох нь: орон нутгийн удирдлагын шинэтгэлийг хэрэгжүүлэх боломжит чиглэлүүд. Хэлэлцүүлэгт зориулсан төсөл. *НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газар*. 2008.10-р сар.
- Нийслэлийн Засаг Даргын эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулиудын жагсаалт, НЗДТГ-аас судалгааны ажлын хэсэгт ирүүлсэн мэдээлэл, 56 хуудас
- Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагуудаас хуульд заагаагүй бусад эрх зүйн актаар зохицуулагддаг эрхүүд, НЗДТГ-аас судалгааны ажлын хэсэгт ирүүлсэн мэдээлэл, 2 хуудас

Гадаад хэл дээрх бусад материал

- Act on the structure of the capital city of Warsaw, 15 March 2002;
- Act on the local self-government of Warsaw, 1994;
- The Statute of the capital city of Warsaw, 2008;
- Закон Республики Казахстан “О статусе столицы Республики Казахстан”, 2007 г.
- Устав города Москвы, М., 15.02.2006, <http://www.businesspravo.ru/>;
- Правила регистрации в Москве, Москвагийн Засгийн газрын тогтоол №859, М., 2006.10.31, <http://www.help-hr.ru/catalog/>;
- Правила о порядке застройки г. Москвы, <http://pravo.levonevsky.org/baza/soviet/sss6520.htm>;
- <http://www.mevzuat.gov.tr/>
- Федеральный закон “О статусе столицы Российской Федерации”. 2004 г. www.consultant.ru
- Закон “О статусе столицы Республики Беларусь-города Минска”. www.base.spinform.ru/
- Устав города Москвы, 2006 г. www.roskodeks.ru
- Устав города Минска, 2001 г. www.myminsk.com/
- Декларация конференции Объединения столиц Европейского Союза 2007. [www. S tolitsa.tallinn.ee/](http://www.tolitsta.tallinn.ee/)
- М.М.Гордеева Столица федеративного государства в системе взаимоотношений “центр-регион”: политический анализ зарубежного и российского опыта. М., 2008 г
- Т.І. Jaskova Capital region and capital position: ratio of concerts. www.belchas.by
- А. Лола Принципы управления крупнейшим городам. www.vasilievaa.narod.ru

**НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТАЛААРХИ ШҮҮМЖ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**
(Харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ)

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Хатанбаатар, Ө.Мөнхтунгалаг,
Ш.Хишигсүрэн/LLM/, Г.Чулуун*

АГУУЛГА

Оршил

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон НЭЗБТХуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл заалтын харьцуулалт (Лавлагаа)

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, түүнийг гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалттай харьцуулсан нь:

- Польш, Казахстан улсын холбогдох хууль тогтоомжийн харьцуулалт
- Туркийн нийслэлийн эрх зүйн зохицуулалт, зарим харьцуулалт
- ОХУ-ын нийслэл Москва хотын эрх зүйн зохицуулалт

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн шүүмж, харьцуулалт, дүгнэлт, санал-зөвлөмж

Ашигласан материал

Оршил

Энэхүү судалгааг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэхэд бэлтгэх ажлын хүрээнд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга (Ө.Энхтүвшин)-ын захиалгаар хийж гүйцэтгэв.

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу Тамгын газрын Судалгааны төвийн ажлын баг нийтдээ гадаадын 4 орон (Польш, ОХУ, Турк, Казахстан)-ы ижил төстэй хууль тогтоомжид агуулгын шинжилгээ хийв. Хууль тогтоомжийн харьцуулалт хийх улс орныг сонгохдоо бид тухайн улс орны төрийн байгууламж нь аль болохоор манайтай адил “нэгдмэл улс” байвал зүгээр юм гэсэн чиг баримжаагаар хандсан. Хэдий тийм боловч, “холбооны улс”-ын хууль тогтоомжид ч тусгаж авууштай туршлага зохицуулалт байх боломжтойг үгүйсгээгүй. Энэ үүднээс хөрш зэргэлдээх ОХУ-ын нийслэлийн эрх зүйн зохицуулалтын баримт бичгүүдийг тухайлан судаллаа. Гадаадын холбогдох хууль тогтоомжийг өөрийн орны төлөвлөж буй шинэ зохицуулалт

(төсөл, заалт)-тай харьцуулахдаа бид ашиглахад дөхөмтөй байх талаас нь бодолцож, тэдгээрийг зүйлчлэн жишиж хүснэгтлэн үзүүлэв.

Мөн, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхдагч шүүмжийг бэлтгэв. Энэ явцдаа, хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)-ийн агуулгын хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой холбогдох уялдаа холбоо, нийцэмж, зөрчлийг гаргах, шаардлагатай гэсэн газрууддаа тэдгээрийг тодотгон тайлбарласан болно.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн ололттой талуудыг хууль санаачлагч (Засгийн газар) танилцуулгадаа дэлгэрэнгүй тайлбарласан болохоор, судалгааныхаа ажлын энэ хэсэгт уг хуулийн төслийн сөрөг агууламжийг олж харах, илрүүлэх, тэдгээрээс улбаалан гарч болох алдаа дутагдлаас шийдвэр гаргагчдыг сэрэмжлүүлэхийн төлөө ажиллаа. Шүүмжийн үндсэн хэсэгт гарсан нийт санаанд тулгуурлаж, төгсгөлд нь бид, товчхон дүгнэлт хийж, тодорхой зарим саналыг дэвшүүлсэн болно. Польш, Казахстаны хуулийг Багийн ахлагч, ахлах судлаач Р.Хатанбаатар, Туркийн хууль тогтоомжид холбогдох боловсруулалтыг референт-судлаач Ш.Хишигсүрэн, ОХУ болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн шүүмж, санал, зөвлөмжийн хэсгийг шинжээч Г.Чулуун, хуучин хууль ба шинэ төслийн агуулгын ялгамжийн лавлагааг судлаач Ө.Мөнхтунгалаг нар тус тус бэлтгэн, төгсгөлд нь, ашигласан материалын нэгтгэсэн жагсаалтыг хавсаргав.

1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон Нэкбтхуул-н шинэчилсэн найруулгын төслийн зүйл заалтын харьцуулалт		
Одоогийн мөрдөгдөж буй хуулийн зохицуулалт		Хуулийн төслийн зохицуулалт /УИХ-д өргөн барьсан шинэчилсэн найруулга/
Нэгдүгээр бүлэг. Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, нийслэлийн удирдлагын үндсэн зарчим, нийслэлийн онцлог чиг үүрэг, нутаг дэвсгэр эдэлбэр газрын талаар		
Хуулийн бүтэц	5 бүлэг 23 зүйлтэй.	6 бүлэг 32 зүйлтэй.
Хуулийн зорилт	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэлийн /цаашид "нийслэл" гэх/ чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын эрх хэмжээ, онцлог, нийслэлээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлж, энэ явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл /цаашид "нийслэл" гэх/-ийн онцлог чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын бүрэн эрх, нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлийн удирдлагаас оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. <i>Нийслэлийн оршин суугчийн эрх үүргийг нэмж оруулсанаар нийслэлийн хөгжилд оршин суугчдын оролцоог нэмэгдүүлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгох зорилготой.</i>
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
Нийслэл, түүний чиг үүрэг	Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн. Нийслэл нь засаг захиргааны хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд	4.2.Нийслэл нь хуулиар олгосон чиг үүрэг, өмч хөрөнгө, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

	<p>хуваагдана.</p> <p>Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот /алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон/-той байж болно.</p> <p>Нийслэлд Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, тус улсад байгаа гадаад орны дипломат төлөөлөгчдийн газар байнга төвлөн оршино.</p> <p>Нийслэл нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ. Төрийн эрх бүхий байгууллага өөрөөр шийдвэрлээгүй бол нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ явагдана.</p>	<p>4.3. Далай ашиглах тухай хуулийн 81.1-д заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хот байна.</p> <p>4.4.Нийслэл нь Улаанбаатар бүсийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх, оршин суугчийн суурьшил, хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах үүднээс алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүстэй байж болно.</p> <p>4.5.Нийслэлд Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар байнга төвлөн оршино.</p> <p>4.6.Нийслэлийн удирдлага нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ.</p> <p>4.7.Төрийн эрх бүхий байгууллага өөрөөр шийдвэрлээгүй бол нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээг зохион байгуулна.</p>
<p>Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газар</p>	<p>Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд түүний дотор хотын эдэлбэр газар байна.</p> <p>Хот байгуулах зориулалтаар хотын ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан гортиг бүхий газрыг нийслэл хотын эдэлбэр газар гэнэ.</p> <p>Нийслэлийн эдэлбэр газарт нийслэлийн хилийн цэсийн дотор оршин буй дагуул хотын эдэлбэр газар</p>	<p>6.1.Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэст багтана.</p> <p>6.2.Нийслэлийн нутаг дэвсгэр нь Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүсчлэлтэй байх бөгөөд байгаль орчныг хамгаалах болон ой, усны нөөц хамгаалах бүстэй байна.</p> <p>6.3.Нийслэлийн нийтийн эдэлбэр газарт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж,</p>

	<p>хамаарна.</p> <p>Нийслэлийн дагуул хотын нутаг дэвсгэр нь нийслэлийн хилийн цэст багтана.</p>	<p>байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамир, спортын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.</p> <p>6.4.Чиг үүргээ биелүүлэх зорилгоор нийслэлийн эзэмших, ашиглах газар нь нийслэлийн хилийн цэсийн гадна байж болно.</p>
Нийслэлийг хөгжүүлэх бодлого	<p>Нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт, нийгэм, эдийн засаг, байгаль орчны зохистой тэнцлийг хангах бие даасан бодлого явуулна.</p> <p>Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт нь үндэсний уран барилгын өв уламжлалыг дэлхийн нийслэл хотуудын хөгжлийн нийтлэг жишигтэй хослуулан хөгжүүлэх бодлогод үндэслэнэ.</p>	<p><i>Нийслэлийг хөгжүүлэх бодлого нь нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн өнөөгийн зохицуулалтаас гадна дараах бодлогыг баримтална.</i></p> <p>5.2.Нийслэлийн удирдлага нь хот байгуулалт, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тэнцвэрийг ханган хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх, хүний хөгжлийг төлөвшүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, засаглалыг сайжруулах бодлого явуулна.</p> <p>5.3.Нийслэлийн удирдлага нь аж үйлдвэр, дэд бүтэц, өндөр технологийн үйлдвэрлэлийг томоохон төслөөр дамжуулан хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгийг татах бодлого баримтална.</p>
Нийслэлийн удирдлага, түүний онцлог	<p>Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдэнэ.</p> <p>- Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуйг биечлэн зохион байгуулах, мэргэжлийн албадыг зохицуулан удирдах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.</p> <p>- Хотын ерөнхий менежер нь Улаанбаатар хотын</p>	<p>Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдэнэ.</p> <p>10.2. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуй, үйлчилгээг удирдан зохион байгуулах, мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.</p> <p>10.3.Улаанбаатар хотын Захирагч нь ажлын албатай байна.</p>

	<p>захирагчийн удирдлага дор ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна. - Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын захирагчийн хувьд өөртөө зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулна. <p>Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийслэлийн нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөө бүхий аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нийслэлийн Засаг даргын ажлын албаны болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан нийслэлийн Засаг дарга батална.</p>	<p>Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байх бөгөөд дарга нь хотын Ерөнхий менежер байна.</p> <p>10.4.Захирагчийн ажлын алба нь Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамж, хотын орон сууц, нийтийн аж ахуй, худалдаа үйлчилгээ, хүн амын хүнсний хангамж, нийтийн тээврийн үйлчилгээ, зам, хот тохижилт, цэцэрлэгжилт, орчны бохирдол, хог хаягдал зэрэг асуудлаар гаргасан Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлийн удирдлагын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>10.5. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагчийн хувьд өөртөө зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.</p> <p>10.6. Энэ хуулийн 10.5-д заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.</p>
Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн удирдлага нь зохион байгуулалт, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндсэн зарчмыг баримтална. - Нийслэлийн удирдлагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ оршин суугчдынхаа хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ. - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, засаг дарга, үйл ажиллагаандаа иргэдийн санал бодол, нутаг дэвсгэртээ ажиллаж буй төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, сүм хийд, буяны болон сайн санааны байгууллага, олон түмний идэвхи 	<p>Нийслэлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8.2-т заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үндсэн зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:</p> <p>3.2.1.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөх;</p> <p>3.2.2.нийслэлийн оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх;</p> <p>3.2.3. нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь олон нийтийн санал, оролцоонд тулгуурлах, ил тод байх.</p>

	оролцсонд тулгуурлах зарчмыг баримтална.	Нийслэлийн удирдлага, зохицуулалтын үндсэн зарчмыг шинээр томъёолон оруулахдаа Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтан чанд мөрдөх, нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь олон нийтийн санал оролцоонд тулгуурлан ил тод байх, оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх, Үндсэн хуульд заасан үндсэн зарчмыг мөрдөж ажиллахаар тусгажээ.
Хоёрдугаар бүлэг. Нийслэлийн удирдлагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрхийн талаар		
Нийслэлийн удирдлагын бүрэн эрх	<p>1. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах;</p> <p>2/ нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>3/ нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавих;</p> <p>4/ нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хүн амын үйлчилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж</p>	<p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийслэлийн талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: .</p> <p>9.1.7.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.8. Нийслэлийн оршин суугчийн суурин амьдралын хэв маяг, хамтач үзлийг хөгжүүлэх, хотын соёл, хамтын хариуцлагыг төлөвшүүлэх ажил зохион байгуулах;</p> <p>9.1.9. нийслэлийн агаар, ус, хөрс, экологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр батлах;</p> <p>9.1.10. нийслэлийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил тогтоох;</p> <p>9.1.11. нийслэлийн тухайн жилийн төсвийн төслийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.12. нийслэлийн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах;</p>

	<p>шийдвэрлүүлэх;</p> <p>5/ нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллага, гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачилгаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах.</p> <p>2. Нийслэлийн Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ нийслэл хот улсын хэмжээнд суурин соёл иргэншлийн тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагуудтай нэгдсэн бодлого явуулах асуудлаар Ерөнхий сайдтай шууд харилцах;</p> <p>2/ нийслэлд хүн амын хэт төвлөрөл бий болох, ажил эрхлэлт, нийтийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэвийн ачаалал алдагдахаас сэргийлэх зорилгоор нийслэлд шилжин суурьших асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх;</p> <p>3/ хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах ашиг сонирхолд нийцүүлэн хүрээлэн байгаа орчныг бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлэхүйц үйлдвэр, объектыг барьж байгуулах асуудалд холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн хориг тавих, үйлдвэрлэл, үйл ажиллагааг нь түр түдгэлзүүлэх, нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>4/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжээс</p>	<p>9.1.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>9.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно.</p> <p>9.3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нийслэлийн Засаг даргын нэгэн адил баталгаагаар хангагдана.</p> <p>Нийслэлийн Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1. Нийслэлийн Засаг дарга тодорхой чиг үүрэг хариуцсан орлогч, зөвлөхтэй байна.</p> <p>10.7.7. Нийслэл дэх үндэстэн, ястан, цөөнхийн түүх, шашин, соёлын өвийг хамгаалан, арвижуулах;</p> <p>10.7.8. газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>10.7.9. Газрын тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;</p> <p>10.7.10. Холбогдох хуулийн дагуу нийслэлийн оршин суугч, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх;</p> <p>10.7.11. Дүүргийн Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын даргын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох;</p> <p>10.7.12. эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтоох;</p> <p>10.7.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
--	--	--

	<p>нийслэлд ажиллах хүчийг зохион байгуулалттайгаар шилжүүлэх асуудлыг зохицуулах;</p> <p>5/ нийслэлийг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;</p> <p>6/ дотоод, гадаад харилцаанд нийслэлийг төлөөлөх.</p> <p>3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.</p>	
Гуравдугаар бүлэг. Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг		
Нийслэл хотын оршин суугч, нийслэлийн өмнө түүний хүлээх үүрэг	<p>Нийслэл хотод хууль ёсоор байнга амьдарч буй Монгол Улсын иргэнийг нийслэл хотын оршин суугч гэнэ.</p> <p>Нийслэл хотын оршин суугч нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхийн зэрэгцээ нийгэм, эдийн засгийн давуу талыг эдэлж, ажиллаж амьдрах таатай нөхцөлөөр хангагдаж байдгийн хувьд нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>1/ нийслэл хотын татварыг хугацаанд нь төлөх;</p> <p>2/ нийслэлийн удирдлагаас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэр, тогтоосон журмыг сахих, гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх ажилд оролцох;</p> <p>3/ нийслэлийн бүх шатны удирдлагаас зохиож буй ажил, нийслэлийг хөгжүүлэх үйлсэд идэвхитэй оролцож, хотын аж ахуй, нийтийн үйлчилгээний байгууламжийг зориулалтын дагуу эзэмшиж, хайрлан хамгаалах, ариун цэврийг сахих, гудамж талбайг цэвэр байлгах;</p> <p>4/ нийслэл хотын оршин суугчийн хууль ёсны баримт</p>	<p>13.1. Нийслэлийн засаг захиргааны нэгжид бүртгүүлэн 183 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар байнга оршин суугаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг нийслэлийн оршин суугч гэнэ.</p> <p>13.2. Нийслэлд 183 хүртэлх хоногийн хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг түр оршин суугч гэнэ.</p> <p>Нийслэлд байнга болон түр оршин суугаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.</p> <p>Нийслэлийн оршин суугч дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>15.1.1. хуульд заасан журмын дагуу албан татвар, хураамж, төлбөр төлөх;</p> <p>15.1.2. Нийслэлийг хөгжүүлэх ажилд идэвхитэй</p>

	<p><i>бичгийн зөрчилгүй байх.</i></p> <p>Нийслэл хотын оршин суугч биш Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийслэл хотод амьдарч байх хугацаандаа энэ хууль, бусад хууль тогтоомж, нийслэлийн удирдлагаас гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.</p>	<p>оролцох;</p> <p>15.1.3. нийтийн эзэмшлийн эд зүйлийг зохистой ашиглах, амьдарч байгаа орчноо цэвэр байлгах;</p> <p>15.1.4. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлийн бүсэд оршин суух;</p> <p>15.1.5. оршин суугаа нутаг дэвсгэртээ гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны болон цагдаа, онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох, нийгмийн хэв журмыг сахих;</p> <p>15.1.6. нийслэлд оршин суухдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу харьяалах хороонд 10 хоногийн дотор бүртгүүлсэн байх;</p> <p>15.1.7. түр хугацаагаар оршин суугч нь хүндэтгэх шалтгааны улмаас энэ хуулийн 13.2-т зааснаас дээш хугацаагаар нийслэлд оршин суух бол мөн хугацаагаар сунгуулах;</p> <p>15.1.8. нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх;</p> <p>15.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.</p>
Нийслэлийн оршин суугчийн эрх	Нийслэлийн оршин суугчийн эрхийн талаар зохицуулалтгүй.	Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаар хэлэлцэж байгаа асуудлаар мэдээлэл авах, санал өгөх, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан санал дэвшүүлэх, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн хэрэгцээний барилга байгууламж, зам, гүүр, инженерийн

		<p>шугам сүлжээ, цэцэрлэгт хүрээлэн байгуулахад зориулж өөрийн өмчлөл эзэмшил, ашиглалтад байгаа газраа чөлөөлсний төлөө зохих журмын дагуу нөхөх олговор авах; нийслэлийн оршин суугч өөрийн санаачилгаар орчноо тохижуулах, мод бут тарих болон нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсныхаа төлөө урамшуулал авах, хөнгөлөлт эдлэх, соёл урлаг, биеийн тамир, спорт, аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг зохих журмын дагуу ашиглах, хууль тогтоомжид заасан бусад эрх.</p> <p>14.2. Энэ хуулийн 14.1.4, 14.1.5-д заасан хөнгөлөлт, урамшуулалын хэмжээг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.</p>
<i>Дөрөвдүгээр бүлэг. Нийслэлийн эдийн засаг, өмч, төсөв, санхүү</i>		
Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс	Нийслэлийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, байгалийн бусад баялаг, хотын мэдлийн аж ахуй, улсын хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгө, татвар, нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс бүрдэнэ.	Нийслэлийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад нөөц баялаг, нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр хураамж болон татварын бус орлого, нийслэлийн сангийн хөрөнгөөс бүрдэнэ.
Нийслэл хотын төсөв	Нийслэл хот нь бие даасан төсөвтэй байна. Төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.	<p><i>Төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.</i></p> <p>4.8. Улаанбаатар хот нийслэлийн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг улсын төсөвт тусган төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт хэлбэрээр олгоно.</p> <p>4.9. Нийслэлд улсын төсвөөс олгох захиалгат</p>

		бүтээгдэхүүний санхүүжилт, гэрээт үйлчилгээний төлбөрийг нийслэлийн төсвийн зохих зүйл ангид тооцно.
Нийслэлийг хөгжүүлэх сан	<p>Нийслэл нь хотын аж ахуйг өргөтгөх, хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хүн амын хангамж, үйлчилгээг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор Засгийн газраас тогтоосон тусгай зориулалтын сантай байж болно.</p> <p>Энэхүү сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулна. Нийслэлийг хөгжүүлэх зориулалтаар дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдсэн сан байж болох бөгөөд сангийн хөрөнгийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч захиран зарцуулж, гүйцэтгэлийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тавина.</p>	<p>Нийслэл нь хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын аж ахуйг өргөтгөх, хүн амын үйлчилгээг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийслэл, дүүргийг хөгжүүлэх сантай байж болно.</p> <p>Санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. Сан нь сангийн үйл ажиллагааны орлого, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ. Нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, дүүргийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дүүргийн Засаг дарга захиран зарцуулж, гүйцэтгэлийг жил бүр нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.</p>
Нийслэлийн өмч	<p>1. Нийслэл нь өөрийн мэдлийн өмчтэй байна.</p> <p>2. Нийслэлийн өмч нь барилга байгууламж, эд хөрөнгө, хотын аж ахуйн болон бусад хөрөнгөөс бүрдэнэ.</p>	<p>18.1. Нийслэл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан өмчтэй байх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.</p> <p>18.2. Нийслэлийн өмч нь хуульд заасан үндэслэлээр олж авсан нийслэлийн өөрийн эд хөрөнгө болон нийслэлийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгөөс бүрдэнэ.</p> <p>18.3. Нийслэлийн өмчийг захиран зарцуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.</p> <p>18.4. Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх, ашиглуулах, бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, нийслэлийн өмчит болон</p>

		<p>өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.</p> <p>18.5. Нийслэл нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу хууль тогтоомжид нийцүүлэн гадаад улс болон аймаг, сумын нутаг дэвсгэрт нийслэлийн төлөөлөгчийн газар байгуулж болно.</p>
Нийслэлийн чөлөөт бүс байгуулах	-----	<p>20.1. Нийслэлийн чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна.</p>
Нийслэл хотын татвар	<p>1. Нийслэл хот татвартай байна.</p> <p>2. Нийслэл хотын татварыг хуулиар тогтооно.</p>	<p>17.2. Нийслэл хот нь албан татвартай байна. Нийслэл хотын татварыг хуулиар тогтооно.</p> <p>17.3. Нийслэлийн хотын албан татвар нь хотын оршин суугчийн албан татвар, хот төлөвлөлтийн албан татвараас бүрдэнэ.</p> <p><i>Хотын онцлогт нийцсэн, татварын орлогын тогтвортой нэр төрлийг нэмэгдүүлэх үүднээс нийслэл хотын оршин суугчийн албан татвар, хот төлөвлөлтийн албан татварыг бий болгох зорилготой.</i></p>
Тавдугаар зүйл. Нийслэлийн удирдлагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах		
Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах	<p>1. Төрийн захиргааны төв байгууллагаас салбарын удирдлагыг хэрэгжүүлэхдээ нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг эрх ашигтай холбогдох асуудлаар нийслэлийн Засаг дарга, шаардлагатай гэж үзвэл иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, эсхүл түүний Тэргүүлэгчидтэй зөвшилцөнө.</p>	<p><i>Нийслэлийн удирдлагаас төрийн захиргааны төв байгууллагатай харилцах зохицуулалтыг шинэчилсэн найруулгын төслөөр субъект тус бүрээр нь нарийвчлан эрх үүргийг нь тусгасан байна. Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар бүлгийг үз.</i></p>

	<p>3.Нийслэлийн удирдлагаас хот тохижилт, хүрээлэн байгаа орчин, хот-нийтийн аж ахуйг хамгаалах талаар гаргасан шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллага биелүүлэх үүрэгтэй.</p> <p>4. Төрийн захиргааны төв байгууллагаас өөрийн болон нийслэлд орших харьяа байгууллагынхаа хэрэгцээнд нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших, түрээслэх тухай асуудлыг нийслэлийн удирдлага тавьж шийдвэрлүүлнэ.</p>	
Нийслэлийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан бусад эрхээр зохицуулагдана.	Нийслэлийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрхийг шинэчилсэн төсөлд нийслэлийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, нийслэлийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
Засгийн газрын бүрэн эрх	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан бусад эрхээр зохицуулагдана.	Нийслэлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллагад мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөгөө үзүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, нийслэлийн удирдлагын саналыг үндэслэн нийслэлийн тогтвортой хөгжлийг хангах зорилт, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
Дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрх	<p>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах, хилийн цэсийг батлах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</p> <p>Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол</p>	<p>Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно.</p> <p>Дүүргийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа,</p>

	<p>Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>Дүүргийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх хэрэгжүүлнэ.</p>	<p><i>нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</i></p> <p><i>11.5.1. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас дүүрэгт шилжүүлсэн өмчийн болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;</i></p> <p><i>11.5.2. хууль тогтоомжид нийцүүлэн захирамж, заавар, дүрэм, журам батлан мөрдүүлж, гүйцэтгэлийг хангуулах;</i></p> <p><i>11.5.3. энэ хуулийн 10.7.10-д зааснаас бусад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;/хасах/</i></p> <p><i>11.5.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</i></p>
Хороо, түүний удирдлагын бүрэн эрх	<p>Хорооны иргэдийн Нийтийн Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>Хорооны Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрх хэрэгжүүлнэ.</p>	<p>Хорооны иргэдийн Нийтийн Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p><i>Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн өөрийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах, барилга байгууламж барих зэрэг асуудлыг хэлэлцэн саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь газар эзэмшүүлэх, ашиглуулах, барилга байгууламж барих зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа энэ хуулийн 12.3.1-д заасан саналыг заавал үндэслэнэ.</i></p> <p><i>12.5. Хорооны иргэдийн Нийтийн Хурал жилд 3-аас доошгүй удаа хуралдана.</i></p> <p><i>12.6. Хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, хорооны Засаг даргын албан тушаалыг сумын Хурлын дарга, сумын Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно.</i></p> <p><i>Хорооны Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг</i></p>

		<p>хэрэгжүүлнэ:</p> <p>12.7.1. хорооны хүн амын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэн хөтлөх;</p> <p>12.7.2. оршин суугчийн хэвийн аж төрөх нөхцлийг хангах үүднээс харьяалах нутаг дэвсгэрт орших сууц өмчлөгчдийн холбоо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсэг, төрийн бус байгууллагатай нягт хамтран ажиллах;</p> <p>12.7.3. хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулсан болон энэ хуулийн 34.1.6, 34.1.7-д заасан торгуулийн мөнгийг хорооны мөнгөн хөрөнгийн санд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулах;</p> <p>12.7.4. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах явцад үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх;</p> <p>12.7.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>12.8. Хорооны иргэдийн нийтийн Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах	<p>1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгэм, соёлын талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.</p> <p>2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нийслэлийн хүн амыг хүнс болон шаардагдах бусад зүйлээр хангах, нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлж, үүрэг хүлээнэ.</p> <p>3. Нийслэлийн хөгжил, хүн амын хангамж, нийгэм, эдийн засгийн үндэс болох үйлдвэр, аж ахуй, хангалтын зориулалттай бааз газрыг Засгийн газрын шийдвэрээр</p>	<p>22.1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжил, иргэдийн суурьшлийн талаар гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.</p> <p>22.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нь нийслэлийн хүн амыг бараа, үйлчилгээгээр хангах, нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлнэ.</p> <p>22.3. Нийслэлийн хөгжилд зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, бүтэц бий болгох үйлдвэр, аж ахуй,</p>

	<p>засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж, гэрээний үндсэн дээр ашиглаж болно.</p> <p>4. Нийслэл, аймаг, бусад хотын хоорондын эдийн засаг, нийгэм, аж ахуйн харилцааг хуулиар тусгайлан зохицуулна.</p>	<p>хангамжийн байгууллагыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж болно.</p> <p>22.4. Аймаг, нийслэл, бусад хот хоорондын эдийн засаг, нийгэм, аж ахуйн харилцааг хуулиар тусгайлан зохицуулна.</p>
Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	<p>1. Нийслэлийн удирдлага нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, ажил үйлчилгээг сайжруулах талаар шаардлага тавина.</p> <p>2. Нийслэлийн удирдлага хотын аж ахуй, нийтийн үйлчилгээний тоног төхөөрөмж, инженерийн барилга байгууламжийн эзэмших хэмжээг тогтоож, ашиглалт засварыг нь хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллагад хариуцуулна.</p> <p>3. Эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтооно.</p> <p>4. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрладаг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудлыг тухайн гэрээнд зааснаар буюу Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулна.</p>	<p>23.1. Нийслэлийн удирдлага нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ажил үйлчилгээг сайжруулах, орчны тохижилт, цэвэрлэгээ хийх зэрэг асуудлаар шаардлага тавина.</p> <p>23.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь хотын аж ахуй, инженерийн барилга байгууламжийн эзэмшлийн зааг хэмжээ, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоож, ашиглалт засвар, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.</p> <p>23.3. Нийслэлийн Засаг дарга нь нутгийн захиргааны тодорхой чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.</p> <p>23.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.</p>
Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж</p>	<p>24.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж</p>

нэгжээс нийслэлийн өмнө хүлээх үүрэг	<p>нь өмчийн хэлбэрээс үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>1/ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн нийслэлийн удирдлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ажиллагсаддаа мэдээлж, биелэлтийг хангах;</p> <p>2/ нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн удирдлагаас явуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>3/ өөрийн эзэмшиж буй эдэлбэр газар, барилга байгууламж болон орчны гудамж, талбайг шаардлагын дагуу зүй зохистой ашиглах.</p>	<p>нь өмчийн хэлбэрээс үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>24.1.1. хууль тогтоомжид нийцүүлэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ажиллагсаддаа мэдээлж, хэрэгжүүлэх;</p> <p>24.1.2. нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн удирдлагаас явуулж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>24.1.3. өөрийн эзэмшиж байгаа эдэлбэр газар, барилга, байгууламжаасаа 50 метр хүртэлх зайд байгаа гудамж, талбайг стандарт, норм, дүрэм, журам, зохих шаардлагын дагуу зүй зохистой ашиглаж, тохижуулан цэвэр цэмцгэр байлгах;</p> <p>24.1.4. барилга байгууламж барих, засварлах явцад гарсан шороо, хог хаягдлыг тээвэрлүүлж, зөвшөөрөгдсөн газар хаях;</p> <p>24.1.5. эрүүл ахуйн стандартыг ханган ажиллаж, хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх.</p> <p>24.2. Энэ хуулийн 23.3-т заасны дагуу нутгийн захиргааны тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, нийслэлийн төсвөөс санхүүжилт авсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь уг ажлаа Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна.</p>
Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлаас нийслэлийн өмнө хүлээх үүрэг	<p>Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлага тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн хэрэгжилтийг хариуцна.</p>	<p>25.1. Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлага тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн хэрэгжилтийг хариуцна.</p>
Зургаадугаар зүйл. Бусад		
Нийслэлийн бэлгэ тэмдэг	<p>1.Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэгтэй байна.</p> <p>2.Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хэрэглэх</p>	<p>26.1. Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэг, хүндэтгэлийн дуутай байна.</p> <p>26.2. Нийслэлийн туг, сүлд, тэмдгийн загвар, хүндэтгэлийн</p>

	журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтооно.	дууг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална. <i>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн хүндэтгэлийн дууг хэрэглэх журмыг батлах үүрэг нэмэгдсэн.</i>
Нийслэлийн хүндэт иргэн ба шагнал	<p>1. Нийслэлийг хөгжүүлэх хэрэгт онцгой хувь нэмэр оруулсан хүнийг "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнаана. "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.</p> <p>2. "Нийслэл хотын хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.</p>	<p>27.1.Нийслэлийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэнийг "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнаана. "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.</p> <p>27.2."Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.</p>
Нийслэлийн мэдээлэл, судалгааны байгууллага	<p>1. Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.</p> <p>2. Нийслэлийн удирдлага нь дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэтийн төлөвийг тодорхойлох, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах шинжилгээ, судалгааны төвтэй байж болно.</p>	<p>28.1.Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.</p> <p>28.2.Нийслэлийн удирдлага нь дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэтийн төлөвийг тодорхойлох, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах шинжилгээ, судалгааны төвтэй байж болно.</p>
Нийслэлийн өдөр	Нийслэлийн өдрийг жил бүр тэмдэглэнэ. Нийслэлийн өдрийг Улсын Их Хурал тогтооно.	29.1.Улсын Их Хурлаас тогтоосон нийслэлийн өдрийг жил бүр тэмдэглэнэ.
Хориглох зүйлс	-----	<p>30.1.Нийслэлийн иргэн, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид дараахь зүйлсийг хориглоно:</p> <p>30.1.1.иргэний бүртгэлгүй оршин суух, төлөвлөлтгүй газар суурьшил үүсгэх болон суурьших;</p>

		<p>30.1.2.хуульд заасан зөвшөөрөлгүйгээр газар эзэмших, ашиглах, барилга угсралтын ажил явуулах, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх ашигт халдах, бусдын орц, гарцыг хаах;</p> <p>30.1.3.инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр ашиглах, гэмтэл учруулах;</p> <p>30.1.4.хотын ногоон байгууламж, байгалийн болон таримал мод, бут, сөөгийг хугалах, устгах, сүйтгэх;</p> <p>30.1.5.байгаль орчин, нуур, цөөрөм, гол, горхи, булаг, шандыг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдуулах;</p> <p>30.1.6.хий, шахмал болон боловсруулсан түлш, нүүрс, мод, цаас, малын гаралтай түлшнээс өөр хорт утаа ялгаруулдаг зүйлсийг түлшинд хэрэглэх;</p> <p>30.1.7.суурьшлын зөвшөөрөгдөөгүй бүсэд мал аж ахуй эрхлэх.</p>
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	-----	<p>31.1.Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:</p> <p>31.1.1.энэ хуулийн 15.1.1-15.1.3, 15.1.5-15.1.9-т заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000 төгрөгөөр торгох;</p> <p>31.1.2.энэ хуулийн 24.1.3-24.1.5-д заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох;</p> <p>31.1.3.энэ хуулийн 30.1.1-30.1.3, 30.1.5-30.1.7-д заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох;</p> <p>31.1.4.энэ хуулийн 30.1.4-т заасныг зөрчсөн бол хугалсан, устгасан мод, бут, сөөгийг ширхэгээр, сүйтгэсэн цэцэг, зүлгийн эзлэх талбайн хэмжээг 5 дахин өсгөсөн хэмжээгээр</p>

		нөхөн сэргээлгүүлэх, эсхүл иргэнийг 50000-150000, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000-500000 төгрөгөөр торгох. 31.2.Энэ хуулийн 15.1.4-т заасныг зөрчиж Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлийн бүсэд оршин суугаагүй иргэнд нийслэл хотын хангамж, үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд үүдэн гарах хохирлыг тухайн этгээд хариуцна.
--	--	---

1.1. НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН БОЛОН ПОЛЬШ, КАЗАКСТАНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

	<i>Монгол Улсын “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулга</i>	<i>Польш улсын хууль</i>	<i>Казахстан улсын хууль</i>
Нэгдүгээр бүлэг. Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, нийслэлийн удирдлагын үндсэн зарчим, нийслэлийн онцлог чиг үүрэг, нутаг дэвсгэр эдэлбэр газрын талаар			
Хуулийн зорилт, хууль тогтоомж,	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл /цаашид "нийслэл" гэх/-ийн онцлог чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын бүрэн эрх, нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлийн удирдлагаас оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино		Бүгд Найрамдах Казахстан улсын нийслэлийн статусын тухай хууль нь нийслэл үйл ажиллагаагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулж, үйл ажиллагааных нь эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг тодорхойлно.
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж	2.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа,	БНПУ-ын нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь “Нийслэл хот Варшавын бүтэцийн хууль” (Act on the	1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь БНКаз.Улсын Үндсэн хууль, Нийслэлийн статусын тухай хууль

	<p>нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p>	<p>structure of the capital city of Warsaw), “Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль” (Act on local self-government) болон Варшав хотын дүрэм (The Statute of the capital city of Warsaw) зэрэг хууль тогтоомжоос бүрдэнэ.</p> <p><i>*Манай хуулийн шинэчлэсэн найруулгад буй гол заалтууд үндсэндээ The Statute-ийн заалттай давхцаж байна.</i></p>	<p>болон БНКаз.Улсын бусад хууль эрхийн актаас бүрдэнэ.</p> <p>2.БНКаз.Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p>
Нийслэл, түүний чиг үүрэг	<p>4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн.</p> <p>4.2. Нийслэл нь хуулиар олгосон чиг үүрэг, өмч хөрөнгө, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>4.3. Далай ашиглах тухай хуулийн 81.1-д заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хот байна.</p> <p>4.4. Нийслэл нь Улаанбаатар бүсийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хүрээлэн байгаа орчин,</p>	<p>-Варшав хот бол улсын нийслэл мөн.</p> <p>-Варшав бол засаг захиргааны мужтай адил</p> <p>-Варшав хотын иргэд нутгийн өөрөө удирдах байгууллагатай байна</p> <p>-Варшав хот өөрийн эрх зүйн статустай бөгөөд суверинитет нь шүүхээр хамгаалагдана</p> <p>-Варшав хот улсын нийслэлийн хувьд төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Засгийн газрын төрийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд нийслэл хотын хувьд гүйцэтгэх аливаа</p>	<p>1. Астана хот бол Бүгд Найрамдах Казахстан улсын нийслэл мөн</p> <p>2.Астана хот БНКаз.У-ын нийслэлийн хувьд 1. улсын улс төрийн болон засаг захиргааны төв, 2. БНКазУ-ын Үндсэн хуулийн эх хувь, БНКаз.У-ын Төрийн сүлд, Төрийн далбааны эталон байх газар мөн. Эдгээр нь БНКаз.У-ын Ерөнхийлөгчийн ордон “Акорда”-д хадгалагдана.</p> <p>3. Нийслэлд БНКаз.У-ын Ерөнхийлөгчийн “Акорда” ордон, Парламент, Засгийн газар, Дээд шүүх болон бусад төрийн төв байгууллагууд байрлана.</p>

	<p>ногоон бүсийг хамгаалах, сэргээх, оршин суугчийн суурьшил, хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах үүднээс алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүстэй байж болно.</p> <p>4.5. Нийслэлд Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар байнга төвлөн оршино.</p> <p>4.6. Нийслэлийн удирдлага нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ.</p> <p>4.7. Төрийн эрх бүхий байгууллага өөрөөр шийдвэрлээгүй бол нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>үүргийг хүлээнэ</p> <p>- Хотын үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн чанартай төрийн бодлогын асуудлууд орно</p> <p><i>*Варшав хотын эрх зүйн байдалтай холбоотой дээрхи хууль, дүрэмд хотын үйл ажиллагааны зарчмын талаар нилээд олон заалт орсон байна. Үүнд:</i></p> <p><i>-Хот үйл ажиллагаагаа явуулахын тулд зохион байгуулалтын нэгж байгуулах, бусад байгууллага, түүн дотор төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллах, хотын хэмжээний тулгамдсан асуудлаар иргэдийн дунд санал асуулга, референдум явуулах, хотын иргэдийн дунд зөвлөлгөөн зохион байгуулах</i></p> <p><i>-Хот, районы байгууллагуудын ажиллагаа ил тод байх, хотын болон районы зөвлөлүүдийн чуулган болох газар, хугацааг нийтэд зарлаж байх, иргэн чуулганы үйл ажиллагааг ажиглах эрхтэй байх, хуулинд</i></p>	<p><i>*БНХАУ-ын нийслэлийн чиг үүргийн талаар хуульд ийнхүү заасан байгаа боловч Ерөнхийлөгчийн зарлиг, шийдвэрүүдээр зохицуулагдах чиг үүрэг, харилцаанууд байдаг.</i></p>
--	--	---	--


		<i>өөрөөр заагаагүй бол иргэн бүр хотын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах, баримт бичигтэй танилцах эрхтэй байх</i>	
Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газар	<p>6.1. Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэст багтана.</p> <p>6.2. Нийслэлийн нутаг дэвсгэр нь Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүсчлэлтэй байх бөгөөд байгаль орчныг хамгаалах болон ой, усны нөөц хамгаалах бүстэй байна.</p> <p>6.3. Нийслэлийн нийтийн эдэлбэр газарт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамир, спортын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.</p> <p>6.4. Чиг үүргээ биелүүлэх зорилгоор нийслэлийн эзэмших,</p>	<p>Дээрх хууль тогтоомжуудад Варшав хотын нутаг дэвсгэрийг хавсралтаар заасан байгаа боловч нийтийн эдэлбэр газрын талаар тусгайлсан заалт алга байна. Харин хот, районы дарга, зөвлөлийн ажлын хүрээнд оруулсан нарийвчилсан заалтууд байна.</p>	<p>1. Нийслэлийн нутаг дэвсгэр нь Засгийн газраас өргөн барьснаар БНКаэ.У-ын Ерөнхийлөгчийн тогтоосон буюу өөрчилсөн Астана хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хил доторхи газар, усны объектуудаас бүрдэнэ. Хилийн цэсийг өөрчлөх буюу тогтоохдоо нутгийн төлөөлөх болон гүйцэтгэх байгууллагуудын саналыг харгалзана.</p> <p>2. Хоттой нийгэм, байгаль орчин, аж ахуйн нэгдсэн нутаг дэвсгэр үүсгэсэн хотын хилийн цэсийн гадна орших газар нутаг нь нийслэлийн орчны дагуул бүс болно. Уг бүсийн хил, хэмжээг нийслэлийн маслихат, акимат болон бүсийн оршин байгаа мужийн маслихат, акиматын хамтарсан саналаар Засгийн газар тогтоох буюу өөрчлөнө. (Маслихат- иргэдийн хурал, акимат- захиргаа)</p> <p>*Нийслэл болон дагуул бүсийн</p>

	ашиглах газар нь нийслэлийн хилийн цэсийн гадна байж болно.		<i>хилийн цэсийг тогтоох буюу өөрчлөх субъектийг энэ хуулиар тодорхой заасан нь манай хуулийн төслөөс ялгагдах гол ялгаа болж байна.</i>
Нийслэлийн бэлгэ тэмдэг	<p>26.1. Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэг, хүндэтгэлийн дуутай байна.</p> <p>26.2. Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хүндэтгэлийн дууг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.</p>	<p>- Варшав хот өөрийн сүлд, туг, өнгөтэй байна. Эдгээрийг Варшав хотын статусаар тодорхойлно</p> <p>- Район мөн өөрийн дүрмээр тодорхойлогдсон туг, сүлд, өнгөтэй байж болох бөгөөд түүнийгээ хотын бэлгэ тэмдэгтэй хамт ашиглаж болно.</p>	Нийслэл өөрийн сүлд, далбаа, сүлд дуутай байна. Сүлд, далбаа, сүлд дууллын тодорхойлолт болон хэрэглэх журмыг нийслэлийн маслихат батална.
Нийслэлийн удирдлага, түүний онцлог	<p>3.1. Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан ёсоор бүрдэнэ.</p> <p>10.2. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуй, үйлчилгээг удирдан зохион байгуулах, мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.</p> <p>10.3. Улаанбаатар хотын Захирагч нь ажлын албатай</p>	Энэ төрлийн заалтууд “Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль” (Act on local self-government)-нд тусгагдсан байна	<p>Хот БНКаз.У-ын нийслэлийн үүрэг гүйцэтгэхтэй холбоотой нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. нийслэл БНКаз.У-ын улс төр, засаг захиргаа, соёл, эдийн засгийн төвийн үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх 2. дэлхийн бусад нийслэлүүдтэй өрсөлдөх боломжийг дээшлүүлэх, тогтвортой хөгжил бүхий хот болгох 3. нийслэлийг олон улсын харилцааны төв болгон хөгжүүлэх

	<p>байна. Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байх бөгөөд дарга нь хотын Ерөнхий менежер байна.</p> <p>10.4. Захирагчийн ажлын алба нь Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамж, хотын орон сууц, нийтийн аж ахуй, худалдаа үйлчилгээ, хүн амын хүнсний хангамж, нийтийн тээврийн үйлчилгээ, зам, хот тохижилт, цэцэрлэгжилт, орчны бохирдол, хог хаягдал зэрэг асуудлаар гаргасан Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлийн удирдлагын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>10.5. Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагчийн хувьд өөртөө зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.</p> <p>10.6. Энэ хуулийн 10.5-д заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын</p>		<p>4. БНКаз.У-ын Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газар, Дээд шүүх болон бусад төрийн захиргааны төв байгууллагууд, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх</p> <p>5. улсын болон олон улсын зохион байгуулах, явуулах нөхцлийг бүрдүүлэх</p> <p>6. БНКаз.У-ын хууль тогтоомжоор тодорхойлогдсон бусад чиг үүргийг гүйцэтгэх</p> <p><i>*Энэ хуулинд нийслэлийн удирдлагын тогтолцоог эхэлж тодорхойлолгүйгээр зөвхөн чиг үүргийг нь заасан байна.</i></p>
--	---	--	--

	Захирагч батална.		
Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим	<p>3.2. Нийслэлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8.2-т заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үндсэн зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:</p> <p>3.2.1. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөх;</p> <p>3.2.2. Нийслэлийн оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх;</p> <p>3.2.3. нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь олон нийтийн санал, оролцоонд тулгуурлах, ил тод байх.</p>	<p>1. Хотын зөвлөлийн гишүүн нь өөрийн сонгогчдоо төлөөлөх бөгөөд, өөрийн сонгогдсон хотын зөвлөл болон нутгийн өөрөө удирдах бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох нь түүний эрхэм үүрэг мөн</p> <p>2. Хотын зөвлөлийн гишүүн нь хотын иргэд болон тэдний байгууллагуудтай тогтмол холбоотой байж, тэдний саналыг хотын удирдлагын байгууллагуудад төлөөлж байх үүрэгтэй</p> <p>3. Хотын зөвлөлийн гишүүн мандатынхаа үндсэн дээр цалин хангамж авах бөгөөд түүний хэмжээг хотын зөвлөл холбогдох зохицуулалтыг үндэслэн тогтооно</p> <p>4. Хотын зөвлөлийн гишүүн өөрийн болон эхнэр, хоёрдугаар үе хүртэлх хамаатан садных нь эрх ашиг тусгагдсан асуудал хэлэлцэхэд оролцохгүй байх үүрэгтэй</p> <p>5. Хотын зөвлөлийн гишүүн мандатаасаа татгалзаж болох бөгөөд энэ тухайгаа бичгийн</p>	

		хэлбэрээр хотын зөвлөлд мэдэгдэнэ		
Хоёрдугаар бүлэг. Нийслэлийн удирдлагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрхийн талаар				
Нийслэлийн бүрэн эрх	удирдлагын	<p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх</p> <p>9.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийслэлийн талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.1.1. нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах;</p> <p>9.1.2. нийслэлийн оршин суугчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж байгаа тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.3. нийгмийн дэг журмыг хамгаалах, хотын аж ахуй, оршин суугч, аж ахуйн нэгжийн нийгэм-соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>9.1.4. нийслэл, түүний оршин</p>	<p>1.Хотын зөвлөлийн бүрэн эрхэнд хуульд өөрөөр заагаагүй бол хотын үйл ажиллагаатай холбоотой бүх асуудал багтана.</p> <p>2. Хуулиар зөвхөн район ба районы зөвлөлийн бүрэн эрхэнд байхаар зааснаас бусад бүх асуудал хотын зөвлөлийн бүрэн эрхэнд хамаарна.</p> <p>3. Дараах асуудлууд зөвхөн хотын зөвлөлийн мэдэлд байх боловч шийдвэр гаргахдаа холбогдох районы зөвлөлийн саналыг авсан байна. Үүнд:</p> <p>1/ Хотын дүрэм батлах</p> <p>2/ Хотын газрын удирдлагын төлөвлөгөөг батлах</p> <p>3/ хотын хөгжлийн программ, урт хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах</p> <p>4/ районуудыг байгуулах, нийлүүлэх, татан буулгах</p> <p>5/ районы дүрэм батлах, районы</p>	<p>БНКаЗ.У-ын бусад хууль тогтоомжоор тогтоогдсон бүрэн эрхээс гадна нийслэлийн маслихат (иргэдийн хурал) өөрийн эрх мэдлийн хүрээнд:</p> <p>1.бусад улсын орон нутгийн төлөөллийн байгууллагуудтай олон улсын харилцаа тогтоох</p> <p>2. хот байгуулалтын төлөвлөгөөг батлахад нийслэлийн нутгаас газар ашиглах нэмэлт нөхцлүүдийг тодорхойлно</p> <p>3. нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, нийслэлийн төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланг батална.</p> <p>Нийслэлийн гудамж, талбайд реклам байрлуулах нөхцөл, журмыг батална.</p> <p>Шаардлагатай иргэдэд үзүүлэх нийгмийн туслалцааны журам, хэмжээг батална</p>

	<p>суугчийн нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>9.1.5. хот байгуулалт, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжил, хүн амын үйлчилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>9.1.6. нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллага, гудамж, талбайг нэршүүлэх, нэрэмжит болгох, хөшөө, дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачлагаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах;</p> <p>9.1.7. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.8. нийслэлийн оршин суугчийн суурин амьдралын хэв маяг, хамтач үзлийг хөгжүүлэх, хотын</p>	<p>үйл ажиллагааны хүрээг тогтоох, өмчийг ашиглуулахаар шилжүүлэх, төсвийн хөрөнгийг хуваарилах</p> <p>6/ хотын бэлгэ тэмдэг, гудамж талбайн нэр, нийтийн эзэмшлийн болон хотын доторх зам, хөшөө дурсгалтай холбоотой эрхийн актуудыг батлах</p> <p>4. Хотын зөвлөл дээрх шийдвэрүүдийг гаргахдаа районы зөвлөлийн саналыг авахаар тогтоосон хугацаанд районы зөвлөл хариу ирүүлээгүй бол санал авах шаардлага биелэгдсэнд тооцно.</p> <p>1. Хотын зөвлөл хяналт шалгалтын комиссийг байгуулна.</p> <p>2. Уг комисс нь бүх бүлгүүдийг төлөөлсөн хотын зөвлөлийн гишүүдээс бүрдэх бөгөөд комисст хотын зөвлөлийн дарга, түүний орлогч нар орж болохгүй</p> <p>3. Комиссийн зорилго нь:</p> <p>1/ хотын дарга, хотын болон районы байгууллагуудын үйл ажиллагаа хуулийн хүрээнд</p>	
--	---	--	--

	<p>соёл, хамтын хариуцлагыг төлөвшүүлэх ажил зохион байгуулах;</p> <p>9.1.9. нийслэлийн агаар, ус, хөрс, экологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр батлах;</p> <p>9.1.10. нийслэлийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил тогтоох;</p> <p>9.1.11. нийслэлийн тухайн жилийн төсвийн төслийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.12. нийслэлийн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах;</p> <p>9.1.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>9.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно.</p> <p>9.3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нийслэлийн Засаг даргын нэгэн адил баталгаагаар хангагдана.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч бүрэн эрх</p> <p>10.1. Нийслэлийн Засаг дарга тодорхой чиг үүрэг хариуцсан</p>	<p>явагдаж буй эсэхийг</p> <p>а. Хууль тогтоомжоос урган гарах үүргийн биелэлт</p> <p>б. Хотын зөвлөлийн шийдвэр, хотын даргын захирамжийн биелэлт</p> <p>в. Аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаа</p> <p>г. Хотын болон түүний байгууллагуудад хийгдсэн зохион байгуулалт, эрхийн өөрчлөлтийн хүрээнд шалгах</p> <p>2/ хотын төсвийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт бэлтгэх, хотын даргын төсвийн мэдэгдлийг хүлээж авах эсэх талаар санал бэлтгэх, хотын зөвлөлд оруулах</p> <p>3/ хотын шинэ суурьшил бий болгох төслийг хотын зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэх</p> <p>4/ хотын даргыг огцруулах талаар референдум явуулах асуудлаар дүгнэлт бэлтгэх</p> <p>4. Хяналт шалгалтын комисс хотын зөвлөлийн даалгавраар хяналтын бусад үүргийг гүйцэтгэж</p>	<p>Казахстан улсын Нийслэлийн статусын хуулинд Аким (хотын дарга) болон Акимат (хотын захиргаа)-ын бүрэн эрхийг тус тусад нь ялган заасан байна.</p> <p>Акиматын бүрэн эрх</p> <p>1. Нийтийн аж ахуйн улсын хэмжээний үйлдвэрийн газрын биш нийтийн аж ахуйн өмчийн жагсаалтыг батлах, нийслэлд бүртгэгдсэн хувьцаат нийгэмлэгүүд дахь улсын хувьцааны пакетыг эзэмших, ашиглах, захирах</p> <p>2. Астана хотын нийтийн аж ахуйн өмчийг эзэмших, ашиглах, захирах</p> <p>3. Астана хотын өмчийг хувьчлах харилцааг зохицуулах тогтоол гаргах</p> <p>4. эдийн засгийн тусгай бүсийн нутаг дэвсгэрт оруулсан бараа, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаархи мэдээллийг татварын албанд гаргаж өгөх</p>
--	---	---	--


	<p>орлогч, зөвлөхтэй байна.</p> <p>10.7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.7.1. нийслэлийн хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагуудтай нэгдсэн бодлого явуулах асуудлаар Ерөнхий сайдтай шууд харилцах;</p> <p>10.7.2. нийслэлд хүн амын төлөвлөлтгүй суурьшил бий болох, дэд бүтцийн болон нийгмийн үйлчилгээний хэвийн ажиллагаа алдагдах, оршин суугчдын амьдрах орчинд аюултай нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх;</p> <p>10.7.3. хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлыг бий болгосон, хүрээлэн байгаа орчныг бохирдуулсан, ашиглах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх, зогсоох, холбогдох байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн барилга, байгууламж барихыг</p>	<p>болно</p> <p>* Хотын зөвлөлийн Хяналт шалгалтын үүргийг маш тодорхой зааж өгснөөрөө манай хуулийн төслөөс ялгагдаж байна</p> <p>Хотын даргын бүрэн эрх</p> <p>1. Хотын дарга хуулиар тогтоогдсон хотын зорилт болон хотын зөвлөлийн шийдвэрийг биелүүлнэ</p> <p>2. хотын дарга:</p> <p>а. хотын зөвлөлийн дүрмийн төслийг бэлтгэнэ</p> <p>б. Хотын хөрөнгийг захиран зарцуулна</p> <p>в. хотын төсвийг захирна. Зохих ёсоор зарцуулах хариуцлага хүлээнэ</p> <p>г. гадаад харилцаанд хотыг төлөөлнө</p> <p>д. Хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана</p> <p>е. Хууль тогтоомжоор хотод оногдсон төрийн удирдлагын</p>	<p>5. эдийн засгийн тусгай бүсийг байгуулах ажилд оролцож буй аж ахуйн нэгжүүдийг бүртгэх, уг бүсд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулах</p> <p>6. төсвийн хууль тогтоомжийн хүрээнд зээл авах</p> <p>7. нийслэлийн нутаг дэвсгэрт улсын архитектур, хот байгуулалт, барилгын бодлого боловсруулахад оролцох</p> <p>8. нийслэлийн хөгжил, барилгажуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж буй субъектүүдийн үйл ажиллагааг зохицуулах</p> <p>9. нийслэлийн хөгжил, барилгажуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах</p> <p>10. нийслэлийн экологи, нийгэм, соёлын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх</p> <p>11. шаардлагатай бүлгийн иргэдэд нийгмийн тусламж үзүүлэх журам, хэмжээг тогтоох</p> <p>12. нийслэлийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг</p>
--	---	---	---

	<p>хориглох, нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай саналыг холбогдох байгууллагад тавих; 10.7.4. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжээс нийслэлд ажиллах хүчийг зохион байгуулалттайгаар шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх; 10.7.5. нийслэлийг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх; 10.7.6. дотоод, гадаад харилцаанд нийслэлийг төлөөлөх; 10.7.7. нийслэл дэх үндэстэн, ястан, цөөнхийн түүх, шашин, соёлын өвийг хамгаалан, арвижуулах; 10.7.8. газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах; 10.7.9. Газрын тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; 10.7.10. холбогдох хуулийн дагуу нийслэлийн оршин суугч, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх; 10.7.11. дүүргийн Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын даргын шийдвэр хууль</p>	<p>асуудлыг хэрэгжүүлнэ</p> <p>ё. Хотын албад, хяналт, хамгаалалтын албадыг удирдана</p> <p>ж. Хэв журам сахиулахтай холбоотой тулгамдсан асуудлаар шийдвэр гаргана. Уг шийдвэрээ хотын зөвлөлийн дараагийн хуралд батлуулахаар оруулна</p> <p>3. Хотын дарга төсвийг хэрэгжүүлэхдээ:</p> <p>а. Хотын санхүүгийн удирдлагыг зөв хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ</p> <p>б. Төсвийн төсөл, нийгэм эдийн засгийн бодлогын чиглэл, төсвийн хөрөнгийн ашиглалтын талаар нийслэлийн иргэдэд мэдээлэх</p> <p>в. Хотын зөвлөл төсвийг баталмагц төсвийн зохицуулалтууд болон өнгөрсөн оны төсвийн гүйцэтгэлийн талаар мэдэгдэл хийнэ</p> <p>4. Хотын дарга нь хотын албан хаагчдын мэргэжлийн удирдлага болон хотын салбарын</p>	<p>хэрэгжүүлэх, зохицуулах</p> <p>13. дулаан, цахилгаан, ус, шатдаг хийн хангам, ус сувгийн системийн найдвартай ажиллагаа, нийслэлийн зам, тээвэр, холбоо, хот тохижилт, цэвэрлэгээ, орон сууцны фондын инженерийн хангамж, ашиглалт, засварын үйл ажиллагааг зохицуулна</p> <p>14. Казахстан улсын хууль тогтоомжийн хүрээнд улсын хэрэгцээнд зориулан газар авах, худалдан авах ажлыг хэрэгжүүлнэ. Нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаагүй буюу зориулалтын бусаар ашиглаж буй газрыг албадан авахаар шүүхэд хандах</p>
--	--	---	--


	<p>тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох; 10.7.12. эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтоох; 10.7.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 10.8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.</p>	<p>удирдлагыг удирдана.</p> <p>5. Хотын дарга хотын дэд дарга нарыг томилж, чөлөөлнө. Ингэхдээ тушаал гарган гүйцэтгэх бөгөөд 4-өөс илүүгүй орлогчийг томилж, чөлөөлж болно.</p> <p>6. Хотын клеркийг (City clerk) хотын даргын саналаар хотын зөвлөл томилж, чөлөөлнө. Чөлөөлсөн тохиолдолд 3 сараас илүүгүй хугацааны дотор дараагийн клеркийг томилно. (манай хотын ерөнхий менежертэй адил албан тушаал)</p> <p>7. Хотын ерөнхий санхүүчийг (Treasurer) хотын даргын саналаар хотын зөвлөл томилж, чөлөөлнө</p>	
<p>Нийслэлийн удирдлага, иргэд, байгууллагын хоорондын харилцаа</p> <p>Төрийн захиргааны төв байгууллагатай харилцах</p>		<p>Ийм төрлийн заалтууд нийслэлийн статусын хуулинд байхгүй байна</p>	<p>Ийм төрлийн заалтууд Казахстаны нийслэлийн статусын хуулинд байхгүй</p> <p>Нийслэлийн Аким :</p> <p>1. БНКаз.У-ын Ерөнхийлөгч, Парламент, Засгийн газар, бусад төрийн төв байгууллагууд, олон улсын байгууллагууд, гадаад орнуудын төлөөлөгчийн газруудтай харилцахад нийслэлийг төлөөлөх</p> <p>2. нийслэлийн эрх ашигтай</p>

			<p>холбоотой Казахстан улсын аливаа хууль эрхийн актуудын төсөлд саналаа оруулах</p> <p>3. нийслэлийн хөгжил, үйл ажиллагаатай холбоотой санал, эрх зүйн актуудын төслийг Засгийн газарт оруулах</p> <p>4. нийслэлд улсын болон олон улсын хэмжээний арга хэмжээ зохиох асуудлыг шийдэхэд оролцох</p> <p>5. нийслэлийн нутаг дэвсгэрт оршдог, хот нийслэлийн үүрэг гүйцэтгэхэд чухал шаардлагатай улсын өмчийн байгууламжийг нийслэлийн өмчид шилжүүлэх саналыг харгалзах төрийн байгууллагад оруулах</p>
<p>Нийслэлийн талаархи төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх</p> <p>Улсын Их Хурлын бүрэн эрх</p>	<p>7.1. Улсын Их Хурал нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.1. нийслэлийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;</p> <p>7.1.2. хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;</p> <p>7.1.3. нийслэлийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>7.1.4. хууль тогтоомжид заасан</p>	<p>Парламентын зүгээс нийслэлтэй холбоотой хэрэгжүүлэх бүрэн эрхийн талаар хуульд заалт байхгүй</p>	<p>Парламентын зүгээс нийслэлтэй холбоотой хэрэгжүүлэх бүрэн эрхийн талаар хуульд заалт байхгүй</p>

	бусад бүрэн эрх.		
Засгийн газрын бүрэн эрх	<p>8.1. Засгийн газар нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.1. нийслэлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>8.1.2. нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллагад мэргэжил арга зүйн удирдлага, зөвлөгөө үзүүлэх;</p> <p>8.1.3. нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;</p> <p>8.1.4. нийслэлийн удирдлагын саналыг үндэслэн нийслэлийн тогтвортой хөгжлийг хангах зорилт, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>8.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>		<p>БНКаэ.У-ын Засгийн газрын бүрэн эрхэд:</p> <p>1. нийслэлд автотээврээр зорчигч болон ачаа тээвэрлэх журам батлана, нийслэлийн нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд худалдаа, зочид буудал, эмнэлэгийн болон бусад үйлчилгээний ажил эрхлэх журам батлана</p> <p>2. нийслэлийн хөгжлийн асуудлаар төрийн хөтөлбөр боловсруулна</p>
Дүүрэг, түүний удирдлагын бүрэн эрх	<p>11.1. Дүүрэг нь хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцлийг харгалзан байгуулсан нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж мөн.</p> <p>11.2. Монгол Улсын Засаг</p>	<p>1. хотыг заавал раойнуудад хуваана</p> <p>2. Район хууль тогтоомж, Варшав хотын дүрэм болон хотын зөвлөлөөс баталсан эрх зүйн актуудын үндсэн дээр нийгмийн зорилтуудыг биелүүлэн ажиллана</p>	<p>Энэ талаархи заалт Казахстаны нийслэлийн статусын хуульд байхгүй</p>

	<p>захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу дүүрэг байгуулах, өөрчлөх, татан буулгах, хилийн цэсийг батлах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.</p> <p>11.3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>11.4. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно.</p> <p>11.5. Дүүргийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>11.5.1. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас дүүрэгт шилжүүлсэн өмчийн болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;</p>	<p>3. Районы үйл ажиллагааны хүрээнд хотын удирдлагын чиг үүрэгт ороогүй районы нутаг дэвсгэр дээрх бүх асуудал багтана:</p> <p>а. хөрөнгө оруулалт</p> <p>б. Районы нутаг дэвсгэр дэхь барилга байгууламж</p> <p>в. Районы мэдлийн үл хөдлөх хөрөнгө</p> <p>г. хотын даргын зөвшөөрлөөр районы мэдлийн үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах</p> <p>д. районы нутаг дэвсгэр дэхь хотын захиргааны байгууллагуудын харьяаны боловсрол, хүмүүжлийн байгууллагууд, районоос санхүүждэггүй боловсролын байгууллагууд. хүүхдийн цэцэрлэг, нийгмийн халамжийн байгууллагын салбарууд, номын сангууд, спорт амралтын байгууллагууд хотын зөвлөлийн шийдвэрээр районд үйл ажиллагаагаараа харьяалагдана</p> <p>е. Хотын мэдлийн ногоон байгууламж, хот доторх зам,</p> <p>ё. Районы захиргааны нэгжүүд</p> <p>ж. Геодези картографийн асуудал</p>	
--	--	--	--

	<p>11.5.2. хууль тогтоомжид нийцүүлэн захирамж, заавар, дүрэм, журам батлан мөрдүүлж, гүйцэтгэлийг хангуулах;</p> <p>11.5.3. энэ хуулийн 10.7.10-д зааснаас бусад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах; /хасах/</p> <p>11.5.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p>з. Орон сууцны түрээс, татаасын асуудал</p> <p>и. соёлын үйл ажиллагаа</p> <p>к. Байгаль орчны хамгаалалт, хог хаягдал, усны асуудал</p> <p>л. Эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл</p> <p>м. Хүн амын бүртгэл, иргэний баримт бичиг олголт</p> <p>н. Жолоочийн үнэмлэх олгох, тээврийн хэрэгсэл бүртгэх</p> <p>о. Татвар хураах, нутгийн болон тэмдгийн хураамж, ой, хөдөө аж ахуйн татварууд</p>	
Хороо, түүний удирдлагын бүрэн эрх	<p>12.1. Хороо нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар дүүргийн засаг захиргааны нэгж мөн.</p> <p>12.2. Хуульд өөрөөр заагаагүй бол хороо нь өөрөө өөрийгөө тэтгэн хөгжүүлж, бие дааж ажиллана.</p> <p>12.3. Хорооны иргэдийн Нийтийн Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.3.1. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн өөрийн нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулах,</p>	<p>1. районы доод түвшний салбарыг районы зөвлөл өөрийн санаачлагаар юмуу тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг сонгуулийн эрхтэй иргэдийн 5 хувиас доошгүйн санаачлагаар байгуулна</p> <p>2. районы доод түвшний салбарын үйл ажиллагааны хүрээ, зохион байгуулалтыг районы зөвлөл тогтооно</p> <p>3. районы доод түвшний байгууллагуудыг нэгтгэх, хуваах, татан буулгах нь анх байгуулсантай адилаар явагдана</p> <p>4. районы доод түвшний байгууллага өөрийн төсөвгүй байх</p>	заалт байхгүй

	<p>барилга байгууламж барих зэрэг асуудлыг хэлэлцэн саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлэх.</p> <p>12.4. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь газар эзэмшүүлэх, ашиглуулах, барилга байгууламж барих зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа энэ хуулийн 12.3.1-д заасан саналыг заавал үндэслэнэ.</p> <p>12.5. Хорооны иргэдийн Нийтийн Хурал жилд 3-аас доошгүй удаа хуралдана.</p> <p>12.6. Хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, хорооны Засаг даргын албан тушаалыг сумын Хурлын дарга, сумын Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно.</p> <p>12.7. Хорооны Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.7.1. Хорооны хүн амын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэн хөтлөх;</p> <p>12.7.2. оршин суугчийн хэвийн аж төрөх нөхцлийг хангах үүднээс харьяалах нутаг дэвсгэрт орших сууц өмчлөгчдийн холбоо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсэг,</p>	<p>ба санхүүгийн үйл ажиллагаа явуулахгүй</p> <p>5. районы доод түвшиний байгууллага нь иргэдийн нийтийн хурал хийдэг байна. Энэ хурлаас гүйцэтгэх байгууллагаа сонгоно.</p>	
--	---	--	--

	<p>төрийн бус байгууллагатай нягт хамтран ажиллах;</p> <p>12.7.3. хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулсан болон энэ хуулийн 34.1.6, 34.1.7-д заасан торгуулийн мөнгийг хорооны мөнгөн хөрөнгийн санд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулах;</p> <p>12.7.4. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах явцад үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх;</p> <p>12.7.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p> <p>12.8. Хорооны иргэдийн нийтийн Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>		
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах	<p>22.1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжил, иргэдийн суурьшлийн талаар гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.</p> <p>22.2. Засаг захиргаа, нутаг</p>	заалт байхгүй	заалт байхгүй

	<p>дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нь нийслэлийн хүн амыг бараа, үйлчилгээгээр хангах, нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлнэ.</p> <p>22.3. Нийслэлийн хөгжилд зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн нэгдсэн сүлжээ, бүтэц бий болгох үйлдвэр, аж ахуй, хангамжийн байгууллагыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж болно.</p> <p>22.4. Аймаг, нийслэл, бусад хот хоорондын эдийн засаг, нийгэм, аж ахуйн харилцааг хуулиар тусгайлан зохицуулна.</p>		
Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах	<p>23.1. Нийслэлийн удирдлага нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ажил үйлчилгээг сайжруулах, орчны тохижилт,</p>	заалт байхгүй	заалт байхгүй


	<p>цэвэрлэгээ хийх зэрэг асуудлаар шаардлага тавина.</p> <p>23.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь хотын аж ахуй, инженерийн барилга байгууламжийн эзэмшлийн зааг хэмжээ, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоож, ашиглалт засвар, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.</p> <p>23.3. Нийслэлийн Засаг дарга нь нутгийн захиргааны тодорхой чиг үүргийг холбогдох хууль тогтоомж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.</p> <p>23.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.</p>	
--	---	--

<p>Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжээс нийслэлийн өмнө хүлээх үүрэг</p>	<p>24.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэрээс үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>24.1.1. хууль тогтоомжид нийцүүлэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг ажиллагсаддаа мэдээлж, хэрэгжүүлэх;</p> <p>24.1.2. нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн удирдлагаас явуулж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;</p> <p>24.1.3. өөрийн эзэмшиж байгаа эдэлбэр газар, барилга, байгууламжаасаа 50 метр хүртэлх зайнд байгаа гудамж, талбайг стандарт, норм, дүрэм, журам, зохих шаардлагын дагуу зүй зохистой ашиглаж, тохижуулан цэвэр цэмцгэр байлгах;</p> <p>24.1.4. барилга байгууламж барих, засварлах явцад гарсан шороо, хог хаягдлыг тээвэрлүүлж, зөвшөөрөгдсөн газар хаях;</p> <p>24.1.5. эрүүл ахуйн стандартыг ханган ажиллаж, хэрэглэгчдийн</p>	заалт байхгүй	заалт байхгүй
--	--	---------------	---------------

	эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх. 24.2. Энэ хуулийн 23.3-т заасны дагуу нутгийн захиргааны тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, нийслэлийн төсвөөс санхүүжилт авсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь уг ажлаа Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна.		
Гуравдугаар бүлэг. Нийслэлийн оршин суугчийн эрх үүрэг			
Нийслэл хотын оршин суугч, нийслэлийн өмнө түүний хүлээх үүрэг		заалт байхгүй	заалт байхгүй
Нийслэлийн оршин суугчийн эрх	14.1. Нийслэлийн оршин суугч дараахь эрх эдэлнэ: 14.1.1. нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаар хэлэлцэж байгаа асуудлаар мэдээлэл авах, санал өгөх; 14.1.2. нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан санал дэвшүүлэх; 14.1.3. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн хэрэгцээний барилга байгууламж, зам, гүүр, инженерийн шугам сүлжээ,	заалт байхгүй	заалт байхгүй

	цэцэрлэгт хүрээлэн байгуулахад зориулж өөрийн өмчлөл эзэмшил, ашиглалтад байгаа газраа чөлөөлсний төлөө зохих журмын дагуу нөхөх олговор авах; 14.1.4. нийслэлийн оршин суугч өөрийн санаачилгаар орчноо тохижуулах, мод бут тарих болон нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсныхаа төлөө урамшуулал авах, хөнгөлөлт эдлэх; 14.1.5. соёл урлаг, биеийн тамир, спорт, аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг зохих журмын дагуу ашиглах; 14.1.6. хууль тогтоомжид заасан бусад эрх. 14.2.Энэ хуулийн 14.1.4, 14.1.5-д заасан хөнгөлөлт, урамшуулалын хэмжээг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.		
Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлагаас нийслэлийн өмнө хүлээх үүрэг	25.1. Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлага тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн хэрэгжилтийг хариуцна.	заалт байхгүй	заалт байхгүй
<i>Дөрөвдүгээр бүлэг. Нийслэлийн эдийн засаг, өмч, төсөв, санхүү</i>			
Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн	16.1. Нийслэлийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний	заалт байхгүй	Нийслэлийн нийтийн өмч БНКаз.У-ын төрийн өмчийн бүрэлдэхуун хэсэг байна.

<p>үндэс</p> <p>Нийслэлийн эдийн засгийн үндэс</p>	<p>хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад нөөц баялаг, нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр хураамж болон татварын бус орлого, нийслэлийн сангийн хөрөнгөөс бүрдэнэ.</p>		<p>Нийслэлийн өмч нь:</p> <ul style="list-style-type: none"> - хувийн өмчийнхээс бусад нийслэлийн нутаг дахь газрын өмч - нийслэлийн акимат хувьцаа эзэмшигч нь байгаа хуулийн этгээдийн хувь болон хувьцаат нийгэмлэгийн хувьцааны эзэмшигчийн эрх - нийслэлийн гудамж, үл хөдлөх хөрөнгө - нийслэлийн акимат өмчлөгч нь байгаа төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн газруудын өмч - бусад өмч, өмчийн эрх, актаас бүрдэнэ
<p>Нийслэлийн өмч</p>	<p>18.1. Нийслэл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан өмчтэй байх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.</p> <p>18.2. Нийслэлийн өмч нь хуульд заасан үндэслэлээр олж авсан нийслэлийн өөрийн эд хөрөнгө болон нийслэлийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгөөс бүрдэнэ.</p> <p>18.3. Нийслэлийн өмчийг захиран зарцуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр</p>		<p>БНКаз.У-ын нийслэлийн статусын хуулинд өмч, төсөв татварын талаар өөр заалтууд байхгүй боловч дараах үндсэн бүлэг заалтууд ихээхэн тодорхой туссан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэл дэхь архитектур, хот байгуулалт, барилгын үйл ажиллагаа - Нийслэлийн дэд бүтэц - Нийслэл дэхь газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын онцлогууд Тухайлбал, нийслэлийн дэд бүтэцэд: 1. инженерийн дэд бүтэц

	<p>иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.</p> <p>18.4 .Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх, ашиглуулах, бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.</p> <p>18.5. Нийслэл нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу хууль тогтоомжид нийцүүлэн гадаад улс болон аймаг, сумын нутаг дэвсгэрт нийслэлийн төлөөлөгчийн газар байгуулж болно.</p>		<p>2. тээврийн дэд бүтэц</p> <p>3. орон сууцны фонд, эрүүлийг хамгаалах, боловсрол, дотоод худалдааны объектуудын засвар, ашиглалт, инженерийн хангамжийн систем</p> <p>4. хот тохижилт, ногоон байгууламжийн систем</p> <p>5. нийслэлийн үйл ажиллагаанд зайлшгүй объект ба системүүд</p> <p>Газрын харилцааны эрх зүйн онцлогт улсын хэрэгцээнд зориулж газар авахад түүний өмчлөгчидтэй харилцах харилцаа болон худалдан авахад үнэ тогтоох, нөхөн олговор олгох зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан байна.</p>
Нийслэл хотын төсөв	<p>17.1. Нийслэл нь өөрийгөө тэтгэх эдийн засаг, бие даасан төсөвтэй байна.</p> <p>17.4. Нийслэл хотын хөгжлийн томоохон төслийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>17.5. Нийслэлийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион</p>	<p>1. Хот төсвийн санхүүгийн удирдлагаа бие даан хэрэгжүүлнэ</p> <p>2. энэ санхүүгийн удирдлага нь иргэдэд ил тод байна</p> <p>3. дараа оны хотын төсвийн төсөл, хотын зөвлөлийн болон районы зөвлөлийн мэдлийн нийтийн аж ахуйн өмчийн тухай мэдэгдлийг хотын дарга 11 дүгээр сарын 15-ны дотор хийж, Бүсийн Санхүүгийн Палатын дүгнэлтийг</p>	


	<p>байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна</p> <p>4.8. Улаанбаатар хот нийслэлийн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг улсын төсөвт тусган төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт хэлбэрээр олгоно.</p> <p>4.9. Нийслэлд улсын төсвөөс олгох захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт, гэрээт үйлчилгээний төлбөрийг нийслэлийн төсвийн зохих зүйл ангид тооцно.</p>	<p>гаргуулан авна</p> <p>4. Хотын зөвлөл төсвийн төслийг боловсруулах тусгайлсан зохицуулалтын журам гаргах ба төсвийн төслийг хэлэлцэх, төслийг дагалдах материалын талаар журам гаргана.</p>	
Нийслэлийг хөгжүүлэх сан	<p>19.1. Нийслэл нь хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын аж ахуйг өргөтгөх, хүн амын үйлчилгээг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийслэл, дүүргийг хөгжүүлэх сантай байж болно. Санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.</p> <p>19.2. Сан нь сангийн үйл ажиллагааны орлого, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн</p>	заалт байхгүй	заалт байхгүй

	хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ. 19.3. Нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, дүүргийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дүүргийн Засаг дарга захиран зарцуулж, гүйцэтгэлийг жил бүр нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.		
Нийслэлийн чөлөөт бүс байгуулах	20.1. Нийслэлийн чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна.	заалт байхгүй	
Нийслэл хотын татвар	17.2. Нийслэл хот нь албан татвартай байна. Нийслэл хотын татварыг хуулиар тогтооно. 17.3. Нийслэлийн хотын албан татвар нь хотын оршин суугчийн албан татвар, хот төлөвлөлтийн албан татвараас бүрдэнэ.	заалт байхгүй	заалт байхгүй
Нийслэлийг хөгжүүлэх бодлого	5.1. Нийслэлийн удирдлага нь суурин соёл иргэншлийн тэргүүлэх байр суурийг хадгалан	заалт байхгүй	заалт байхгүй

	<p>хөгжүүлэх бие даасан бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>5.2. Нийслэлийн удирдлага нь хот байгуулалт, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тэнцвэрийг ханган хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх, хүний хөгжлийг төлөвшүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, засаглалыг сайжруулах бодлого явуулна.</p> <p>5.3. Нийслэлийн удирдлага нь аж үйлдвэр, дэд бүтэц, өндөр технологийн үйлдвэрлэлийг томоохон төслөөр дамжуулан хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хөрөнгийг татах бодлого баримтлана.</p> <p>5.4. Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт нь үндэсний уран барилгын өв уламжлалыг орчин үеийн ололт, хот байгуулалтын дэлхийн шилдэг жишигтэй хослуулан хөгжүүлэх бодлогод үндэслэнэ.</p>		
Нийслэлийн хүндэт иргэн ба шагнал	<p>27.1. Нийслэлийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэнийг "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнана. "Нийслэлийн хүндэт иргэн"-д</p>	<p>1. Польшийн болон гадаадын иргэний байгуулсан гавьяа, гайхамшигт ололтыг нь үнэлж Варшав хотын хүндэт иргэнээр өргөмжлөнө</p> <p>2. Хэнийг ч Хүндэт иргэнээр</p>	<p>1. Астана хотын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, соёлын хөгжилд онцгой гавьяа байгуулсан БНКаз.У-ын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүст Маслахитын тодорхойлсноор</p>

	<p>өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ. 27.2. "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.</p>	<p>зөвхөн нэг удаа өргөмжлөнө</p> <p>3. Хүндэт иргэн болгох саналыг</p> <ul style="list-style-type: none"> - хотын дарга - Хотын зөвлөлийн дарга - Хотын зөвлөлийн гишүүдийн клуб - районы зөвлөл гаргана <p>4. Хүндэт иргэн цолыг Хотын зөвлөл олгоно</p> <p>5. Хүндэт иргэн болсон хүнд</p> <ul style="list-style-type: none"> а. хотын зөвлөлийн акт б. медаль в. гэрчилгээ олгоно <p>6. Хүндэт иргэн</p> <ul style="list-style-type: none"> а. хотын зөвлөлийн чуулган б. хотын ёслолын арга хэмжээ в. хотын удирдлагаас зохион байгуулж байгаа соёл, спортын болон бусад арга хэмжээнд хүндэт зочноор оролцож болно. <p>7. Хүндэт иргэн хотын нийтийн тээврээр үнэгүй зорчино</p> <p>8. Хүндэт иргэн цол олгохтой холбоотой зардлыг хотын төсвөөс гаргана</p>	<p>нийслэлийн Аким "Астана хотын хүндэт иргэн" цол олгоно</p> <p>2. Нийслэлийн орон нутгийн төлөөллийн болон гүйцэтгэх байгууллага бусад төрлийн урамшлын хэлбэрийг тогтоох, хэрэглэх эрхтэй</p>
Нийслэлийн мэдээлэл, судалгааны байгууллага	<p>28.1. Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.</p> <p>28.2. Нийслэлийн удирдлага нь дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэтийн төлвийг тодорхойлох, хотжилт, хот байгуулалт, хүн ам,</p>	заалт байхгүй	заалт байхгүй

	хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах шинжилгээ, судалгааны төвтэй байж болно.		
Нийслэлийн өдөр	29.1. Улсын Их Хурлаас тогтоосон нийслэлийн өдрийг жил бүр тэмдэглэнэ.	Варшавын бослого эхэлсэн өдөр 8 дугаар сарын 1 нь Варшав хотын Дурсгалын өдөр байна	Нийслэлийн өдөр 7 сарын 1-нийг улс нийтийн баяр болгон тэмдэглэдэг учир энэ хуулинд заалт байхгүй
Хориглох зүйлс	<p>30.1. Нийслэлийн иргэн, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид дараахь зүйлсийг хориглоно:</p> <p>30.1.1. иргэний бүртгэлгүй оршин суух, төлөвлөлтгүй газар суурьшил үүсгэх болон суурьших;</p> <p>30.1.2. хуульд заасан зөвшөөрөлгүйгээр газар эзэмших, ашиглах, барилга угсралтын ажил явуулах, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх ашигт халдах, бусдын орц, гарцыг хаах;</p> <p>30.1.3. инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр ашиглах, гэмтэл учруулах;</p> <p>30.1.4. хотын ногоон байгууламж, байгалийн болон таримал мод,</p>	заалт байхгүй	заалт байхгүй

	<p>бут, сөөгийг хугалах, устгах, сүйтгэх;</p> <p>30.1.5. байгаль орчин, нуур, цөөрөм, гол, горхи, булаг, шандыг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдуулах;</p> <p>30.1.6. хий, шахмал болон боловсруулсан түлш, нүүрс, мод, цаас, малын гаралтай түлшнээс өөр хорт утаа ялгаруулдаг зүйлсийг түлшинд хэрэглэх;</p> <p>30.1.7. суурьшлын зөвшөөрөгдөөгүй бүсэд мал аж ахуй эрхлэх.</p>		
<p>Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж зөрчигчид хариуцлага хүлээлгэх</p>	<p>31.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:</p> <p>31.1.1. энэ хуулийн 15.1.1-15.1.3, 15.1.5-15.1.9-т заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000 төгрөгөөр торгох;</p> <p>31.1.2. энэ хуулийн 24.1.3-24.1.5-д заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох;</p> <p>31.1.3. энэ хуулийн 30.1.1-30.1.3, 30.1.5-30.1.7-д заасныг зөрчсөн</p>		

	иргэнийг 50000-100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох; 31.1.4. энэ хуулийн 30.1.4-т заасныг зөрчсөн бол хугалсан, устгасан мод, бут, сөөгийг ширхэгээр, сүйтгэсэн цэцэг, зүлгийн эзлэх талбайн хэмжээг 5 дахин өсгөсөн хэмжээгээр нөхөн сэргээлгүүлэх, эсхүл иргэнийг 50000-150000, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000-500000 төгрөгөөр торгох. 31.2. Энэ хуулийн 15.1.4-т заасныг зөрчиж Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлийн бүсэд оршин суугаагүй иргэнд нийслэл хотын хангамж, үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд үүдэн гарах хохирлыг тухайн этгээд хариуцна.	
--	---	--

1.2. ТУРКИЙН НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЗАРИМ ХАРЬЦУУЛАЛТ

	<i>Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зохицуулалт</i>	<i>Турк улсын хууль тогтоомж</i>
<i>Нэгдүгээр бүлэг. Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, нийслэлийн удирдлагын үндсэн зарчим, нийслэлийн онцлог чиг үүрэг, нутаг дэвсгэр эдэлбэр газрын талаар</i>		
Хуулийн бүтэц	6 бүлэг 32 зүйлтэй.	

Хуулийн зорилт	<p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл /цаашид "нийслэл" гэх/-ийн онцлог чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын бүрэн эрх, нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлийн удирдлагаас оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Нийслэлийн оршин суугчийн эрх үүргийг нэмж оруулсанаар нийслэлийн хөгжилд оршин суугчдын оролцоог нэмэгдүүлэх үүрэг хариуцлагыг тодорхой болгох зорилготой.</p>	<p>Турк Улсад нийслэл Анкара хотын эрх зүйн байдлын талаар тусгайлан зохицуулсан бие даасан хууль байдаггүй бөгөөд Анкара хот нь Анкара муждаа байдаг бөгөөд Мужийн нутгийн удирдлагын эрх зүйн байдлыг 5302 дугаартай Мужийн тусгай удирдлагын тухай хууль, 5355 дугаартай Дүүргийн удирдлагын нэгдлийн тухай хуулиар, хот, дүүргийн эрх зүйн байдлыг 5393 дугаар Хотын захиргааны хуулиар /Belediye Kanunu/, томоохон буюу улсын хэмжээний хотын эрх зүйн байдлыг 2004 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 5216 дугаар Их хотын захиргааны хуулиар /Büyükşehir belediyesi kanunu/ тус тус зохицуулсан байна.</p>
Нийслэл, түүний чиг үүрэг	<p>4.1. Монгол Улсын Үндсэн хуулийн арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын нийслэл нь Улаанбаатар хот мөн.</p> <p>4.2. Нийслэл нь хуулиар олгосон чиг үүрэг, өмч хөрөнгө, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p> <p>4.3. Далай ашиглах тухай хуулийн 81.1-д заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хот байна.</p> <p>4.4. Нийслэл нь Улаанбаатар бүсийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх, оршин суугчийн суурьшил, хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах үүднээс алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүстэй байж болно.</p>	<p>Туркийн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд Турк Улсын нийслэл Анкара гэж заасан байдаг.</p> <p>5216 дугаар Их хотын захиргааны хуулийн 7 дугаар зүйлд Их хотын захиргааны чиг үүрэг, эрх мэдэл, хариуцлагыг дараахи байдлаар зохицуулсан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дүүрэг, анхан шатны захиргааны саналыг аван Их хотын стратеги төлөвлөгөөг, жилийн зорилтууд, хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон эдгээртэй нийцсэн төсөв бэлтгэх, 2. Байгаль орчны зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нийцүүлсэн байх болзолтойгоор их хотын захиргааны бүсэд 1/5000 болон 1/25000-ын хооронд дахь бүхий л хэмжээст барилга төлөвлөлтийг хийх, хийлгэх, батлан хэрэгжүүлэх, хяналт тавих гэх мэт, 3. Хуулиар Их хотын захиргаанд олгосон чиг

	<p>4.5. Нийслэлд Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар байнга төвлөн оршино.</p> <p>4.6. Нийслэлийн удирдлага нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ.</p> <p>4.7. Төрийн эрх бүхий байгууллага өөрөөр шийдвэрлээгүй бол нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээг зохион байгуулна.</p>	<p>үүрэг, үйлчилгээтэй холбоотой төсөл, барилга байгууламж, засвар зэрэг бүхий л барилга байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зэрэгт зөвшөөрөл олгох,</p> <p>4. Их хотыг захиргааны зүгээс хийх эсхүл үйл ажиллагааны салбарын хувьд их хотын захиргаанд харьяалагдах асуудлаар тухайн салбарын үйл ажиллагаа явуулахад нь зөвшөөрөл олгох, хянах,</p> <p>5. Хотын захиргааны хуулийн 68 болон 72 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх,</p> <p>6. Их хотын тээврийн үндсэн төлөвлөгөөг хийх эсхүл хэрэгжүүлэх, нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, тэдгээрийг зохицуулах, билетний үнэ, хугацаа, ямар төрлийн үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг хариуцдаг.</p> <p>7. Их хотын мэдлийн талбайд талбай, өргөн чөлөө, гудамж, гудам, хурдны зам хийх, хийлгэх, завсар үйлчилгээгээр хангах, хотжилтын төлөвлөлтийн төсөлтэй уялдуулан дээрхи газар зар сурталчилгаа, зар тавих, зар сурталчилгааны хэлбэр, тоо хэмжээг тогтоох, талбай, өргөн чөлөө, гудамж, гудам зэрэгт нэр өгч номерлох,</p> <p>8. Газар зүйн болон хотын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх,</p> <p>9. Хүнстэй холбоотойгоор 1 дүгээр зэрэглэлийн эрүүл ахуйн байгууллагуудад зөвшөөрөл олгох, хянах, лаборатори байгуулах, ажиллуулах,</p> <p>10. Их хотын мэдлийн эсхүл түүний удирдлага дахь талбайд сэргийлэх үйлчилгээг үзүүлэх,</p> <p>11. Шаардлагатай үед эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээний барилга байгууламж байгуулах, төрийн байгууллагын дээрхи барилга</p>
--	--	--

		байгууламжийн бүх л төрлийн засвар, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай материалаар дэмжих зэрэг нэлээд олон асуудлыг хариуцдаг байна.
Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газар	<p>6.1.Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэст багтана.</p> <p>6.2.Нийслэлийн нутаг дэвсгэр нь Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүсчлэлтэй байх бөгөөд байгаль орчныг хамгаалах болон ой, усны нөөц хамгаалах бүстэй байна.</p> <p>6.3.Нийслэлийн нийтийн эдэлбэр газарт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн гудамж, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамир, спортын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.</p> <p>6.4.Чиг үүргээ биелүүлэх зорилгоор нийслэлийн эзэмших, ашиглах газар нь нийслэлийн хилийн цэсийн гадна байж болно.</p> <p>Нийслэлийн нутаг дэвсгэр, эдэлбэр газрыг тогтоохдоо хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын тухай хуулийг баримталснаар төлөвлөлтгүй суурьшил бий болох, байгаль орчныг хамгаалах болон ойн, усны нөөц хамгаалах ач холбогдолтой юм байна.</p>	<p>5216 дугаар Их хотын захиргааны хуулийн 5 дугаар зүйлд Их хотын захиргааны хилийн цэсийг зохицуулсан байна. Их хотын хилийн цэс тухайн хотын дүүргийн хилийн цэс болон энэ дүүргийн их хотын захиргаанд хамаарагдаж байгаа хил юм. Анхан шатны захиргаанд их хотын хилийн цэсээс гадна хилийн цэстэй байж болохгүй.</p> <p>5355 дугаартай Дүүргийн удирдлагын нэгдлийн тухай хуулиар дүүргийн хилийн цэсийн талаар тодорхой нарийвчлан зохицуулсан байдаг.</p>
Нийслэлийн удирдлага, түүний онцлог	3.1.Нийслэлийн удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан	5302 дугаартай Мужийн тусгай удирдлагын тухай хууль, 5393 дугаар Хотын захиргааны хууль, 5216 дугаар Их хотын захиргааны хуульд паралель хэлбэрээр Хотын захиргааны хурал /Иргэдийн

	<p>ёсоор бүрдэнэ.</p> <p>10.2.Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд тэрээр хотын аж ахуй, үйлчилгээг удирдан зохион байгуулах, мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий хотын ерөнхий менежерийг томилон ажиллуулна.</p> <p>10.3.Улаанбаатар хотын Захирагч нь ажлын албатай байна. Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байх бөгөөд дарга нь хотын Ерөнхий менежер байна.</p> <p>10.4.Захирагчийн ажлын алба нь Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамж, хотын орон сууц, нийтийн аж ахуй, худалдаа үйлчилгээ, хүн амын хүнсний хангамж, нийтийн тээврийн үйлчилгээ, зам, хот тохижилт, цэцэрлэгжилт, орчны бохирдол, хог хаягдал зэрэг асуудлаар гаргасан Улсын Их Хурал, Засгийн газар, нийслэлийн удирдлагын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <p>10.5.Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагчийн хувьд өөртөө зөвлөх эрх бүхий мэргэжлийн орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.</p> <p>10.6.Энэ хуулийн 10.5-д заасан мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.</p>	<p>төлөөлөгчдийн хурал/, Их хотын захиргааны зөвлөл, их хотын засаг дарга бүхий удирдлагын тогтолцоотой.</p>
Хоёрдугаар бүлэг. Нийслэлийн удирдлагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрхийн талаар		
Нийслэлийн удирдлагын бүрэн	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх	<p>Их хотын захиргааны хурал</p> <p>12 дугаар зүйл. Их хотын захиргааны хурал</p>

<p>эрх</p>	<p>9.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийслэлийн талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>9.1.1.нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах;</p> <p>9.1.2.нийслэлийн оршин суугчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж байгаа тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.3.нийгмийн дэг журмыг хамгаалах, хотын аж ахуй, оршин суугч, аж ахуйн нэгжийн нийгэм-соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;</p> <p>9.1.4.нийслэл, түүний оршин суугчийн нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>9.1.5.хот байгуулалт, экологи, эдийн засаг, нийгмийн хөгжил, хүн амын үйлчилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>9.1.6.нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллага, гудамж, талбайг нэршүүлэх, нэрэмжит болгох, хөшөө, дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачлагаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах;</p> <p>9.1.7.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл хөтөлбөр, алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>9.1.8.нийслэлийн оршин суугчийн суурин амьдралын хэв маяг, хамтач үзлийг хөгжүүлэх, хотын соёл, хамтын</p>	<p>Хотын захиргааны шийдвэр гаргах байгууллага бөгөөд холбогдох хуулиар сонгогдсон гишүүдээс бүрдэнэ. Их хотын Засаг дарга хурлын дарга нь байх ба их хот дахь бусад дүүргийн засаг дарга нар хурлын үндсэн гишүүд байна. Их хотын дүүрэг болон анхан шатны захиргааны хурлын үйл ажиллагааг Хотын захиргааны хуулиар зохицуулна.</p> <p>Их хотын захиргааны хурал гишүүдээсээ 5-9 хүний бүрэлдэхүүнтэй холбогдох асуудал хариуцсан тусгай комисс байгуулж болно. Комиссд улс төрийн намын гишүүн болон бие даагч нараас хувь тэнцүүлэн сонгоно.</p> <p>Их хотын Засаг даргын бүрэн эрх:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хотын захиргааны хамгийн дээд удирдлага болохын хувьд хотын захиргааг удирдах, хотын иргэдийн эрх ашгийг хамгаалах, 2. Хотын захиргааг стратеги төлөвлөгөөнд нийлүүлэн удирдах, хотын захиргааны стратегийг бий болгох, үүнд нийцүүлэн төсөв бэлтгэх, хэрэгжүүлэх, хотын захиргаа болон хүн хүчний үйл ажиллагааны түвшингийн хэмжээг тогтоох, хянах, үнэлэх, үүнтэй холбоотой тайлан хуралд өгөх, 3. Хотын захиргааны хурал болон зөвлөлийг даргалах, эдгээр байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, 4. Энэ хуулиар их хотын захиргаанд өгсөн чиг үүрэг, үйлчилгээг хүртээмжтэй хэлбэрээр хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах,
-------------------	---	---

	<p>хариуцлагыг төлөвшүүлэх ажил зохион байгуулах; 9.1.9.нийслэлийн агаар, ус, хөрс, экологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр батлах; 9.1.10.нийслэлийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил тогтоох; 9.1.11.нийслэлийн тухайн жилийн төсвийн төслийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 9.1.12.нийслэлийн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд хэлэлцэн батлах; 9.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 9.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно. 9.3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нийслэлийн Засаг даргын нэгэн адил баталгаагаар хангагдана.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрх</p> <p>10.1.Нийслэлийн Засаг дарга тодорхой чиг үүрэг хариуцсан орлогч, зөвлөхтэй байна.</p> <p>10.7.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.7.1.нийслэлийн хөгжлийн тогтвортой орчин бүрдүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагуудтай нэгдсэн бодлого явуулах асуудлаар Ерөнхий сайдтай шууд харилцах; 10.7.2.нийслэлд хүн амын төлөвлөлтгүй суурьшил бий болох, дэд бүтцийн болон нийгмийн үйлчилгээний хэвийн ажиллагаа алдагдах, оршин суугчдын амьдрах орчинд</p>	<p>5. Их хотын захиргаа болон түүнтэй холбоотой байгууллага, аж ахуйн нэгжийн хүртээмжтэй удирдлагаар хангах, эдгээр байгууллагын төсвийн төсөл, төсөвтэй холбоотой бусад асуудлыг бэлтгэх, 6. Их хотын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харах, орлого, авлагыг барагдуулах, 7. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр их хотын захиргааны нэрийн өмнөөс гэрээ байгуулах, хандив авах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, 8. Их хотын төлөөлөх, өмгөөлөгчөөр төлөөлүүлэх, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагчаар орох, 9. Их хотын захиргааны албан тушаалтанг томилох, захиргааны харьяа байгууллагыг хянах, 10. Шаардлагатай тохиолдолд гэрлэлт батлах, 11. Бусад хуулиар хотын захиргаанд өгсөн чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэх, 12. Шаарлагатай үед зарим эрх үүргээ бусад дүүргийн Засаг дарга болон анхан шатны захиргааны засаг даргад шилжүүлэх, 13. Төсөвт тусгасан ядуучууд болон шаардлагатай этгээдэд хуваарилсан төлбөрийг хэрэглэх, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой үйл ажиллагааг дэмжих зорилгоор хөгжлийн бэрхшээлийн төв байгуулах.</p>
--	---	---

	<p>аюултай нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх; 10.7.3.хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлыг бий болгосон, хүрээлэн байгаа орчныг бохирдуулсан, ашиглах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх, зогсоох, холбогдох байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн барилга, байгууламж барихыг хориглох, нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай саналыг холбогдох байгууллагад тавих; 10.7.4.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжээс нийслэлд ажиллах хүчийг зохион байгуулалттайгаар шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх; 10.7.5.нийслэлийг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх; 10.7.6.дотоод, гадаад харилцаанд нийслэлийг төлөөлөх; 10.7.7.нийслэл дэх үндэстэн, ястан, цөөнхийн түүх, шашин, соёлын өвийг хамгаалан, арвижуулах; 10.7.8.газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах; 10.7.9.Газрын тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; 10.7.10.холбогдох хуулийн дагуу нийслэлийн оршин суугч, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх; 10.7.11.дүүргийн Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын даргын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох; 10.7.12.эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтоох; 10.7.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 10.8.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын</p>	
--	--	--

	<p>Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.</p> <p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх</p> <p>Хотын өсөлтийн өнөөгийн бодит нөхцөл, хөгжлийн түвшин, ирээдүйн шаардлагыг харгалзан НИТХ-аар шийдвэрлүүлэх ажлын цар хүрээ өргөжиж, шийдвэрлэх ажиллагаа нэмэгдэж байгаа нь НИТХ-ыг байнгын ажиллагаатай байхаар тусгасан.</p> <p>НИТХ-ын дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн адил баталгаагаар хангахаар төсөлд тусгагдсан байна.</p>	
Дөрөвдүгээр бүлэг. Нийслэлийн эдийн засаг, өмч, төсөв, санхүү		
<p>Нийслэлийн онцлог чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс</p> <p>Нийслэлийн эдийн засгийн үндэс</p>	<p>16.1.Нийслэлийн эдийн засгийн үндэс нь түүнд хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлсэн газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад нөөц баялаг, нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос бий болсон хуримтлал, албан татвар, төлбөр хураамж болон татварын бус орлого, нийслэлийн сангийн хөрөнгөөс бүрдэнэ.</p>	<p>Их хотын захиргааны орлого:</p> <p>23 дугаар зүйл. Их хотын захиргааны орлогод дараахь орлого хамаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдсэн төслийн татварын орлогоос дүүргийн болон анхан шатны захиргааны олгосон хувиас Засгийн газрын тогтоосон хувийн хэмжээнд олгох хувь, - Их хотын хилийн цэс нэгдсэн төсвийн татварын орлогын нийлбэр дүнгээс Сангийн яамны тооцоогоор их хотын захиргаанд оруулах 5 хувь, - 2465 дугаартай Хотын захиргааны орлогын тухай хуульд заасан хувь, их хотын захиргааны авах морьны уралдаан болон хамтын бусад бооцооноос авах татварын 20 хувийг хамтын бооцоот уралдааныг хийсэн газрын захиргаанд, 30 хувийг хүн

		<p>амын тоогоор нь тараахаар бусад дүүрэг болон анхан шатны захиргаанд хуваарилсны дараа үлдсэн 50 хувь,</p> <ul style="list-style-type: none"> - Их хотын захиргааны нийтийн болон соёлын байгууламж, спорт, цэнгээний болон амралтын газар болон ногоон байгууламжаас авах бүх төрлийн хотын захиргааны татвар, хураамж, төлбөр, - Их хотын захиргааны мэдлийн талбайд байрлуулсан зар сурталчилгааны татвар болон төлбөр, - Их хотын захиргааны үзүүлсэн байх нөхцөлтэйгөөр 2464 дугаартай Хотын захиргааны орлогын хуульд заасны дагуу зам, ус болон шугам сүлжээний зардалд оролцсон хувь, - Түрээс, хүү, шийтгэлийн орлого, - Төрийн байгууллагын тусламж, - Харьяа байгууллагын тайлангийн орлого, зарлагын хоорондох зөрүүнээс шилжүүлэх орлого, - Их хотын захиргааны аж ахуйн нэгжийн цэвэр орлогоос их хотын захиргааны хурлаар тогтоосон хувь, - Их хотын хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн орлого, - Үзүүлж байгаа үйлчилгээний хөлс, - Болзолтой болон болзолгүй хандив.
Нийслэл хотын төсөв	<p>17.1.Нийслэл нь өөрийгөө тэтгэх эдийн засаг, бие даасан төсөвтэй байна.</p> <p>17.4.Нийслэл хотын хөгжлийн томоохон төслийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p> <p>17.5.Нийслэлийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль</p>	<p>Их хотын захиргааны төсөв</p> <p>25 дугаар зүйл. Их хотын захиргааны төсөв болон дүүрэг, анхан шатны захиргааны төсвийг их хотын захиргааны хуралд хүргүүлэх ба их хотын захиргааны хурал хөрөнгө оруулалт болон үйлчилгээний хооронд бүхэл байдлыг хангах хэлбэрээр өөрчлөлт оруулалгүй эсхүл өөрчлөлт оруулан батлана.</p>

	<p>тогтоомжоор зохицуулна</p> <p>4.8.Улаанбаатар хот нийслэлийн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг улсын төсөвт тусган төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт хэлбэрээр олгоно.</p> <p>4.9.Нийслэлд улсын төсвөөс олгох захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт, гэрээт үйлчилгээний төлбөрийг нийслэлийн төсвийн зохих зүйл ангид тооцно.</p>	<p>Их хотын захиргааны, дүүрэг, анхан шатны захиргааны төсвийг батлахдаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсөвт хууль тогтоомж зөрчсөн заалт байвал түүнийг өөрчлөх, тусгахгүй байх, 2. Хотын захиргааны хураах бүрэн эрхгүй татварын орлогыг хасах, хуулийн хүрээнд татвар, хураамжийн хэмжээг тогтоох, 3. Хотын захиргааны өрийг төсөвт тусгах, 4. Хамтын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлбөрийг оруулах бүрэн эрхтэй.
--	---	--

1.3. ОХУ-ЫН НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Нийслэл (Улаанбаатар хот)-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийн явцад, олон асуудлыг гадаад хөрш зэргэлдээх улс оронд яаж шийдсэнийг мэдэх сонирхох хэрэгцээ шаардлага гарч болно. Гарах ч байх. Тиймээс бид, ОХУ-ын нийслэл Москва хотын эрх зүйн зохицуулалтын зарим анхаарал татахуйц онцлогийн талаар энд товч өгүүлэх болно. Москвагийн хууль тогтоомжийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг бол Москвагийн дүрэм ... тул бид чухамхүү түүнд гол анхаарлаа хандууллаа. Үүнд:

Дүрмийн заалт	Москва хотын Дүрмийн заалтын агуулга, утга санаа (Албан бус орчуулгаар хэсэгчлэн авав)
1.2.	Москва хотын статус нь ОХУ-ын Үндсэн хууль ба ОХУ-ын нийслэлийн статусын тухай хууль, Москва хотын дүрмээр тодорхойлогдоно.
1.5.	Москва хотын нутаг дэвсгэр дээр ОХУ-ын Үндсэн хууль, бусад хуулийн [зэрэгцээ], Москва хотын Дүрэм ёсоор орон нутгийн өөрөө удирдах ёс хэрэгжинэ.
3.3.	Москवाद түр оршин суугаа гадаадын болон дотоодын иргэн, харъяалалгүй хүмүүс ч Москва хотын хүн амыг бүрдүүлэгч мөн.
4.3.	Москва хотын засгийн эрхийг хэн ч хувьдаа өмчлөхгүй
5.2.	Москвагийн засгийн газар бол засаг захиргааны нэгж дэх гүйцэтгэх засаглалын дээд байгууллага юм. Москва хотын дарга нь Москвагийн Засгийн газрын тэргүүн мөн.
7.3.	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд Москва хотын төр засгийн байгууллагуудын системд орохгүй.
7.6.	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагаа хотын аж ахуйн нэгдмэл байдал, Москва хотыг цогцолбороор нь хөгжүүлэх үйл явцыг гажуудуулах ёсгүй.
8.7.	Москва хотын эрх зүйн актууд Москва хотын Дүрэмтэй зөрчилдвөл...дүрмийн заалтыг дагана.
10.3.	Москвагийн дүрэм бол Москва хотын Үндсэн хууль мөн. Москвагийн төр засгийн болон нутгийн өөрөө удирдах ёсны бүх байгууллага...тэдгээрийн албан тушаалтнуудын хэлбэрэлтгүй дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг мөн. Дүрэм хуулийн дээд хүчинтэй.
20.1.	Москва хотын төсвийн мөнгө, хотын улсын үйлдвэрийн газар, албан газруудын эд хогшил, аж ахуйн байгууллагууд дахь Москва хотын хувьцаа, хувь, иргэний бусад объект, түүний дотор Москва хотын хилийн дотор байгаа хуулийн дагуу хувийн өмч болоогүй газар, байгалийн нөөц, хуулиар тодорхойлогдсон өмчлөгчдийн өмч ... бүгд Москва хотын өмчид байна.
20.3.	Москва хотын нутаг дэвсгэрийн гадна байгаа эд хогшил, Холбооны улсын хууль тогтоомжийн дагуу Москва хотын өмчид байж болно.

- §21. Энд, Москва хотын өмчийн албадан хурааж үл болох объектуудын ерөнхий нэрийн жагсаалт орсон.
- 29.2. Москва хотын төсвийн бүрэлдэхүүнд төсвийн зорилтот сангуудыг байршуулж болно.
- 29.3. Москва хотын төсвийн орлогыг Холбооны улсын хууль тогтоомж, Москва хотын дүрмийн дагуу бүрдүүлнэ. Москва хот нь төсвийн мөнгийг зарцуулах чиглэлүүдээ өөрөө бие даан шийдэж тодорхойлно.
- 34.6. Москва хотын депутатын тангарагийг энд үгчлэн тодорхойлсон байна.
- 34.7. Москва хотын депутат байнгын үндсэн дээр ажиллах бөгөөд, багшлах, судлах, уран бүтээлийн ажил эрхлэхээс өөр цалин хөлстэй ажил өөр газарт эрхэлж болохгүй. Москва хотын депутат бүрэн эрхээсээ сайн дураараа татгалзах эрхтэй.
- 35.21. Москва хотын гэрээ хэлэлцээрийг ... Холбооны улсын хууль, Москва хотын дүрмээр тогтоосон журмын дагуу Москвагийн Дума батална.
- 40.1. Москва хотын дарга нь Москва хотын дээд албан тушаалтан мөн. (Албан тушаалд орохдоо тангараг өргөдөг байна)
- 40.9. Москва хотын дарга ОХУ-ын төрийн Думын депутат ... Холбооны зөвлөлийн гишүүн байж болохгүй бөгөөд, ОХУ-ын субъектын төрийн албаны системийн албан тушаал, хотын захиргааны сонгуульт албан тушаалыг хашиж болохгүй.
- 53.2. Москва хотын дарга нь хууль тогтоомжийн дагуу Москва хотод ... цагдаагийн анги алба байгуулах эрхтэй.
- 58.1. Москва хотын төрийн захиргааны байгууллагууд нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- 58.1. Москва хотын төрийн захиргааны байгууллагууд ба орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хоорондын харилцааг...Москва хотын хууль тогтоомж гаргах, [талуудын хооронд] **гэрээ хэлэлцээр байгуулах** замаар зохицуулна.
- 65.1. Иргэн бүр, эсвэл хэсэг бүлэг иргэн Москва хотын төрийн захиргааны болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад...буюу тэдгээрийн албан тушаалтнуудад хандах эрхтэй.
- §67 Москва хотын оршин суугчид тангарагтаны шүүгч, хөндлөнгийн шүүгчийн хувиар ... тогтоосон журмын дагуу шүүн таслах үйл ажиллагаанд оролцоно.

ОХУ-ын Нийслэлийн статусын тухай хууль (Холбооны Улсын хууль)

1. ОХУ-ын нийслэл нь Москва хот. ОХУ-ын нийслэлийн нутаг дэвсгэр бол Москва хотын нутаг дэвсгэр мөн.
3. Москва хот ОХУ-ын нийслэлийн үүргээ биелүүлж байгаатай холбоотойгоор ОХУ-ын төрийн захиргааны төв байгууллагууд, Москва хотын засаг захиргааны хооронд үүсч болох зохицуулагдаагүй асуудлуудыг талуудын хооронд гэрээ байгуулах замаар

зохицуулана.

6. Москва хот ОХУ-ын нийслэлийн үүргээ биелүүлэхэд ОХУ-ын төсвөөс гарах, гаргах тэтгэмжийг Холбооны улсын нэгдсэн төсөвт тусгай зүйл анги болгон суулгана.
9. Москва хотын өмчлөлд байгаа газрыг Холбооны улсын түвшний төрийн захиргааны байгууллагуудад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хэрэг болох байшин барилгаа барихад нь зориулж ... ОХУ-ын Засгийн газраас гаргасан жагсаалтын дагуу олгоно. Олгох газрыг ОХУ-ын өмч болгон худалдаж ... мөн түрээслүүлж болно. Ингэхдээ, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хохирол учруулахгүй.
12. ОХУ-ын нийслэл Москва хотын дүрмийг Москвагийн Дума батална.

2. НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШҮҮМЖ, ЗАРИМ ХАРЬЦУУЛАЛТ

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль 1994 онд батлагдсан. Түүний агуулгыг эргэн харж, өөрчилж сайжруулахаар боловсруулсан энэ төсөл-шинэчилсэн найруулга хуучнаасаа ихээхэн ялгаатай юм. Оруулахаар зэхсэн нэмэлт өөрчлөлтийн хэмжээ одоо үйлчилж байгаа хуучин хуулийн бүтэц агуулгын дийлэнхи хэсгийг хамарчээ. Төсөл санаачлагчаас УИХ-д ирүүлсэн танилцуулгад тухайн хуулийн агуулгын өөрчлөлтийн шинэлэг ... хуучнаасаа давуулаг талыг нь дэлгэрэнгүй дурдсан байна. Тиймээс бид хуулийн төслийн агуулгыг аль болох өөр өнцгөөс харж, улам сайжруулах боловсронгуй болгох чиглэлд шүүмж санаа гаргах, зарим дэвшилтэт саналыг гадны туршлагад тулгуурлан хэлэхийг зорьсон болно.

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу Тамгын газрын Судалгааны төвийн ажлын баг нийтдээ гадаадын 5 орны ижил төстэй хуульд агуулгын шинжилгээ хийсэн. Энд бид, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхдагч шүүмжийг бэлтгэхдээ завсар хоорондуур нь Оросын Холбооны Улсын нийслэлийн эрх зүйн зохицуулалтын зарим анхаарууштай онцлог байдлын талаар (тусад нь бус), харин төслийн тухайн холбогдох заалтынх нь харалдаа шаардлагатай гэж үзсэн газраа зэрэгцээ байдлаар дурдаад явахаар хялбаршуулж нэгтгэсэн бүтцийг ашиглав.

Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл ... харин хойд хөрш маань холбооны улс юм. Гэхдээ, энэ нь Оросын Холбооны Улсын эрх зүйн зохицуулалт Монголд таарамжгүйг нотлох үзүүлэлт болох үндэсгүй. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн байдлыг тогтоохдоо гадаадын шилдэг туршлагыг авч хэрэглэх, юуны өмнө, хөрш зэргэлдээх улс орнуудад тухайн асуудлыг хэрхэн зохицуулсныг тухайлан сонирхох нь зүй ёсны ... эн тэргүүнд хийгдэх анхдагч ажилбарын нэг байх ёстой болов уу.

УИХ-аар хэлэлцэн батлахаар зэхэж байгаа Нийслэл (Улаанбаатар хот)-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн¹⁰ агуулгын зарим сөрөг онцлогийг тодруулахыг зорихдоо бид бүлэг заалтын дугаарын өсөх дарааллаар, аль болохоор зүйлчлэн ахих боломж эрсэн. Ингэх нь, төслийг дүүрэн харах бололцоо олгож, гадны туршлагыг чухам хаана юун дээр голлон анхаарахыг хэлэхэд дөхөмтэй болгоно гэж үзэв.

¹⁰ Шинэчилсэн найруулга, 2010.4.06;

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл /цаашид "нийслэл" гэх/-ийн онцлог чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, удирдлагын бүрэн эрх, нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлийн удирдлагаас оршин суугч, аж ахуйн нэгж, байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- ОХУ-д төрийн Думаараа зөвхөн нийслэлийн статусыг л тогтоодог. Оросын нийслэлийн статусын тухай хууль нь дотроо 13 заалттай. Товчдоо, үүнээс цаашихыг нь Москва хотын "Дүрэм"-ээр хот өөрөө шийддэг байна. Ингэж шийдэж байгаа нь Москва хот нийслэл учраас ч тэгж байгаа биш юм. Оросын Холбооны Улсад нутгийн өөрөө удирдах ёс, зарчмыг харьцангуй илүү хүндэтгэн дээдэлж байна. Хотын дүрмийг Москвагийн Дума батална. Хотын дүрэм бол үнэн хэрэгтээ Москва хотын үндсэн хууль болж өгдөг.
- Манай хуулийн төслийн 4.12-т Нийслэл Улаанбаатар хот ч [мөн] дүрэмтэй байна; гэжээ. Гэхдээ, ийм дэлгэрэнгүй агуулгатай хууль батлагдсаны дараа хотын Дүрмээр чухам юу зохицуулах нь бүрхэг болоод явчихаж мэдэх юм. Мөн хуулийн төслийн 4.13-т "энэ зүйлийн 4.12-т заасан дүрмийг нийслэлийн оршин суугч, нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага хэлбэрэлтгүй дагаж мөрдөх үүрэгтэй" гэж заасан байна. Энэ байдлыг анхаарахгүй орхих аваас хожим гарч ирэх тэрхүү Хотын дүрмийг УИХ батлах үүрэг ч хүлээж болохор байна. Гэтэл хуулийн төслийн 10.3 "...дүрмийг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал [өөрөө] батлана" гэдэг. Ойлгомжгүй логик яваад байна.
- Нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг түлхүү дээдэлсэн (тухайн тохиолдолд) Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн иймэрхүү уян хатан гэмээр онцлог нь манайд зарим талаар туршлага болох үндэстэй мэт.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

- ✓ Үндсэн хуулийн хавсралт хуульд "...Монгол Улсын хуулийн заалт олон улсын гэрээтэй зөрчилдсөн тохиолдолд олон улсын гэрээний заалтыг баримтална" гэсэн нь бий. Энэхүү Хавсралт хууль Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй. Тэгэхээр дурдсан заалт бол Монгол Улсын Үндсэн хуулийн заалт юм. Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг [хууль гаргах бүрт] ийм маягаар дахин давтан тусгай заалт болгож дурдах нь илүүц юм. Энэ практикаас татгалзах нь зөв мэт.
- ✓ Үндсэн хуулийн 50.4-т Улсын дээд шүүх (Үндсэн хуулиас бусад) хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрхтэй гэсэн байдаг. Хэдийгээр энд шүүхийн эрхийн тухай яригдаж байгаа ч гэлээ ...цаана нь бас "Үндсэн хууль ба бусад хуулийг нэг түвшинд эн тэнцүүхэн авч үзэж болохгүй" гэсэн том зарчим харагдаж байна. Энэ зарчмыг эш болговол, үндсэн хуулийн ямар ч заалт бусад хуулинд "байршиж болохгүй" байх үндэстэй.

3.2. Нийслэлийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8.2-т заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үндсэн зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

3.2.1. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөх;

3.2.2. нийслэлийн оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэх;

3.2.3. нийслэлийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь олон нийтийн санал, оролцоонд тулгуурлах, ил тод байх.

- 🚩 (3.2.1.) Хотын хөгжлийн төлөвлөгөөг мөрдөх нь зарчим биш үүрэг байх болов уу. Харин төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчим гэж яривал өөр болно.

✚ (3.2.2.), (3.2.3.) Эдгээр нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нэгэнт заагдсан “дахин батлах шаардлагагүй” зарчмууд юм. Жишээ нь, Төрийн албаны тухай хуулинд [төрийн албаны ажилтан] -ард түмэнд үйлчлэх; -ил тод байх; -хууль дээдлэх; Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд - ардчилсан шударга ёс; -оршин суугчдын ашиг сонирхлыг төлөөлөх гэх зэргээр олон зарчмыг тус тус тоочиж заасан байдаг. Улсын алба, засаг захиргааны алба, төрийн алба ... эд бүгд ерөнхий утгаараа нэг зүйл мөн.

✚ Үндсэн хуулийн 59, 62, 63 дугаар зүйлд “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулна”, “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно”, “Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль тогтоомжид тухайлан заагаагүй бол, түүнийг нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан шийдвэрлэж болно” гэж заасан. Тиймээс энд шинээр зарчим заалт болгож оруулах шаардлага харагдахгүй байна.

4.3 Далай ашиглах тухай хуулийн 81.1-д заасны дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт нь Улаанбаатар хот байна.

❖ Далай ашиглах тухай Монгол Улсын хуулиар далай ашиглахтай холбогдсон [бүх] харилцааг зохицуулдаг. Бие даасан тусгай хуулиар нэгэнт зохицуулагдсан асуудлыг дахин сөхөж, энд өөр хуулиар давхар “баталгаажуулах” нь зохимжгүй. Энэ заалт Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд “Бүртгэлийн боомт нь УБ хот байна” гэж орсон атал Далай ашиглах тухай хуулийн 9.1-д “бүртгэлийн боомт нь УБ хотод байна” гэжээ. Хэллэгт утгын том ялгаа байна. Бүртгэлийн боомтын бүрэн эрхийн олон асуудал цаана нь байдаг тул бичлэгийг жигдлэх шаардлагатай.

❖ Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомт байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар [түүгээрээ] шийдвэрлэдэг. Тийм хуультай юм. Засгийн газрын эрх хэмжээний асуудлыг Монгол Улсын хуулиар дээрээс шийдвэрлэх нь оновчтой бус гэж үзнэ.

4.4. Нийслэл нь Улаанбаатар бүсийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хүрээлэн байгаа орчин, ногоон бүсийг хамгаалах, сэргээх, оршин суугчийн суурьшил, хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах үүднээс алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүстэй байж болно.

✓ Энд, Улаанбаатар хот чөлөөт бүстэй байж болох тухай өгүүлж “Хотын чөлөөт бүс” гэдэг нэр томъёо шинэ юм. Нийслэлийн эрх зүйн байдалд хамааралтай хэм хэмжээ тогтоосон олон хууль байдаг. Тэдгээрийн агуулгад юуг ойлгох нь тодорхойгүй маш олон нэр томъёо бий. Тэдгээрээс жишээлж дурдъя.

Аймгийн төв, сумын төв, баг-бригадын төв, орон нутаг, хот газар, суурин газар, хот суурин газар, төвлөрсөн суурин газар, хөдөө тосгон, хөдөө орон нутаг, ... тасаг, ... завод, ... уурхай, ... үйлдвэр, ... хороо, ... өртөө, дагуул хот, хаяа хот, аймгийн төвийн сум, сумын төвийн суурин, сумын төвийн баг, орон нутгийн хот, улс аймгийн зэрэгтэй хот, улсын чанартай хот, нийслэл хот, нийслэл, тусгай статустай хот, Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Орхон аймаг, чөлөөт бүсийн хот, бүсийн төв, бүсийн хөгжлийн төв, бүсийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, алслагдсан дүүрэг, жишиг хот, (нинжаг дагасан) явуулын хөдөлгөөнт төр, хилийн боомт, хилийн гарц, засаг захиргааны нэгж, нутаг дэсвгэр–засаг захиргааны нэгж, нийгмийн цогцолбор [энэ тэр] гээд албан ба албан бус хэлбэрийн үй олон нэрс байна. Эд бүгдийг Монгол Улсын хууль тогтоомжийн агуулгаас түүж авав. Хууль тогтоомжид байгаа л бол эд бүгдээрээ албан ёсны нэр болж таарна.

✓ Эдийн засгийн чөлөөт бүс, чөлөөт бүсийн хот гэсэн нэршил хууль тогтоомжид бий. Харин “хотын чөлөөт бүс” гэдгийг тодруулах шаардлагатай. Хуулийн төслийн өөр хэсэгт “хотын чөлөөт бүсийн гудамж, зам, талбай”-н тухай бас дурдсан байна. Хот дотор нэг тусгай газар байх ба тэр нь эдийн засгийн бичил чөлөөт бүс байх мэт. Албан ёсны цэгцтэй тодруулга

дутагдаж байна. Жишээ нь, голландад “жуулчин татах зохиулалттай” өвөрмөц гудамж¹¹ ...[энэ тэр] гэж байдаг юм байна. Тэнд, тэрийгээ эдийн засгийн чөлөөт бүс гэдэггүй юм байна.

- ✓ Энэ төслийн 20.1–д, Нийслэлийн чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна; гэжээ.

4.8. Улаанбаатар хот нийслэлийн чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлыг улсын төсөвт тусган төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт хэлбэрээр олгоно.

- ✓ ОХУ–ын хууль тогтоомжид “хот нийслэлийн үүргийг хэрэгжүүлэх” гэсэн үг хэллэг бий. Тэндэхийн, нийслэлийн статусын тухай хуульд, Москва хотын Засаг захиргааны бүрэн эрхийг нэмж өргөтгөх маягаар зохицуулалт хийж “тухайн хотын нийслэлийн үүргийг биелүүлэх” боломжийг хангасан байдаг.
- ✓ Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “УБ хот нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэх” гэснийг ялимгүй өөрчилж дээрх хэлбэрт оруулж болох юм. Угтаа бол, хот үүрэг биелүүлээд байгаа биш хотын дарга тухайн хотын удирдлагад тусгай статусаар олгогдсон нэмэлт бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд л уг тавигдсан зорилго биелэнэ.

5.1. **Нийслэлийн удирдлага нь** суурин соёл иргэншлийн тэргүүлэх байр суурийг хадгалан хөгжүүлэх бие даасан бодлого хэрэгжүүлнэ.

5.4. Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт нь үндэсний уран барилгын өв уламжлалыг орчин үеийн ололт, хот байгуулалтын дэлхийн шилдэг жишигтэй хослуулан хөгжүүлэх бодлогод үндэслэнэ.

- ✓ (5.1.) Нийслэлийн удирдлага, Улаанбаатар хотын удирдлагыг тус тусдаа зүйл мэтээр ойлгох хандлага байна. Нийслэлийн удирдлага гэвэл хотын удирдлагын, эсхүл, хотын удирдлага гэвэл нийслэлийн удирдлагыг хэлж байлтай. Гэтэл үгүй, энд ойлголтын зөрүү яваад байна. Бүр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч–ийн албан тушаалыг дотор нь 2 салгах тухай яриа ч гарч байгаа юм.
- ✓ Хууль гарчгийн хувьд л “нийслэлийн” гээд яваад байгаа болохоос биш, [үнэн чанартаа] монголын том хотын тухай хууль юм. Улаанбаатар бол эхлээд хот ... дараа нь нийслэл. Тиймээс ядаж “нийслэл Улаанбаатар хотын ...” гээд явсан ч болохоор юм.
- ✓ (5.4.) Манай үндэсний уран барилгын өв уламжлал гэж онцолж сүрхий дурдаад байхаар бодит зүйл байхгүй нь гашуун боловч үнэн юм. Хэдэн сүм бий. Харин, УБ хотод ижил барилга байшин аль болохоор цөөн байлгах тэр чиглэлд санаа оноо оруулбал нэн сайн байхсан.

6.1. Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байх бөгөөд алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгон, чөлөөт бүсийн нутаг дэвсгэр нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэст багтана.

¹¹ жишээ нь, амстердамын зарим гудамж;

- ❖ ОХУ-ын хууль тогтоомжид “Москва хотын хилийн цэс нь (давхар) нийслэлийн хилийн цэс байна” гэжээ. Тэр заалт хот ба нийслэл нь “нэг зүйл мөн” гэдгийг тодотгодог. Ингэж тэнд, “Москва хотын хил бол ОХУ-ын нийслэлийн хил мөн” гэж заах замаар хот ба нийслэл тусдаа зүйл биш гэдгийг эвтэйхэн зохицуулсан байна. Бас, Москва хотын статусыг тусгайлан тогтоожээ.
- ❖ Нийслэлийн удирдлага, Улаанбаатар хотын удирдлага тусдаа гэж ойлголт төрөхүйц хэллэг ухагдахуун хуулийн төслийн агуулгад олон байна. Улаанбаатар хот бол улсын нийслэл. Нийслэл гэдэг тодотгол нь УБ хотын статус юм. Хотын статус өргөгдөхийн хэрээр хотын удирдлагын бүрэн эрх нэмэгддэг.

6.2. Нийслэлийн нутаг дэвсгэр нь Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүсчлэлтэй байх бөгөөд байгаль орчныг хамгаалах болон ой, усны нөөц хамгаалах бүстэй байна.

- ✓ Хот байгуулалтын тухай хуулийн агуулгын хүрээнд зохицуулагдсан асуудлыг Нийслэлийн эрх зүйн байдлын тухай “өргөтгөх” нь хэр оновчтой бол?!
- ✓ Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд,
 - орон сууц, олон нийтийн бүс;
 - үйлдвэрлэлийн бүс;
 - инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс;
 - ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс;
 - хөдөө аж ахуйн бүс;
 - зуслангийн бүс;
 - тусгай зориулалтын бүс; -ийн тухай заасан байдгийг дурдсан.
- ✓ Байгаль орчныг хамгаалах бүс; ой усны нөөц хамгаалах бүс; хотын чөлөөт бүс; эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс; гэсэн шинэ бүсүүд энэ хуулиар [шинээр] тодорхойлогдож байна. Хууль гарах тоолонгоор бүс бүслүүр нэмээд байх нь хуулийг хэрэглэгч талдаа төөрөгдөл үүсгэх нөхцөл бий болгон, эцсийн дүндээ оршин суугчийн эрх ашигт хохирол учруулах магадлалтай. Хуулийн төслийн агуулга дотор нэр томъёоны тайлбар оруулах хэрэгцээ гарч байна.
- ✓ Тусгай зориулалтын бүс ба чөлөөт бүс, эсхүл, байгаль хамгаалах бүс ба ногоон байгууламжийн бүс, хөдөө аж ахуйн бүс, эрчимжсэн мал аж ахуйн бүс ... эдгээрийн хооронд ямар ялгаатайг тодруулах нь зөв болов уу.

6.3. Нийслэлийн нийтийн эдэлбэр газарт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дагуул хот, тосгон, **чөлөөт бүсийн гудамж**, талбай, зам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамир, спортын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

- ❖ Энд дурдагдаж байгаа “чөлөөт бүс” бол **эдийн засгийн бичил чөлөөт бүс** гэдэг тухайн хуулийн төслийн өөр заалтуудаар дам тодорч байгаа. Уг нь, энд тэр тодотголыг оруулчихмаар байгаа юм.
- ❖ Чөлөөт бүсийн тухай хуулийн 3.1-т, “чөлөөт бүс” гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаа, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ. Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна” гэж заасан байдаг.

6.4. Чиг үүргээ биелүүлэх зорилгоор нийслэлийн эзэмших, ашиглах газар нь нийслэлийн хилийн цэсийн гадна байж болно.

- ❖ Монгол улсын нутаг дэвсгэр аймаг нийслэлд хуваагдах замаар Засаг захиргааны бие даасан нэгжүүдэд бүрэн харъяалагддаг. Засаг захиргааны нэгж болгон хилийн цэстэй. Тэгэхээр ... нийслэлийн эзэмших газар түүний хилийн гадна байх учиргүй.
- ❖ Тийм хэрэгцээ шаардлага байлаа гэхэд түүнийг холбогдох засаг захиргааны нэгжүүд тэгш эрхийн үндсэн дээр гэрээ хэлцлийн зарчмаар “эдийн засгийн хууль”-ийн дагуу шийддэг баймаар юм. Төсөлд байгаа шиг “хуулиар далайлгах” арга байж болохгүй.

7.1. Улсын Их Хурал нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. нийслэлийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

7.1.2. хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

7.1.3. нийслэлийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль дотроо “УИХ” гэсэн зүйл заалттай байх нь тун зохимжгүй юм. Хуулийн төслийн 7.4 дэх заалт бүхэлдээ хууль тогтоох дээд байгууллагын хийх ажил (бүрэн эрх)-ын тодорхой хүрээг зааж байна. УИХ-ын бүрэн эрх үндсэн хуулиар тодорхойлогддог. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд, “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэж заасан. Тэнд,

- 11) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;
- 12) нутгийн өөрөө удирдах болон захиргааны бйгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох; ...тухай заасан байна.

(7.1.1.) Нийслэлийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого [зарим талаар] “үндсэндээ тодорхойлогдчихсон” гэж хэлж болно. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бол Монгол Улсын төрийн бодлогын баримт бичиг юм. Өөр баримт бичгүүд ч бий.

8.1. Засгийн газар нийслэлийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.3. нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

Засаг захиргааны нэгжид төрийн ба нутгийн [хосмол] удирдлага харилцан уялдаатайгаар хэрэгждэг. Хуулийн төсөлд байгаа “нутгийн захиргааны байгууллага” гэдэгт энэхүү хосмол удирдлагыг хамтруулж ойлгох уу, зөвхөн, “нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага”-ыг ойлгох уу!? Эдгээрийн аль нь ч байлаа гэсэн, тухайн заалт бүхэлдээ, орон нутгийн өөрийн удирдлагыг үгүйсгэх чиглэлтэй болсон байна. Дээрээс нь удирдаад чиглүүлээд байдаг юм бол тэнд ажил асуудлаа яаж бие дааж шийдэх вэ гэсэн асуулт гарч ирнэ.

9.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нийслэлийн талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.4. **нийслэл, түүний оршин суугчийн нийтлэг ашиг** сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

9.1.6. нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллага, гудамж, талбайг нэршүүлэх, нэрэмжит болгох, хөшөө, дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачлагаар болон **иргэд, байгууллагын саналыг үндэслэн** шийдвэр гаргах;

9.1.10. нийслэлийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил тогтоох;

9.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байнгын ажиллагаатай байж болно.

9.3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нийслэлийн Засаг даргын нэгэн адил баталгаагаар хангагдана.

- ❖ (9.1.4.) Нийслэлийн эрх ашиг гэсэн нэг ухагдахуун яваад байна. Тийм юм байх ёсгүй, хэрвээ байдаг бол тэр оршин суугчийн эрх ашгийн дараа эрэмбэлэгдмээр юм. Нийслэлийн эрх ашиг, нийслэлийн оршин суугчийн эрх ашиг бол саланги тусдаа зүйл биш. (9.1.6.) Энд жишээ нь, ... хөшөө босгох асуудлыг нэг иргэн, ямар нэгэн байгууллагын саналыг үндэслэн шийдэх нэрийн дор эрх бүхий байгууллагууд хэтэрхий их эрх мэдэлтэй явж ирсэн. Тиймээс “баахан удирдагч”-ийн хөшөө олон газар сүндэрлэсэн. Үндэсний түүх өв соёлын калоритыг харуулах, хотын өнгө үзэмжид доминант (өргөлт) өгөх зорилгыг хангах үүднээс асуудлыг [эцсийн эцэст, зөвхөн] холбогдох төрийн захиргааны байгууллагын санал дүгнэлтэд тулгуурлан шийдэж баймаар. Хуулийн төсөлд ийм заалт хэрэгтэй байна.
- ❖ (9.1.9.) Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, учирсан бэрхшээлийг нэг мөр шийдэх нь нийгмийн тулгамдсан асуудал мөн. Тиймээс ч Үндэсний хөтөлбөрийн тухай парламентын түвшиндээ ярьж судалж томоохон зохицуулалтыг хийхийн төлөө шаргуу ажиллаж байна. (9.1.9.)-т заасан зүйлс нь “ажлын төлөвлөгөө” хэлбэрийн санаа юм. Үүнийг, төрөл бүрийн Үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэг хүлээх ... хүлээлгэх хэлбэртэйгээр томъёолох нь илүү зохистой байх болов уу.
- ❖ (9.3.) Нийслэлийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүний баталгаагаар хангагдана; гээд байгаа. Энд, НИТХ-ын дарга “засаг даргын нэгэн адил” баталгаагаар хангагдана; гэжээ. Ижил санааг хоёр өөрөөр томъёолсны цаана ямар ялгамж санаа байгааг тодруулах хэрэгтэй. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ерөнхий үндсэн үүрэг бол иргэдийг төрөөс хамгаалах явдал мөн; гэсэн зарчмыг эш болговол, тухайн заалтын томъёолол 2 албан тушаалын эрхийн тэнцвэржилтийг хангах үүднээсээ үг үсгийн хувьд ч ижил баймаар байгаа юм.

10.1. Нийслэлийн Засаг дарга тодорхой чиг үүрэг хариуцсан орлогч, зөвлөхтэй байна.

10.7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.7.2. нийслэлд хүн амын төлөвлөлтгүй суурьшил бий болох, дэд бүтцийн болон нийгмийн үйлчилгээний хэвийн ажиллагаа алдагдах, оршин суугчдын амьдрах орчинд аюултай нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх;

10.7.3. хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлыг бий болгосон, хүрээлэн байгаа орчныг бохирдуулсан, ашиглах бодисын зөвшөөрөгдөх хэмжээг хэтрүүлсэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх, зогсоох, холбогдох байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн барилга, байгууламж барихыг хориглох, нийслэлээс нүүлгэн шилжүүлэх тухай саналыг холбогдох байгууллагад тавих;

10.7.4. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжээс нийслэлд ажиллах хүчийг зохион байгуулалттайгаар шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

10.7.5. нийслэлийг хөгжүүлэх асуудлаар төсөл санаачлах, төсөлд санал, дүгнэлт өгөх, түүнийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;

10.7.6. дотоод, гадаад харилцаанд нийслэлийг төлөөлөх;

10.7.7. нийслэл дэх үндэстэн, ястан, цөөнхийн түүх, шашин, соёлын өвийг хамгаалан, арвижуулах;

10.7.8. газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах;

10.7.9. Газрын тухай хуулийн 21.2.3-т заасны дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;

10.7.10. холбогдох хуулийн дагуу нийслэлийн оршин суугч, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх;

10.7.11. дүүргийн Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын даргын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй бол хүчингүй болгох;

10.7.12. эрчим хүчний болон нийтийн тээврийн ачааллыг зохицуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний ажил эхлэх, дуусах цагийг тогтоох;

10.8. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.

- (10.1.) Хотын даргын орлогч зөвлөхийн асуудал шинэ асуудал биш. Хуучин байсан ... одоо ч байгаа. Гол асуудал нь хэдэн орлогч зөвлөхтэй байх тухай “жижиг” зүйлд оршиж байна. Засгийг газрын тогтоолоор, тодорхой стандарт тооцооны дагуу, орлогч зөвлөхийн орон тоог тогтоохгүй бол асуудал аажимдаа дур зоргын шинжтэй болж хувирна.
- (10.7.2.) Нийслэлийн хөгжил төлөвлөлтийн өнөөг хүртэл явж ирсэн уламжлал бол нүүдэлч түмний “дураараа нүүх суух” уламжлалт эрх” дээр тодорхой хэмжээгээр суурилж ирсэн. Нийслэлд түрүүлж нүүж ирсэн сүүлд ирсэн нэгнээ хавчин гадуурхах “шударга бус” байдал байнга байсаар ирсэн. “Төлөвлөөгүй суурьшил” үүсэхгүй гэсэн нэрийн дор нийслэлд хөдөөнөөс хүн ирж суурьших боломжийг “захиргаадан” хаах гэсэн санаа халхлагдах вий. Нийслэлийн хүн амын (хэзээнээсээ байсаар ирсэн) механик өсөлтийг хүлээн авах чадамж бий болгох, түүнийг нэмэгдүүлэх тухай зааж өгвөл Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхсэн.
- (10.8.) “... Бүрэн эрх хэрэгжүүлэхэд ЗГ-ын гишүүний баталгаагаар хангагдана” гэдэг томъёолол анхаарал татахуйц байна. “Бүрэн эрх” гэдэг бол өөрөө эрхийн баталгаа байдаг. Засаг даргын албан тушаалын статусыг өргөх, ингэхдээ, Засгийн газрын тухай хуулийн агуулгад хохирол учруулахгүйгээр шийдэх гэсэн гарц юм болов уу.
- Засгийн газрын тухай хуульд “Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын сайд байна. Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээний ажлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна”, “Засгийн газрын гишүүн бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ” гээд бүс нутгийн хөгжлийн нэгдсэн бодлогын асуудлыг Монгол Улсын Шадар сайдад хариуцуулсан байдаг.
- Нийслэлийн засаг дарга бол засаг захиргааны нэгжийн дарга. Өөрөөр хэлбэл орон нутагт “орон нутгийн асуудал” шийддэг албан тушаалтан. Засгийн газар улс орны хэмжээний бодлогын цогц асуудал шийднэ. Зарчмын ийм хандлагын үүднээс яривал Нийслэлийн засаг дарга Монгол Улсын Засгийн газрын гишүүн–Монгол Улсын сайд байж болохгүй байгаа юм. Асуудлыг, албан тушаалын ангилал зэрэглэлийг дүйцүүлэн жиших тухай эрх бүхий байгууллагын тогтоолоор шийдэх нь илүү зохистой.
- Хотын мэр аж ахуйн ажил хариуцдаг. Түүнийг цаашдаа хотын нийт оршин суугчид өөрсдөө сонгодог болох магадлал ч бий. Дэлхийн олон оронд, түүний дотор ОХУ-д, Москва хотын даргыг тэгж сонгодог. Ийм хүн, хэрэг дээрээ, үзэгдэхүйц эрх мэдлээрээ сайдаас илүү ... хангалттай өндөр зэрэглэлийн албан тушаалтан байдаг.
- “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч”–Албан тушаалын энэ нэр Үндсэн хуулийн агуулгад захирагдаж үүссэн. Уг нь, тухайн албан тушаалыг “Нийслэл Улаанбаатар хотын Засаг дарга бөгөөд Улаанбаатар бүсийн зөвлөлийн дарга” гэмээр

байгаа юм. Энэ мэтээр Үндсэн хууль өөрөө олон өөрчлөлтийн саатуулагч хүчин зүйл болж байдгийг дашрамд бас ч хэлмээр байна.

- Улаанбаатарын бүсийн зөвлөл 2005 онд байгуулагдсан. Г.Мөнхбаяр Улаанбаатарын бүсийн зөвлөлийн даргаар 2008 онд томилогдсон. Түүний энэ албан тушаалыг [зориуд] дурдахгүй байгаа нь өөрөө бүсчилсэн хөгжлийн үзэл санааг сурталчлахгүй байгаагийн илрэл, бараг сөрөг сурталчилгаа талдаа үйлдэл гэж үзэж ч болохоор байна. Улаанбаатарын бүсийн зөвлөл 22 гишүүнтэй. Бүсийн зөвлөлийн бүрэн эрх гэж “том эрх мэдэл” бий. Улаанбаатар бүсийн зөвлөлийн аппаратын ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцдаг.

11.1. Дүүрэг нь хүн амын байршил, эдийн засгийн чадавхи, газар зүйн байршил, зам харилцааны нөхцлийг харгалзан байгуулсан нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж мөн.

11.4. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргын албан тушаалыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын албан тушаалтай тус тус адилтган үзэж болно.

11.5. Дүүргийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.5.1. нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас дүүрэгт шилжүүлсэн өмчийн болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

11.5.2. хууль тогтоомжид нийцүүлэн захирамж, заавар, дүрэм, журам батлан мөрдүүлж, гүйцэтгэлийг хангуулах;

11.5.3. энэ хуулийн 10.7.10-д зааснаас бусад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргах;

- Нийслэлийн алслагдсан дүүрэг ч нийслэлийн салшгүй хэсэг мөн. Жишээ нь, Багануур бол хот, харин УБ бол нийслэл гэж ярихаар зэрэг, ерөнхий ухамсарын түвшиндээ, нээрээ тийм юм уу гэхээр хялбаршуулсан сэтгэлгээний суурь болж өгнө. Энэ байдал нь нийслэл ба хот гэдэг ухагдахуунууд тэмээ ямаа шиг ялгаатай мэт буруу төсөөлөл төрүүлдэг байна.

12.2. Хуульд өөрөөр заагаагүй бол хороо нь өөрөө өөрийгөө тэтгэн хөгжүүлж, бие дааж ажиллана.

- ✓ (12.2.) Монгол Улсын хууль тогтоомжид “засаг захиргааны нэгжийг өөрийгөө тэтгэн хөгжиж болохгүй, битгий бие дааж ажиллаарай” гэж заахгүй, заагаагүй нь ойлгомжтой. Тэгэхээр “хуульд өөрөөр заагаагүй бол” гэдэг үг ямар үүрэгтэй нь эргэлзээ төрүүлж байна. Бие дааж ажилла; гэвэл “цаадах нь хэцүүднэ” гээд араас нь тэтгэх гарц - орц үлдээж байгаа юм шиг байна. Уг нь, үндсэн хуулийн үзэл санаа засаг захиргааны нэгжийн бие даасан хөгжлийг дэмждэг тул “өөрөөр заах” нь өөрөө харин эргэлзээтэй үйлдэл.
- ✓ Дашрамд тэмдэглэхэд, “хуульд өөрөөр заагаагүй бол” гэдэг заалт иргэний эрх ашгийг хохироох чиглэлд үйлчилж байна. Хаа нэгтээ үүнээс өөрөөр зааж уу, үгүй юу ... гэдгийг тодруулахын тулд, тухайн асуудлыг сонирхогч иргэн монголын бүх хуулийг унших хэрэгцээ шаардлагатай тулж байна.

12.7. Хорооны Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.7.3. хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулсан болон энэ хуулийн 34.1.6, 34.1.7-д заасан торгуулийн мөнгийг хорооны мөнгөн хөрөнгийн санд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулах;

12.7.4. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах явцад үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх;

(12.7.3.) Энэ бол үнэхээр аймаар заалт. “Хорооны мөнгөн хөрөнгийн сан” хуулийн дагуу бий болох нь. Тэр нь торгуулийн мөнгөөр бүрдэх нь. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн удирдлагыг “торгох донтой” болгох учраас энэ заалтыг аюултай гэж хэлж байгаа юм. Хорооны мөнгөн хөрөнгийн санг зориулалтын дагуу зарцуулна гэсэн байна. Тэр нь чухам ямар зориулалттайг тодруулах хэрэгтэй юм.

Торгуулиар мөнгөн сан бүрдүүлнэ гэдэг байж болшгүй зүйл. Үүний оронд яригдаад байгаа “нийслэлийн оршин суугчийн татварын ... (төдөн) хувь нь хороондоо үлдэж нийтийн эрх ашгийн төлөө зарцуулагдана” ... гэвэл хамаагүй дээр.

14.1. Нийслэлийн оршин суугч дараахь эрх эдэлнэ:

14.1.1. нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаар хэлэлцэж байгаа асуудлаар мэдээлэл авах, санал өгөх;

14.1.2. нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан санал дэвшүүлэх;

(14.1.1.) Нийслэл Улаанбаатар хотын удирдлага иргэний саналыг хүлээж авахаас цааргалах, санал тавихыг санаархсан хүнийг үзэгдэхүйц эрх мэдэлгүй субъект руу “пааслах” гэсэн санаагаа үүгээр баталгаажуулах гэж байна. Энд, иргэний эрх оршин суугчийн эрхийн ялгамжийг зааглан тодруулах шаардлага гарч ирж байна.

Нийслэлийн удирдлагад гаргаж байгаа санал бол өргөдөл гомдлын асуудал. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол санал тусгай хуулийн дагуу шийдэгддэг. Тэр хуулийн 7 дугаар зүйлд “харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох албан тушаалтан заавал хүлээн авах тухай, мөн тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдол, саналыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй; тухай тус тус заасныг нэмж дурдъя.

15 дугаар зүйл. Нийслэлийн оршин суугчийн үүрэг

15.1. Нийслэлийн оршин суугч дараахь үүрэг хүлээнэ:

15.1.2. нийслэлийг хөгжүүлэх ажилд идэвхитэй оролцох;

15.1.3. нийтийн эзэмшлийн эд зүйлийг зохистой ашиглах, амьдарч байгаа орчноо цэвэр байлгах;

15.1.4. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлийн бүсэд оршин суух;

15.1.5. оршин суугаа нутаг дэвсгэртээ гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны болон цагдаа, онцгой байдлын байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох, нийгмийн хэв журмыг сахих;

15.1.6. нийслэлд оршин суухдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу харьяалах хороонд 10 хоногийн дотор бүртгүүлсэн байх;

15.1.7. түр хугацаагаар оршин суугч нь хүндэтгэх шалтгааны улмаас энэ хуулийн 13.2-т зааснаас дээш хугацаагаар нийслэлд оршин суух бол мөн хугацаагаар сунгуулах;

15.1.8. нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх;

(15.1.2.) Ач холбогдол багатай заалт. Нийслэлийн иргэн татвараа төлж байгаа нь нийслэл хотынхоо хөгжилд хувь нэмрээ оруулж байгааг илтгэх хангалттай үзүүлэлт мөн. Төсөлд, энэ мэт, тунхаглал шинжтэй тодорхойгүй заалтууд нилээн байна.

(15.1.7.) Түр хугацаагаар суугаа гадаадын иргэнийг ч тэр бүр бүрэн сайн бүртгэж чадахгүй байгаатай харьцуулж, нилээн прагматик байдлаар асуудалд хандвал монголынхоо иргэнд хавьгүй өргөн боломж нээмээр байна. Дээр үеийн “зам явах” гэж нэг айхтар чирэгдэлтэй бичиг байсансан ...

18.1. Нийслэл нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан өмчтэй байх бөгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.

18.2. Нийслэлийн өмч нь хуульд заасан үндэслэлээр олж авсан нийслэлийн өөрийн эд хөрөнгө болон нийслэлийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгөөс бүрдэнэ.

18.3. Нийслэлийн өмчийг захиран зарцуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

18.4. Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх, ашиглуулах, бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

18.5. Нийслэл нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу хууль тогтоомжид нийцүүлэн гадаад улс болон аймаг, сумын нутаг дэвсгэрт нийслэлийн төлөөлөгчийн газар байгуулж болно.

(18.5) Төслийн анхаарал татсан заалтын нэг. Нийслэл гадаадад өөрийн төлөөлөгчөө томилж суулгах нь зарчмын бус үйлдэл мөн. ОХУ-д нийслэлийн элчингийн газар бий болохоор төсөөлөгдөж байна. Дотоодод, суманд суух нийслэлийн төлөөлөгч гэж юу хэлээд байгаа ч тодруулбал зохино. Бизнесийн байгууллагын төлөөлөгч бол гадаад дотоодод бишгүй байдаг. Засаг захиргааны нэгжийн удирдлага бол төрийн байгууллага учраас ийм байж болохгүй мэт.

Энэ мэт эрх мэдлийг хэтрүүлэх ... завхруулгын шинжтэй байж магадгүй санааг Монгол Улсын хуулийн заалт болгоод авах гэж “зүтгэж” байгааг шүүмжилмээр байгаа юм. Хууль нэгэнт батлагдвал заалт заавал хэрэгжинэ. Ийм хуультай учраас ... гэж байгаад л томилж гарна.

Хотын удирдлага орон нутгийн өмчийн үйлдвэр аж ахуйн газруудыг өөрсдийн хүнээр удирдуулах замаар, өөрсдөө тухайн төлөөлөн удирдах зөвлөлд нь орж, гадаадад явах, тендергүй эсвэл хуурамч тендерээр халхавчилж, тэдгээрт өөрсдийн бараа үйлчилгээг шахах, албан тушаалаа ашиглан хотын төсвийн (бусад) байгууллагуудыг, зөвхөн өөрийн ашиг сонирхолтой газраас үйлчилгээ авахыг тулгах явдал газар авсан; гэсэн шүүмжлэл их гардгийг энд дурдалтай. Тиймээс хотын удирдлагын эрх мэдлийг чухам энэ чиглэлд хэт өргөтгөхгүй байхыг анхаарууштай байгаа юм.

Хот гэдэг их айлын аж амжиргааг тэтгэх сэдэлтэй элдэв төрлийн сан, банк, корпораци байгуулах эрхийн тухай санаа шинэ зүйл биш. Ийм санаа өмнөх, өмнөхийн өмнөх хуулийн төслүүдэд байсан. Харин сүүлчийн төсөлд эдгээр заалтын хүрээ хумигдсан нь боловсруулалтын шатны үр дүн биз ээ.

19.1. Нийслэл нь хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын аж ахуйг өргөтгөх, хүн амын үйлчилгээг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор нийслэл, дүүргийг хөгжүүлэх сантай байж болно. Санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

19.2. Сан нь сангийн үйл ажиллагааны орлого, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

19.3. Нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, дүүргийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дүүргийн Засаг дарга захиран зарцуулж, гүйцэтгэлийг жил бүр нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

Нийслэлийг хөгжүүлэх Улаанбаатар сангийн үйл ажиллагааны түүхэн туршлагыг эргэж харахад илүүдэхгүй. Тэр санг анх 1997 онд НИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр орон нутгийн өмч дээр үндэслэн байгуулсан. 2002.01.30-нд мөн НИТХ-аар Улаанбаатар сан УУГ -ыг “нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, хот тохижилтийг сайжруулах, хотын төсөв санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх” зорилгоор ХХК болгон өөрчилжээ. Тус

компанийг үүсгэн байгуулагч бөгөөд хувьцаа эзэмшигч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурал бөгөөд удирдах байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Улаанбаатар сангийн хөрөнгөөр "Улаанбаатар хотын хөгжлийн банк" байгуулах нийслэлийн засаг даргын саналыг дэмжсэн тогтоолыг НИТХ Тэргүүлэгчид 1998.01.07-нд гаргасан. 1998.01.28-нд Улаанбаатар сангийн Удирдах зөвлөл хуралдаж Улаанбаатар банк байгуулах ажлын хэсгийг сонсоод "төр ба хувийн өмч оролцсон ХХК байх Улаанбаатар банкыг байгуулах, дүрмийн сан нь 500 сая төг байх бөгөөд 51 хувь нь Улаанбаатар сан эзэмших шийдвэр гаргажээ. Улаанбаатар банкны удирдах зөвлөл хуралдаж НИТХ-ын нэг Тэргүүлэгчийг тухайн банкны ерөнхий захирлаар батлав. Тийнхүү сангийн мөнгөөр банк байгуулж Улаанбаатар хотын дансыг төвлөрүүлжээ. 1999.9.21-ны Улаанбаатар сангийн удирдах зөвлөлийн тогтоолоор банкны дүрмийн санд 500 сая төг оруулан, тодорхой 2 иргэнтэй хэлэлцээ хийж, банк байгуулах тухай гэрээ, дүрэмд гарын үсэг зурах шийд гарсан. 2001.6.14-нд Улаанбаатар хотын банкны хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол гарч банкны дүрмийн санг 2 тэрбум болгох Монгол банкны шаардлагын дагуу Улаанбаатар сан 500 саяыг, нэр бүхий 3 иргэн нийлээд 500 сая төг-ийг тус тус нэмж хийхийг зөвшөөрчээ. Улаанбаатар банкны 1 тоот гэрчилгээгээр 2001.6.30-нд "Нийслэлийг хөгжүүлэх Улаанбаатар сан" ХХК-гаас 1 тэрбум төг. авсан. 2003.10.15-ны өдрийн банкны хувь нийлүүлэгч хурлын тогтоолоор дүрмийн санг 5 тэрбум болгож 20 хувийг Улаанбаатар сан, үлдэгч 80 хувийг хувь нийлүүлэгч иргэдийн хөрөнгө байна гээд сангын тэргүүн ба нэр бүхий 5 иргэн гарын үсэг зурав. Бас нэр бүхий 4 иргэн нэмэгдэж нийт 3 тэрбум төг оруулахаар болсон байдаг. Энэ банкыг нийслэлийн хөрөнгөөр байгуулсан боловч дүрмийн санг өсгөх шаардлага нэрээр удирдлага өөрсдийн хүмүүсээ ээлжлэн оруулсаар УБ хотын банкны ихэнхийг "хувьчлаад" авчихсан бололтой юм. Уг нь бол тэр эзэн нь гээд байгаа НИТХ өөрөө банкны тайлангаа сонсож хэнийг яаж оруулах тухай хэлцсэн байх ёстой мэт. 2000.3.08-нд Улаанбаатар сангийн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Улаанбаатар Даатгал компани байгуулах НИТХ-ын шийдвэр гарсан. 2002.5.08-нд Улаанбаатар сан нэр бүхий 6 иргэнтэй хамтран 100 сая төг-ийн дүрмийн сантай Улаанбаатар даатгал ХХК байгуулж мөнгө гаргах болов. 2005.7.01-д бас л дүрмийн санг нэмэх шаардлагын дагуу хувь нийлүүлэгч иргэд нь дүрмийн сангаа 500 сая төг. хүртэл өсгөж Улаанбаатар санд ногдох хувийг 8% болгосон байдаг.

25 дугаар зүйл. Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлагаас нийслэлийн өмнө хүлээх үүрэг

25.1. Нийслэлийн дүүрэг, хорооны удирдлага тухайн нутаг дэвсгэртээ энэ хуулийн хэрэгжилтийг хариуцна.

Албан тушаалтан нийслэлийн өмнө үүрэг хүлээнэ гэдэг эргэлзээтэй хэллэг юм. Албан тушаалтан хуулиар оногдсон эрхээ хэрэгжүүлэх, ажлаа дээд шатныхаа удирдлагын өмнө хариуцахад л энэ зүйл заалтын утга санаа оршиж байгаа юм.

26.1. Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэг, хүндэтгэлийн дуутай байна.

26.2. Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хүндэтгэлийн дууг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

27.1. Нийслэлийг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэнийг "Нийслэлийн хүндэт иргэн" -д өргөмжлөх болон бусад шагналаар шагнана. "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

27.2. "Нийслэлийн хүндэт иргэн"-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

(26.1.) Орон нутгийн засаг захиргааны бие даасан нэгж “туг, сүлд тэмдэг, хүндэтгэлийн дуутай” байх эсэх нь энд, биш тэнд [түүгээрээ] шийдэгдэж байвал илүү зохимжтой юм. Энэ заалтаар заавар сүлдтэй байхыг “үүрэгдэж” байгаа нь илт байна.

(27.1.) Улсын Их Хурлын [тодорхой] бүрэн эрхийн жагсаалтад шагналын асуудал орж, парламент ямар хүрээнд шийдвэр гаргах хязгаар нь тодорхой болсон. Тэр хязгаар дотор “байгууллагын шагнал” байхгүй. Үндсэн хуулийн 25.13-т “улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох” тухай л заажээ. Хэдийгээр, Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болно, гэдэг ч тэр нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд тодорхой “тоочиж заасан жагсаалт”-ын гаднах хүрээнд хамаатай.

Аймаг хотын шагнал бий болгоно гээд эрх бүхий субъектээс санаачлаад ороод ирвэл ... асуудлыг түүгээрээ шийд гээд буцаах аргумент үлдээх хэрэгтэй. Нийслэлийн шагнал бий болгох асуудлыг Засгийн газрын тогтоолоор шийдэж болно.

28 дугаар зүйл. Нийслэлийн бүртгэл, мэдээлэл, судалгааны байгууллага

28.1. Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.

28.2. Нийслэлийн удирдлага нь дэргэдээ хотын хөгжлийн түүх, хэтийн төлөвийг тодорхойлох, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал болон олон нийтийн санаа бодлыг судлах шинжилгээ, судалгааны төвтэй байж болно.

(28.0) Нийслэлийн бүртгэлийн байгууллага, нийслэлийн мэдээллийн байгууллага, нийслэлийн судалгааны байгууллага; Хуулиар баталгаажсан баахан байгууллага байгаагаар харагдаж байна. Хуульд нэр заасан “заавал” байх ёстой тийм байгууллагууд Нийслэлийн засаг даргын Тамгын газрын дотоод бүтцийг оновчтой тогтооход сайнаар нөлөөлөхгүй. Зүйлийн гарчиг агуулгатайгаа нийцээгүй байна.

(28.1) Нийслэлийн телевиз ба нийслэлийн радиогийн тухай ярьж байна уу...аль эсвэл, телевизийн нэвтрүүлэг ба радиогийн нэвтрүүлэгийн тухай ярьж байна уу. Ер нь энэ асуудал их маргаантай хүнд асуудал юм. UBS телевиз буюу Ulaanbaatar Broadcasting System нь 1992 онд байгуулагдсан, [Монгол](#) улсад үйл ажиллагаагаа явуулдаг. Анх нийслэл [Улаанбаатар](#) хотын телевизийн статустай байсан.

2005 онд Олон Нийтийн Радио Телевизийн тухай хууль батлагдсанаар Монголын үндэсний телевиз “олон нийтийн” гэсэн статустай болж өргөн олон нийт, ард иргэддээ, хараат бус мэдээллээр тэгш үйлчлэх хууль зүйн орчин бүрдсэн юм. Ийнхүү олон нийтийн статустай, үндэсний хэмжээний телевиз үүсэн бий болсон нь монголын хэвлэл мэдээллийн түүхэнд гарсан эргэлтийн чанартай үйл явдал гэж үздэг. Дээрээ хараат орших үндэстэй тийм хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дахин төрүүлэхгүй байх нь зөв болов уу.

“Өөрийн” хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байна гэдэг бол удирдлага өөрийнхөө байр суурийг илэрхийлэхийн тулд төсвийн мөнгийг түүгээр дамжуулж өөрт ашигтайгаар зарлагадах зарах эрх боломжтой; байна гэсэн үг. Түүнд тийм боломж олгоно гэдэг бол зарчимд харш осолтой алхам байх болно. “Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боогдуулсан ямар ч хуулийг парламент батлах ёсгүй» гэсэн зарчмын тухай энд тодотгон ярьж байгаа болно.

29.1. Улсын Их Хурлаас тогтоосон нийслэлийн өдрийг жил бүр тэмдэглэнэ.

ОХУ-д Мосгордумын хуралдаанаар хотынхоо баярын өдрийн асуудлыг [өөрсдөө] шийддэг. Орон нутгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх журмыг Москвагийн Засгийн газар тодорхойлно. Москва хотод доорхи баяруудыг тэмдэглэдэг. Үүнд:

1. Нийслэлийн өдөр;
2. Москва хотын сүлд ба далбааны өдөр;
3. Москвагийн улсын их сургуулийн өдөр;

30.1. Нийслэлийн иргэн, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид дараахь зүйлсийг хориглоно:

30.1.1. иргэний бүртгэлгүй оршин суух, төлөвлөлтгүй газар суурьшил үүсгэх болон суурьших;

30.1.2. хуульд заасан зөвшөөрөлгүйгээр газар эзэмших, ашиглах, барилга угсралтын ажил явуулах, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх ашигт халдах, бусдын орц, гарцыг хаах;

30.1.3. инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр ашиглах, гэмтэл учруулах;

30.1.4. хотын ногоон байгууламж, байгалийн болон таримал мод, бут, сөөгийг хугалах, устгах, сүйтгэх;

30.1.5. байгаль орчин, нуур, цөөрөм, гол, горхи, булаг, шандыг ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдуулах;

30.1.6. хий, шахмал болон боловсруулсан түлш, нүүрс, мод, цаас, малын гаралтай түлшнээс өөр хорт утаа ялгаруулдаг зүйлсийг түлшинд хэрэглэх;

30.1.7. суурьшлын зөвшөөрөгдөөгүй бүсэд мал аж ахуй эрхлэх.

(30.1.6) Иргэдээ ядуурлаас гаргах ... том зорилт шийдэгдэхийн хэрээр дурдсан зөрчил багасч асуудал аажмаар дээрдэнэ. Ядуу иргэд аргагүйн эрхэнд үнэгүй юм олж (тэр нь бас хог) түлдэг. Байдал ийм байхад шууд хууль гаргаад торгоод байх нь зөв үү ... ингэж иргэнийг эрх бүхий албан тушаалтны "барьцаанд" оруулж болохгүй. Ийм зөрчил гаргасан иргэнийг Хорооны засаг дарга 100000 хүртэл төг-өөр торгох (34.1.7)-оор зохицуулагдсан байна.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

31.1.1. энэ хуулийн 15.1.1-15.1.3, 15.1.5-15.1.9-т заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000 төгрөгөөр торгох;

31.1.2.энэ хуулийн 24.1.3-24.1.5-д заасныг зөрчсөн иргэнийг 50000-100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох;

31.1.3. энэ хуулийн 30.1.1 - 30.1.3, 30.1.5 - 30.1.7 -д заасныг зөрчсөн иргэнийг 50000 - 100000, аж ахуйн нэгж, байгууллагыг 300000-1000000 төгрөгөөр торгох;

31.1.4. энэ хуулийн 30.1.4-т заасныг зөрчсөн бол хугалсан, устгасан мод, бут, сөөгийг ширхэгээр, сүйтгэсэн цэцэг, зүлгийн эзлэх талбайн хэмжээг 5 дахин өсгөсөн хэмжээгээр нөхөн сэргээлгүүлэх, эсхүл иргэнийг 50000-150000, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000-500000 төгрөгөөр торгох;

31.2. Энэ хуулийн 15.1.4 -т заасныг зөрчиж Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлийн бүсэд оршин суугаагүй иргэнд нийслэл хотын хангамж, үйлчилгээ үзүүлэхгүй бөгөөд үүдэн гарах хохирлыг тухайн этгээд хариуцна.

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдож үүссэн харилцааг бие даасан тусгай хуулиар зохицуулдаг. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн энэ бүлэг заалтыг Захиргааны хариуцлагын тухай хууль руу шилжүүлж болно.

Дүгнэлт

1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар, нийслэлийн “... өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор” байх [Үндсэн хуульд онцолж дурдсан] тэр чадамжийг нэмэгдүүлэхийг зорьсон нь төслийн танилцуулга тайлбарт дурдагдсан. Гэхдээ их хот, өөрийн удирдлагын хүрээн дэх хамаг асуудлыг өөр газрын ... дээд газрын хуулиар “заалгаж” шийдүүлэхээр “төлөвлөсөн” нь, эргээд нийслэлийн “өөртөө эзэн байх” хожмын эрх ашигт уршигтай тусах урьдач нөхцлийг бий болгосон байна.

2. Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, бүхэлдээ Үндсэн хуулийн алдаа дутагдалд хүлэгдсэн ... холбогдох олон хуулийн эмхтгэл чиглэл рүү хэлбийсэн агуулгатай, үнэндээ, “хот” ба “нийслэл” ухагдахууны чанарын ялгааг ч тодруулж тооцоогүй ... баримт бичиг болжээ. Тийм учраас Үндсэн хуулийн IV бүлгийг янзалтал түүнийг санаачлагчид нь түр буцаах боломжийг авч үзмээр байна.

3. Үндсэн хуулийг өөрчлөх хэцүү. Энэ бол хүнд даваа, том саад юм. Учирсан саад бэрхшээлээс халган тойрч ... бие даасан хуулийн агуулгад “өнгө заслын өөрчлөлт” хийх замаар аргацаах байдалтай явсаар бид олон жилийг үдэв. Доод талдаа, дээд газрын бүтээлч шийдвэрийг хүлээсээр сүүл сүүлдээ бүр цөхөрч, хуулийн төсөлд, үндсэн хуулийн үзэл санааг гуйвуулан гүжирдэх, илт эргэлзээтэй санаа оноо шургуулах, тэгсэнээ мэдэн будилж нүд анин зүтгүүлэх, хуулийн төслийг агуулгын хэмжээг нүсэржүүлэн илэрхий дутагдлын анзаарагдахгүй байх боломжийг ихэсгэх, хэлэлцүүлгийн шатанд өрнөх зарчмын шинжтэй том маргааны сүүдэрт халхлагдсаар “гэм зэмгүй сэм хоцордог жижиг хирнээ уршигт заалтуудын ногоон гэрлээр нэвтрэх” магадлалыг өсгөх ... зэрэг явуур муутай арга руу [санамсаргүйгээр] хальтрах шинжтэй болж ирж байна. Үүнд холбогдох зарим тодорхой жишээг бид өмнө дэлгэрэнгүй дурдсан.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн 13.1-т, «улсын нийслэл-Улаанбаатар, Улаанбаатар бол хот мөн» гэсэн утга санаа [бол] байгаа. Улаанбаатар бол хот юм. Энэ хотод “Монгол Улсын төрийн дээд болон төв байгууллага, монголд байгаа гадаад орны дипломат төлөөлөгчдийн газар төвлөн оршдог”, зөвхөн үүгээрээ тэр монголын бусад хотоос ялгаатай. Түүнийг бусдаас ялгаж нэрлэсэн гол шалтгаан ерөөсөө энэ юм. Энд нэрлэсэн хэдэн байгууллагыг ирээдүйд өөр газар луу шилжүүлж гэмээнэ “нийслэл” нэр тийшээ дагаад явж “одно”. Тэглээ гээд Улаанбаатар хот нүүхчихгүй ... аймаг, сум болоод хувирчихгүй.

Дахин тэмдэглэхэд, Улаанбаатар бол эхлээд хот ... дараа нь нийслэл юм. Тиймээс одоо хэлэлцэх гэж байгаа шинэчилсэн найруулгын төслийг “Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын ...” гэж нэрлэх боломж байна. Энэ нь, “Нийслэл хотын Засаг дарга бөгөөд УБ бүсийн зөвлөлийн дарга” ... [энэ тэр] гээд жижиг том олон өөрчлөлтийг дэмжсэн алхам болно гэж үзэж байна.

5. Улаанбаатар хотын “нийслэл” гэдэг тодотгол нь, мөн чанартаа, түүний өргөмж нэр, статус юм байна. Одоо хэлэлцэж буй “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь, хэрэг дээрээ, нийслэлийн тухай ч хууль биш, бас зөвхөн Улаанбаатар хотын тухай ч хууль биш, харин монголын “том хотын” тухай хууль юм. Энэ хууль яаж гарахыг, тухайн хуулийн агуулга

ямархан байхыг манай томоохон хэдэн хотын удирдлага харж хүлээж, өдөр тутмын ажил хэрэгтээ, түүнийг төсөөтэйгээр хэрэглэхээр төсөөлж байгаа болов уу.

6. «Монголын хот, тосгон, түүний удирдлага нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн биш, харин “... нэгж доторхи” статустай. Ингэж Үндсэн хуулийн үзэл баримтлалд заасан. Монгол Улс бол хотгүй улс биш, харин хот нь засаг захиргааны нэгждээ харъяалагддаг, төрийн удирдлагын тогтолцооны энгийн хуваарьтай, [энэ талаараа] их цэгцтэй орон» гэсэн хялбаршуулсан тайлбар, хааяа, Засгийн газар талаас гарч байдаг. Хууль хэрэгжүүлэгч гүйцэтгэх засаглалын зүгээс ингэж ярих ёстойг ойлгож болно. 1992 оны Үндсэн хуулийг хүндэтгэж дээдэлсэн үг. Харин хууль тогтоогч тал энэ тайлбарт шууд итгэх ёсгүй. Тэгээд ч, Засгийн газар аргументаа Үндсэн хуулинд гээгүй, “Үндсэн хуулийн үзэл баримтлалд...” гэжээ.

7. Хот тосгоныг жинхэнэ утгаар нь засаг захиргааны нэгж байлгах боломжийг хангасан чанарын үзүүлэлт талаас нь харвал, тухайн асуудал дээр 1960 оны Үндсэн хууль одоогийнхоос хавьгүй дээр байсан байна. 1960 оны Үндсэн хуулийн 46 дугаар зүйлд “... улсын нутаг дэвсгэр засаг захиргааны талаар аймаг, хот болж хуваагдана. Аймаг нь сумдад, хот суурин нь дүүрэг, хороонд тус тус хуваагдана” гэжээ.

8. Өнөө цагт, нийгмийн анархи гэдэг нь тухайн нийгэм хуулийн хомсдолтой байхын нэр биш, харин ч эсрэгээр, учир нь олдохгүй, хаана юу байгаа нь мэдэгдэхгүй, замбараагүйтсэн, хэт олон хуультай байхын нэр гэдэг. Нийслэлийн эрх зүйг шууд ба дамаар зохицуулсан 120 гаруй хууль тогтоомж үйлчилж байгаа ба төсөл батлагдсанаар, дараа дараагийн тодорхой нэр бүхий бие даасан хууль мэндлэх шинэ эрх нээгдэхээр байна. Дараагийн хуулийн орших эрхийг өмнөх хуулиар зарлан баталгаажуулах хэрэггүй байх. Энэ тал дээр бусад хууль Үндсэн хуулийг дуурайх эрхгүйг, учир шалтгааных нь талаас өмнө бид лавшруулж тайлбарласан.

9. Аливаа хууль түүний төслийг, хэрэгжүүлэх эзнээр нь [өөрөөр нь] дам санаачлуулахаар, тэд бүхий л асуудлыг байгууллагын, удирдлагын эрх ашгийн нүдээр харж, өөрсдийнхөө ажлыг хялбаршуулах сэтгэлгээгээр ханддаг. Ингэсний дүнд, иргэдийн эрх ашиг хохирч үлдэх нь элбэг байдаг гэнэ. Тухайлбал, цагдаагийн хуулийг цагдаагаар өөрөөр нь хийлгэж болохгүйн нэгэн адил, нийслэлийн хуулийн төслийг нийслэлийн удирдлагад 100% даатгаж болохгүй. Энэ удаад тэгсэн шинж илэрч ажиглагдав.

10. Үндсэн хуульд зохих өөрчлөлтийг эхэлж оруулалгүйгээр, хот тосгоны болон нийслэлийн эрх зүйн байдлыг тойрсон цогц асуудлыг ... хуулийг найруулах замаар зохицуулах гэж оролдох нь дутуудсан, дарааллын хувьд ч эргэлзээтэй, үр дүнгүй алхам болох эрсдэлтэй байна. Нийслэлийн эрх зүйн байдлын шинэчилсэн найруулгыг, Улсын Их Хурлаар хэлэлцэхдээ, асуудлыг Үндсэн хуулийн холбогдох бүлэг заалттай хамтатгах маягаар нэг мөр цогцоор нь шийдэх чиглэлд анхаарал хандуулмаар байна. Ийм хэрэгцээ шаардлага тулгамдсан шинжтэй болжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн IV бүлэг бүхэлдээ энд, “саатуулагч механизм”-ын үүрэг гүйцэтгэх болсон байна. Эхлээд үндсэн хуулийг өөрчилж, засаг захиргааны нэгжүүдэд өөрийнхөө асуудлыг түүгээрээ [~ бүгдийг] өөрсдөө шийдээд явдаг тийм тогтолцоонд зоригтой шилжмээр байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
3. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль;
4. Act on the structure of the capital city of Warsaw, 15 March 2002;
5. Act on the local self-government of Warsaw, 1994;
6. The Statute of the capital city of Warsaw, 2008;
7. Закон Республики Казахстан "О статусе столицы Республики Казахстан", 24 июля 2007 г.
8. Устав города Москвы, М., 15.02.2006, <http://www.businesspravo.ru/>;
9. Правила регистрации в Москве, Москвагийн Засгийн газрын тогтоол №859, М., 2006.10.31, <http://www.help-hr.ru/catalog/>;
10. Правила о порядке застройки г. Москвы, <http://pravo.levonevsky.org/baza/soviet/sssr6520.htm>;
11. Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа (Ph.D), Б. Буяндэлгэр, Хот тосгоны эрх зүйн орчны шинжилгээ, Бодлогын судалгаа шинжилгээ (эмхтгэл), УБ, 2009;
12. Нутгийн удирдлага (онол, практик, арга зүйн) сэтгүүл,
13. Ю. Эрдэнэтуяа (Ph.D), Г. Чулуун, Хот тосгоны эрх зүйн зохицуулалтын асуудал, Бодлогын судалгаа шинжилгээ (эмхтгэл), УБ, 2009;
14. Бусад;

**СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ЗОХИСТОЙ ХУВИЛБАРЫГ СОНГОХ ЗАРЧИМ***/ Харьцуупсан судалгаа-мэдээлэл /**Ц.Товуусүрэн***а/ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ**

Сонгуулийн тогтолцоо буюу санал хураах тогтолцоо гэдэг нь сонгогч тодорхой хувилбаруудаас өөрийн сонголтыг хийхтэй хопбогдсон харилцаа юм. Сонгуулийн тогтолцоо нь санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журмыг өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцоог судалдаг онолыг *сонгуулийн эрх зүй* гэж хэлбэр талаас нь тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн засаг, математикийн агуулга оршиж байдаг. ОХУ-д сонгуулийн тогтолцоог өргөн хүрээнд, хязгаарлагдмал хүрээнд гэсэн хоёр түвшинд авч үзэж агуулгыг нь тодорхойлдог.

- Иргэнд сонгуулийн эрхийг нээж өгөх, сонгуулийн эрхийн зарчмыг тодорхойлох, хураалтын дүнг нэгтгэж, үр дүнг тодорхойлох зэрэг харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь сонгуулийн эрх зүй гэдэг. Ийм эрх зүйн системийг бүхэлд нь сонгуулийн эрх зүй гэдэг.
- Санал хураалтын дүнг нэгтгэн тодорхойлох журмыг сонгуулийн тогтолцооны хязгаарлагдмал хүрээний тодорхойлолт гэж үздэг.

1936 оны Орос улсын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог өргөн утгаар нь тодорхойлох хүртэл гадаадын улс орнуудын судлаачид сонгуулийн тогтолцоог хязгаарлагдмал хүрээнд тодорхойлж иржээ.

Сонгуулийн саналын агуулга, тойргийн хэмжээ, санал хураалтын дүнг мандатад шилжүүлэн тооцох журам, саналаа тухайлсан нэр дэвшигчийн төлөө, эсвэл түүнийг хамруулж байгаа нам, эвсэл /нэрсийн жагсаалт/-ийн төлөө өгөх зэрэг хувьсах чанартай үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог дор дурдсанаар ангилдаг.

Сонгуулийн тогтолцооны ангилал

Дэлхийн улс орнуудад сонгуулийн тогтолцооны маш олон хувилбар үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь дотроо олон хувилбартай байгаа юм. Үүнийг хялбарчлан сонгуулийн *олонхийг төлөөлөх тогтолцоо*, сонгуулийн *хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо*, сонгуулийн *холимог тогтолцоо* гэсэн гурван ангилалд авч үздэг. Эдгээрийн алинд ч хамааруулж болохооргүй *үл шилжих нэг саналын, хязгаарлагдмал саналын, саналыг дугаарлаж өгөх Бордогийн тооцооны* арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал бас байдаг.

1. Олонхийг төлөөлөх тогтолцоо: Тодорхой нэр дэвшигчээр дамжуулан эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог олонхийг төлөөлөх тогтолцоо гэнэ.

Олонхийг төлөөлөх тогтолцоо нь харьцангуй олонхийн, багц саналын, намын багц саналын, дараалал тогтоож саналаа өгөх альтернатив саналын, хоёр шатлалтай саналын гэх мэт хувилбаруудтай. Сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдох бөгөөд туйлын олонхи $1/50+1/$, харьцангуй олонхи /хамгийн олон санал авсан/, дийлэнхи $1/2/3/$ болон үнэмлэхүй олонхи $3/4/$ -ийн саналаар сонгогдох гэж ангилдаг.

2. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо: Нам эвслийн төлөөллөөр дамжуулан сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо гэнэ. Нам эвслийн авсан саналын хувьтай мандатын тоо нь уялдаж байх ёстой. Хувь тэнцүүлэн

хуваарилах тогтолцоо нь жагсаалт /нээлттэй ба хаалттай/-ын, шилжих бололцоотой нэг саналын гэх мэт олон хувилбартай. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд:

- нам эвслүүдэд суудал хуваарилах тооцоо нь давуу тал олонтой ч зарим талаар хүндрэлтэй
- ихэнхи тохиолдолд сонгуулийн босго тогтоох замаар суудлыг хуваарилдаг
- сонгуулийн босгыг ихэнхидээ тухайн тойрог /улсын хэмжээнд/-ийн сонгуулийн хучинтэй саналын тоог мандатын тоонд харьцуулж тодорхойлдог
- намын нэрийн жагсаалтаас хэдэн хүнд мандат хуваарилагдах вэ гэдэг нь босго саналын тоо тухайн намын авсан саналын тоонд хэд дахин багтаж байгаагаар илэрхийлэгдэнэ.
- үлдэгдэл саналыг хэрхэн хуваарилах нь хамгийн том асуудал.

3. Сонгуулийн холимог тогтолцоо: Олонхийг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Энэхүү тогтолцоог холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ /паралель/ гэж ангилж болно.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдэгээрээ онцлог юм.

Зэрэгцээ (паралель) саналын арга нь сонгогч олонхийг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдөгөөрөө ялгаатай.

Сонгуулийн янз бүрийн тогтолцооны эцсийн үр дүн нь олон янз байж болох бөгөөд ялангуяа илэрхий олонхи байхгүй тохиолдолд бүр ч илүү мэдрэгддэг.

Иймээс сонгуулийн тогтолцоог сонгохдоо хэлбэр талаас нь биш агуулгаар нь авч үзэхийг онолын талаас нь шаардах болжээ.

Сонгуулийн тогтолцооны агуулгад дор дурдсан хүчин зүйлүүдийг зайлшгүй тооцох хэрэгтэй байдаг. Үүнд;

1. Сонгуулийн тогтолцооны агуулгад
 - саналаа илэрхийлэх хэлбэр
 - санал адил жинтэй байх шаардлага
 - саналын босго тогтоох арга
 - сонгуурийн тойрог, сонгогчид хамаарах үндэсний болон хүйсийн онцлогийг тооцож үзэх шаардлага

2. Олон ялагчдыг тодруулах арга
 - хувь тэнцүүлэн хуваарилах арга
 - хагас хувь тэнцүүлэх арга
 - холимог тогтолцооны арга

3. Ганц ялагчыг тодруулах арга
 - нэг болон дараалалд оруулсан саналын арга
 - шилдгийг тодруулах олон шатлалтай саналын арга
 - зэрэглэх саналын арга /саналаа дугаарлаж, хэлэлцүүлэгтэй санал өгөх/
 - нэг ялагчийг шалгаруулах үнэлгээний шалгуур зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

Сонгуулийн олонхийг төлөөлөх тогтолцоогоор 5 удаагийн сонгууль явуулж, түүний давуу болон сул талыг амьдрал дээр мэдэрч, энэ тогтолцоог халах хувилбарыг УИХ бүхэлдээ хүлээн зөвшөөрөх уур амьсгал бүрэлдсэн учраас олонхийг төлөөлөх тогтолцооны талаар үүгээр хязгаарлаж, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны талаар илүү дэлгэрэнгүй авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Харин олон нийтийн дунд тэр дундаа УИХ-ын гишүүдийн дотор ч Үндсэн хуульд заасан "...гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж заасныг "гишүүний төлөө саналаа гаргахгүйгээр намын төлөө саналаа өгвөл шууд бус болно" гэж тайлбарладагаасаа бүрэн татгалзах хэрэгтэй. Үүнээс татгалзах үндэслэл нь сонгуулийн эрх зүйн судлалд сонгогчид

хамааруулсан эрх зүйн үндсийг "нийтээрээ, чөлөөтэй, шууд нууц" гэсэн зарчмууд гэж үздэг. Иймээс "...шууд сонгох эрхийн үндэс..."-ийг сонгогч саналаа гаргахдаа ямар нэг төлөөллөөр дамжуулж гаргахгүй өөрийн биеэр шууд гэж ойлгоход хүргэдэг болохоос нэр дэвшигчийн төлөө эсвэл нам эвслийн төлөө гэдэгт хамааралгүй гэж нэг мөр хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог сонгохдоо парламентад намуудын тоог нэмэгдүүлнэ гэдгийг ухамсартайгаар хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Ер нь аливаа үзэл бодол гудамжинд илэрхийлэгдэх бус парламент дотроо мэтгэлцээн болж байх нь дээр гэдгийг л зөвшөөрнө гэсэн үг.

Төрийн эрх барих, хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагын хувьд сонгогчдын саналыг бодитоор үнэлж, нийгэмд оршиж байгаа олон ургалч үзэл, янз бүрийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг бүрэн тооцох боломжийг нэг танхимд төвлөрүүлдэг нь хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны хамгийн том давуу тал юм. *Сонгуулийн хуваарилах тогтолцоог* агуулга талаас нь авч үзвэл:

- ✓ Сонгогч саналаа шууд, нууц гаргах эрхийн үндсийг бүрэн хангах боломжтой.
- ✓ Сонгуульд нэр дэвшигчийн талаас нь авч үзвэл нам, эвсэл, нам, эвслээс гаргасан нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт, тухайлсан нэр дэшигчийн аль нь ч байж болохоор байна.
- ✓ Нэг сонгогч-нэг санал гэсэн саналын хувийн жин тэнцүү байх боломжийг бүрдүүлж чадна.

Саналын босгыг оновчтой тогтооход онцгой анхаарах нь чухал. Босгыг хэт өндөр тогтоох нь парламент дахь үзэл бодлын төлөөллийн тоог хязгаарлаж, олонхийг төлөөлөх тогтолцооныхоос нэг их ялгаагүй болгодог бол хэт доогуур тогтоовол олонхийн төлөөлөл тогтохгүй, хамтарч Засгийн газраа байгуулахад хүргэдэг сул талуудтай учир энэ босгыг онож тогтоохоос парламентын ардчиллын хувь заяа шийдэгдэх учиртай. Судалгаанд хамрагдсан 75 улсын сонгуулийн тогтолцооноос харахад 11 улс 5%-иар, 13 улс 5-аас доош хувиар, 6 улс (Лихтенштейн 8%, Румыний депутатуудын танхим 8-10%, ОХУ 7%, Шри Ланк (1/3) 12.5%, Швед тойрогтоо 12%, Турк мужийн түвшинд 10%) 5%-иас дээш босго тогтоосон байхад 45 улсад босго тогтоохгүйгээр сонгуулийн үр дүнгээр хүчинтэй саналын тоонд үндэслэн дор дурдсан томъёоны аль нэгээр нуугдмал босгыг тогтоогоод суудлыг хуваарилдаг байна. Нэлээд улс орнуудад саналын босгыг 5% буюу түүнээс доош тогтоосныг ч анхаарах хэрэгтэй

$$\text{Харегийн томъёо } K = \frac{V}{S} : \text{Друпийн томъёо: } K = \frac{V}{S+1}$$

$$\text{Имперал квотын томъёо: } K = \frac{V}{S+2}$$

K- босго саналын тоо
V- Хүчинтэй саналын тоо
S- Мандат(суудал)-ын тоо

$$\text{Сент Лагийн томъёо: } K = \frac{V}{2S + 1}$$

$$\text{D'Hondt-ын томъёо: } K = \frac{V}{S+1}$$

$$\text{Хагенбах Бишхофф-ын томъёо: } K = \frac{V}{S+1}$$

Харе, Сент Лагийн арга нь суудал хуваарилахад жижиг намуудад илүү тааламжтай байдаг бол Друпийн арга нь том намуудад арай илүү, D'Hondt-ын арга нь том намуудад бүр илүү, имперал арга нь хамгийн том намд илүү тааламжтай байдаг байна. Сонгуулийн санал хураасны дараа эдгээр

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

томъёоны аль нэгийг хэрэглэж хүчин төгөлдөр саналаас тооцоо хийхэд тойрогт ч, муж, бүс нутгийн хэмжээнд ч, үндэсний 1 тойргийн хэмжээнд ч босгыг тогтоох боломтой.

Империаал квотын томъёог маш цөөхөн оронд тухайлбал Экватар, Италийн Депутатуудын танхимын сонгуульд хэрэглэдэг.

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд олонхи орнуудад саналын босгыг тогтоохдоо Hare, Droop-ийн босго тогтоох аргыг хэрэглэдэг байна. Харин суудал хуваарилахдаа D'Hondt, Сент-Лагийн аргыг түлхүү хэрэглэдэг байна. Судалгаанд хамрагдсан 75 улсын дотор намуудад суудал хуваарилахдаа D'Hondt-ын аргыг 33 улсад, Сент лагийн аргыг 7 улсад ашигладаг байхад Хагенбах-Бишхоффын зэрэг зарим аргуудыг цөөхөн зарим орнуудад ашиглаж байна. Эдгээрээс дундажийг нь сонгоё гэвэл D'Hondt-ын аргыг сонгож болохоор байна.

Сонгуулийн тойрог, сонгогчид хамаарах онцлогийг сонгуулийн хуульд зөв тусгах хэрэгтэй. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог сонгосон тохиолдолд тойргийг хэд хэдэн хувилбараар байгуулж болох талтай. Тойрогт оногдох суудлын тоо олон байх тутам суудлын хуваарилалт улам илүү хувь тэнцүүлсэн шинжтэй болдог байна. Үүнд:

а/ Улсын хэмжээнд нэг тойрог байгуулах хувилбарыг сонгоход намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт олонхи тохиолдолд хаалттай байдгийг анхаарлын гадна үлдээж болохгүй. Энэ тохиолдолд нэрсийн жагсаалтыг нам дотроо эрэмбэлж тогтоогоод сонгуулийн компаний үед хуульд заасан тодорхой тохиолдлоос бусад нөхцөлд өөрчлөлт оруулахгүй байх механизмыг тогтоох шаардлагатай.

б/ Улсын хэмжээнд олон мандат бүхий хэд хэдэн тойрог байгуулж, тэдгээрт нэр дэвшигчдийг сонгохдоо намын нээлттэй нэрийн жагсаалтаас сонгодог практик хувь тэнцүүлэн хуваарилах сонгуулийн тогтолцоотой олонхи оронд ашиглаж байна. Намуудын нээлттэй нэрийн жагсаалтаас сонголт хийхэд 2 үндсэн аргыг хэрэглэж байна.

- Намаас нэр дэвшигчдийн нээлттэй жагсаалтыг гаргаж тодорхой нэр дэвшигчийн төлөө саналаа өгч, тэр нь намын саналд тооцогддог. Намын нэр дэвшигчдийн нээлттэй жагсаалтаас сонголт хийх хувилбар нь намынхаа нэр хүндийг дагаж, цөөхөн санал авсан том намын нэр дэвшигчид суудал оногдож байхад олон санал авсан жижиг намын нэр дэвшигчид суудал оногдохгүй байх тохиолдол цөөнгүй гардаг нь энэ хувилбарын дутагдалтай тал гэж үзэж байна. Голландад тойрогтоо босго саналын 25%-иас дээш санал авсан нэр дэвшигчид дараалал хамаарахгүй суудал олгогддог байна.

- Намаас нэр дэвшигчдийн жагсаалтад бүхэлд нь дүгнэлт өгч, жагсаалтад нь санал өгөх хувилбар байдаг.

Судалгаанд хамрагдсан сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоо бүхий 75 улсаас 37 нь намын хаалттай жагсаалтыг, 38 нь намын нээлттэй жагсаалтыг журамласан байгаагийн дотор үндэсний хэмжээний 1 тойрогтой тогтолцоонд намын хаалттай жагсаалтыг түлхүү хэрэглэж байна.

в/ Хувь тэнцүүлэн хуваарилах болон олонхийг төлөөлөх тогтолцоо хосолсон холимог хувилбарыг дэлхийн 30 шахам орнуудад ашигладаг. Ер нь холимог тогтолцоог ихэнхи тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэстний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнуудад сонгосон байдаг.

Б/ Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий зарим улс орны эрх зүйн зохицуулалт

Одоогийн байдлаар судалгаанд хамрагдсан дэлхийн 75 улсад сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах, түүнтэй ойролцоо тогтолцоогоор хууль тогтоох дээд байгууллага буюу аль нэг танхимыг нь бүрдүүлж байгаагийн дотор Боливи, Ардчилсан Конго, Герман, Унгар, Шинэ Зеланд, Тайвань, Тайланд зэрэг 18 улсад сонгуулийн холимог тогтолцоог сонгосон байна. Мөн Ази тивийн 11, Европ тивийн 37, Африк тивийн 13, Америк тивийн 14, Австрали, далайн орнуудын 2, Франц, Голландын эзэмшил арлын 4 улсад сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах буюу түүнтэй ойролцоо тогтолцоотой байна. **Сонгуулийн тогтолцоог сонгохдоо түүнд нөлөөлдөг хүчин зүйлүүдийг нэг энгээр нь**

чирч тал тал руугаа зүтгэхгүйгээр тэдгээрийг цогцоор нь авч үзэж нэгдсэн шийдвэрт хүрэх нь хамгийн оновчтой гэдгийг онолын талаас нь тайлбарласан байна.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөхөд хүргэдэг үндсэн 2 шалтгаан байдаг гэж үзэх болсон байна. Үүнд:

1. Улс төрчдийн суурь мэдлэг, мэдээлэл дутмаг байснаас сонгуулийн тогтолцооны хувилбаруудын үр дагаврыг таньж мэдээгүй байх;
2. Улс төрчид сонгуулийн тогтолцооны талаархи мэдлэгээ ашиглаж өөрсдийн намдаа ашигтай хувилбарыг илүүд үзэх,

Сонгуулийн тогтолцоог сонгоход алсаа бодож харахгүй, улс төрийн явцуу эрх ашгийг урьтал болгох нь түүний яваандаа үзүүлэх үр дагаврын улмаас өргөн хүрээний ашиг сонирхлыг хохирооход хүргэдэг.

Сонгуулийн тогтолцооны шинэчлэлийг Италид 1993 онд холимог хувь тэнцүүлэх тогтолцоонд шилжсэнээр эхэлсэн гэж үзэж байна. 1993-2008 оны хооронд дэлхийн 26 улсад сонгуулийн тогтолцоондоо өөрчлөлт оруулахдаа Мадагаскар улсаас бусад нь олонхийг төлөөлөх тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны элементээр баяжуулах эсвэл бүхэлд нь хувь тэмцүүлэн хуваарилах тогтолцоогоор халсан байна.

Гадаадын зарим орнуудын сонгуулийн тогтолцоо

Монгол улсын нийгэм, эдийн засаг, газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, парламентын гишүүдийн тоо зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий зарим улс орнуудын сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг тив, тивийг төлөөлүүлэн түүвэрлэн авч үзье. **Ази тивээс** Израйль, Шри Ланк улсыг сонгов.

1. **Израйль улс** 7.6 сая хүн амтай. 22072 ам.км нутаг дэвсгэртэй. Израйль улсын парламент Кнессет нь 120 гишүүнтэй, Кнессетийн сонгуулийг үндэсний хэмжээний 1 тойрогт намуудын хаалттай нэрсийн жагсаалтаар санал хурааж, D'Hondt-ын аргаар суудлыг хуваарилдаг байна. Намуудын авсан байвал зохих доод саналын босгыг 2%-иар тогтоожээ.

2. **Шри Ланк улс** 20.3 сая хүн амтай, 65610 ам.км нутаг дэвсгэртэй. Шри Ланк улсын парламент 225 гишүүнтэй. Шри Ланк улсын парламентын сонгуулийг хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоогоор явуулдаг. Парламентын гишүүдийн 196-г 4-20 мандат бүхий 22 тойргоос, 29-ийг үндэсний хэмжээний 1 тойргоос намын нээлттэй жагсаалтаар санал хурааж намуудын авсан саналд хувь тэнцүүлэн хуваарилдаг байна. Намуудын авсан байвал зохих саналын доод босго 22 тойрогт тойргийн нийт хүчинтэй саналын 1/3, үндэсний хэмжээний 1 тойрогт D'Hondt-ын томьёогоор тодорхойлохоор заажээ. Сонгогч 1 саналыг дэмжиж байгаа намдаа, 3 саналыг дэмжиж байгаа нэр дэвшигчийн төлөө өгөх журамтай. Нэр дэвшигчийн төлөө өгсөн санал нь суудал хуваарилахад тэдгээрийн эрэмбийг тогтоох хүчин зүйл болдог байна.

Африк тивээс Ангола, Намиби улсыг Хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, нэгдмэл улс гэсэн шалгуураар сонгож авлаа. Энд Ангола улсын хүн амын тоо миний шалгуурт тохирохгүй байгааг дурдах хэрэгтэй. Гэхдээ парламентын гишүүдийн тоо харьцангуй ойролцоо байгаа юм.

3. **Намиби улс** 2.4 сая хүн амтай. 825,4 ам км. нутаг дэвсгэртэйгээрээ манайхтай харьцангуй ойролцоо. Намиби улсын Үндэсний Ассамблей 78 гишүүнтэй, 6 гишүүнийг Ерөнхийлөгч ажлын туршлага, мэргэжил чадварыг нь харгалзан томилдог, таслах эрхгүй 72 гишүүнийг бүх ард түмнээс шууд нууцаар сонгохдоо улсын хэмжээнд 1 тойрогт хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны намын хаалттай жагсаалтаар сонгууль явуулдаг бөгөөд суудлыг D'Hondt-ын аргаар хуваарилдаг байна.

4. **Ангола улс** 13.5 сая хүн амтай, 1246.7 ам км нутаг дэвсгэртэй. Ангола улсын Үндэсний Ассамблей 220 гишүүнтэй, 90 гишүүнийг улсын 18 мужийн 18 тойргоос, 130 гишүүнийг улсын хэмжээний 1 тойргоос сонгохдоо хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны намын хаалттай жагсаалтын аргыг хэрэглэдэг. Суудлыг D'Hondt-ын аргаар хуваарилдаг байна. **Европ тивээс** сүүлийн үед ЗХУ-ын бүрэлдэхүүнд байгаад бие даасан улс болсон Латви, парламентын олон жилийн уламжлал бүхий Дани, Финлянд улсыг сонгож авлаа.

5. **Латви улс** 2.2 сая хүн амтай, 64589 ам км нутаг дэвсгэртэй. Латви улсын нэг танхимтай парламент-Сейм нь 100 гишүүнтэй Сеймийн сонгуулийг 14-29 мандат бүхий 5 тойрогт намаас нэр дэшигчдийн нэрсийн жагсаалтыг сонгох хэлбэрээр явуулдаг. Тойргийн хэмжээнд сонгуульд намуудын нэрсийн жагсаалтад өгсөн саналыг хувь тэнцүүлэн хуваарилахдаа Сент Лагийн аргаар хуваарилдаг. Энэ аргын үндэс нь намуудын тойрогтоо авсан саналын нийлбэрийг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 ... гэх мэтээр мандатын тоо хүртэл тоонд хувааж, гарсан ногдворт багтсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцох бөгөөд дутсан суудалд их үлдэгдлийг харгалзан суудал хуваарилдаг арга юм.

6. **Дани улс** 5,5 сая хүн амтай, 43,1 мянган ам км. нутаг дэвсгэртэй. Дани улсын парламент нэг танхимтай, 179 гишүүнтэй, Фолкетинг гэж нэрлэгддэг. Парламентын сонгуулийг олон мандат бүхий 10 тойрогт намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг эсвэл аль нэг нэр дэвшигчийг сонгох (намыг сонгосонд тооцогдох) журамтай. Тойргийн хэмжээнд намуудаар саналын дүнг нэгтгэж, Сент Лагийн арга, Харегийн босго тогтоох аргын боловсронгуй болгосон хувилбарыг ашигласнаар жижиг намуудыг илүү дэмждэг хувилбарт тооцогддог байна. Энэхүү аргын дээр дурдсанаас ялгагдах онцлог нь 1-ээс эхлэн мандатын тоо хүртэл сондгой тоонд хувааж, парламентын 135 суудлыг хуваарилсаны дараа үлдэгдэл суудлыг улсын хэмжээнд 2%-иас дээш санал авсан намд суудал хуваарилах, тойргуудын суудал хуваарилалтыг тэнцвэржүүлэх зорилгоор нөхөн хуваарилдаг байна.

7. **Финлянд улс** 5.3 сая хүн амтай, 338.4 мянган ам км нутаг дэвсгэртэй. Финлянд улсын парламент нэг танхимтай. 200 гишүүнтэй, Eduskunta гэж нэрлэгддэг. Парламентын сонгуулийг Арланд арал 1 мандаттай 1 тойрогт олонхийг төлөөлөх зарчмаар, эх газарт 6-34 мандат бүхий 14 тойрогт хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны намын нээлттэй нэрийн жагсаалтаас зөвхөн нэг нэр дэвшигчийг сонгогч сонгох хувилбарыг хэрэглэдэг. Нэр дэвшигчид өгсөн санал нь намын саналд тооцогдох бөгөөд D'Hondt-ын аргаар суудлыг хуваарилдаг.

Америк тивээс Парламентын гишүүдийн тооны хувьд манайтай ойролцоо Перу, Парагвай, Гайана улсыг сонгож авлаа.

8. **Перу улс** 29,1 сая хүн амтай, 1285.2 мянган ам км нутаг дэвсгэртэй. Перу улсын парламент нэг танхимтай Конгресс 120 гишүүнтэй. Парламентын сонгуулийг олон мандат бүхий 25 тойрогт нам, эвслийн нэрийн хаалттай жагсаалтаар санал хураах хувилбарыг хэрэглэдэг. Суудлыг их үлдэгдлийн аргаар хуваарилдаг байна.

9. **Парагвай улс** 6.3 сая хүн амтай, 406.7 мянган ам км нутаг дэвсгэртэй. Парагвай улсын Депутатуудын, Сенатын гэсэн 2 танхим бүхий парламентыг Конгресс гэж нэрлэдэг. Депутатуудын танхим 30 гишүүнтэй, Сенатын танхим 45 гишүүнтэй. Депутатуудын сонгуулийг олон мандаттай 18 тойрогт намын нэрийн хаалттай жагсаалтаар, Сенатын сонгуулийг 45 мандат бүхий 1 тойрогт намын нэрийн хаалттай жагсаалтаар санал хурааж, хувь тэнцүүлэн хуваарилдаг байна.

10. **Гайана улс** 772.3 мянган хүн амтай, 215 мянган ам км нутаг дэвсгэртэй. Гайана улсын парламент-Үндэсний Ассамблей нь нэг танхимтай, 70 гишүүнтэй Үндэсний Ассамблейн гишүүдийг 40 мандат бүхий 1 тойрог болон хэд хэдэн мандат (бүгд 25) бүхий 10 тойрогт намын нэрийн жагсаалтаар санал хурааж, Харегийн саналын босго тогтоох аргаар хамгийн их үлдэгдлийн аргаар суудлыг нам эвслийн авсан саналтай хувь тэнцүүлэн хуваарилдаг байна. 5 гишүүн нь томилогддог.

Далайн орнуудаас Шинэ Зеландыг сонгож авав.

11. **Шинэ Зеланд улс** 4.4 сая хүн амтай, 268 мянган ам км нутаг дэвсгэртэй. Шинэ Зеланд Улсын парламент 1 танхимтай, Төлөөлөгчдийн танхим гэж нэрлэдэг. Төлөөлөгчдийн танхим 120 гишүүнтэй. Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн 70 нь олонхийг төлөөлөх тогтолцоогоор 1 мандат бүхий тойргоос сонгогдох ба үүний дотор 7 нь уугуул маори үндэстний тойрог байдаг. 50 нь үндэсний хэмжээний 1 тойргоос намын хаалттай нэрийн жагсаалтаар сонгогдоно. Сонгогч нэр дэвшигчид 1, намын нэрийн жагсаалтад 1 бүгд 2 санал өгнө. 5%-ийн саналын босготой.

в/ Сонгуулийн хүчин зүйлийн нөлөөлөл

Сонгуулийн тогтолцооны нөлөөлөл			Сонгогч саналаа гаргах чиглэлийн нөлөөлөл			
Олонхийг төлөөлөх	Хувь тэнцүүлэн хуваарилах	Холимог	Намын нэрийн жагсаалтад	Нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад	Тухайлсан нэр дэвшигчид	
					Олонхийг төлөөлөх тогтолцоо	Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо
Давуу талууд						
Том намуудад давуу тал үүсгэдэг. Төрийн эрхийг том намууд тогтвортой барих нөхцөл бүрдүүлнэ.	Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ	Олонхийг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товойлгох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой.	Жижиг намуудад суудал ногдох боломжийг илүү бүрдүүлнэ. Хувь тэнцүүлсэн шинж улам тодрох, санал адил жинтэй байх, санал өгөх, тооцоход хялбар, хүйсийн тэгш байдал, үндэстний асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.	Намын нээлттэй нэрийн жагсаалт байдгаараа сонгогчид илүү ойлгомжтой. Жижиг намуудад суудал ногдох боломж давуутай.	Цөөн намын нөлөөг нэмэгдүүлж, олонхийн Засгийн газар бүрдэж, хариуцлага, нэг хүчинд төвлөрнө.	Парламентад хэд хэдэн нам орж, ялангуяа жижиг нам суудал авах магадлал өснө. Намын доторх нэр дэвшигчдийн сонгогдох дараалалд сонгогч нөлөөлөх боломж бүрдүүлнэ.
Дутагдалтай талууд						
Сонгогчдын саналын багагүй хэсэг парламентад тусгалаа олохгүй байх сул талтай	Засгийн газраа намууд нэгдэж байгуулах, хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй болох, Засгийн газар огцрох магадлал өснө	Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, Парламентад өөр өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай.	Орон нутаг, парламентын гишүүдийн амьд холбоо сулрах, намын лидерүүдийн давамгайл байдал тогтох, эсвэл нөлөө багатай, үгнээс гардаггүй хүмүүсийг жагсаалтдаа оруулах, намын доторх эрүүл санал бодлыг үл хүндэтгэх талтай	Парламент олон намын оролцоотой болж, Засгийн газрыг намууд хамтарч бүрдүүлэх тохиолдол элбэг байдаг.	Сонгогчийн өгсөн саналын нэлээд хэсэг нь парламентад тусгалаа олохгүй гадна талд нь үлддэг.	Намын нээлттэй нэрсийн жагсаалтаас сонголт хийх нь Сонгуульд оролцож байгаа нам бүрээр нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гаргаж сонгогч бүр түүнээс сонголт хийхэд төвөгтэй.

Монгол улсын нөхцөлд						
Манай улсын хувьд энэ тогтолцоог өөрчлөх сэтгэлзүйн бэлтгэл хангагдсан.	Манай улсын хувьд энэ тогтолцоог сонгох чиглэлээр 2 өөр төсөл өргөн баригдсан. Энэ тогтолцоог сонгоход, манай улсын хүн ам сийрэг, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ томд тооцогддог харьцангуй төвлөрөл ихтэй зэрэг нөхцөл байдлаа үнэлэн энэ тогтолцооны ямар хэлбэр, суудал хуваарилах аль аргыг сонгохоо зөв шийдэх шаардлагатай	Манай улсын хувьд төвөөс алслагдсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж олонтой, тэнд ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн эрх ашгийг парламентад тооцдог байх талаасаа тохиромжтой байж болох талтай.	Манай улсын хувьд цэвэр, ба холимог тогтолцоог сонгосон тохиолдолд улс 1 тойрог гэж үзвэл намын нэрийн хаалттай жагсаалтыг сонгох нь онолын хувьд тохиромжтой.	Манай улсын хувьд улсын хэмжээнд олон мандат бүхий цөөн тойрог байгуулна гэж үзвэл намын нэрийн нээлттэй жагсаалтад санал өгөх хувилбарыг сонгох нь тохиромжтой.	Манай улсын хувьд сонгуулийн холимог тогтолцоог сонговол олонхийг төлөөлөх хэсэгтээ нэг нэр дэвшигч-нэг санал гэсэн хувилбар байх нь илүү тохиромжтой	Манай улсын хувьд улсын хэмжээнд цөөн мандат бүхий олон тойрог байгуулбал тодорхой нэр дэвшигчийн төлөө санал өгөх хувилбарыг сонгох нь дээр.

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны босго тогтоох аргуудын нөлөөлөл				Босгыг урьдчилан тогтоохын нөлөөлөл		Тойргийн хэмжээ, тооны нөлөөлөл		
Харегийн арга	Сент Лагийн арга	Друпийн арга	Империал арга	Өндөр босго	Бага босго	Улс 1 тойрог/том/	Олон мандаттай цөөн тойрог	Цөөн мандаттай олон тойрог
Давуу талууд								
Жижиг нам парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Жижиг намууд парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Томоохон намуудын суудлын тоог нэмэгдүүлэх магадлал илүү.	Томоохон намуудын суудлын тоог нэмэгдүүлэх магадлал бүр илүү.	Томоохон намууд үүнийг сайшаан дэмжинэ.	Жижиг намуудын парламентад суудал авах магадлалыг өсгөнө.	Намуудад суудал хувь тэнцүүлэн хуваарилах шинж чанарыг өсгөнө	Намуудад суудал хувь тэнцүүлэн хуваарилах шинж чанарыг өсгөнө	Нэр дэвшигчдийг сонгогчтой илүү ойр дотно байлгах нөхцлийг бүрдүүлнэ.
Дутагдалтай талууд								
Томоохон намууд энэ аргаас аль	Томоохон намууд энэ аргаас аль	Жижиг намуудад төдийлөн	Жижиг намууд энэ аргаас аль	Жижиг намууд, бие даасан нэр	Томоохон намуудын суудлыг	Парламенты н гишүүд орон нутгийн	Сонгуулийн газар зүйн зургийг	Намуудын суудал хуваарилалт олонхийг төлөөлөх

болох зайлсхийнэ.	болох зайлсхийнэ.	таатай биш.	болох зайлсхийнэ.	дэвшигчид суудал авах магадлалыг бууруулна	жигжиг намууд хуваалцана.	хоорондын харилцаа суларна.	тусгайлан гаргаж, засаг захиргааны олон нэгж 1 тойрогт хамрагдана.	зарчимд илүү ойртож сонгогчийн санал парламентад тусгалаа олохгүй байх магадлалыг өсгөнө.
Монгол улсын нөхцөлд								
Манай нөхцөлд улс терийн 2 том намын дэмжлэг авах магадлал багатай	Манай нөхцөлд энэ аргыг сонгоход жигжиг намуудад тааламжтай ч том намуудын зүгээс дэмжлэг авах магадлал багатай.	Дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрөгд- дөгөөрөө энэ аргыг сонгох магадлал өндөр	Энэ аргыг хэрэглэдэг улс орон маш цөөн бөгөөд Италид ашиглаж байгаад больсон. Экваторт одоо ашигладаг. үүнийг авч ашиглахгүй байх нь дээр.	Манай хувьд үндэстний салан тусгаарлах үзэл санаатай нам, эвсэл байхгүй учраас саналын босгыг өндөр (5%- иас дээш) тогтоохгүй нь дээр	Парламенты н суудлыг хувь тэнцүүлэн хуваарилах үед санал хураасны дараа улсын дүнгээр нам тус бүрийн хүчинтэй саналаас Друпийн томъёогоор тогтоож болно	Улс 1 тойрог хувилбарыг сонговол намын хаалттай жагсаалтыг сонгох нь дээр. Энэ хувилбар бол цэвэр парламен- тын эрх мэдэл давуу улсад байдаг	Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль ч хувилбарт намын нээлттэй жагсаалтаар сонгууль явуулахад тохирно	Том намууд энэ хувилбарыг дэмжих магадлал өндөр, Цэвэр хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд тохиромжгүй

Г. Санал зөвлөмж

Монгол улсын хувьд сонгуулийн тогтолцооны аль нэг хувилбарыг сонгох нь хууль тогтоогчдын бүрэн эрхийн асуудал хэдий ч сонгуулийн тогтолцооны онол, арга зүйн зарим асуудлыг судалж үзсэний үндсэн дээр монголын ард түмэн, түүнийг төлөөлж байгаа хууль тогтоогчдын өмнө сонгуулийн тогтолцоо, сонгогч саналаа гаргах хувилбар, саналын босго тогтоох арга, босгын хэмжээ, тойргын тоо зэрэг нөлөө бүхий үзүүлэлтүүдээр том, жижиг намын аль альных нь эрх ашгийг бодолцож тооцсон хувилбар байх нь зохистой. Ийм учраас дор дурдсан хувилбарын аль нэгийг сонгох нь манайд илүү тохиромжтой байж болох үндэслэлтэй.

1. Сонгуулийн холимог тогтолцоог сонгох дор дурдсан үндэслэл байна гэж үзэж байна:

а/ Манай улс хүн амын тоо цөөн ч нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд харьцангуй томд тооцогдох бөгөөд сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл түргэсч байгаа нь орон нутгийн ашиг сонирхол парламентад илэрхийлэгдэж байх шаардлагыг өсгөж байгааг харгалзан үзэхэд хүргэж байна. Нөгөө талаар улс төрийн намуудын төлөвшилийг төгөлдөршүүлэх, саналаа илэрхийлэх хэлбэр нь сонгогчдод хялбар байх, сонгуулийн тогтолцоо, суудал хуваарилах арга саналын босгын хэмжээ, тойрог байгуулах хэлбэр нь том, жижиг аль ч намын зүгээс илэрхий эсэргүүцэхгүй, дундажийг барьсан хувилбар байх нь чухал болоод байна. Эдгээр шаардлагыг тооцон үзэх аваас *сонгуулийн холимог тогтолцоог* сонговол орон нутгийн төлөөллийг хангах, том болоод жижиг намын аль нь ч эрс эсэргүүцэхгүй байх, тойргийг одоогийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваариар хийснийг үндсэнд нь хадгалах боломжтой бөгөөд харин нэг мандатад ногдох сонгогчдын тоо харьцангуй тэнцүү байхаар тооцож тойрогт ногдох мандатын тоог өөрчлөх нь зүйтэй. Намууд тойргуудад мандатын тоогоор нэр дэвшүүлнэ. Нэг сонгогч-нэг санал гэсэн зарчмыг баримтлан сонгогч зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө. Саналын дүнг нэгтгэхэд тухайн тойрогт Друпийн томъёогоор тогтоосон босго саналаас дээш хамгийн олон санал авсан 1 нэр дэвшигчийг сонгогдсонд тооцож, сонгогдсон нэр дэвшигчийн босго саналаас дээшхи санал болон бусад нэр дэвшигчдийн авсан саналыг улсын хэмжээнд нам эвслээр нь нэгтгэж дүнг гаргана. Ингэж нэгтгэсний дараа нам, эвслүүдэд суудлыг хувь тэнцүүлэн хуваарилна. Хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт саналын босго тогтоохоор шийдвэр гаргавал Үндэсний хэмжээнд 5%-иас илүүгүй байх нь олон улсын жишигт илүү нийцнэ. Ер нь урьдчилж босго тогтоохгүй нуугдмал босготой байж ч болно. Улсын хэмжээнд саналыг нэгтгэсний дараа бүх хүчинтэй саналын нийлбэрээс

V

Друлийн томъёо ($K = \text{-----} + 1$)-гоор босго саналын босгыг тогтоож, түүнээс

S+1

дээш санал авсан нэр дэвшигчдэд суудлыг хуваарилахдаа нэр дэвшигчдийн санал авсан дарааллыг баримтална. Үлдэгдэл суудлыг D'Hondt-ын их үлдэгдлийн аргаар хуваарилна. Энэхүү хувилбарт дүн шинжилгээ хийж үзвэл:

а/ *Сонгуулийн холимог тогтолцоо* том, жижиг аль ч нам хүлээн авах боломжтой. Аль ч намд тааламжтай.

б/ Саналаа зөвхөн нэр дэвшигчийн төлөө гаргах нь нэг сонгогч-нэг санал гэсэн тэгш зарчмыг хангах бөгөөд сонгогчид илүү хялбар байгаа тул улс төрийн үзэл бодлоос үл хамааран бүх хүн хүлээн зөвшөөрөх боломжтой. Аль ч намд тааламжтай.

в/ Хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогдож орон нутгийг төлөөлөх боломж бүрдүүлж байгаа ч хувь тэнцүүлэн хуваарилах аргаар сонгогдсон гишүүд бусад гишүүдтэй яг адилхан саналын зарчмаар сонгогдсон учир шүүмжлэлд өртөхгүй байх боломжтой. Аль ч намд тааламжтай.

г/ Сонгуулийн босгыг 5%-иас дээш тогтоох үндэстний болон улс төрийн хүчин зүйл манай улсад байхгүй учраас %-иас доош тогтооход том намууд жижиг намууддаа боломж олгох улс төрийн эр зориг гаргахаас өөр юуг ч шаардахгүй. Жижиг намд тааламжтай.

д/ Үлдэгдэл саналыг их үлдэгдлийн арга/ D'Hondt-ын арга/-аар хуваарилах нь том намуудад тааламжтай.

Энэ бүхнээс үзэхэд сонгуулийн холимог тогтолцооны энэ хувилбарыг сонгосноор дээр дурдсан 5 шалгуураас 3 нь аль намд тааламжтай, 1 нь жижиг намд, 1 нь том намд тааламжтай байгаа учраас эсэргүүцээд байх шалтгаан байхгүй байна. Норвеги, Румыний жишгээр авч хэрэглэх боломжтой байна.

2. Цэвэр хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоог сонгоно гэвэл дор дурдсан хувилбарыг сонгох нь тохиромжтой гэсэн дүгнэлт энэ судалгаанаас гарч байна

а/ Улсын хэмжээнд нэг тойрог байна гэж үзвэл цэвэр парламентын эрх мэдэл давамгайлсан улсуудад түгээмэл байдгаараа тохиромжтой мэт боловч манайх шиг Ерөнхийлөгчийн эрх мэдэл харьцангуй өндөр улсад яг тохирно гэхэд эргэлзээтэй. Харин энэ системийг сонгоход хүрвэл:

- Намын нэрийн хаалттай жагсаалтаар нэг сонгогч-нэг санал гэсэн саналын хэлбэрийг авах
- Намуудын саналын босгыг үндэсний хэмжээнд 5%-иас дээшгүйгээр тогтоох
- Үлдэгдэл саналыг D'Hondt-ын их үлдэгдлийн аргаар хуваарилах

Ингэснээр том, жижиг намуудын сонирхол харилцан тэнцвэржих боломж бүрдэнэ.

б/ Улсын хэмжээнд 1-ээс дээш тойрог байна гэж үзвэл Л.Болд нарын өргөн барьсан хувилбараар 5-аас илүүгүй тойрог байх нь сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах зарчмыг илүү илэрхийлэх бөгөөд олонхийг төлөөлөх зарчмаасаа татгалзсаныг ч тод харуулах болно. Энэ тохиолдолд сонгуулийн газар зүйн зургийг тусгайлан гаргаж 2 сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд түүнийг шинэчилж байхаар зохицуулах нь зөв болов уу. Санал гаргахдаа сонгогч нэг саналыг намын нэр дэвшигчдийн жагсаалтын төлөө, нэг саналыг нэр дэвшигчийн төлөө өгнө. Энэ нь сонгогч саналаа илэрхийлэх хэлбэрийн хувьд хялбар, намуудаас гаргасан нэрсийн жагсаалтыг үндэслэн намыг сонгох, нэр дэвшигчдийг нь сонгогч дараалалд оруулах зэрэг давуу талтай. Энэ тохиолдолд нуугдмал босготой байх нь дээр бөгөөд санал хураалтын дүнгээр тойрог тус бүрт Друпийн томъёогоор босго тогтоож, суудлыг намуудад хуваарилахдаа нэр дэвшигчдийн авсан саналын дарааллаар нам доторхи суудал хуваарилагдана.

в/ Хүйсийн тэгш байдлыг хангах зорилгоор 6-9 мандаттай эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан үндэсний хэмжээний 1 тойргийг зарим нэг улсын жишгээр зохион байгуулж болох юм.

Сонгуулийн холимог тогтолцоотой улсуудын судалгаа а/ Холимог тогтолцоотой

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Жагсаалтын хэлбэр	Босгын %	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Бүх суудал(Хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал)
1.	Боливи –дээд --доод	Нэр дэвшигчид Нэр дэвшигчид	Нээлттэй нээлттэй	Нуугдмал нуугдмал	Намын нэрийн олонхоор Их үлдэгдлийн	4 мандаттай 9 тойрог Олон тандаттай 9 тойрог	130/60 36/36
2.	БНА Конго -доод дээд	Нэр дэвшигчид Нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад	Нээлттэй нээлттэй	Нуугдмал нуугдмал	Харегийн их үлдэгдлийн Их үлдэгдлийн арга	109 олон мандаттай тойрог Муж бүр 1 тойрог	500/440 108/108
3.	ХБНГУ Бундестаг	Нэр дэвшигчид, намд	нээлттэй	5%	Сент Лагийн	Олон мандаттай 16 тойрог	598/299
4.	Литва	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	141/70
5.	Шинэ Зеланд	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	5%	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	120/50
6.	Тайланд	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	10 мандаттай 8 тойрог	480/80
7.	Япон -доод -дээд	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	Нээлттэй нээлттэй	Нуугдмал нуугдмал	D`Hondt D`Hondt	Олон /6-29/ мандаттай 11 тойрог Үндэсний 1 тойрог 96 мандаттай, (2-10)бүгд 146) мандаттай 47 тойрог	480/180 242/242
8	Лесото	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	40 мандаттай үндэсний 1 тойрог	120/40
9.	Унгар	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	5%	D`Hondt	64 мандаттай 1 тойрог, олон мандаттай 20 тойрог	386/210
10.	Мексик -доод	Намд	Хаалттай	Нуугдмал	Их үлдэгдлийн	200 мандаттай үндэсний 1 тойрог	500/200

	-дээд	намд	хаалттай	нуугдмал	Их үдэгдлийн	32 мандаттай үндэсний 1 тойрог	128/32
11.	Румын дээд, доод танхим	Нэр дэвшигчид	Нээлттэй	5%	D'Hondt	1 мандаттай тойрогт эхний шатанд тооцогдоогүй саналыг үндэсний хэмжээнд нэгтгэж, намуудад хувь тэнцүүлэн хуваарилдаг.	1 мандаттай 315 тойргоос 50%+1 санал авсан нь шууд сонгогдсонд тооцож, үлдсэнийг нь үндэсний хэмжээнд нэгтгэж 10%-ийн босго давсан намд хувь тэнцүүлэн хуваарилна.
12.	Норвеги	Нэр дэвшигчид	нээлттэй	4%	Сент Лаг	19 тойргоос тус бүр 1 нь шууд сонгогдсонд тооцогдож, 150 нь хувь тэнцүүлэн хуваарилагдана.	1699/150
13.	Болгар	Намд, Нэр дэвшигчид	хаалттай	4%	Харе	31 нь олонхийг төлөөлөх тогтолцоогоор 209 нь олон мандаттай 31 тойргоос	240/209
14.	БНСУ	Намд	нээлттэй	3%			299(54)
15.	Тайвань	намд	хаалттай	нуугдмал			225(49)
16.	Украйн	намд	хаалттай	3%	Сент Лаг		450(225)
17.	Венесуэл	намд	хаалттай	нуугдмал	D'Hondt	үндэсний 1 тойрог	164/1 мандаттай тойргийг хассан
18.	Шотланд	Намд-1 санал, Нэр дэвшигчид нэмэлт 1 санал	нээлттэй	нуугдмал	D'Hondt	Олон мандаттай 8 тойрог	129/56

Хавсралт №2

Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой улсуудын судалгаа

№	Улсын нэр	Сонгогч саналаа өгөх субъект	Жагсаалтын хэлбэр	Босгын %	Суудал хуваарилах арга	Тойргийн хэлбэр	Суудлын тоо
1.	Алжир -доод танхим	Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	Сент Лагийн их үлдэгдлийн	Олон мандат бүхий 48 тойрог	389
2.	Ангол	намд	хаалттай	нуугдмал	D'Hondt-ын	Үндэсний 1 тойрог	220
3.	Австрали -дээд танхим	Нэр дэвшигчдийг зэрэглэж	нээлттэй	нуугдмал	D'Hondt-ын	12 мандаттай 6 тойрог, 2 мандаттай 2 тойрог	76
4.	Австри -доод танхим	Намд	Хаалттай	4%	D'Hondt Hare	3-12 мандаттай 9 тойрог	183

	-дээд танхим	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt Hare	7-36 мандаттай тойрог	9	62
5.	Аргентин -Доод танхим -дээд танхим	Намд намд	Нээлттэй нээлттэй	3% -	D`Hondt Тойрогтоо хамгийн их санал авсан намд 2 суудал, дараагийнхад нь 1 суудал хуваарилдаг	Олон мандаттай тойрог 3 мандаттай 24 тойрог	24	257 72
6.	Бельги -доод танхим Дээд танхим	Намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	Нээлттэй нээлттэй	Нуугдмал нуугдмал	D`Hondt D`Hondt	Олон мандаттай тойрог Олон мандаттай тойрог	11 3	150 40
7.	Бразил -доод танхим	Намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	D`Hondt	8-70 мандаттай тойрог	24	513
8.	Буркина- Фасо	Намын нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	15 мандаттай үндэсний хэмжээний 1 тойрог, 2- 10 мандаттай 13 тойрог		111
9.	Бурунди -доод танхим	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	Олон мандаттай тойрог	17	118/100
10.	Камбодж	Намд	хаалттай	нуугдмал	Xape	Олон мандаттай тойрог	21	123
11.	Кабо-Верде	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	2-15 мандаттай тойрог	16	72
12	Колумб -доод танхим -дээд танхим	Намд Намд	Хаалттай хаалттай	Нуугдмал нуугдмал	D`Hondt D`Hondt	Олон мандаттай тойрог 100 мандаттай үндэсний тойрог, 2 мандаттай тусгай тойрог	33 102	166 102
13.	Коста-Рика	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-21 мандаттай тойрог	7	57
14.	Хорват	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	5%	D`Hondt	14 мандаттай тойрог, 8 мандаттай үндэсний тойрог, гадаадад оршин	10	153

						суугчдад зориулсан тойрог /мандатын тоо заагаагүй/	
15.	Кипр	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Харегийн арга	Олон мандаттай 6 тойрог	80
16.	Чех Доод танхим	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	Нам-5% Эвсэл (2 нам)-10% Эвсэл(3 нам)-15% Эвсэл(4 нам)-20%	D`Hondt	Олон мандаттай 14 тойрог	200
17.	Чили -дээд танхим Доод танхим	намд	хаалттай	-	Намын олонхийн систем	13 олон мандаттай тойрог, 60 олон мандаттай тойрог	38 120
18.	Дани	Нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Сент Лагийн	Олон мандаттай 10 тойрог	179
19.	Доминикан -доод танхим	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	Олон мандаттай 29 тойрог, Үндэсний 1 тойрог	183
20.	Экваторын Гвиней	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	Мужийн тоогоор олон мандаттай тойрог	100
21.	Эстони	намд	хаалттай	5%	D`Hondt	6-13 мандаттай 13 тойрог	101
22.	Финлянд	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	нуугдмал	D`Hondt	6-33 мандаттай 14 тойрог	200
23.	Грек	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	3%	Хагенбах Бишхофф	үлүн мандаттай 56 тойрог, 12 мандаттай үндэсний 1 тойрог	300
24.	Гвиней-Бисау	Намын нэр дэвшигчдийн жагсаалт	нээлттэй	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 27 тойрог	102
25.	Гайана	намд	хаалттай	нуугдмал	Харегийн хамгийн их үлдэгдлийн	10 тойрогт 2: суудал, 40 мандаттай үндэний 1 тойрог	65
26.	Исланд	намд	хаалттай	5%	D`Hondt	10-11 мандаттай тойргууд	63
27.	Энэтхэг -дээд танхим	Нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Шилжих нэг саналын	Шууд бус сонгууль	245/233
28.	Индонез -доод танх.	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	2,5%	Заяцын хүчин зүйл	Олон мандаттай 33 тойрог	560

29.	Ирак	Нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал		7-70 мандаттай 18 тойрог	325/318
30.	Израйль	намд	хаалттай	2%	D`Hondt	120 мандаттай үндэсний 1 тойрог	120
31.	Итали -доод танх. -дээд танх.	Намд	хаалттай	2-4%	Олон суудлыг урамшуулах	Олон мандаттай 26 тойрог	630
32.	Латви	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	5%	Сент лагийн	14-29 мандаттай 5 тойрог	100
33.	Лихтенштейн	Нам, нэр дэвшигчийн аль нэгд	нээлттэй	8%	Хамгийн их үлдэгдлийн арга	10,15 мандаттай 2 тойрог	25
34.	Люксембург	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	7-23 мандаттай 4 тойрог	60
35.	Мальта	Нэр дэвшигчийг зэрэглэж	нээлттэй	нуугдмал	үлдэгдлийг дахин хуваарилах	5 мандаттай 13 тойрог	65
36.	Молдав	Намд	хаалттай	Нам-5% Бие даагч-3%	D`Hondt	Үндэсний 1 тойрог	101
37.	Намиби	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Үндэсний 1 тойрог	72
38.	Нидерланд -доод танхим -дээд танхим	Намд намд	Хаалттай хаалттай	0,67%	D`Hondt	Олон мандаттай 18 тойрог 12 мужийн зөвлөл	150 75
39.	Никарагуа	намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	20 мандаттай Үндэсний 1 тойрог, 2-19 мандаттай 17 тойрог	90
40.	Умарт Ирланд	Нэр дэвшигчид	нээлттэй	-	Шилжих 1 саналын		
41.	Парагвай -доодтанхим -дээд танхим	Намд намд	Хаалттай Хаалттай	Нуугдмал Нуугдмал	D`Hondt D`Hondt	Олон мандаттай 18 тойрог. Үндэсний нэг тойрог	80 45
42.	Перу	Намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 25 тойрог	120
43.	Польша -Сейм	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	5%	D`Hondt	7-19 мандаттай 41 тойрог	460
44.	Португали	Намд, нэр дэвшигчид	нээлттэй		D`Hondt	Олон мандаттай 22 тойрог	230
45.	ОХУ Доод танхим	Намын нэр дэвшигчдийн	нээлттэй	7%	Харегийн	Үндэсний 1 тойрог	450

		жагсаалтад					
46.	Сан-Томе ба Принсип	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	Олон мандат 7 тойрог	55
47.	Словак	Намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтад	нээлттэй	5%	Хагенбах Бишхофф	Үндэсний 1 тойрог	150
48.	Словени -доод танхим Дээд танхим	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	4%	D`Hondt	11 мандаттай 88 тойрог, италичуудад зориулсан 2 мандаттай 1 тойрог	90
49.	ӨАБНУ -доод танхим	Намд	хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	4-43 мандаттай 9 тойрог	400
50.	Испани -доод танхим -дээд танхим	Намд намд	Хаалттай хаалттай	Нуугдмал Байхгүй	D`Hondt Шууд бус	Олон мандаттай 50 тойрог, Олон мандаттай 52 тойрог	350 208
51.	Шри Ланк	Намд, нэр дэвшигчид	нээлттэй	1/8 тойрогтоо		4-20 мандаттай 22 тойрог, 29 мандаттай үндэсний 1 тойрог	225
52.	Суринам	намд	хаалттай	нуугдмал	D`Hondt	Олон мандаттай 10 тойрог	51
53.	Швед -Риксдаг	Нэр дэвшигчид	нээлттэй	4% -үндэсний хэмжээнд, 12% тойрог	Сент Лаг	2-34 мандаттай 29 тойрог, 39 мандаттай үндэсний 1 тойрог	349
54.	Швейцари -доод танхим	Нэр дэвшигчид	нээлттэй	нуугдмал	Хагенбах Бишхофф	Олон тандаттай 26 тойрог	200
55.	Турк	Намын нэр дэвшигчдийн жагсаалтад	нээлттэй	10%	D`Hondt	Олон мандаттай 79 тойрог	550
56.	Урагвай -доод танхим -дээд танхим	Намд намд	Хаалттай хаалттай	нуугдмал	Их үлдэгдлийн	Олон мандаттай 19 тойрог, 30 мандаттай үндэсний 1 тойрог	99 31/30
57.	Уэльс	Жагсаалтад-1 санал, Нэр дэвшигчид-1 санал	нээлттэй	нуугдмал	Нэмэлт саналын систем		

Жич: 75 улсын парламентын сонгуулийн зарим үзүүлэлтийг хавсаргав. Зарим арлын болон холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг улсуудын материал бүрэн олдоогүй учир оруулаагүй болно

ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААР

/Лавлагаа, мэдээлэл/

Р.Хатанбаатар

Олон улсын эрх зүйн актуудаар тэгш эрх, улс төрийн эрхийн зарчмыг тунхаглаж, үндэстний шинж тэмдгээр ялгаварлан гадуурхахыг хориглосон нь үндэсний цөөнхийн зүгээс тухайн орны голлох үндэстэнтэй адил тэгшээр улс төрийн амьдралд оролцох эрх зүйн тодорхой суурийг бүрдүүлнэ. Гэхдээ энэ нь тухайн улс орон, үндэстэн бүрийн хувьд өөр өөрөөр хэрэгжсээр иржээ.

Үндэсний цөөнхийн зүгээс улс төрийн амьдралд оролцох эрх зүйн олон төрлийн зохицуулалт байдгаас зөвхөн парламентын сонгуультай холбоотой дараахь зохицуулалтын хэлбэрүүд байдаг байна. Үүнд:

- Сонгуульд оролцоход нь давуу байдал олгох систем
 - Парламентын суудлын квот тогтоох
 - Парламентад үндэстнүүдийн төлөөллийн пропорци тогтоох.
1. Сонгуульд оролцоход нь давуу байдал олгох систем нь юуны өмнө бага санал авсан намууд парламентад ороход саад болдог шаардлагуудаас үндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалсан намуудыг чөлөөлөхөд оршдог. Тухайлбал, ХБНГУ-д ийм практик байдаг. Эдний Холбооны сонгуулийн хуулиар муж улсын жагсаалтаар суудал хуваарилахдаа бүх Германы нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгогчдын 5 хувиас доошгүй хоёрдугаар санал авсан нам юмуу 3-аас доошгүй сонгуулийн тойрогт депутатын мандат авсан намуудыг оролцуулдаг боловч үндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалсан намуудыг энэ шаардлагаас чөлөөлдөг байна. (ХБНГУ-д Холбооны сонгуулиар сонгогч бүр нэгдүгээр саналаа тухайн сонгуулийн тойргоор, хоёрдугаар саналаа улсын хэмжээний сонгуулийн жагсаалтаар тус тус өгдөг). Энэхүү давуу байдал олгох системийг гол төлөв сонгуулийн холимог тогтолцоо бүхий холбооны улсуудад хэрэглэдэг байна.
 2. Цөөн хүнтэйн улмаас парламентад нийтийн адилаар өөрийн төлөөлөлтэй болох бололцоогүй үндэсний цөөнхид зориулсан өөр нэг хөнгөлөлт бол квот тогтоох арга юм. Сонгуулийн процесст квот тогтоох арга нь дэлхийн практикт нилээн өргөн хэрэглэдэг арга болно. Тухайлбал, парламент дахь үндэсний цөөнхийн төлөөллийн квот дэлхийн 50 гаруй улсад байдаг байна.
 - Парламентын доод танхимдаа үндэсний цөөнхийн төлөөлөлийн (1-ээс 10 хүртэл суудал) квоттой Бельги, Дани, Энэтхэг, Иран, Итали, Казахстан, БНХАУ, Пакистан, Португал, Хорват, Румын, Словени зэрэг 35 улс
 - Парламентын дээд танхимдаа үндэсний цөөнхийн квоттой 17 улс тус тус байдаг байна.

Ер нь квотын хэд хэдэн хэлбэр байдаг. Үүнд:

- Бельгид Сенатын 71 суудлаас 21-ийг нь фламанд, франц болон герман хэлтний Нийгэмлэгүүдийн Зөвлөлөөс сонгодог.
- Их Британийн Лордуудын танхимын 26 гишүүн нь шашны зүтгэлтнүүд байна.
- Казахстанд парламентын доод танхимын 107 суудлын 9 нь Казахстаны Ард түмнүүдийн Ассамблейд ноогдоно. Уг Ассамблейд шашны 45 үндсэн конфессийг дагадаг Казахстаны 130 үндэстэн ястны төлөөлөл ордог байна.

Хэдийгээр Квотын систем нь тэгш биш байдал бий болгож байна гэж үздэг боловч зарим тохиолдолд гарцаагүй хэрэглэхээс аргагүй болдог. Жишээлбэл, Энэтхэгт уламжлал ёсоор парламентын суудлын 2 нь англи гаралтай энэтхэгчүүдэд оногддог бол Бельгид хэлний янз бүрийн бүлэглэлээс сонгогдох сенатын гишүүдийн тодорхой хэсэг нь сонгуулийн өдрийн байдлаар нийслэл Брюссельд амьдардаг байх ёстой. Ингэснээр хэлний бүлэглэлүүдийн тэнцвэр парламентад хадгалагдана гэж үздэг. Хорват улсын парламент дахь үндэстэн, ястан, цөөнхийн төлөөллийг мөн хуульчлан зохицуулдаг. Улсын нийт хүн амын 8 хувиас багагүйг эзэлдэг үндэсний цөөнхид парламентын депутатын 5 суудал оногддог бол бусад цөөнхид тэдний хүн амын тоонд пропорционал тооны суудал оногдоно. Сүүлийн сонгуулиар 4,7 сая хүн амтай Хорватын парламентын 153 депутатын 8 нь үндэсний цөөнхийг, 5 нь бусад цөөнхи ястнуудыг төлөөлөн сонгогдсон байна.

3. Цөөнхийн улс төрийн төлөөллийг хангах бас нэг арга бол парламент дахь үндэстэн ястны төлөөллийн пропорцийг хуульчлан тогтоох арга юм. Жишээлбэл, Киприйн үндсэн хуулиар 50 депутаттай парламентын гишүүдийн 70 хувь нь грекчүүдийн дундаас, 30 хувь нь Туркчүүдийн дундаас тус тусдаа сонгогддог. Пропорцийн системийн нилээд нарийн хувилбарыг сонгосон улс бол Бельги юм. Тус улсын парламентын доод танхимыг шууд пропорционал сонгуулиар сонгодог бол дээд танхим Сенатыг 3 үндсэн аргаар бүрдүүлдэг: 40 сенаторыг сонгогчдыг коллегууд сонгоно. Үүний 25 нь Нидерланд сонгогчдын коллегууд, 15 нь франц сонгогчдын коллегууд сонгогдоно; 21 сенатор нь нийгэмлэгүүдийн Зөвлөлөөс томилогдоно. Үүний 10 нь фламандчуудын нийгэмлэгийн Зөвлөлөөс, 10 нь францчуудын нийгэмлэгийн Зөвлөлөөс, 1 нь герман хэлтний нийгэмлэгүүдийн Зөвлөлөөс тус тус томилогдоно; Ийнхүү сонгогдсон болон томилогдсон 61 сенатор өөрсдөө нэмж 10 сенаторыг томилно.

Улс орнуудын Улс төрийн намуудын тухай хуулиудыг үзэхэд үндэсний цөөнхийн төлөөллийг парламентын сонгуульд заавал нэр дэвшүүлэх тухай заалт олдохгүй байна. Асуудлыг намууд өөрийн дотоод дүрэм, журмаар зохицуулдаг бололтой. Харин нилээд олон оронд тухайн орны аль нэг үндэстний дагнасан намууд байдаг байна.

Ийнхүү үндэсний цөөнхи парламентад өөрийн төлөөлөлтэй боллоо гэдэг нь тэдний сонирхол бодитойгоор тооцогдох баталгаа бас хараахан биш юм. Энэ бол цөөнх өөрийн сонирхолыг парламентын индрээс илэрхийлэх маш чухал нэг арга хэрэгсэл боловч олон тохиолдолд асуудлыг шийдэхэд хангалтгүй байдаг. Үндэсний цөөнхийн улс төрийн төлөөлөл бодитойгоор эрх ашгаа хангахад парламентын тодорхой процедур, механизм чухал байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛС ТӨРИЙН СОНГУУЛИЙН НӨЛӨӨГӨӨР ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ӨӨРЧЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ АСУУДАЛ, ХАНДЛАГА

/Харьцуулсан судалгаа/

С.Дорждагва

СУДАЛГААНЫ ЗАХИАЛГА: Улс төрийн сонгуулийн үр дүнд төрийн албан хаагчдын тодорхой хэсэг нь чөлөөлөгдөх болон өөрчлөгддөг жишиг олон улсын практикт байдаг эсэх, Монгол улсад энэ үйл явц ямар байгаа талаар тодруулах, мөн энэ асуудлыг хуулиар хэрхэн зохицуулдаг эсэх талаар дүгнэлт гаргах, харьцуулан судлах.

Уг захиалгын хүрээнд холбогдох кейс, мэдээллийг эрэн хайлт хийсэн боловч уг захиалгад тохирох албан ёсны тоон мэдээлэл олдоогүй тул зарим орны туршлага болон онолын асуудлын хүрээнд судалгааны ажлыг гүйцэтгэв.

1. Төрийн албаны өөрчлөлт, хөдөлгөөний байдал (бусад орнуудад)

Сэдвийн хүрээнд дэлхийн улс орнуудын төрийн албаны тогтолцоо болон зарим улс орнуудын (түүний дунд төв Азийн хуучин социалист орнуудын) Төрийн албаны тухай хуулиудыг харьцуулах замаар баримт материалд дүн шинжилгээ хийв. Улс орон бүрийг дэлгэрэнгүй авч үзээгүй болно.

Улс орон бүр төрийн албаны бодлогоо өөрийн уламжлал соёл, засаглал, хүний хөгжилдөө тохируулан онцлог байдлаар явуулдаг байна. Сонгуулийн үр дүнгээс шалтгаалж өөрчлөлт, хөдөлгөөн оруулах асуудал Төрийн захиргааны албан хаагчид¹²-ын хувьд нилээд маргаантай байдаг. Энэ асуудал нь олон улсын практикт дараахь чиг хандлага байна гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

1. Тухайн байгууллагын удирдлага, сайд нар (Яам, Нутгийн захиргааны байгууллагууд) нь сонгуулийн үр дүнд өөрчлөгдөхөд тухайн байгууллагын албан хаагчдын тодорхой хэсэг нь мөн дагаж солигддог. Өөрөөр хэлбэл, удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын аль аль нь хамрагдана гэсэн үг. (Удирдлагаа дагаж багаараа өөрчлөгдөх хандлага)
2. Сонгуулийн үр дүнгээр удирдлага солигдоход тухайн байгууллагын удирдах албан тушаалтан (Төрийн нарийн бичгийн дарга, Тамгын газрын болон газар, хэлтсийн дарга нар) солигдож гүйцэтгэх албан тушаалтан нь хэвээр үргэлжлэн ажилладаг.
3. Төрийн Улс төрийн албан хаагчдаас бусад төрийн албан хаагчид сонгуулийн үр дүнд ямар нэгэн хөдөлгөөн ордоггүй хууль Монгол улсад үйлчилж байна.

Монгол улс төрийн албан хаагчдаа улс төрийн намаас түдгэлзүүлэх хууль гаргасан. Энэ бол Англи улсын туршлага юм. Англид төрийн албан хаагч намын гишүүн байх нь хориотой төдийгүй тэднийг халж, солихыг зөвшөөрдөггүй бол Скандинавын орнуудад төрийн албан хаагч гэсэн статус байхгүй, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн хамгааллын харилцааг тарифын гэрээгээр зохицуулдаг.

Төрийн албаны тогтолцооны хувьд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан төв Азийн улс орнуудын тогтолцоо манай улстай төстэй байна.

¹² Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуулинд тодорхойлсоноор “Төрийн захиргааны жинхэнэ албан хаагч” юм. Төрийн Албаны тухай хуулийн 11.2. дахь заалт.

Дээрхи хувилбарууд нь ихэнхдээ тухайн улсын Засаглалын тогтолцооноос шалтгаалдаг байна. Тухайлбал, үүний тодорхой жишээ нь АНУ-д сонгуулийн үр дүнд сайд нь солигдоход төрийн албан хаагчдын хөдөлгөөн их гардаг бол Герман улсад зөвхөн Төрийн нарийн бичгийн дарга болон газар хэлтсийн дарга нар солигддог.

Гэхдээ, Герман улсад Төрийн нарийн бичгийн дарга нь хоёр байдаг бөгөөд энэ жишиг одоогоор манай улсад Ерөнхийлөгчийн Тамгын газар хоёр дэд даргатай, Яамдын түвшинд Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга байдагтай зүйрлүүлж болох юм. Тухайлбал, Герман улсад нэг Төрийн нарийн бичгийн дарга нь яамны дотоод асуудлыг голчлон хариуцаж улс төрөөс хараат бусаар тогтвортой ажил үүргээ гүйцэтгэдэг бол нөгөө Төрийн нарийн бичгийн дарга нь сайдын улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажилладаг байна.

Төрийн нарийн бичгийн дарга нь яамыг сайдтай (Засгийн газар), парламенттай холбож өгдөг чухал албан тушаал гэж үздэг. Улс төрийн бодлогыг хэрэгжүүлэгч төрийн нарийн бичгийн дарга нь парламентад тухайн салбарын асуудлыг хариуцаж ажилладаг. Ийм албан тушаалыг төрийн захиргааны гэхээсээ илүүтэй улс төрийн шинжтэй гэж үздэг.

Германд төрийн албан хаагч намын гишүүн байж болно. Гэхдээ улс төрийн үзэл бодлоо даруу илэрхийлэх, аль нам гэдгээ ил тод байлгах хэрэгтэй гэж үздэг. Улс төрийн намын гишүүн төрийн албан хаагчийн хувьд биеэ хэрхэн зөв авч явах эсэх нь тэр хүний соёлоос их хамаардаг аж. Германчууд намын харъяаллыг нууцлах нь сөрөг нөлөөтэй гэж үзнэ. Германчууд хэдий намын харъяалал ил тод байдаг ч улс орныхоо төлөө үнэнчээр зүтгэдэг ба иргэд ч төрийн албан хаагчиддаа хүндэтгэлтэйгээр хандаж сурсан байдаг. Энэ уламжлал Пруссийн эзэнт улсын үеэс үүдэлтэй гэж эрдэмтэн судлаачид үздэг ба олон улсад Герман соёл хэмээн нэрийдсэн нь бий.

Дээрх хоёр хувилбар тус бүрдээ өөрийн ололт, дутагдалтай байна. Тухайлбал, АНУ-ын систем бол манай улсын нөхцөлд тохирох магадлал муутай. Учир нь, АНУ бол хүний нөөцийн боломж сайн, өөрийн хүчирхэг аппаратыг цаг тухайд нь шинээр бүрдүүлэх бүрэн боломжтой улс бөгөөд манай улсад төрийн мэргэшсэн албан хаагчийг сонгуулийн үр дүнгээр тухай бүр солих асуудал хүндрэл учруулна. Нөгөө талаар, АНУ бол төрийн байгууллын тогтолцоо нь манайхаас өөр улс билээ.

Тус улсад ийнхүү төрийн албан хаагчдыг сонгуулийн үр дүнд солих хандлага нь төрийн дээд байгууллагын хүрээнд л байна. АНУ-д төв Засгийн газрын хэмжээнд Улс төрийн албан хаагч 2000 орчим хүн байдаг байна¹³.

Харин Герман улсад удирдах албан тушаалтан нь солигдож байгаа үндэслэл нь сайдын баг болж удирдлагын түвшинд бодлого тодорхойлоход оролцдог гэж үздэгтэй холбоотой. Япон улсын төрийн албаны тогтолцоог Герман улсаас өнгөрсөн зууны дунд үеэр хааны эрх мэдлийг хязгаарлаж засаглалын шинэ хэлбэрийг сонгосоны дараагаар хуулбарлан авч хэрэгжүүлсэн гэж үздэг¹⁴. Эдгээр улсууд нь засаглалын хувьд манай улстай төстэй тул жишиг болгон үзэх боломжтой.

Тус улсын тогтолцоогоор төрийн албаны удирдах албан тушаалд томилогдохын тулд тухайн салбарын бүхий л албан тушаалыг хашиж үзсэн, тухайн салбарын ажлаа маш сайн мэддэг болсон байхыг чухалчилдаг байна. Өөрөөр хэлбэл, төрийн албаны карьерийн системийг нилээд сайн хэвшүүлсэн байна. Карьерийн системийг олон улсад Хүний нөөцийн удирдлагын шинжлэх ухааны хэлээр Мерит систем гэж нэрлэдэг.

¹³ Энэ тоог АНУ-ын Төрийн албаны төв байгууллагын ажилтан Монгол улсад айлчлах үеэр хийсэн семинарын үед авсан тоо билээ. Судлаач.

¹⁴ <http://www.jstor.org/pss/440930> . Japanese Civil Service System. Relevance for Developing Countries. V V Bhatt, Hyung-Ki Kim. June 3. 2000

Монгол улсын хувьд 1994 онд УИХ-аас “Төрийн албаны тухай” хуулийг анх батлан гаргасан ба энэ хуулийн онолын үндсэн үзэл баримтлал нь Мерит тогтолцоо юм. Мерит систем гэдэг нь албан хаагчдыг ажилд авах, халах, өөрчлөх гол зарчим бол улс төрийн аль нэгэн намтай холбоотойгоор, аль эсвэл хүйс, нас, арьс өнгөний ялгаагаар бус харин өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх чадвараар тодорхойлогдоно¹⁵.

Төрийн албаны чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтдийн тодорхойлсоноор Мерит тогтолцооны үүсэл хөгжил нь АНУ-аас эхтэй бөгөөд 1870-аад онд тус улсад үүссэн нөхцөл байдал нь өнөөгийн Монгол улсын нөхцөл байдалтай (2000 оноос хойш эхэлсэн гэж үздэг) тун төстэй байсан гэж үздэг. Тухайн үеийн АНУ-д улс төрийн харъяаллыг харгалзах, танил тал, Британы ноёрхлын эсрэг тэмцэлд оруулсан гавъяа зүтгэлийг харгалзан үзэж төрийн албанд томилдог байсан нь авилгал, хүнд суртлыг дэврээж, танилын хүрээ хэт өргөжсөнөөс аливаа хяналт суларч төсвийн хөрөнгийн зарцуулалт нь улс орон, нийгэмд тусаа өгч чадахгүйд хүрч байсан байна.

Энэ үед гарсан нэгэн том сөрөг үр дагавар нь тус сонгуулийн үр дүнд шинээр томилогдсон болон дэвшсэн албан тушаалтнуудын авилгын асуудал байсан юм. Гэхдээ эдгээр албан тушаалтнууд зөвхөн өөрсдөө үйлчлүүлэгчдээсээ авилга авах бус өөрийг нь томилсон болон түүнд оролцсон хүмүүст төлөөс төлөх хүсэл зорилгоос үүдэлтэй авилгын асуудал байсан юм.

Карьерийн системийн сонгодог жишээ нь Герман, Япон улсад хэрэгжиж байна. Тус улсад төрийн албан хаагч хэдэн насандаа ямар албан тушаалд хүрэхээ урьдчилан төсөөлсөн байдаг. Жишээлбэл, хэд хэдэн хэлтэст ажиллах замаар салбарынхаа түвшинд универсаль мэргэжилтэн болж, хэлтсийн орлогч даргаар ажиллах шалгуур давдаг байна. Энэ зарчим л бүх албан тушаалд томилоход баримтлагдана.

2. Монгол улсын төрийн албан хаагчдын өөрчлөлт, хөдөлгөөний талаархи судалгаа, дүгнэлт:

Монгол улсад төрийн захиргааны албан хаагчдын тоо нь 2009 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар 13104 буюу нийт төрийн албан хаагчдын 9,1%-ийг хувийг эзэлж байна¹⁶.

Монгол улсад 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 144049 төрийн албан хаагч байна. Үүнд:

Албан тушаалын ангилал	Төрийн захиргааны төв байгууллага	Нутгийн захиргааны байгууллага	Нийслэлийн төр захиргааны байгууллага	НИЙТ
Төрийн улс төрийн албан тушаалд	463	2,101	140	2,704
Төрийн захиргааны албан тушаалд	3,318	7,751	2,035	13,104
Төрийн тусгай албан тушаалд	21,777	2,631	1,280	25,688
Төрийн үйлчилгээний албан тушаалд	23,355	59,469	19,729	102,553
НИЙТ	48,913	71,952	23,184	144,049

Төрийн албан хаагчдын хөдөлгөөний талаар дүн мэдээг Төрийн албаны зөвлөл албан ёсоор эмхэтгэн гаргадаг. Төрийн албаны зөвлөлөөс өнгөрсөн 2009 онд эмхэтгэн гаргасан “Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаарх статистикийн тойм”-оос харахад манай улсад төрийн

¹⁵ Төрийн бодлого ба төрийн хүний нөөцийн менежмент. Монгол менежмент төв. 1998 он.

¹⁶ Монгол улсын Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний талаарх статистикийн тойм. Төрийн албаны зөвлөл. 2009 он.

албан хаагчдын хөдөлгөөн сонгуулийн дараагийн жилүүдэд багагүй хэмжээгээр нэмэгдэх хандлага гардаг байна.


Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын судалгаа

Хүснэгт №1

Төрийн албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг хийхдээ Албан тушаал дэвшүүлэх болон Нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулдаг байна.


1. Албан тушаал дэвшүүлэх журмаар

Ангилал	Он					
	2003	2004	2005	2006	2007	2008
Нэр дэвшүүлсэн хүний тоо	3	75	113	47	76	82
Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргасан хүний тоо	3	55	108	47	76	82
Томилогдсон хүний тоо	3	24	44	17	29	42



Хүснэгт №2 2. Нээлттэй өрсөлдөөний зарчмаар

Ангилал	Он				
	2004	2005	2006	2007	2008
Нэр дэвшүүлсэн хүний тоо	10	200	64	27	65
Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргасан хүний тоо	10	182	59	27	65
Төрийн албаны зөвлөлөөс санал болгосон	10	150	57	27	65
Зарлагдсан албан тушаалд томилогдсон	2	43	15	8	18



Дээрхи статистикаас харахад сонгуулийн дараагийн жил буюу 2005 онд удирдах ажилтны хөдөлгөөн эрс нэмэгдсэн дүн гарчээ. Энэ байдал сонгуулийн бүрэн эрхийн сүүлийн жилүүд болох 2006-2007 онд багасаад эргээд 2008 онд сонгууль явагдсаны дараа оны төгсгөлөөс өсөх хандлага гарсан байна. 2009 оны дүнг одоогоор Төрийн албаны зөвлөл эмхтгэж байгаа тул энэ судалгаанд ашиглах боломжгүй байлаа. Төрийн албаны зөвлөлийн мэргэжилтнүүдийн албан бус тайлбараар энэ тоо мөн л өсч гарах (дээрхи графикт тасархай зураасаар дүрслэв) хандлагатай.

Манай улсын яамдын төрийн нарийн бичгийн дарга нар улс төрийн сонгуулийн нөлөөгөөр хамгийн их солигддог гэж эрдэмтэн судлаачид үздэг. Энэ албан тушаалын өөрчлөлт, хөдөлгөөнийг хавсралтаар үзүүлэв.


Герман, Япон улсад төрийн албаны шалгалтыг Улсын тусгай комисс авдаг. Шалгуурын оноонд хүрвэл ажилд орох эрх нээгдлээ гэсэн үг. Өмнө нь ажиллаж байсан байгууллагын даргын тодорхойлолт эсвэл түүнээс илүүтэйгээр хамт олны зөвлөлийн тодорхойлолтыг их анхааралтай авч үзэх нь шударга ёсонд нийцнэ, тухайн хүнийг хамт олон нь л шударгаар үнэлнэ гэсэн зарчим байна.

Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд Төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөх иргэдийн тоо болон нээлттэй зарлаж байгаа орон тооны хэмжээ өссөн байна.

Хүснэгт №3 Төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүн

Он	Зарлагдсан ажлын байр	Шалгалт өгсөн хүний тоо	Шалгалтанд тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн хүний тоо	Хувь	Нөөцөд бүртгэгдсэн хүмүүсээс ажилд орсон хүний тоо	Хувь
1996	265	503	358	71.2%	270	75.4%

1997	829	1067	528	49.5%	388	73.5%
1998	1406	1717	1092	63.6%	888	81.3%
1999	842	1318	815	61.8%	572	70.2%
2000	832	1608	870	54.1%	549	63.1%
2001	1213	2423	1395	57.6%	911	65.3%
2002	1488	2656	1718	64.7%	818	47.6%
2003	892	2799	1988	71.0%	435	21.9%
2004	640	3047	1309	43.0%	752	57.4%
2005	970	4024	1829	45.5%	970	53.0%
2006	1968	4719	1968	41.7%	1180	60.0%
2007	927	3601	847	23.5%	300	35.4%
2008	2045	8133	2444	30.1%	920	37.6%




Дээрхи статистик тоонуудыг шууд утгаар нь сонгуулийн үр дүнтэй холбож тайлбарлах боломжгүй ч сонгуулийн үр дүнгээс тодорхой хэмжээнд (албан бус тайлбараар дийлэнх хувь нь. Төрийн албаны зөвлөл) шууд бусаар шалтгаалсан гэж үзэж болно. Төрийн албаны мэргэшлийн шалгалтын журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлага өндөрсөж байгаа ч сонгуулийн хугацаанаас хамаарсан өөрчлөлт, хөдөлгөөн нэмэгддэг гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Үүнийг дагаад төрийн албан хаагчаас ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэсэн гомдлын хэмжээ өссөн байна. Үүнийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №4

Төрийн албаны зөвлөлийн нэр дээр төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, маргааны харьцуулсан судалгаа

Он	Төрийн албаны зөвлөлд ирсэн нийт маргааны тоо	Үүнээс ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргааны тоо
2003	42	13
2004	37	29
2005	137	113
2006	113	58
2007	100	60
2008	104	45



2009 оны үзүүлэлт албан ёсны дүн гараагүй ч мөн өсөх хандлагатай байна. (Тасархай зураасаар дүрслэв)

2008 оны статистикаас Төрийн албан хаагчдын өөрчлөлт, хөдөлгөөний үндэслэлүүдийг харахад хуулинд тусгагдаагүй "Сонгуулийн үр дүнгээр өөрчлөгдсөн" (Хүснэгт №5-ын 5 дугаар багана) гэсэн нэг бүлэг нь анхаарал татаж байна.

Төрийн албан хаагчийн хөдөлгөөн 2008 оны байдлаар

Нийт	Бүтцийн өөрчлөлтөөр	Жилээс дээш хугацаагаар эмчлүүлэх	Нас барсан	Сургуульд сурах болсон	Сонгуулийн үр дүнгээр өөрчлөгдсөн	ГА хаах насны дээд хязгаарт хүрсэн	ТАТХ-ийн 15-р зүйлийг зөрчсөн	ТАТХ-ийн 23.2-оор өөрчлөгдсөн	Тэтгэвэрийн насанд хүрсэн	Цэргийн алба хаах болсон	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн	Өөр ажилд шилжсэн	Гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон	Монгол улсын харъяатаас гарсан	ГА-д 1 жилийн хугацаанд эргэн орохгүйгээр халагдсан
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
11005	0	173	265	317	709	61	125	120	1410	19	3892	3827	17	3	67

“Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших болсон бол хуульд заасны дагуу нэр дэвшигчээр бүртгүүлэхээр сонгуулийн хороонд холбогдох баримт бичгийг ирүүлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй”¹⁷ гэсэн Төрийн албаны тухай хуулийн заалтаас өөр сонгуультай холбоотой төрийн албанаас чөлөөлөгдөх үндэслэл байхгүй юм. Энэ үндэслэлийг Хүснэгт №5-ын 8 дугаар баганад тусгасан байна.

Хуулийн ямар нэгэн заалт байхгүй байхад чухам яагаад “сонгуулийн үр дүнд” өөрчлөлт оров? гэсэн асуултад тайлбар авахад “тухайн байгууллагаасаа Төрийн албаны зөвлөлд тайлангаа ирүүлэхдээ ийм төрлийн мэдээлэл ирдэг. Ирсэн тоог нь энэ хэвээр нь гаргасан” гэснээс өөр тайлбар өгсөнгүй. Зарим албан хаагчид ийм ташаа ойлголт байсаар байгаа юм.

Германд төрийн албан хаагч улс төрд орж сонгуульд нэр дэвших бол улс төрийн албан хаагч болтлоо төрийн албан хаагчийн статусаа хадгална. Сонгогдох хүртлээ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч нь тангараг өргөсөнөөс эхлээд насан туршдаа төрийн албан хаагчийн статус олгодог байна.

Парламентын гишүүнээр ажиллаад дараагийн удаа сонгогдохгүй бол эргээд төрийн албан хаагчийн статус нь сэргэдэг аж. Учир нь Германд төрийн албан хаагчийг насан туршид нь томилдог зарчимтай¹⁸.

Төрийн албан хаагч нь насан туршийн статустай байснаар тухайн албан хаагч улс төрийн сонгуулийн нөлөөгөөр ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд албан тушаалынхаа цалингийн 70 хувийг дараагийн ажилд ортлоо авч байдаг ба нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг нь улсаас 100 хувь төлж байдаг байна. Ингэснээрээ “насан туршийн” гэсэн статусыг хангадаг гэж үздэг ажээ¹⁹.

¹⁷ Төрийн албаны тухай хуулийн 23.2. дугаар зүйл.

¹⁸ Best practices in civil service reform. ARCADIS BMB. Management Consultants BV. Aug 2003

¹⁹ Мөн тэнд

Ашигласан материал

- Монгол улсын Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний талаарх статистикийн тойм. Монгол улсын Төрийн албаны зөвлөл. Улаанбаатар хот. 2009
- Төрийн бодлого ба төрийн хүний нөөцийн менежмент. Монгол менежмент төв. 1998 он.
- <http://www.jstor.org/> Japanese Civil Service System. Relevance for Developing Countries. V V Bhatt, Hyung-Ki Kim. June 3. 2000
- <http://www.wikipedia.org/>
- <http://www.chanrobles.com/legal3csc.html>
- http://www.mongabay.com/reference/country_studies/germany/GOVERNMENT.html
- Монгол улсын Төрийн албаны тухай хууль. 2002 он
- Гадаад зарим орны төрийн албаны тухай хууль. Герман, Грек, Унгар, Армен, Серб, Македон болон бусад
- The 21st Century Civil Service. United Kingdom. Oct 2009
- Politics and Administration: Ministers and Civil Servants. Third Report of Session 2006–07. Berlin
- Structure of the civil service employment in seven OECD countries. OECD 1999
- Best practices in civil service reform. ARCADIS BMB. Management Consultants BV. Aug 2003

Яамдын төрийн нарийн бичгийн дарга нарын хөдөлгөөний мэдээ

№	Яамдын нэр	Төрийн нарийн бичгийн даргын нэр	Ажилласан он
1	Сангийн яам	1. Д.Махбал	1996.08-2000.08
		2. Н.Түмэндэмбэрэл	2000.08-2003.05
		3. Ч.Хүрэлбаатар	2003.05-2007.12
		4. Д.Баттөр	2007.12 -
2	Хууль зүй, дотоод хэргийн яам	1. Д.Сугар	1996-2000
		2. Г.Баясгалан	2000-2001
		3. Б.Цэрэндорж	2001-2006
		4. Г.Баясгалан	2006 -
3	Гадаад харилцааны яам	1. О.Очиржав	1996-2000
		2. Л.Баярт	2000-2001
		3. Б.Ганболд	2001-2003
		4. Р.Алтангэрэл	2003-2006
		5. Х.Бэхбат	2006-2008
		6. Д.Цогтбаатар	2008 -
4	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	1. Д.Баасандорж	1997.07-1999.12
		2. С.Банзрагч	1999.12-2003.04
		3. Я.Адъяа	2003.04-2006.09
		4. Д.Загджав	2006.09-2006.12
		5. Ц.Шийрэвдамба	2006.12-2008.02
		6. Т.Гантулга	2008.02-2009.02
		7. Н.Батсуурь	2009.02 -
5	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	1. Р.Жадамбаа	2000-2003.04
		2. О.Байгальмаа	2003.04-2009.04
6	Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам	1. н.Самбасанчир	2004-2005
		2. Ц.Батсайхан	2005-
		3. Ц.Ганхүү	2006-2008
		4. С.Төмөрхуяг	2008.03-2008.09
		5. Ж.Бат-Эрдэнэ	2008.09 -
	Эрдэс баялаг, эрчим хүчний яам	1. Мэдээлэл өгөөгүй	
7	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	1. Р.Бат-Эрдэнэ	1996-2000.08
		2. Б.Мишигжав	2000.08 -
8	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1. Б.Зардыхан	1996-1998
		2. С.Бямбаа	1998-2000
		3. П.Дамдиндорж	2000-2003
		4. Н.Батсуурь	2003-2009
		5. Т.Гантулга	2009.03 -
9	Батлан хамгаалахын яам	1. Ц.Дашзэвэг	1997-2001
		2. С.Баасанхүү	2001-2006
		3. М.Борбаатар	2006 -
10	Эрүүл мэндийн яам	1. А.Зангад	1996-2000
		2. Ц.Содномпил	2000-2005
		3. Б.Батсэрээдэнэ	2005-2007.12
		4. Ж.Алтантуяа	2008.01-2008.12
		5. Н.Хүрэлбаатар	2009.04 -

Эх үүсвэр: Яамдын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөцийн менежерүүд

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХИ
ЗАРИМ ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ**
/Лавлагаа, мэдээлэл/

*К.Пүрэвсүрэн, Б.Хатантуул/LLM/
Ш.Хишигсүрэн/LLM/*

**Үндсэн хуулийн цэц /шүүх, зөвлөл/-ийн шийдвэрийн талаархи Турк, Франц, Испани, Казакстан,
Австри, Польш Улсын зохицуулалт**

1. Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улс нь эх газрын эрх зүйн тогтолцоотой, парламентын нэг танхимтай, нэгдмэл улс юм. Энэ талаараа манайхтай нэлээд төстэй.

БНТУ-ын Үндсэн хуулийн 146-153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн байгуулалт, түүний бүрэн эрх, үйл ажиллагааны талаархи асуудлыг зохицуулсан байна.

БНТУ-ын Үндсэн хуулийн 148 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүх нь хууль, хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр тогтоол болон Туркийн Үндэсний Их Хурлын дотоод дэгийг Үндсэн хуулийн хэлбэр болон агуулгад нийцэж байгаа эсэхэд хяналт тавихаар заасан байна. Харин Үндсэн хуулийн өөрчлөлтийг зөвхөн хэлбэрийн хувьд хянадаг. Гэвч онцгой байдал, онц байдал болон дайны байдалд гаргасан хууль адил хүчин төгөлдөр тогтоолыг хэлбэр болон агуулгын хувьд Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болохгүй гэж заасан байна.

БНТУ-ын Үндсэн хуулийн 153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг зохицуулсан бөгөөд үүнд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийнх байна. Тухайн хүчингүй болгосон шийдвэрт Үндсэн хуулийн шүүх үндэслэлийг заавал дурдана. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг Төрийн хэвлэлд нийтэлснээр тухайн хэм хэмжээг хүчингүй болсонд тооцно. Түүнчлэн хүчингүй болгох өдрийг тусгайлан зааж өгч болох боловч энэ хугацаа нь нэг жилээс ихгүй байна.

Үндсэн хуулийн шүүхийн байгуулалт болон чиг үүргийн тухай 1983 оны 2949 дугаар хуульд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн талаар зохицуулсан байна.

Үндсэн хуулийн шүүхийн байгуулалт болон чиг үүргийн тухай хуулийн 53 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байна. Шийдвэрийг хянан шалгасан эсхүл шүүх хэлэлцэхэд оролцсон дарга болон гишүүд гарын үсэг зурах бөгөөд эсрэг саналтай байгаа нь эсрэг саналаа тайлбарлана. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийнх бөгөөд үндэслэлийг нь тайлбарлана.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг Төрийн сонинд даруй хэвлэх бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх байгууллага, захиргааны алба, хувь хүн болон хуулийн этгээд дагаж мөрдөх ёстойг Турк Улсын Үндсэн хуулийн 153 дугаар зүйлийн 6 дахь заалт болон Үндсэн хуулийн шүүхийн байгуулалт болон чиг үүргийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд тус тус тусгайлан зохицуулсан байна.

Нөгөө талаас Туркийн Үндэсний Их Хурлын дотоод дэгт Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг Туркийн Үндэсний Их Хурлаар тусгайлан авч хэлэлцэх талаар ямар нэг зохицуулалт байхгүй байна.

Иймд эрх зүйн зохицуулалтын хувьд Турк Улсын Үндсэн хуулийн шийдвэр эцсийнх байх бөгөөд түүнийг Төрийн сонинд албан ёсоор нийтэлдэг байна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хууль тогтоох болон бусад байгууллагад танилцуулах талаар ямар нэг эрх зүйн зохицуулалт олдсонгүй.

2. Франц Улс

Франц Улсын 1958 оны 5 дугаар Үндсэн хуулиар Үндсэн хуулийн зөвлөлийг байгуулсан байна. Уг зөвлөл нь Үндсэн хуулийн шүүхийн онцлог бүхий өөрийн онцлогтой. Учир нь Франц Улсын Үндсэн хуулийн зөвлөл нь хүчин төгөлдөр болоогүй байгаа нормыг /A priori хяналт/ авч хэлэлцдэгээрээ бусад Европын орнуудаас онцлогтой юм.

Франц Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хууль зөрчсөнийг тунхагласан аливаа нэг актыг нийтлэхгүй ба дагаж мөрдөхгүй”, 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн зөвлөлийн шийдвэрийг давж заалдах боломжгүй. Энэхүү шийдвэрийг Үндсэн хуулийн байгууллага, захиргаа болон шүүх байгууллага дагаж мөрдөх ёстой” гэжээ. /Үндсэн хуулийн зөвлөл нь гаргасан шийдвэрийнхээ эсрэг аливаа хандлагыг хүлээн авахаас татгалздаг байна/

Үндсэн хуулийн зөвлөл нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаархи хяналтыг хууль болон олон улсын гэрээг нийтлээд мөрдөж эхлэхээс, дотоод дэгийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө хийх шаардлагатай байдаг. Үндсэн хуулийн зөвлөлд хууль болон олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар өргөдөл гаргаснаар уг хууль болон олон улсын гэрээг нийтлэх болон дагаж мөрдөх асуудлыг түдгэлзүүлдэг бөгөөд Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн заалтыг хэрэгжүүлэхээс татгалздаг ба хууль бүхэлдээ Үндсэн хууль зөрчсөн бол уг хуулийг бүхэлд нь нийтлэхгүй. Харин хуулийн зарим нэг заалт Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг хасч нийтлэх ба эсхүл парламент руу эргүүлэн илгээдэг.

Францын Үндсэн хуулийн зөвлөл нь шүүн таслах чиг үүргийнхээ хажуугаар зөвлөх, хяналт тавих чиг үүрэг бүхий дээд шүүх юм. Тус улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хяналтын нэг хэлбэр нь /A priori/ хийсвэр /абстракт/ нормын хяналт юм. A priori хяналтаар Үндсэн хуулийн шүүгч хуулийн улс төрийн процессийн үед байхад нь оролцож норматив бүтээгдэхүүний процесст ордог байна.

Органик хууль болон дотоод дэг хэвлэгдэн нийтлэгдэхээс өмнө Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар хяналт тавьдаг. Үндсэн хуулийн зөвлөл нормыг Ерөнхий сайд эсхүл холбогдох танхимын даргын хүсэлтээр хяналтыг хэрэгжүүлдэг байна. Үндсэн хуулийн зөвлөл аливаа нэг хүсэлт болон үндэслэлээс ангид байх бөгөөд шийдвэр нь эцсийнх байж түүнийг бүгд дагаж мөрдөх ёстой байдаг байна.

Мөн Франц Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтаас үзэхэд Үндсэн хуулийн зөвлөл нь өөрийн гэсэн нэлээд онцлогтой, түүний шийдвэр нь эцсийнх байдаг тул уг шийдвэрийг аливаа нэг байгууллага авч хэлэлцэх тухай асуудал байдаггүй байна.

3. Испани Улс

Испани Улсад Үндсэн хуультай холбоотой хэрэг маргааныг эртний уламжлалтай Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн шүүх нь 9 жилийн хугацаагаар томилогдсон 12 шүүгчээс бүрддэг²⁰. Тэдгээрээс:

-4 шүүгчийг Төлөөлөгчдийн Танхим (гишүүдийн дийлэнх олонхийн буюу 3/5-ын саналаар)

-4 шүүгчийг Сенат (гишүүдийн дийлэнх олонхийн буюу 3/5-ын саналаар)

-2 шүүгчийг Засгийн газар

-2 шүүгчийг Шүүх эрх мэдлийн ерөнхий зөвлөл тус тус санал болгож хаан албан тушаалд томилдог.²¹

20 <http://www.tribunalconstitucional.es/en/Pages/Home.aspx>

21 Ley Orgánica 2/1979, de 3 de octubre, del Tribunal Constitucional

Шүүх нь бүгд хурлаар, эсхүл танхимын журмаар ажилладаг. Шүүгчид тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй 2 танхимд хуваагддаг. Санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг.

Шүүх нь бие даасан хараат бус байна.

Шүүхийн эцсийн шийдвэр нь Төрийн хэвлэлд нийтлэгдсэн өдрөөс хэрэгжинэ.

4. Казакстан Улс²²

Казакстан Улсад Үндсэн хуулийн дагнасан шүүх байдаггүй нь тус улсын шүүхийн тогтолцооны онцлог юм. Үндсэн хуулийн хяналтыг 7 гишүүнтэй Үндсэн хуулийн Зөвлөл хэрэгжүүлдэг. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 6 жил.

Үндсэн хуулийн Зөвлөл нь бие даасан хараат бус байна.

Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Ерөнхийлөгчөөс томилогддог Үндсэн хуулийн Зөвлөлийн дарга, 2 гишүүн; Сенатын даргаас томилогддог 2 гишүүн; доод танхимын даргаас томилогддог 2 гишүүн байна. Түүнчлэн тус Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч асан хүмүүс насан туршдаа Үндсэн хуулийн Зөвлөлийн гишүүн байх эрхтэй.

Үндсэн хуулийн Зөвлөл нь Ерөнхийлөгч ёсчлохоос өмнө парламентаас баталсан хуулийг хянаж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, олон улсын гэрээг парламентаас соёрхон батлахаас өмнө Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, маргаан гарсан тохиолдолд Ерөнхийлөгчийн болон парламентын гишүүдийн сонгууль, ард нийтийн санал асуулга хуулийн дагуу явагдсан эсэх талаар дүгнэлт гаргах, Үндсэн хуулийн хэм хэмжээг албан ёсоор тайлбарлах, Ерөнхийлөгч өвчний улмаас үүргээ удаан хугацаагаар хэрэгжүүлэх чадваргүй болсон тохиолдолд түүнийг албан тушаалаас хугацаанаас нь өмнө чөлөөлөх боломжийн талаар дүгнэлт гаргах, Ерөнхийлөгчийг эх орноосоо урвасан хэрэгт ял тулгасан тохиолдолд Үндсэн хуулиар тогтоосон журмыг ягштал мөрдсөн эсэх талаар дүгнэлт гаргах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үндсэн хуулийн Зөвлөлийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

5. Польш Улс²³

Үндсэн хуулийн шүүх нь тухайн улсын хууль тогтоомж Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүх хэрхэн шийдвэр гаргах ба шийдвэр хэрхэн эцсийнх болох тухай уг хуулийн 89 дүгээр зүйлд заасан байна.

4. Аливаа хууль нь Үндсэн хуультай нийцэхгүй байгаа тухай Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгчээс Съемд өргөн барьснаас хойш 6 сарын хугацаанд Съемээр хэлэлцэгдээгүй буюу хэлэлцэгдсэн хэдий ч нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бол Үндсэн хуультай нийцээгүй заалтуудыг хүчингүй болгосон тухай Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэр нь эцсийнх байна. Харин тухайн хууль болон заалтуудын хүчинтэй хугацаа дуусгавар болсон тухай Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгчийн мэдэгдэл БНПУ-ын төрийн хэвлэлд нийтлэгдсэн өдрөөс эхлэн үйлчлэхгүй.

6. Австри Улс²⁴

Австрийн Үндсэн хуулийн 137-145 дугаар зүйлд заасан Үндсэн хуулийн шүүхийн чиг үүргийн дагуу тус шүүх нь холбооны хууль болон холбооны бүрэлдэхүүн орон нутгийн хууль нь Үндсэн хууль зөрчиж байгаа эсэх талаарх хэргийг авч хэлэлцдэг (140-р зүйл). Тухайн хууль үндсэн хуулийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэрээр уг хууль хүчингүй болох бөгөөд энэхүү

²² <http://www.constcouncil.kz/eng/norpb/ocons/>

²³ <http://www.trybunal.gov.pl/eng/index.htm>

²⁴ http://www.servat.unibe.ch/icl/au00000_.html

шийдвэрээр Холбооны канцлер эсхүл холбогдох орон нутгийн засаг даргад энэ тухай нэн даруй хэвлэлд мэдээлэл өгөхийг үүрэг болгодог.

Жич: Үндсэн хуулийн шүүх нь 14 гишүүнтэй (12 гишүүн, дарга, орлогч дарга). Мөн гишүүнийг орон ажиллах орон тооны бус 6 гишүүн байдаг. Дарга болон орлогч даргыг Холбооны канцлер томилдог. Гишүүд томилогдсоноосоо хойш өмнө нь эрхэлж байсан ажлаа үргэлжлүүлж болдог. Үндсэн хуулийн шүүхийн гишүүн нь нэгэн зэрэг Холбооны Засгийн газар, холбооны бүрэлдэхүүн орон нутгийн Засгийн газар, үндэсний болон холбооны, бусад гүйцэтгэх, хууль тогтоох байгууллагын гишүүн байж болохгүй. Мөн тус шүүхийн гишүүн аливаа улс төрийн намын албан тушаал хашиж болохгүй.

Тайлбар: Цэц гаргасан дүгнэлт шийдвэрээ танилцуулах тухайд ямар нэгэн заалт байхгүй. Шийдвэр гаргасан л бол хэвлэлд нийтлэснээр хүчин төгөлдөр болно.

Австрийн Үндсэн хуулийн шүүх нь олон төрлийн чиг үүрэгтэй.

Энэ нь хуулиуд Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл манайхтай төстэй боловч ямар асуудлаар шийдвэр гаргаснаасаа хамаарч процедур нь өөр өөр байна. Жишээ нь: өмчлөх эрхтэй холбоотой хэргүүдийг бусад шүүхээр шийдвэрлэж чадаагүй бол авч хэлэлцэнэ. Мөн шүүх хоорондын, холбооны болон орон нутгийн захиргаа хоорондын маргаан, холбооны байгууллагуудын хууль бус тогтоомжуудыг хүчингүй болгох, улсаас байгуулсан гэрээнүүд хууль зөрчсөн зэрэг хэрэг маргааны талаар хэлэлцэж шийдвэр гаргана.

Мөн сонгуулийг хүчингүй болгох, европарламентын гишүүний мандатыг хүчингүй болгох, олон улсын хэм хэмжээ зөрчсөн тухай гомдлыг хэлэлцэх, ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллагын, засгийн газрын гишүүн, засаг дарга нар, нийслэлийн захирагч зэрэг албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэнд татагдсан тухай хэргүүдийг буруу шийдвэрлэсэн гэх зэрэг хэргүүдийг хэлэлцэж шийдвэр гаргадаг байна.

Ерөнхийдөө тус улсын Үндсэн хуулийн шүүхийн чиг үүрэг нь бусад засаглалын байгууллагын гүйцэтгэж болох чиг үүрэгтэй хэтэрхий давхцсан гэж үздэг байна.

Дүгнэлт

Эдгээр улсын хүрээнд авч үзэхэд Үндсэн хуулийн цэц /шүүх, зөвлөл/-ийн Үндсэн хууль зөрчсөн талаархи маргааныг хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр нь шууд хүчин төгөлдөр болохоор зохицуулагдсан байх тул уг шийдвэрийг парламентаар дахин хэлэлцэх болон парламентад танилцуулах тухай зохицуулалт байхгүй байна. Польш улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийн процедурын явцад шийдвэрийг хүлээн авахгүй буцаах асуудал байх боловч энэ тодорхой заагдсан хугацааны дотор Съемээс ямар нэгэн шийдэлд хүрэхгүй бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр шууд хэрэгжихээр зохицуулагдсан байна.

Эдгээр улсын Үндсэн хуулийн шүүхийн хуулийг судлан үзэхэд Үндсэн хуулийн цэц /шүүх, зөвлөл/ нь аливаа хууль зүйн актууд Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хэлэлцээд гаргасан шийдвэр нь эцсийнх байдаг байна. Зарим улсын эцэслэн гаргадаг бол Үндсэн хуулийн зөвлөл бүхий орнуудад аливаа хууль тогтоомж хүчин төгөлдөр болон мөрдөгдөж эхлэхээс өмнө Үндсэн хуульд нийцэх эсэхэд дүгнэлт гаргах, мөн хүчин төгөлдөр болсон хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар Үндсэн хуулийн шүүхийн адил эцсийн шийдвэр гаргадаг байна.

1. Constitution of Austria

Part B The Constitutional Court

Article 137 [Pecuniary Claims]

The Constitutional Court pronounces on pecuniary claims of the Federation, the States, the Districts, the Counties and County Associations which cannot be settled by ordinary legal process nor be liquidated by the ruling of an administrative authority.

Article 138 [Conflicts of Competence]

(1) The Constitutional Court also pronounces on conflicts of competence:

- a) between courts and administrative authorities;
- b) between the Administrative Court and all other courts, in particular between the Administrative Court and the Constitutional Court itself, as well as between the ordinary courts and other courts;
- c) between the States as well as between a State and the Federation.

(2) The Constitutional Court furthermore determines at the application of the Federal Government, or a State Government whether an act of legislation or execution falls into the competence of the Federation or the States.

Article 138a [Competence Agreements]

(1) The Constitutional Court establishes on application by the Federal Government or a State Government concerned whether an agreement within the meaning of Article 15a (1) exists and whether the obligations arising from such an agreement, save in so far as it is a matter of pecuniary claims, have been fulfilled.

(2) If it is stipulated in an agreement within the meaning of Article 15a (2), the Court also establishes on application by a State Government concerned whether such an agreement exists and whether the obligations arising from such an agreement, save in so far as it is a matter of pecuniary claims, have been fulfilled.

Article 139 [Ordinances]

(1) The Constitutional Court pronounces on application by a court whether ordinances issued by a Federal or State authority are contrary to law, but ex officio in so far as the Court would have to apply such an ordinance in a pending suit. It also pronounces on application by the Federal Government whether ordinances issued by a State authority are contrary to law, and likewise on application by the County concerned whether ordinances issued by a County supervisory authority in accordance with Article 119a (6) are contrary to law. It also pronounces whether ordinances are contrary to law when an application alleges direct infringement of personal rights through such illegality in so far as the ordinance has become operative for the applicant without the delivery of a judicial decision or the issue of a ruling; Article 8 (3) applies analogously to such applications.

(2) If the litigant in a suit lodged with the Constitutional Court, entailing application of an ordinance by the Administrative Court, receives satisfaction, the proceedings initiated to examine the ordinance's legality shall nevertheless continue.

(3) The Constitutional Court may rescind an ordinance as contrary to law only to the extent that its rescission was expressly submitted or the Court would have had to apply it in the pending suit. If the Court reaches the conclusion that the whole ordinance

- a) has no foundation in law;
- b) was issued by an authority without competence in the matter; or
- c) was published in a manner contrary to law,

it shall rescind the whole ordinance as illegal. This does not apply if rescission of the whole ordinance manifestly runs contrary to the legitimate interests of the litigant who has filed an application pursuant to the last sentence in Paragraph (1) or whose suit has been the occasion for the initiation of ex officio examination proceedings into the ordinance.

(4) If the ordinance has, at the time of the Constitutional Court's delivery of its judgment, already been repealed and the proceedings were initiated ex officio or the application was filed by a court or an applicant alleging direct infringement of his personal rights through the ordinance's illegality, the Court must pronounce whether the ordinance contravened the law. Paragraph (3) applies analogously.

(5) The judgment by the Constitutional Court which rescinds an ordinance as contrary to law imposes on the highest competent authority in the Federation or State the obligation to publish the rescission without delay. This applies analogously in the case of a pronouncement pursuant to Paragraph (4) above. The

rescission enters into force on the day of publication if the Court does not set a deadline, which may not exceed six months or, if legal dispositions are necessary, a year, for the rescission.

(6) If an ordinance has been rescinded on the score of illegality or if the Constitutional Court has pursuant to Paragraph (4) pronounced an ordinance to be contrary to law, all courts and administrative authorities are bound by the Court's decision. The ordinance shall, however, continue to apply to the circumstances effected before the rescission, the case in point excepted, unless the Court in its rescissory judgment decides otherwise. If the Court has in its rescissory judgment set a deadline pursuant to Paragraph (5), the ordinance shall apply to all the circumstances effected, the case in point excepted, till the expiry of this deadline.

Article 139a [Legal Norms]

The Constitutional Court pronounces on application by a court whether in the re-publication of a legal norm the limits of the authority conferred were transcended; ex officio, in so far as the re-publication of the legal norm constitutes the prerequisite to a judgment by the Court itself; also on application by a State Government, in the case of legal norms re-published by the Federation. Likewise on application by the Federal Government in the case of legal norms republished by a State. It pronounces furthermore whether in the re-publication of a legal norm the limits of the authority conferred were transcended when an application alleges direct infringement of personal rights in so far as the republished legal norm has become operative against the applicant without the delivery of a judicial decision or the issue of a ruling. Article 59 (2), (3) and (5) as well as Article 139 (2) to (6) apply analogously.

Article 140 [Laws]

(1) The Constitutional Court pronounces on application by the Administrative Court, the Supreme Court, or a competent appellate court whether a Federal or State law is unconstitutional, but ex officio in so far as the Court would have to apply such a law in a pending suit. It pronounces also on application by the Federal Government whether State laws are unconstitutional and likewise on application by a State Government or by one third of the House of Representatives' members whether Federal laws are unconstitutional. A State constitutional law can provide that such a right of application as regards the unconstitutionality of State laws lies with one third of the State Parliament's members. The Court also pronounces whether laws are unconstitutional when an application alleges direct infringement of personal rights through such unconstitutionality in so far as the law has become operative for the applicant without the delivery of a judicial decision or the issue of a ruling. Article 89 (3) applies analogously to such applications.

(2) If the litigant in a suit lodged with the Constitutional Court, entailing application of a law by the Court receives satisfaction, the proceedings initiated to examine the law's constitutionality shall nevertheless continue.

(3) The Constitutional Court may rescind a law as unconstitutional only to the extent that its rescission was expressly submitted or the Court would have to apply the law in the suit pending with it. If, however, the Court concludes that the whole law was enacted by a legislative authority unqualified in accordance with the allocation of competence or published in an unconstitutional manner, it shall rescind the whole law as unconstitutional. This does not apply if rescission of the whole law manifestly runs contrary to the legitimate interests of the litigant who has filed an application pursuant to the last sentence in Paragraph (1) or whose suit has been the occasion for the initiation of ex officio examination proceedings into the law.

(4) If the law has, at the time of the Constitutional Court's delivery of its judgment, already been repealed and the proceedings were initiated ex officio or the application filed by a court or an applicant alleging direct infringement of personal rights through the law's unconstitutionality, the Court must pronounce whether the law was unconstitutional. Paragraph (3) applies analogously.

(5) The judgment by the Constitutional Court which rescinds a law as unconstitutional imposes on the Federal Chancellor or the competent State-Governor the obligation to publish the rescission without delay. This applies analogously in the case of a pronouncement pursuant to Paragraph (4). The rescission enters into force on the day of publication if the Court does not set a deadline for the rescission. This deadline may not exceed one year.

(6) If a law is rescinded as unconstitutional by a judgment of the Constitutional Court, the legal provisions rescinded by the law which the Court has pronounced unconstitutional become effective again, unless the judgment pronounces otherwise, on the day of entry into force of the rescission. The publication on the rescission of the law shall also announce whether and which legal provisions again enter into force.

(7) If a law has been rescinded on the score of unconstitutionality or if the Constitutional Court has, pursuant to Paragraph (4), pronounced a law unconstitutional, all courts and administrative authorities are

bound by the Court's decision. The law shall, however, continue to apply to the circumstances effected before the rescission, the case in point excepted, unless the Court in its rescissory judgment decides otherwise. If the Court has in its rescissory judgment set a deadline pursuant to Paragraph (5), the law shall apply to all the circumstances effected, the case in point excepted, till the expiry of this deadline.

Article 140a [Treaties]

(1) Article 140 shall apply to treaties concluded pursuant to Article 50 with the sanction of the House of Representatives and correspondingly Article 139 to all other treaties with the provision that the authorities competent for their execution shall, from the day of the judgment's publication, not apply those which the Court establishes as being contrary to law or unconstitutional unless it determines a deadline prior to which such a treaty shall continue to be applied. The deadline may not exceed two years in the case of treaties specified in Article 50 and one year in the case of all others.

(2) If the Constitutional Court establishes that a treaty whose fulfillment requires the issue of laws or ordinances is contrary to law or unconstitutional, the effect of the vote in accordance with Article 50 (2) or of the ordinance in accordance with Article 65 (1) second sentence expires.

4. Үндсэн хууль зөрчсөн талаар цэцийн гишүүдээс гаргасан шийдвэрийг Сеймд өргөн баригдснаас хойш 6 сарын хугацаанд Сеймээр хэлэлцэгдээгүй тохиолдолд, эсхүл авч хэлэлцсэн боловч ямар нэгэн шийдвэр гаргаагүй буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд цэцийн шийдвэр эцсийнх байна.

16.1. Үндсэн хуулийн шүүхийн ерөнхийлөгч нь хууль, дүрэм журамд заагдсан эрхийн хүрээнд түүнийг гадаад үйл ажиллагаанд төлөөлөх болон бусад үйл ажиллагаанд оролцоно.

16.2. Дэд ерөнхийлөгч нь ерөнхийлөгчийг эзгүй үед түүнийг орлох бөгөөд мөн ерөнхийлөгчөөс өгсөн бусад үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ.

16.3. Дээрх 2-ийн аль аль нь үүргээ гүйцэтгэх боломжгүй үед ерөнхийлөгчөөс томилсон шүүгч тэднийг орлох бөгөөд ерөнхийлөгч тусгайлан томилоогүй тохиолдолд хамгийн ахмад настай шүүгч тэднийг орлоно.

Article 141 [Elections]

(1) The Constitutional Court pronounces upon:

- a) challenges to the election of the Federal President and elections to the popular representative bodies or the constituent authorities (representative bodies) of statutory professional associations;
- b) challenges to elections to a State Government and to local authorities entrusted with executive power;
- c) application by a popular representative body for a loss of seat by one of its members;
- d) application by a constituent authority (representative body) of a statutory professional associations for a loss of seat by one of the members of such an authority;
- e) the challenge to rulings whereby the loss of a seat in a popular representative body, in a local authority entrusted with executive power or in a constituent authority (representative body) of a statutory professional association has been enunciated, in so far as laws of the Federation or States governing elections provide for declaration of a loss of seat by the ruling of an administrative authority, and after all stages of legal remedy have been exhausted.
- f) The challenge (application) can be based on the alleged illegality of the electoral procedure or on a reason provided by law for the loss of membership in a popular representative body, in a local authority entrusted with executive power, or in a constituent authority (representative body) of a statutory professional association. The Court shall allow an electoral challenge if the alleged illegality has been proved and was of influence on the election result. In the proceedings before the administrative authorities, the popular representative body or statutory professional association has litigant status.

(2) If a challenge pursuant to Paragraph (1)(a) is allowed and it thereby becomes necessary to hold the House of Representatives or a State Parliament election in whole or in part again, the representative body's members concerned lose their seat at the time when it is assumed by those elected at the ballot which has to be held within a hundred days after delivery of the Constitutional Court's decision.

(3) The premise for a decision by the Constitutional Court in challenges to the result of initiatives or referenda will be prescribed by Federal law. How long, in view of the possibility of such a challenge, it is necessary to retard publication of the law about which a referendum took place, can also be enacted by

Federal law.

Article 142 [Liability of Officers]

- (1) The Constitutional Court pronounces on suits which predicate the constitutional responsibility of the highest Federal and State authorities for legal contraventions culpably ensuing from their official activity.
- (2) Suit can be brought:
- a) against the Federal President, for contravention of the Federal Constitution: by a vote of the Federal Assembly;
 - b) against members of the Federal Government and the authorities placed with regard to responsibility on an equal footing with them, for contravention of the law: by a vote of the House of Representatives;
 - c) against members of a State Government and the authorities placed by the present law or the State constitution with regard to responsibility on an equal footing with them, for contravention of the law: by a vote of the competent State Parliament;
 - d) against a State-Governor, his deputy (Article 105 (1)) or a member of the State Government (Article 103 (2) and (3)) for contravention of the law as well as for non-compliance with ordinances or other directives (instructions) of the Federation in matters pertaining to the indirect Federal administration, in the case of a member of the State Government also with regard to instructions from the State-Governor in these matters: by a vote of the Federal Government;
 - e) against the authorities of the Federal capital, Vienna, in so far as within its autonomous sphere of competence they perform functions from the domain of the Federal executive power, for contravention of the law: by a vote of the Federal Government;
 - f) against a State-Governor, for non-compliance with an instruction pursuant to Article 14 (8) by a vote of the Federal Government;
 - g) against a president or executive president of a State school board, for contravention of the law as well as for non-compliance with ordinances or other directives (instructions) of the Federation: by a vote of the Federal Government.
- (3) If, pursuant to Paragraph (2)(d), the Federal Government brings a suit only against a State-Governor or his deputy and it is shown that another member of the State Government in accordance with Article 103 (2) concerned with matters pertaining to the indirect Federal administration is guilty of an offence within the meaning of Paragraph (2)(d), the Federal Government can at any time pending the passing of judgment widen its suit to include this member of the State Government.
- (4) The condemnation by the Constitutional Court shall pronounce a forfeiture of office and, in particularly aggravating circumstances, also a temporary forfeiture of political rights. In the case of minor legal contraventions in the instances mentioned in Paragraph (2)(d), (f), and (g) the Court can confine itself to the statement that the law has been contravened. From forfeiture of the office of president of the State school board ensues forfeiture of the office with which pursuant to Article 81a (3)(b) it is linked.
- (5) The Federal President can avail himself of the right vested in him in accordance with Article 65 (2)(c) in the cases under Paragraph (2)(a), (b), and (c) only on the request of the representative body which has voted for the filing of the suit, in cases under Sub-Paragraphs (d), (f), and (g) only on the request of the Federal Government, and in all cases only with the approval of the defendant.

Article 143 [Criminal Liability of Officers]

A suit can be brought against the persons mentioned in Article 142 also on the score of actions involving penal proceedings connected with the activity in office of the individual to be arraigned. In this case, competence lies exclusively with the Constitutional Court; any investigation already pending in the ordinary criminal courts devolves upon it. The Court can in such cases, in addition to Article 142 (4), apply the provisions of the criminal law.

Article 144 [Administrative Jurisdiction]

- (1) The Constitutional Court pronounces on rulings by administrative authorities in so far as the applicant alleges an infringement by the ruling of a constitutionally guaranteed right or the infringement of personal rights on the score of an illegal ordinance, an unconstitutional law, or an unlawful treaty. On the same premises, the Court likewise pronounces on complaints against the exercise of direct administrative power and compulsion against a particular individual. The complaint can only be filed after all other stages of legal remedy, in so far as such come into consideration, have been exhausted.
- (2) The Constitutional Court can, before the proceedings, decide to reject a hearing of the complaint if it has no reasonable prospect of success. The rejection of the hearing is inadmissible if it concerns a case

that according to Article 133 is barred from the competence of the Administrative Court.

(3) If the Constitutional Court finds that a right within the meaning of Paragraph (1) has not been infringed by the challenged ruling or the exercises of direct administrative power and compulsion, and if it does not concern a case that in accordance with Article 133 is barred from the competence of the Administrative Court, the Court shall, on the request of the applicant, at the same time as it rejects the plea transfer the complaint to the Administrative Court for decision whether the applicant, by the ruling or the exercise of direct administrative power and compulsion, sustained the infringement of any other right. This applies analogously in the case of decisions in accordance with Paragraph (2).

Article 145 [International Law]

The Constitutional Court pronounces judgment on contraventions of international law in accordance with the provisions of a special Federal law.

Article 146 [Enforcement]

(1) The enforcement of judgments pronounced by the Constitutional Court on claims made in accordance with Article 137 is implemented by the ordinary courts.

(2) The enforcement of other judgments by the Constitutional Court is incumbent on the Federal President. Implementation shall, in accordance with his instructions, lie with the Federation or States authorities, including the Federal Army, appointed at his discretion for the purpose. The request to the Federal President for the enforcement of such judgments shall be made by the Constitutional Court. The aforementioned instructions by the Federal President require, if it is a matter of enforcements against the Federation or Federal authorities, no countersignature in accordance with Article 67.

Article 147 [Establishment]

(1) The Constitutional Court consists of a President, a Vice-President, twelve additional members, and six substitute members.

(2) The President, the Vice-President, six additional members, and three substitute members are appointed by the Federal President on the recommendation of the Federal Government; these members shall be selected from among judges, administrative officials, and professors holding a chair in law. The remaining six members and three substitute members are appointed by the Federal President on the basis of recommendations listing three candidates for each vacancy, the House of Representatives submitting those for three members and two substitute members and the Senate those for three members and one substitute member. Three members and two substitute members must have their domicile outside the Federal capital, Vienna. Administrative officials who are appointed members of the Constitutional Court shall, in so far and for as long as they are not superannuated, be freed from all official duties.

(3) The President, the Vice-President, and the other members and substitute members must have completed their studies in law and political science and for at least ten years have held a professional appointment which prescribes the completion of these studies.

(4) The following cannot belong to the Constitutional Court: members of the Federal Government or a State Government, members of the House of Representatives, the Senate, or any other popular representative body; for members of these representative bodies who have been elected for a fixed term of legislation or office such incompatibility continues until the expiry of that term of legislation or office. Finally, persons who are under employment of or hold office in a political party cannot belong to the Constitutional Court.

(5) Anyone who, during the preceding four years, has exercised one of the functions specified in Paragraph (4), cannot be appointed President or Vice-President of the Constitutional Court.

(6) Articles 87 (1) and (2), 88 (2) apply to members of the Constitutional Court; detailed provisions will be prescribed in the Federal law to be promulgated pursuant to Article 148. The 31 Dec of the year in which a judge completes his seventieth year of life is fixed as the age limit on whose attainment his term of office ends.

(7) If a member or substitute member disregards without satisfactory excuse three successive requests to attend a hearing of the Constitutional Court, the Court shall formally establish the fact after listening to his testimony. Establishment of the fact entails loss of membership or the status of substitute membership.

Article 148 [Organizational Law]

Detailed provisions about the organization and procedure of the Constitutional Court will be prescribed by a special Federal law and in Standing Orders to be voted by the Constitutional Court on the basis of this.

**ЯПОН БОЛОН ИХ БРИТАНИ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО,
ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ***/Лавлагаа, мэдээлэл/**Б.Хатантуул/LLM/, Ш.Хишигсүрэн/LLM/*

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын захиалгаар Их Британи, Японы Прокурорын байгууллагын тогтолцоо болон үйл ажиллагааны талаархи холбогдох мэдээллийг бэлтгэв.

1. Их Британи, Япон Улсын Прокурорын байгууллагын тогтолцооны талаархи харьцуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”, мөн зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж тус тус заасан байдаг. Үүнээс үзэхэд прокурорын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага бөгөөд прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг 1992 оны шинэ Үндсэн хуулийн дагуу 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулиар тогтоосон байна. Харин 2002 оны 7 дугаар сарын 4-ны өдрийн хуулиар 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болгож, “Прокурорын байгууллагын тухай” хуулийг шинэчлэн баталсан нь, Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг шинэчлэн тодорхойлсон байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлд прокурорын байгууллагын бүтцийг тогтоосон бөгөөд прокурорын байгууллага нь Улсын ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газраас бүрдэнэ. Түүнчлэн прокурорын газрыг ажлын шаардлага, хүн ам, нутаг дэвсгэрийн байдлыг харгалзан Улсын Их Хурал байгуулна. Прокурорын хяналтын ажлын онцлог, Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн дагнасан прокурорын газрыг байгуулж болно. /ПБТХ-ийн 8.2./

Прокурорын газар үйл ажиллагааныхаа чиглэлээр зохион байгуулалтын бүтцийн нэгж, алба болон ажлын аппараттай байна. Прокурорын хяналтын эрх зүйн үндэс нь Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрэлддэг байна.

Төрийн байгууллагын тогтолцоонд прокурорын байгууллагын эзлэх байр суурийг түүний эрх хэмжээ, үүрэг, зорилтоос шалтгаалан ялгаатай тодорхойлсон байдаг бөгөөд дэлхийд прокурорын байгууллагыг үндсэн 4 бүлэгт хувааж авч үзсэн байдаг²⁵.

1. Прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны бүрэлдэхүүнд багтдаг.
2. Прокурорын байгууллага нь шүүхийнхээ корпусын бүрэлдэхүүнд багтаж, шүүхийнхээ дэргэд байдаг бөгөөд захиргааны хувьд бие даасан байдалтай байдаг.
3. Прокурорын байгууллага нь тусдаа бие даасан байдалтай байдаг.
4. Прокурор, эсхүл түүнтэй төстэй байгууллага байхгүй байдаг.

²⁵ Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал; хүний эрх шүүх эрх мэдэл” Хоёрдугаар дэвтэр, УБ. 2004 он, 231 дэх тал.

1. Япон улсын прокурорын байгууллага, түүний тогтолцоо

Япон Улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд “прокурорууд Дээд шүүхийн эрх мэдэлд хамаарна” гэж заасан байдаг. Японы прокурорын байгууллага нь шүүхийн тогтолцоотойгоо зохицсон бүтэцтэй байдаг байна. Японы Шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, давж заалдах шатны шүүх, дүүргийн шүүх, гэр бүлийн шүүх, онцгой шүүх гэсэн бүтэцтэй байдаг бол Прокурорын байгууллага нь дээд шүүхийн дэргэдэх ерөнхий прокурорын газар, дээд шатны, нутаг дэвсгэрийн болон бусад шүүхүүдийн дэргэдэх прокурорын албад гэж тогтолцоотой байна. Нөгөө талаас Японы прокурорын байгууллагыг Ерөнхий прокурор тэргүүлдэг нь нэгдмэл, төвлөрсөн шинжтэй бөгөөд захиргааны хувьд Хууль зүйн яамны харьяанд байдаг, харин эрх мэдэл нь тусдаа прокурорын байгууллагын нэгдмэл тогтолцооны зарчимд тулгуурласан гэж үздэг байна.

Японы прокурорын байгууллага нь эрүүгийн хамгийн чухал ноцтой хэргийг мөрддөг, эрүүгийн хэрэг үүсгэж, хэргийг шүүхэд шилжүүлдэг, хэргийн талаар шүүхэд шилжүүлэхгүйгээр шийдвэр гаргадаг, шүүх хуралдаан дээр яллах ажиллагааг хэрэгжүүлдэг байна²⁶. Түүнчлэн прокурор нь цагдаагийн мөрдөн байцаах ажиллагаанд шууд оролцох, зарим тохиолдолд зарим мөрдөн байцаах ажиллагааг шууд хэрэгжүүлдэг байна. Мөн цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, бусад ажиллагаанд хяналт тавьж, эрүүгийн ялын биелэлтийг хангана, өөрөөр хэлбэл шүүхээс ногдуулсан ялыг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Прокурорууд эрүүгийн мөрдөлт мөшгилтийг үүсгэж, ялын дүгнэлт гарган шүүхэд танилцуулж, яллах, иргэний хэргийг шүүхээр хянан хэлэлцэх үед “нийтийн ашиг сонирхол”-ыг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх эдэлдэг байна.

Дагаж мөрдөж буй шүүн таслах ажиллагааны журам ёсоор прокурор нь өөрийн мэдэлд байгаа бүхий л нотлох баримтыг яллагдагч болон өмгөөлөгчид нь үзүүлж мэдэгдэх ёсгүй төдийгүй яллагдагчид ашигтай нотолгоо, ялангуяа түүний гэм буруугийг нотлох нотолгоог ч нуун далдалж болно²⁷. Прокурор нь хэргийн бүх материалыг танилцуулах албагүй (шүүх хурлаас өмнө) бөгөөд шүүгчид ямарваа бусад бичиг баримтгүйгээр гагцхүү ялын дүгнэлтийг шилжүүлэн өгнө.²⁸ Энэ нь шүүх хуралдааны мэтгэлцэх зарчмыг нээлттэй болгож өгдөг байна.

Япон Улсад²⁹ улсын хэмжээнд 430 гаран прокурорын алба Онцгой шүүхийн дэргэд байдаг бол, дүүргийн болон гэр бүлийн шүүхийн дэргэд 50 прокурорын алба, давж заалдах шатны шүүхийн дэргэд 8, Дээд шүүхийн дэргэд Прокурорын ерөнхий газар гэсэн бүтэцтэй байна.

Үүнээс үзэхэд Япон Улсад прокурор нь нэлээд өргөн хүрээний бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

2. Их Британи улсын прокурорын байгууллага, түүний тогтолцоо

Их Британид прокурорын институт байхгүй бөгөөд төрийн нэрийн өмнөөс яллах ажиллагаа нэг бол өмгөөлөгчид (баристер, солиситор), эсхүл тусгай төрийн байгууллага-Хатан хааны Ял шийтгэх алба (The Crown Prosecution) хэрэгжүүлдэг. 1985 оны Гэмт хэрэгт ял шийтгэх Актаар (Prosecution of Offences Act 1985) Хатан хааны Ял шийтгэх албыг байгуулж (The Crown Prosecution) Английн Цагдаагын Байгууллагын хамааралд байсан гэмт хэрэгт ял тулгах ажиллагааг хариуцах

²⁶ Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан, “Прокурорын хяналт” УБ 2009, 31-47 дахь тал.

²⁷ Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан мөн номын 31-47 дахь тал.

²⁸ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001 он. 440 дэх тал

²⁹ <http://www.kantei.go.jp/foreign/judiciary/0620system.html-aac> татав /2010.3.15/

болжээ. Цагдаагийн байгууллага нь мөрдөн шалгах болон хэрэгт ял тулгахыг хавсран гүйцэтгэх нь буруу юм гэдгийг хүлээн зөвшөөрч уг шинэчлэлийг хийжээ.

Уламжлалаас үзэхэд Английн шүүхээр яллагдаж байгаа эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажлын ихэнхийг цагдаагийн байгууллага гүйцэтгэж ирсэн бөгөөд гагцхүү хамгийн ноцтой хүнд хэргийн тухайд л Ял шийтгэх алба хариуцдаг байна.

Хатан хааны Ял шийтгэх албын удирдлага (Нийтийн ял шийтгэхийн захирал- Director of Public Prosecution) нь Ерөнхий Атторнейгоос томилогддог. Уг байгууллага нь 5 зэрэглэлийн хуульч нараас бүрддэг байна.

-Хатан хааны прокурор

-Хатан хааны ахлах прокурор

- Хатан хааны өмгөөлөгчид

- Хатан хааны ахлах өмгөөлөгчид

- Хатан хааны үндсэн өмгөөлөгчид

Хатан хааны ахмад өмгөөлөгчид болон Хатан хааны үндсэн өмгөөлөгчид нь гагцхүү хамгийн ноцтой хүнд хэргийн яллах ажиллагаанд оролцдог байна.

Энэ алба (төрийн ялагчдын үндсэн үүрэг) нь эрүүгийн хэрэг үүсгэн эрүүгийн мөрдөлтийг явуулахаас гадна цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар бүх шатны шүүхэд төрийн яллах ажиллагааг дэмжих, зарим тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, тэдгээрийн мөрдөн байцаах ажилд биечлэн оролцох явдал байдаг байна.

Ерөнхий Атторней нь сайд нарын танхимын гишүүн бөгөөд улсын ашиг сонирхлын хөндсөн шүүх ба хууль зүйн бусад хэргийг эрхэлж улс төрийн онцгой ач холбогдолтой хэргийн талаархи яллах ажиллагааг шүүхэд дэмжих асуудлыг хариуцдаг³⁰.

Хатан хааны Ял шийтгэх албатай төстэй алба нь Австрали, Англи, Канад, Уэльс, Гонконг, Умард Ирланд, ӨАБНУ гэх мэт Вэстминстрийн тогтолцоотой орнуудад байна.

2. 1990 ОНООС ӨМНӨХ ЦААЗААР АВАХ ЯЛЫН ТАЛААРХИ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

1990 оноос өмнөх хуульд цаазаар авах ялыг ямар гэмт хэрэгт ногдуулж байсныг 2002 оны Эрүүгийн хуультай харьцуулсан холбогдох мэдээллийг бэлтгэв. Харин тухайн ялтай холбоотой мэдээлэл болох цаазаар авах ял гүйцэтгэх журам, ажиллагаа, гүйцэтгэсэн тухай баримт бичгийг **маш нууц зэрэглэлд** хамааруулан нууцлах хугацааг **байнга** гэж 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 55 дахь хэсэгт заасан. Иймд цаазаар авах ял оноосон гэмт хэргийн хавтас хэрэгтэй танилцаж судлах боломж бага байдаг. Монгол Улсад цаазаар авах ял шийтгүүлэгчдийн тоог албан ёсоор хэвлэн гаргахыг зөвшөөрдөггүй.

2.1. 1987 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялын байдал

1987 оны (шинэчлэн найруулсан) Эрүүгийн хуулиар эх орноосоо урвах (60 дугаар зүйл); тагнуул хийх (61 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн

³⁰ S.NARANGEREL. English-Mongolian Jurisprudence Dictionary. УБ 2005, 121-122 дахь тал

зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); зандалчлах (73 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (85 дугаар зүйл); хүчиндэх (112 дугаар зүйл); улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл); цагдан сэргийлэх байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах (222 дугаар зүйл); агаарын хөлгийг авч зугатаах (268 дугаар зүйл) гэмт хэрэгт цаазаар авах ял тогтоосон байна. Ийнхүү эрүүгийн хуулийн 12 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Мөн хуулиар 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял ногдуулахыг хориглосон.

1990 оноос хойшхи зарим шинэчлэлт БНМАУ-ын Бага Хурал **1991** онд “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль баталж, эд хөрөнгийн шинжтэй гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхийг хүчингүй болгосон нь цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг хумисан алхам болсон.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хууль баталсантай холбогдуулан дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийг түүнтэй нийцүүлэх зүй ёсны шаардлага гарч ирсэн байна. Монгол Улсын Их Хурал **1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр** “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” баталж, өмнөх Эрүүгийн хуулиар 10 гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулж байсныг дараахь таван төрлийн гэмт хэрэгт эл ялыг тогтоосон байна: улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (86 дугаар зүйлийн 2 дахь хэсэг); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (112 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)

2.2. 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялын байдал

Монгол Улсын Их Хурал 2002 онд шинэ Эрүүгийн хууль баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдүүлж байна. Тус Эрүүгийн хуулиар дараахь төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон байна: төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах (81.2 дугаар зүйл); хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (91.2 дугаар зүйл); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл) зандалчлах (177.2 дугаар зүйл); төрлөөр устгах (302 дугаар зүйл) зэрэг хэрэгт цаазаар авах ял оногдуулж байсан бол Эрүүгийн хуульд (178¹ дүгээр зүйл) Терроризм гэсэн зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэнээр нийтдээ 7 зүйлд цаазаар авах ял оногдуулахаар заасан. Мөн хуулийн 53.4 дүгээр зүйлд “Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй” хэмээн заасан.

2002 оны Эрүүгийн хуулийн хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл) гэмт хэрэгт үйлдвэр, байгууламж, зам харилцаа, холбооны хэрэгсэл, бусад эд хөрөнгийг тэслэх, дэлбэлэх, галдан шатаах болон бусад аргаар хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хүн мал, ургамлын гоц халдварт өвчин тараасан зэрэг хүний амь нас зориуд бусниулаагүй үйлдэлд цаазаар авах ял ногдуулах боломжтой байгаа юм. Өмнөх Эрүүгийн хуульд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтай санаатай алсан 14 үндэслэлийг жагсааж цаазаар авах ял тогтоож байсан бол 2002 оны Эрүүгийн хуулиар эл жагсаалт 17 болж гурваар нэмэгдүүлсэн байна. Онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл) гэмт хэрэгт эл гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, өөр хүнд хор уршиг учирсан, бага насны хүүхэд хүчиндсэн зэрэг хүний амь нас хохируулаагүй таван тохиолдолд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоожээ. Зандалчлах “терроризм үйлдэх” (177.2 дугаар зүйл) гэмт хэрэгт эл гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, өөр хүнд хор уршиг учирсан зэрэг хүний амь нас

хохируулаагүй дөрвөн тохиолдолд цаазаар авах ял тогтоосон байна. Төрлөөр устгах (302 дугаар зүйл) бие махбодид хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан зэрэг хүний амь нас бусниулаагүй дөрвөн үйлдэлд цаазаар авах ял хэрэглэхээр заажээ. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд төрлөөр устгах гэмт хэрэгт цаазаар авах ял тогтоогоогүй бол Монгол улсын 2002 оны Эрүүгийн хуулиар цаазаар авах ял заасан байна. Ийнхүү Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийг өмнөх хуультай (1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуультай) харьцуулахад цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг өргөжүүлсэн байна.

Монгол улсад цаазаар авах ялыг шүүхээс сүүлийн 40 жилд ногдуулсан байдалд хийсэн судалгаа (1965-2005)³¹

Он	Нийт	Өсөлт / бууралтын харьцуулалтын хувь (%)	
		өмнөх жилтэй	1965 онтой
1965	7		
1966	12	+71.4%	+71.4%
1967	8	-33.3%	+14.2%
1968	10	+25%	+42.8%
1969	10	0%	+42.8%
1970	4	-60%	-57.1%
1971	8	+100%	+14.2%
1972	5	-37.5%	-28.5%
1973	8	+37.5%	+14.2%
1974	10	+25%	+42.8%
1975	13	+30%	+85.7%
1976	12	-7.6%	+71.4%
1977	12	0%	+71.4%
1978	14	+12.6%	+100%
1979	26	+85.7%	+271.4%
1980	19	-26.9%	+171.4%
1981	18	-5.2%	+157.1%
1982	17	-5.5%	+142.8%
1983	13	-23.5%	+85.7%
1984	17	+23.5%	+142.8%
1985	27	+58.8%	+285.7%
1986	19	+29.6%	+171.4%
1987	14	-26.3%	+100%
1988	13	-7.1%	+85.7%
1989	14	+7.1%	+100%
1990	15	+7.1%	+114.2%
1991	21	+40%	+200%
1992	34	+61.9%	+385.7%
1993	28	-17.6%	+300%
1994	30	+7.1%	+328.5%

³¹ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайлангаас УБ., 2005 он, Монголын Эмнести Интернэшнл судалгааны тайлангаас зөвшөөрөлтэйгээр нийтлэв.

1995	32	+6.6%	+357.1%
1996	21	-34.3%	+200%
1997	24	+14.2%	+242.8%
1998	17	-29.1%	+142.8%
1999	24	+29.1%	+242.8%
2000	13	-45.8%	+85.7%
2001	24	+45.8%	+242.8%
2002	18	25%	+157.1%
2003	22	+22.2%	+214.2%
2004	22	0%	+214.2%
2005	31	+29%	+342.8%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЦААЗААР АВАХ ЯЛЫН БАЙДАЛ, ХАНДЛАГА, БАЙР СУУРЬ

/Харьцуулсан лавлагаа, мэдээлэл/

Б.Хатантуул/LLM/, Ш.Хишигсүрэн/LLM/

Нэг. Цаазаар авах ялыг халах талаархи олон улсын баримт бичгүүд

Цаазаар авах ялыг халах тухай олон улсын дөрвөн гэрээ, хэлэлцээр байдгийн нэг нь дэлхий нийтийн, гурав нь бүс нутгийн улс орнуудад үйлчлэх баримт бичгүүд байна. Улс орнууд эдгээр баримт бичгийн үзэл санааг хүлээн зөвшөөрч соёрхон баталснаар тухайн гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон *оролцогч улс* болно. Ингэснээр олон улсын эрх зүйн хүрээнд заасан нөхцлүүдийг хамгаалах, хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Мөн улс орнууд гэрээ, хэлэлцээрийн үзэл санааг дэмжиж *гарын үсгээ зурж* болдог бөгөөд энэ нь тухайн баримт бичгийн зорилго, зорилтыг үгүйсгэх ямар нэг зүйл хийхгүй байхыг хүлээж буй хэрэг юм.

1.1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хоёр дахь нэмэлт Протокол

Цаазаар авах ялыг халах зорилго бүхий энэхүү баримт бичгийг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд баталжээ. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халахыг хангадаг бөгөөд оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд энэ ялыг дайны цагт хэрэглэхийг зөвшөөрдөг байна. Тухайлбал, 2008 онд Аргентин, Чили, Гондурас, Руанда, Узбекистан зэрэг 5 улс уг Протоколд нэгдэн орсноос Чили улс дайны үеийн онц ноцтой цэргийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял хэрэглэж болзошгүй хэмээн урьдчилан тайлбар хийсэн байна. Хүний эрхийг хамгаалахын төлөөх олон улсын хөдөлгөөн Эмнести Интернэшнл байгууллагаас гаргасан судалгаагаар 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү Протоколд оролцогч 70 орон³², хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан боловч хараахан соёрхон батлаагүй байгаа 4 орон байгаа ажээ (Гвиней-Бисау, Никарагуа, Польш, Сан-Томе ба Принсипи).

1.2. Хүний эрхийн Америкийн конвенцийн Протокол

Америкийн улсуудын байгууллагын Ерөнхий Ассамблей 1990 онд баталсан бүс нутгийн улс орнуудад үйлчлэх баримт бичиг. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халахыг хангадаг бөгөөд оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд энэ ялыг дайны цагт хэрэглэхийг зөвшөөрдөг байна. 2008 оны байдлаар Өмнөд Америкийн 11 орон уг Протоколыг хүлээн зөвшөөрч баталснаар оролцогч орон (Аргентин, Бразил, Чили, Коста Рика, Эквадор, Мексик, Никарагуа, Панам, Парагвай, Уругвай, Венесуэл) болжээ.

³² Албани, Андорра, Аргентин, Австрали, Австри, Азербайжан, Белги, Босни Герцеговин, Болгар, Канад, Кабо Верде, Чили, Колумб, Косто Рика, Хорват, Кипр, Чех, Дани, Джибути, Эквадор, Эстони, Финланд, Франц, Грж, Герман, Грек, Гондурас, Унгар, Исланд, Ирланд, Итали, Либер, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальт, Мексик, Молдав, Монако, Монтенегро, Мозамбик, Намиби, Непал, Голланд, Шинэ Зеланд, Норвеги, Панам, Парагвай, Филиппин, Португаль, Румын, Руанда, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Сэйчэллийн арлууд, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцари, Згн Тимор, Турк, Туркмен, Украин, Их Британи, Уругвай, Узбекистан, Венесуэл

1.3. Хүний эрхийн Европын конвенцийн 6 дугаар Протокол

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн цаазаар авах ялыг халах талаархи заалтыг хэрэгжүүлэхээр Европын зөвлөлөөс 1982 онд батлан гаргасан баримт бичиг. Энэ нь энх тайван цагт цаазаар авах ялыг халахыг хангадаг боловч оролцогч улс дайны болон дайн бүхий байдлын цагт энэ ялыг хэрэглэх боломжтой ажээ. 2008 оны байдлаар уг Протоколд Хүний эрхийн Европын конвенцид оролцогч 46 орон уг Протоколд оролцогч орон³³, ОХУ хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байна.

1.4. Хүний эрхийн Европын конвенцийн 13 дугаар Протокол

Энэхүү баримт бичгийг Европын зөвлөлөөс 2002 онд батлан гаргажээ. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халах буюу дайны болон дайн бүхий байдлын цагт ч хэрэглэхийг хориглодог байна. 2008 оны байдлаар уг Протоколд оролцогч 40 орон³⁴, гарын үсэг зурсан 5 орон байна. (Армени, Итали, Латви, Польш, Испани)

Цаазаар авах ялыг халах тухай олон улсын дээрхи үндсэн баримт бичгүүдээс гадна 2008 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей цаазаар авах ялаас түр хугацаагаар түдгэлзэхийг уриалсан хоёр дахь тогтоолоо батлан гаргажээ. НҮБ-ын нийт гишүүн орнууд хамтран цаазаар авах ялаа түр зогсоохыг уриалсан тогтоолыг баталсан нь нийт улс орнууд болон бүс нутгийн хэмжээнд зарим чухал алхам хийхэд зохих түлхэц болж байна. Жишээ нь, Африкийн Хүний эрхийн хорооноос цаазаар авах ялыг хэрэглэж байгаа Африкийн улсуудад хандан бүс нутгийн хэмжээнд энэ ялыг халах чиглэлийг баримтлан цаазаар авах ялын гүйцэтгэлийг түр хугацаагаар түдгэлзүүлэхийг уриалсан байна. Мөн Арабын иргэний нийгэм, Арабын орнуудын холбоо, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар ба түүнчлэн олон улсын төрийн бус байгууллагуудын (Эмнести Интернэшнл г.м) төлөөлөгчид 2008 оны 5 дугаар сард Египетэд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2007 оны 62/149 тоот тогтоолын хэрэгжилтийн тухай хэлэлцэж, цаазаар авах ялыг аажимдаа халах, 18-аас доош насныханд энэ ялыг оноохгүй байхын тулд бодит алхамыг авч хэрэгжүүлэхийг Арабын орнуудаас уриалсан хамтарсан тунхаглал гаргажээ. Түүнчлэн 2010 оны 10 дугаар сард болох НҮБ-ын 65 дахь удаагийн Ерөнхий Ассамблейн чуулганд цаазаар авах ялыг түр зогсоох тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2007, 2008 оны хоёр тогтоолын хэрэгжилтийн талаар Ерөнхий нарийн бичгийн даргын тайланг хэлэлцэх юм.

2010 оны 2 дугаар сард Женев хотноо болсон “Цаазаар авах ялын эсрэг дэлхийн 4 дүгээр конгресс” –оос дараах 5 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Иргэний нийгмийн байгууллагууд болон улс орнуудын төр, засгийн газрын цаазаар авах ялын эсрэг хамтын ажиллагааг өргөжүүлэх

³³ Албани, Андorra, Армени, Австри, Азербайжан, Белги, Босни Герцеговин, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Грж, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальт, Молдав, Монако, Монтенегро, Голланд, Норвеги, Польш, Португаль, Румын, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи

³⁴ Албани, Андorra, Австри, Белги, Босни Герцеговин, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Грж, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Лихтенштейн, Литва, Люксембург, Македони, Мальта, Молдав, Монако, Монтенегро, Голланд, Норвеги, Португаль, Румын, Сан Марино, Серб (Косовог оролцуулан), Словак, Словени, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи

2. Африк, Ази, Өмнөд Америк болон Карибын орнуудын цаазаар авах ялын эсрэг байр суурийг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах
3. Улс орнуудын цаазаар авах ялын эсрэг хийж буй алхамуудыг дэмжих, уг ялыг бүрмөсөн халахад нь урам зориг, бодит дэмжлэг үзүүлэх
4. Цаазаар авах ялыг халахын төлөөх үндэстэн хийгээд бүс нутгийн, дэлхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх
5. Олон улсын түвшинд олон нийтийн санаа бодлыг илүү сонсч, цаазаар авах ял шийтгэгдсэн, мөн хилс хэрэгт баривчлагдан уг ялаар шийтгүүлсэн боловч гэм буруугүй нь нотлогдон цагаадсан хүмүүсийн үгийг сонсч хүмүүст бодитой мэдээлэл өгөх зэрэг зорилтууд оржээ.

Цаазаар авах ялыг бүх нийтээр устгахын төлөө санал санаачилга, тэмцэл, хөдөлгөөн дэлхий нийтэд эрчимтэй өрнөсөөр байна.

Хоёр. Цаазаар авах ялын дэлхий нийтийн байдал

Хүний эрхийг хамгаалахын төлөө кампанит ажил явуулдаг 150 гаруй улс орны 2,2 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий нийтийн хөдөлгөөн Эмнести интернэшнл (Amnesty International) нь 1977 оноос эхлэн цаазаар авах ялыг бүх нийтээр халахын төлөө тууштай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд цаазаар авах ялын дэлхий нийтийн байдлын талаархи судалгааг 2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нэгтгэн гаргажээ. Уг судалгаагаар³⁵ дэлхийн улс орнуудын гуравны хоёроос илүү хувь нь буюу нийт **138** оронд цаазаар авах ялыг халж, харин **59** орон энэ ялыг хэрэглэж байгаа ажээ. Үүнийг доорхи байдлаар ангилан харуулбал:

- Бүх төрлийн гэмт хэрэгт халсан 92
- Ердийн гэмт хэрэгт халсан 10
- Практикт халсан 36 орон тус тус байна.

2008 онд цаазаар авах ялыг хэрэглэж байгаа 59 орноос 25 нь цаазаар авах ялыг гүйцэтгэснийг Эмнести интернэшнл судлан тогтоосноос Хятад (наад зах нь 1718), Иран (346), Саудын Араб (102), АНУ (37), Пакистан (36), Ирак (34), Вьетнам (19), Афганистан (17), Хойд Солонгос (15), Япон (15), Йемен (13), Индонез (10), Ливи (8), Бангладеш (5), Беларусь (4), Египет (2), Малайз (1), Монгол (1), Арабын Нэгдсэн Эмират (1), Бахрейн (1), Бостван (1), Сингапур (1), Гэгээн Киттс ба Невис (1) байна. Энэ нь нийт дүнгээр авч үзвэл 2008 онд 52 оронд 8864 хүнд энэ ялыг оногдуулж, 25 оронд 2390 хүнд уг ялыг гүйцэтгэжээ. Ялын гүйцэтгэлд толгойг нь авах, цахилгаанаар цохиулах, дүүжлэх, хортой тариа хийх, буудах болон чулуудан хороох зэрэг аргыг хэрэглэжээ.

Эмнести Интернэшнлийн судалгаанаас үзэхэд сүүлийн таван жилийн туршид цаазаар авах ял гүйцэтгэсэн **Хятад, Бангладеш, Беларусь, Индонез, Иран, Япон, Хойд Солонгос, Пакистан, Саудын Араб, Сингапур, Вьетнам, Йемен, АНУ** зэрэг 13 орон байна. Мөн өмнөх жилүүдийн адил 2008 онд хамгийн олон цаазаар авах ял гүйцэтгэсэн 5 орны тоонд **Хятад, Иран, Саудын Араб, Пакистан, АНУ** оржээ.

Цаазаар авах ялын гүйцэтгэлийг бүс нутгийн байдлаар авч үзвэл:

2008 онд нийт бүртгэгдсэн цаазаар авах ялын гүйцэтгэлийн 1,838 (76%)-ыг **Ази тивийн орнууд** эзэлж байна. 16 оронд **Хятад (7003), Пакистан (236), Бангладеш (185), Афганистан (131),**

³⁵ <http://www.worldcoalition.org>

Энэтхэг (70), **Вьетнам** (59), **Япон** (27), **Малайз** (22), **Индонез** (10), **Тайван** (8), **Сингапур** (5), **Тайланд** (3), **Хойд Солонгос** (+), **Өмнөд Солонгос** (2), **Шри Ланк** (2), **Лаос** (2) нийт 7767 хүнд энэ ял оноосноос 11 оронд **Хятад** (1718), **Пакистан** (36), **Вьетнам** (19), **Афганистан** (17), **Хойд Солонгос** (15), **Япон** (15), **Индонез** (10), **Бангладеш** (5), **Монгол** (1), **Малайз** (1), **Сингапур** (1) нийт 1838 цаазаар авах ял гүйцэтгэжээ.

Хятадад ялын дээд хэмжээ авч байгаа хүмүүс нь шударга шүүхээр шүүлгэж чадахгүй байх, өмгөөлөгчтэй холбоо тогтоож чадахгүй байх, гэм буруугүй гэдэгт нь үл итгэх, шүүх үйл ажиллагаанд улс төрийн оролцоо их, эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг хүлээн зөвшөөрүүлэх зэрэг алдаа, дутагдлууд гарсаар байгааг судалгаанд тэмдэглэсэн байна. Хятадын Хууль зүйн яам болон Ардын дээд шүүх хамтран цаазаар авахуулах хэрэгт оролцох өмгөөлөгчдийн үүргийг тодорхойлсон хуулийн тайлбарыг 2008 оны 5 дугаар сард гаргаснаар шүүхийн байгууллага болон засгийн газрын хяналтад байдаг өмгөөлөгчдийн холбоонд цаазаар авах ялтай хэргүүдэд удирдамжаар хангаж хөндлөнгөөс оролцох эрх олгожээ.

Энэтхэгт цаазаар авах ялын хэрэгт мөрдөн байцаах, шүүх, ял оноох болон давж заалдах бүх шатанд дур зоргоороо, дүрэм журмыг үл даган, хууль дүрмийг зөрчих, түүнчлэн цаазаар авах ялыг ихэвчлэн үндэсний цөөнх, ядуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй эмзэг бүлгийнхэнд түлхүү хэрэглэж байгааг судлан тогтоожээ. Харин 2008 онд Энэтхэгт нэг ч цаазаар авах ялыг гүйцэтгээгүй боловч 70 гаруй хүнд цаазаар авах ял оноосон байна.

2008 онд цаазаар авах ял гүйцэтгэсэн бүс нутгуудын хоёрдугаарт **Ойрхи Дорнод болон Хойд Африкийн улс орнууд** (21%) оржээ. Энэ бүс нутгийн **Ирак** (285), **Алжир** (200), **Египет** (87), **Иордан** (14), **Сири** (7), **Кувейт** (6), **Баруун Сахар** (4), **Иран, Саудын Араб** зэрэг 10 оронд нийт 609 хүнд цаазаар авах ял оноосноос **Иран** (346), **Саудын Араб** (102), **Ирак** (34), **Йемен** (13), **Ливи** (8), **Египет** (2), **Бахрайн** (1), **Сир** (1), **Арабын Нэгдсэн Эмират** (1) зэрэг 9 оронд нийт 508 цаазаар авах ял гүйцэтгэжээ. Түүнчлэн зарим оронд чулуугаар шидэж алах, дүүжлэх, олон нийтийн өмнө толгойг нь авах зэрэг хамгийн харгис, хүнлэг бус аргуудыг нийт 346 хүн цаазлахад хэрэглэснийг тогтоожээ.

Мөн энэ бүс нутгийн зарим орны хувьд насанд хүрээгүй хүн болон эмэгтэйчүүдийг цаазлах, мөн шударга бус шүүхээр шүүгдэх, Африк, Азиас ирсэн ядуучууд, цагаач иргэдэд орчуулга, өмгөөллийн үйл ажиллагаа авах эрхийг нь үл хүндэтгэх зэрэг зөрчил, доголдол нийтлэг байгаа ажээ.

2008 онд Америкт нийт 38 цаазаар авах ял гүйцэтгэсний 37-г нь АНУ, 1-ийг нь ихэр арал болох **Гэгээн Киттс ба Невист** тус тус гүйцэтгэжээ. 2008 онд Америк тивийн 6 оронд нийт 125 цаазаар явах ял оноосноос: **АНУ** (111), **Тринидад Тобаго**(10), **Багамын арлууд**(1), **Гэгээн Киттс ба Невист** (1), **Гэгээн Винсент ба Гренадс** (1) ба **Ямайка**(1) тус тус байна.

АНУ цаазаар авах ялаас ангижрах чиг хандлага руу шилжиж байгаа хэдий ч 2008 оны байдлаар **Америк тивд** цаазаар авах ялыг гүйцэтгэсээр байгаа цорын ганц орон нь байсаар байна. 1995 оноос хойш энэ ялыг гүйцэтгэсэн жилүүдтэй харьцуулахад 2008 онд АНУ-д цаазаар авах ялын гүйцэтгэл буурчээ. Мөн АНУ дахь цаазаар авах ялыг дарангуйлал, ялгаварлан гадуурхал, шүүхийн алдаатай багагүй холбоотой байдаг хэмээн хүний эрхийн талаархи тайлан илтгэлүүдэд тэмдэглэжээ. Тухайлбал, 2008 онд 4 эрэгтэй гэм буруугүй нь тогтоогдож цаазаар авахуулах ялаас чөлөөлөгдсөн бөгөөд ингэснээр 1975 оноос хойш цагаадсан хүний тоо 120 болсон байна³⁶.

³⁶ Death sentences execution 2008. http://www.amnestyusa.org-abolish-annual_report

Латин Америкийн Улс орнуудын хувьд:

-**Цаазаар авах ялыг бүх төрлийн гэмт хэргүүдэд халсан** 12 орон (Доминиканы Бүгд Найрамдах Улс, Коста Рика, Эквадор, Мексик, Никарагуа, Панам, Парагвай, Уругвай, Венесуэл, Гондурас, Колумб)

-**Дайны байдал зэрэг тусгай нөхцөл байдлаас бусад үед Цаазаар авах ялыг халсан** 5 орон (Бразил, Боливи, Чили, Сальвадор, Перу)

- **Цаазаар авах ял хэрэглэдэг** 2 орон (Куба, Доминикан) тус тус байна.

Латин Америкийн улс орнуудын тухайд цаазаар авах ялын талаархи зохицуулалтыг гол төлөв Үндсэн хуулиараа зохицуулсан байна. Тухайлбал, Аргентин Улс Үндсэн хуулийн 18 дугаар зүйлдээ “Цаазаар авах ялыг бүх төрлийн гэмт хэрэгт бүр мөсөн халсан” гэж заасан байхад Венесуэл Улсын Үндсэн хуулийн 43 дүгээр зүйлд “Хүний амьд явах эрх халдашгүй дархан байна. Аливаа нэгэн хуулиар эсхүл, төрийн байгууллага болон албан тушаалтан цаазаар авах ялыг тогтоон хэрэгжүүлэхгүй” гэж заажээ. Тэгвэл цаазаар авах ял хэрэглэдэг Куба Улс нь Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиндаа “Хуульд заасан зөвхөн онц хүнд гэмт хэрэгт ялын дээд хэмжээг онооно. Уг ялыг эмэгтэйчүүд болон 20 нас хүрээгүй хэрэгтэнд оноохгүй” гэж заажээ. Куба нь 2000 онд цаазаар авах ялд мориторум тогтоосон хэдий ч 2003 онд буцаан хэрэглэсэн байна. Кубад цаазаар авах ялын талаар гаргасан албан ёсны статистик тоо баримт олдохгүй боловч цаазаар авах ял авсан бараг бүх хоригдлуудын ялыг хөнгөлсөн тухай Хүний эрхийн байгууллагуудын зарим мэдээлэлд дурьдагджээ³⁷.

Доминикан Улсын Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйлд “Ялын дээд хэмжээ авсан хоригдол нь Ерөнхийлөгч гүйцэтгэл товлон хүртэл тусгай хамгаалалтанд байж зөвхөн тодорхой хэсэг хүн уулзах эрхтэй. Гүйцэтгэлийн үед хорих газрын албаны хүмүүс болон хоригдолын гэр бүлийнхэн байлцана” гэж заажээ.

Карибд гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаагаас үүдэн цаазаар авах ял дахин хэрэглэж эхлэхийг уриалсан, **Ямаикт** хууль тогтоох 2 танхим хоёулаа цаазаар авах ялыг хэвээр үлдээхийг дэмжсэн, **Аргентин болон Барбуда**д хохирогч үхсэн ч, үхээгүй ч галт зэвсэг оролцсон гэмт хэрэгт цаазаар авах ял оноох хууль санаачилсан, **Гайаны** Засгийн газар далайн дээрэмд цаазаар авах ял оноохыг зөвшөөрсөн, **Тринидад Тобаго, Гэгээн Винсент ба Гренадинс** дүүжлэх ялыг дахин сэргээхийг дэмжсэн зэрэг нь цаазаар авах ялыг халах талаар энэ бүс нутгийн улс орны санаачилга хангалтгүй байгааг харуулж байна.

Африкийн 19 оронд нийт 362 цаазаар авах ял оноосноос: **Уганда** (114), **Судан** (60), **Ардчилсан Бүгд Найрамдах Конго** (50), **Нигери** (40), **Этиоп** (39), **Малти** (15), **Чад** (12), **Мавритан** (8), **Ботсвани** (4), **Гана** (3), **Гаяана** (3), **Сьерра-Леоне** (3), **Гамби** (2), **Буркина Фасо** (1), **Бурунди** (1), **Нигер** (1), **Кени, Мадагаскар, Танзани**-д тус тус бүртгэгджээ. Харин Баруун Сахарын Африкт **Ботсвани, Суданд** тус тус нэг цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. 2008 онд цаазаар авах ялыг дахин хэрэглэж эхэлсэн ганц орон нь **Либер** байна.

Нигерт цаазаар авахуулахаар хүлээгдэж байгаа хэрэгтний тоо 735 болж байгаа бөгөөд тэдний 11 нь эмэгтэй байна. Хэдэн зуун хүн шударга шүүхээр шүүлгэж чадаагүй бөгөөд бараг 140 хүн цаазаар авахуулах ял сонсоод 10-20 жил болжээ. Тэдний 40 нь хэрэг үйлдэх үедээ насанд

³⁷ Death sentences execution 2008. http://www.amnestyusa.org-abolish-annual_report

хүрээгүй хүүхэд байжээ. 2008 оны 7 дугаар сард дээрэм ба галт зэвсгийн Актаар цаазаар авах ял оноох эрхийг халж, бүх насаар нь хорих ял болгох хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим батлаагүй аж.

Европ нь цаазаар авах ялыг халах хандлагыг ганцаараа тууштай барьж чадсан бүс нутаг юм. **ОХУ** цаазаар авах, оноох, гүйцэтгэхээ зогсоогоод арав гаруй жил болж байгаа боловч цаазаар авах ял хуулийн заалтанд нь хүчинтэй хэвээр байсаар байна. 2008 онд 4 хүнийг цаазаар авч, нэг хүнд цаазын ял оноосон **Беларусыг** эс тооцвол Европ нь дэлхий дээрх цорын ганц цаазаар авах ялгүй бүс нутаг юм. **Беларусь** нь Европт болон хуучин Зөвлөлт Холбоот Улс дахь цаазаар авах ял гүйцэтгэж байгаа хамгийн сүүлчийн орон юм. Беларусьд цаазаар авах ялын тоо баримтын талаар мэдээлэл нууц байгаа боловч 1991 онд Беларусь тусгаар тогтносноос хойш дор хаяж 400 хүн цаазаар авахуулсан хэмээн Эмнести Интернэшнл үзжээ.

Төв Азид цаазаар авах ялыг халах томоохон алхмууд гарсаар байна. Тухайлбал, **Казахстан, Кыргызстан, Тажикстан, Туркменистан, Узбекистан** нь 1991 онд тусгаар тогтнохдоо цаазаар авах ялаа хэвээр үлдээсэн боловч 2008 оны 9 дүгээр сард **Казахстан, Кыргызстан, Туркменистан, Узбекистан** цаазаар авах ялыг бүрэн халсан бөгөөд **Тажикстан** гүйцэтгэлээ түр зогсоогоод байна.

Цаазаар явах ялын байдал дэлхий нийтэд хэдийгээр иймэрхүү дүр зурагтай байгаа хэдий боловч “цаазаар авах ял нь хүний эрхийг хүндэтгэн сахиулахад нийцэхгүй байна” хэмээн үзэж уг ялыг хуулиар болон практикт хэрэглэхээс түдгэлзээд байгаа улс орнуудын тоо сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. 2008 онд энэ ялыг хэвээр хадгалан хэрэглэж байгаа орнуудын тоо ч мөн адил буурав. Узбекистан болон Аргентин цаазаар авах ялыг бүх хэргүүдэд халжээ. Бурунди, Мали болон Того зэрэг орнуудад цаазаар авах ялыг халахад чиглэсэн шинэчлэл боловсруулалтын шатандаа явж байна. Ливаны Хууль Зүйн сайд нь цаазаар авах ялыг халах хуулийн төслийг өргөн мэдүүлэв. Алжирт сөрөг хүчний бүлэг Хүний эрхийн түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг тохиолдуулан цаазаар авах ялыг халах тухай хуулийн төслийг парламентад өргөн барьжээ. Вьетнам зэрэг хэд хэдэн орон цаазаар авах ялын хүрээг багасгах талаар тодорхой арга хэмжээ авч буй. Вьетнамын Эрүүгийн хуулиас 17 хэрэгт цаазаар авах ял оноох зүйл заалтыг хасах саналыг хэдийгээр Үндэсний Ассамблей нь дэмжээгүй боловч энэ нь цаазаар авах ялыг халах чиглэлд хийсэн анхны томоохон алхам байсан бөгөөд хэд хэдэн ялыг хорих ял болгон хөнгөлөөд байна.

Гурав. Монгол Улсын хууль тогтоомж дахь ялын дээд хэмжээ

Цаазаар авах ялыг Монгол улсад эртнээс нааш хэрэглэж ирсэн тухай “Их засаг хууль”, Монгол-ойродын цааз бичиг, Халх журам зэрэг түүхэн баримт бичигт тодорхой заасан байсныг судалгаараар тогтоосон байдаг. Ардын Засгийн газрын үед буюу 1921 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Ардын Засгийн газар 7 дугаар хуралдааны тогтоолоор алах ялыг эх орноосоо урвах, хувьсгалын эсэргүү гэмт хэрэг, цэргийн зарим хүнд гэмт хэрэглэхээр болсон бөгөөд Ардын Засгийн газар 1923 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Эрүүгийн хуулийг боловсруулж, дагаж мөрдөх хүртэл зэвсэг хэрэглэсэн дээрэм, шунахай зорилгоор хүн алсан хэрэгт цаазаар авах ял ногдуулахаар шийдвэрлэжээ.

Монгол Улс 1926, 1929, 1934, 1942, 1961, 1987 (шинэчлэн найруулсан), 2002 онд Эрүүгийн хууль баталж, дагаж мөрдүүлж ирсэн.

Монгол Улсын 1926, 1929, 1934, 1942 оны Эрүүгийн хуулиудад цаазаар авах ялыг улс төрд тэрсэлсэн онц аюултай гэмт хэргүүд, улс төрөөс урвасан гэмт хэргүүд, гадаад улсад суугаа тус улсын элчин, тэдгээрийн төлөөлөгчдийг алах, хорлон сүйтгэх улсын зоос, мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, бусдыг хүндрүүлэх шалтгаантайгаар санаатайгаар алах зэрэг гэмт хэрэгт

оногдуулж байсан байна. 1926 оны Эрүүгийн хуулийн 13 зүйлд, 1929 оны Эрүүгийн хуулийн 14 зүйлд, 1934 оны Эрүүгийн хуулийн 21 зүйлд, 1942 оны Эрүүгийн хуулийн 44 зүйлд цаазаар авах ялыг хэрэглэхээр тогтоосон байсан бөгөөд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1953 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн “Алах ялыг өөрчлөх тухай” 93 дугаар зарлигт “БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс энх тайван цаг үед алах ялыг хойшид хэрэглэхийн хэрэггүй гэж үзнэ” зааж, уг зарлигаар зөвхөн эх орноос урвагчид, тагнуулчид, хорлон сүйтгэгч нарт цаазаар авах ялыг хэрэглэж байхаар тогтоосон байжээ. Гэвч цаазаар авах ялыг хүчингүй болгосон энэ заалт дөнгөж 10 орчим сар хэрэгжүүлж, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1954 оны 67 дугаар зарлигаар хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алсан гэмт хэрэгт буудан алах ял хэрэглэж байхаар тогтоож байжээ.

Монгол Улсын 1961 оны Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг онцгой ял хэмээн үзэж, 9 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр заажээ.

1987 оны (шинэчлэн найруулсан) Эрүүгийн хуулиар эх орноосоо урвах (60 дугаар зүйл); тагнуул хийх (61 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); зандалчлах (73 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (85 дугаар зүйл); хүчиндэх (112 дугаар зүйл); улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл); цагдан сэргийлэх байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах (222 дугаар зүйл); агаарын хөлгийг авч зугатаах (268 дугаар зүйл) гэмт хэрэгт цаазаар авах ял тогтоосон байна. Ийнхүү эрүүгийн хуулийн 12 зүйлд цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон бөгөөд уг хуулиар 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял ногдуулахыг хориглосон.

1990 оноос хойшхи зарим шинэчлэлт БНМАУ-ын Бага Хурал 1991 онд “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль баталж, эд хөрөнгийн шинжтэй гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхийг хүчингүй болгосон нь цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг хумисан алхам болсон.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хууль баталсантай холбогдуулан дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийг түүнтэй нийцүүлэх зүй ёсны шаардлага гарч ирсэн байна. Монгол Улсын Их Хурал 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” баталж, өмнөх Эрүүгийн хуулиар 10 гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулж байсныг дараахь таван төрлийн гэмт хэрэгт эл ялыг тогтоосон байна: улс төрийн зорилгоор аллага хийх (62.1 дүгээр зүйл); улс төрийн зорилгоор гадаад улсын төлөөлөгчийн эсрэг аллага хийх (63.1 дүгээр зүйл); хорлон сүйтгэх (64 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (86 дугаар зүйлийн 2 дахь хэсэг); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (112 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтад “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;” гэж заасан бөгөөд ялын дээд хэмжээг Эрүүгийн хуульд заасан байх үндсэн шаардлагыг тавьсан байна. Үндсэн хуулийн заалт нь ялын дээд хэмжээг тогтоосон Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл болох бөгөөд уг заалтын дагуу ялын дээд хэмжээг оногдуулах нь нэлээд хэдэн шалгууртай байна. Эдгээрийн тоймлон жагсаавал:

1. Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг байх,
2. Эрүүгийн хуульд заасан тухайн онц хүнд гэмт хэргийг үйлдсэн байх,

3. Уг үйлдлийг шүүхээс тогтоосон хүчин төгөлдөр тогтоол байх,
4. Шүүхийн уг тогтоол нь ялын дээд хэмжээг оногдуулсан байх гэх зэрэг шалгууртай байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ялын хэмжээгээр нь ангилсан бөгөөд мөн зүйлийн 5 дахь заалтад онц хүнд гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангид арван жилээс дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих, онцгой тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэрэг гэж тодорхойлсон байна.

Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд ялыг торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн 7 төрөлд хуваасан байдаг. Торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай хэрэглэхийг Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байдаг.

Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд ялын дээд хэмжээ болох цаазаар авах ялын талаар зохицуулсан байна. “Зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болох бөгөөд уг ялыг буудаж гүйцэтгэнэ” гэж Эрүүгийн хуульд тусгайлан зохицуулсан байна. /Эрүүгийн хуулийн 53.1, 53.2/

Эрүүгийн хуульд хэдийгээр цаазаар авах ял оногдуулахаар заасан боловч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдэд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх, Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучлах зэрэг уг ялаас хэтрүүлэн өөр ялаар солих боломжийг өгч хүний амьд явах эрхийг хангахад чиглэсэн зохицуулалтыг хуульд заасан байна. /Эрүүгийн хуулийн 53.3/

Түүнчлэн цаазаар авах ялыг зөвхөн насан хүрсэн 60-аас доош насны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй хүнд оногдуулж болох бөгөөд уг хэргийг насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд үйлдсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болохгүйг Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг заасан байна.

Онц хүнд гэмт хэрэгт бэлтгэсэн буюу завдсан этгээдэд арван таван жилээс дээш хугацаагаар хорих буюу цаазаар авах ял оногдуулахгүйг Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан байна.

Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй гэж заасан байна /Эрүүгийн хуулийн 72.4/

Цаазаар авах ял шийтгүүлж уучлагдсан, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдэд ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах журмыг хэрэглэхгүй болохыг Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан байна.

Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг арван таван жил өнгөртөл биелүүлээгүй бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй бөгөөд уг ялын оронд хорих ял оногдуулахаар заасан байна.

2002 онд шинэ Эрүүгийн хуулиар дараахь төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэхээр тогтоосон байна: төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах (81.2 дугаар зүйл); хорлон сүйтгэх (84 дүгээр зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдыг санаатай алах (91.2 дугаар зүйл); онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх (126.3 дугаар зүйл) зандалчлах (177.2 дугаар зүйл); төрлөөр устгах (302 дугаар зүйл) зэрэг хэрэгт цаазаар авах ял оногдуулж байсан бол Эрүүгийн хуульд (178¹ дүгээр зүйл) Терроризм гэсэн зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэнээр нийтдээ 7 зүйлд цаазаар авах ял оногдуулахаар заасан. Төрлөөр устгах (302 дугаар зүйл) бие махбодид хүнд гэмтэл учруулсан, төрөлтийг хүчээр зогсоосон, хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан зэрэг хүн амь нас бусниулаагүй дөрвөн үйлдэлд цаазаар авах ял хэрэглэхээр заажээ. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд төрлөөр устгах гэмт хэрэгт цаазаар авах ял тогтоогоогүй бол Монгол улсын 2002 оны Эрүүгийн хуулиар цаазаар авах ял заасан байна. Ийнхүү Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийг өмнөх хуультай (1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуультай) харьцуулахад цаазаар авах ялыг хэрэглэх хүрээг өргөжүүлсэн байна.

Монгол Эмнести Интернэшнлийн Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайланд 1965-2006 он хүртэл Монгол Улсад цаазаар авах ялыг шүүхээс сүүлийн 40 жилд ногдуулсан байдлыг Хавсралт 2-оос харна уу.

Дөрөв. Цаазаар авах ялын талаархи олон нийтийн санаа бодол

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 оны 1 дүгээр сарын 15-нд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэгжүүлэхийг түр хугацаагаар түдгэлзүүлэн татгалзах санал гаргаж үг хэлсэнтэй холбогдуулан энэхүү ялын талаар олон нийт санаа бодлоо илүү их илэрхийлэх болсон. Тиймээс энэ хугацаанаас хойш өдөр тутмын зарим сонинд гарсан нийтлэлд цаазаар авах ялыг халах асуудлаархи олон нийтийн санаа бодол, байр суурийг нэгтгэн үзэв. Түүвэр хийж авсан 23 нийтлэлд үзэл бодлоо илэрхийлсэн улс төрч 4, хүний эрхийг хамгаалахын төлөө ажилладаг ТББ-ын ажилтан 2, хууль, хяналтын байгууллагын ажилтан 8, иргэд 7, сэтгүүлч 3 байна. Эдгээрээс зарим гол санааг хураангуйлан авч үзвэл:

- Ардчилсан, хүмүүнлэг нийгэмд гэмт хэрэг хийсэн хэмээн бусдыг цаазаар авах нь дэндүү харгислал гэдгийг Ерөнхийлөгчийн гаргасан энэхүү санаачилга олон нийтэд төдийгүй бусад улс гүрэнд ч харууллаа.
- Цаазаар авах ялыг хэрэглэж байгаа орнуудын чиг хандлагаас харахад уг ялын хэрэглээг зөвтгөхдөө ихэвчлэн онц ноцтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эсхүл, олон нийтийн сэтгэл зүй бэлтгэгдээгүй гэсэн шалтаг хэлдэг. Гэвч энэ нь зөв шийдвэр болохын нотолгоо болж чадаагүй.
- Цаазаар авах ял нь хүний амьд явах эрхийг зөрчиж байгаа хүнлэг бус ял шийтгэл, төрийн харгислал юм.
- Ардчилсан нийгмийн нэг зарчим нь төрийн эрх ард түмний мэдэлд байдаг. Монгол Улсад ч мөн адил үүнийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Тиймээс хүн өөртөө байхгүй эрхийг төр засагт шилжүүлж болохгүй.
- Цаазаар авах ялаас түдгэлзэхэд эрүүгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөөс илүү нийгмийн уур амьсгал эрүүлжиж, гэгээрнэ.
- Амийг нь хөнөөхөөс илүү ялыг нь үүрүүлж хорих, учруулсан хохирлыг нь төлүүлж, барагдуулах нь шудрага ёсонд илүү нийцнэ.
- Цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ялаар солих нь гэмт хэрэгтэнд гэмшил төрүүлж, хийсэн бузар үйлдэлдээ харамсах, гашуудах, ухаарч, ойлгох боломжийг олгох магадлалтай.

- Цаазаар авах ялыг халах, эсэхээ иргэдийнхээ санал асуулгаар, ялангуяа хохирогчдын ар гэрийнхнийх нь саналыг харгалзаж байж шийдэх ёстой.
- Цаазаар авсан гүйцэтгэлийн зарим мэдээг ил болгож, цааз тойрсон эргэлзээ, тээнэгэлзээг арилгах ёстой. Мөн цогцсыг хүний ёсоор хөдөөлүүлэх эрхийг төрөл төрөгсдөд нь олгох нь зүйтэй.
- Цаазын ялаас амийг нь хэлтрүүлэх нь арга зам биш, гэмт хэрэг үйлдэгдэх болсон учир шалтгаантай биш, үр дагавартай нь тэмцэж байгаа хэрэг. Харин нийгмээ бүхэлд нь хүмүүнлэг, хүний эрхийг дээдэлдэг байлгахын тулд гэмт хэрэг үйлдсэн хойно нь бус, гэмт хэрэг гарахаас өмнө нь тэрхүү хөрс, дэвсгэрийг нь арилгах, ядуурал, гуйланчлал, ажилгүйдэл, архидалт, боловсролын болоод ёс суртахууны хоцрогдол, доголдлыг арилгаж, хүн шиг амьдарч болох нөхцлийг нь бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй юм.
- Цаазаар авах ялыг халах нь ардчилсан, хүмүүнлэг талдаа зөв зүйтэй алхам боловч Монгол Улсын иргэний амьд явах, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах хуулиар олгосон эрхийг хөсөрдүүлнэ.
- Эрүүгийн нөхцөл байдал хүнд байгаа үед захиалгат аллага нэмэгдэх аюул дагуулж болзошгүй.
- Цаазаар авах ялыг хамгийн их эрсдэл дагуулсан ялын хувьд гэм буруу нь нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон тохиолдолд гагцхүү шүүх оногдуулах, хүний хувь заяа нэгэнт эцэслэн шийдвэрлэгдсэн онцгой нөхцөл байдал үүсдэг учраас туйлын хянамгай хэрэглэх хэрэгтэй.
- Цаазаар авах ял оногдуулах хэргийн тоог цөөрүүлэх, хэтдээ ялын төрлөөс хасах чиглэл баримтлахыг УИХ 2003 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг батлахдаа төрийн бодлогын хэмжээнд тодорхойлсон. Тиймээс цаазаар авах ялыг устгах нь зөв бөгөөд дэлхий нийтээрээ энэ ялаас татгалзаж байгаа чиг хандлагаас Монгол Улс ангид байх учиргүй.
- Цаазаар авах ялыг халах хэд хэдэн арга зам байна. Нэгд, санаачлага гаргаад хууль баталж, хуулиар шууд халах арга. Хоёр дахь арга зам нь ард түмнээс санал авч болно. Гуравт цаазлах ял оногдуулахаа багасгаж болно.
- Энэ ялаар шийтгэх, түүнийг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л харилцааг зөвхөн хуулиар зохицуулж байгаа. Иймд Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай, Төрийн нууцын тухай гэх мэт олон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

Хавсралт 1.

Цаазаар авах ялыг халсан болон хэрэглэж байгаа орнууд

(2008 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)

1. **Бүх төрлийн гэмт хэрэгт халсан орнууд:** (нийт 92 орон, улсын ард энэ ялыг халсан оныг оруулав)

Албани 2007, Андorra 1990, Ангол 1992, Аргентин 2008, Армени 2003, Австрали 1985, Австри 1968, Азербайжан 1998, Белги 1996, Бутан 2004, Босни Герцеговин 2001, Болгар 1998, Камбож 1989, Канад 1998, Кабо Верде 1981, Колумб 1910, Күүкийн арлууд 2007, Косто Рика 1877, Кот д'Ивуар 2000, Хорват 1990, Кипр 2002, Чех 1990, Дани 1978, Джибути 1995, БНДоминикан Улс 1966, Эквадор 1906, Эстони 1998, Финланд 1972, Франц 1981, Гүрж 1997, Герман 1987, Грек 2004, Гвиней-Бисау 1993, Гайти 1987, Гондурас 1956, Унгар 1990, Исланд 1928, Ирланд 1990, Итали 1994, Лихтенштейн 1987, Литва 1998, Люксембург 1979, Македони 1991, Мальт 2000, Мексик 2005, Молдав 1995, Монако 1962, Монтенегро 2002, Мозамбик 1990, Намиби 1990, Непал 1997, Голланд 1982, Шинэ Зеланд 1989, Никарагуа 1979, Норвеги 1979, Панам 1922, Парагвай 1992, Филиппин 2006, Польш 1997, Португаль 1976, Румын 1989, Руанда 2007, Самоа 2004, Сан Марино 1865, Сан-

Томе ба Принципи 1990, Сенегал 2004, Серб (Косовог оролцуулан) 2002, Сэйчэллийн арлууд 1993, Словак 1990, Словени 1989, Өмнөд Африк 1997, Испани 1995, Швед 1972, Швейцари 1992, Зүүн Тимор 1999, Турк 2004, Туркмен 1999, Украин 1999, Их Британи 1998, Уругвай 1907, Узбекистан 2008, Венесуэл 1863.

2. *Ердийн гэмт хэрэгт халсан орнууд: (10)*

Боливи 1997, Бразил 1979, Чили 2001, Сальвадор 1983, Фижи 1979, Израил 1954, Казахстан 2007, Кыргызстан 2007, Латви 1999, Перу 1979.

3. *Практикт халсан орнууд: (36 орон, хамгийн сүүлд гүйцэтгэл явуулсан он)*

Алжир 1993, Бенин 1987, Бруней 1957, Буркино Фасо 1988, Камерун 1997, Төв Африкийн БНУ 1981, Конго 1982, Эритрей 1989, Габон 1981, Гамби 1981, Гренад 1978, Кени 1987, Лаос 1989, Либерии 2000, Мадгаскар 1958, Малави 1992, Малдивийн арлууд 1952, Мали 1980, Мавритани 1987, Марокко 1993, Мьянмар 1980, Нигер 1976, Папуа-Шинэ Гвиней 1950, ОХУ 1999, Өмнөд Солонгос 1997, Шри ланк 1976, Швейцари 1983, Суринам 1982, Тажикистан 2004, Танзани 1995, Того 1978, Тонга 1982, Тунис 1991, Замби 1997.

4. *Цаазаар авах ял хэрэглэж байгаа орнууд: (59)*

Афганистан, Антигуа ба Барбуда, Бахрейн, Багамын арлууд, Бангладеш, Барбадос, Беларусь, Белиз, Бостван, Бурунди, Чад, Хятад, Коморын арлууд, Куба, Конго, Доминика, Египет, Экваторын Гвиней, Этиоп, Гватемал, Гвиней, Гана, Энэтхэг, Индонез, Иран, Ирак, Ямайка, Япон, Йордан, Кувейт, Ливан, Лесото, Ливи, Малайз, Монгол, Нигер, Хойд Солонгос, Оман, Пакистан, Палестин, Катар, Сент-Киттс ба Невис, Сент Люсия, Сент-Винсент ба Гренадин, Саудын Араб, Сьерра-Леоне, Сингапур, Сомали, Судан, Сири, Тайвань, Тайланд, Тринидад ба Тобаго, Уганда, Арабын Нэгдсэн Эмират Улс, АНУ, Вьетнам, Йемен, Зимбабве.

5. *2008 онд цаазаар авах ял оноосон байдал: (51)*

Хятад(7003+), Ирак(285+), Пакистан(236), Бангладеш(185+), Афганистан(131), Уганда(114), АНУ(111+), Египет(87+), Энэтхэг(70+), Судан(60), Вьетнам, (59+) Конго(50+), Нигер(40+), Этиоп (39), Япон(27), Малайз(22+), Мали(15+), Йордан(14+), Чад(12+), Индонез(10+), Тринидад ба Тобаго(10), Тайвань(8+), Мавритани(8), Сири(7+), Кувейт(6+), Сингапур(5), Марокко, (4+) Бостван(4+), Тайланд(3+), Гана(3), Гвиней(3), Сьерра-Леоне(3), Өмнөд Солонгос(2+), Гамби(2), Лаос(2), Шри Ланка(2), Багамын арлууд(1+), Сент-Киттс ба Невис(1+), Сент-Винсент ба Гренадин(1+), Беларусь(1), Буркина Фасо(1), Бурунди(1), Ямайка(1), Нигер(1) Иран(+), Кени(+), Ливи(+), Мадагаскар(+), Хойд Солонгос(+), Саудын Араб(+), Танзани(+).

6. *2008 онд цаазаар авах ялын гүйцэтгэсэн байдал: (25)*

Хятад (1718+), Иран(346+), Саудын Араб(102+), АНУ(37+), Пакистан(36+), Ирак(34+), Вьетнам(19+), Афганистан(17+), Хойд Солонгос(15+) , Япон(15), Йемен(13+), Индонез(10), Ливи(8+), Бангладеш(5), Беларусь(4), Египет(2+), Малайз(1+), Монгол(1), Сингапур(1+), Судан(1+), Сири(1+), Арабын Нэгдсэн Эмират Улс(1+), Бахрейн(1), Бостван(1), Сент-Киттс ба Невис(1).

Тайлбар: Энэ хавсралтад байгаа тоо баримтыг Эмнести Интернэшнлийн судалгаанаас авсан ба улс орнуудын дараа “+” тэмдэг бичсэн нь тухайн оронд цаазаар авах ял оноосон ба гүйцэтгэсэн тухай тоо баримтыг хамгийн багаар илэрхийлсэнийг харуулах бөгөөд түүнээс илүү байх магадлалтай байхыг илэрхийлнэ.

Хавсралт 2.

Монгол улсад цаазаар авах ялыг шүүхээс сүүлийн 40 жилд ногдуулсан байдалд хийсэн судалгаа (1965-2005)³⁸

Он	Нийт	Өсөлт / бууралтын харьцуулалтын хувь (%)	
		өмнөх жилтэй	1965 онтой
1965	7		
1966	12	+71.4%	+71.4%
1967	8	-33.3%	+14.2%
1968	10	+25%	+42.8%
1969	10	0%	+42.8%
1970	4	-60%	-57.1%
1971	8	+100%	+14.2%
1972	5	-37.5%	-28.5%
1973	8	+37.5%	+14.2%
1974	10	+25%	+42.8%
1975	13	+30%	+85.7%
1976	12	-7.6%	+71.4%
1977	12	0%	+71.4%
1978	14	+12.6%	+100%
1979	26	+85.7%	+271.4%
1980	19	-26.9%	+171.4%
1981	18	-5.2%	+157.1%
1982	17	-5.5%	+142.8%
1983	13	-23.5%	+85.7%
1984	17	+23.5%	+142.8%
1985	27	+58.8%	+285.7%
1986	19	+29.6%	+171.4%
1987	14	-26.3%	+100%
1988	13	-7.1%	+85.7%
1989	14	+7.1%	+100%
1990	15	+7.1%	+114.2%
1991	21	+40%	+200%
1992	34	+61.9%	+385.7%
1993	28	-17.6%	+300%

³⁸ Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял судалгааны тайлангаас УБ., 2005 он, Монголын Эмнести Интернэшнл судалгааны тайлангаас авав.

1994	30	+7.1%	+328.5%
1995	32	+6.6%	+357.1%
1996	21	-34.3%	+200%
1997	24	+14.2%	+242.8%
1998	17	-29.1%	+142.8%
1999	24	+29.1%	+242.8%
2000	13	-45.8%	+85.7%
2001	24	+45.8%	+242.8%
2002	18	25%	+157.1%
2003	22	+22.2%	+214.2%
2004	22	0%	+214.2%
2005	31	+29%	+342.8%

Ашигласан материалын жагсаалт:

1. Цаазаар авах ялыг халах тухай олон улсын гэрээ хэлэлцээрийг баталсан байдал. Эмнести интернэшнл
2. Цаазаар авах ялыг халсан болон хэрэглэж байгаа орнуудын жагсаалт (2008 оны 12 дугаар сарын 31)
3. Цаазаар авах ял ба гүйцэтгэл. 2008, Эмнести интернэшнл
4. Монгол Улс дахь хүний эрх,эрх чөлөөний 2007 оны байдлын талаархи илтгэл. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2008 он
5. Хүний амьд явах эрх ба цаазаар явах ял. 2006 он

Сонин хэвлэлийн нийтлэл:

1. Цаазалсан хүнийхээ тоогоор Хятадаас 2.6 дахин илүү гарчээ. Шаабар. Өдрийн сонин 2010.01.06
2. УИХ-ын гишүүн Д.Загджав: Ерөнхийлөгч цаазын ялтай хүн бүрийг уучлах нь ардчилсан зарчмыг алдагдуулна. Зууны мэдээ, 2010.01.05
3. Амийг амиар солих хатуу ялыг халах нь ээ. Д.Дорждагва. Өдрийн сонин 2010.01.16
4. Цаазыг алгасах алхам, дэлхийг цочоосон шилгээлт. Г.Энхтөр, Д.Ганчимэг. Өнөөдөр, 2010.01.16
5. Цаазын ялаас татгалзах нь буюу үр дагавараас учир шалтгааныг хайхуй. Б.Сэмүүн. Ардын эрх, 2010.01.18
6. Цаазын цаана, наана... Н.Наран. Зууны мэдээ, 2010.01.19
7. Ц.Элбэгдорж та хэнийг өршөөж байгаагаа тасаалж байна уу? Н.Батжаргал. Зууны мэдээ, 2010.01.20
8. Тэнгэрийн дор төрж, хуулийн дор амьдардаг. Х.Индра. Монголын мэдээ, 2010.01.18
9. Х.Тэмүүжин: Ерөнхийлөгч цаазаар авах ялыг насаар нь хорих болгоно шүү гэдэг дохио өгсөн. Монголын мэдээ, 2010.01.19
10. Ерөнхийлөгч хүний амьд явах эрхийг баталгаажуулах эхний алхмыг хэрэгжүүлж чадлаа. Ч.Бүжин. Ардын сонин, 2010.01.24
11. Монгол цаазаар авах ялыг халах нь зөв үү, буруу юу. Өнөөдөр, 2010.01.21
12. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дэвшүүлж буй саналд нэг санаа. С.Алимаа. Үнэн, 2010.01.21
13. Улс төрийн хүн хар гөрөөс. Д.Төмөрбаатар. Зууны мэдээ, 2010.01.26

14. Доктор И.Дашням: Цаазлах ялыг шүүх оногдуулдаг. Ерөнхийлөгч шууд шийдэхгүй шүү дээ. Зууны мэдээ, 2010.01.27
15. Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж байна. Өдрийн сонин, 2010.01.30
16. Цаазын ялыг халах нь улс төрийн илтгэл тавихаас өөр. Н.Батжаргал. Зууны мэдээ, 2010.02.04
17. Цаазлуулах ялтан бүрийг судалж байж өршөөх эсэхээ шийдэх ёстой. Г.Мөнхболд. Зууны мэдээ, 2010.02.10
18. Хүний эрх зөрчсөн аллагыг бүрмөсөн халъя. Хууль зүйн Lexus төв. Өдрийн сонин, 2010.02.11
19. Цаазаар авах нь хүсэх зүйл биш ч, түүнийг халах цаг нь болоогүй. Өнөөдөр, 2010.02.23

Цахим хаяг:

- 1.<http://www.ya.com/penademuerte/listapaises.htm>
- 2.http://www.amnestyusa.org-abolish-annual_report
- 3.<http://www.deathpenalty.org>
- 4.<http://www.amnesty.mn>
- 5.<http://www.bookrags.com>
- 6.<http://www.saber.ula.ve/bitstream/123456789/19135/articulo8.pdf>
- 7.<http://www.worldcoalition.org>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ТӨРИЙН АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД
НИЙГМИЙН АУДИТЫН ҮҮРЭГ***/Харьцуулсан судалгаа/**А.Пагма/МА/***АГУУЛГА**

1. Удирдтгал
2. Нийгмийн аудитын тухай ойлголт
3. Нийгмийн аудитын зорилго, арга зүй, үндсэн зарчим
4. Төрийн захиргаан дахь нийгмийн аудитын үйл явц
5. Нийгмийн аудитын үзүүлэх үр өгөөж
6. Нийгмийн аудитын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлсэн зарим орны туршлага
7. Дүгнэлт
8. Ашигласан материал

УДИРТГАЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Ө.Энхтүвшингийн захиалгаар “Төрийн албаны үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд нийгмийн аудитын үүрэг” сэдэвт судалгааны ажлыг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн референт-шинжээч А.Пагма гүйцэтгэв.

Захиалагчаас ирүүлсэн судалгааны сэдэв нь төрийн албаны үйлчилгээний чанар, үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах тухай өргөн хүрээний асуудлыг хамарсан байсан тул ТББХ-ны референт З.Нямцогттой уулзан судалгааны сэдвийн хүрээг тодруулсаны үндсэн дээр төрийн албаны үйлчилгээний үнэлгээнд нийгмийн аудитын аргыг хэрэглэх тухай асуудлыг уг судалгааны объект болгон авч үзэхээр тогтсон болно.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, хүртээмжийн талаархи нийгмийн аудит хэмээх харьцангуй шинэлэг санхүүгийн бус, олон нийтийн оролцоо бүхий хяналт, шинжилгээний аргын тухай ойлголт, мөн чанар, зарчим, арга зүйн талаар тодруулж, эрх зүйн зохицуулалт, зарим оронд хэрэгжүүлсэн туршлагын талаар харьцуулан судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

Судалгааны зорилтууд:

- Нийгмийн аудитын тухай ойлголтыг тодруулах,
- Нийгмийн аудитын зорилго, зарчим, арга зүйг судлах,
- Нийгмийн аудитын үйл явц, үзүүлэх үр нөлөөг судлах,
- Нийгмийн аудитын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлсэн зарим орны туршлагыг судлан дүгнэлт хийх

Судалгааны аргачлал:

- Нийгмийн аудитын шинж чанар, онцлогын харьцуулалт,
- Нийгмийн аудитын талаарх материалыг нэгтгэн дүгнэх,
- Бичиг баримтын судалгаа

Судалгааны үр дүн:

- Нийгмийн аудиттай холбоотой ном, материалд анализ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

1. Нийгмийн аудитын тухай ойлголт

Нийгмийн аудитын тухай үзэл санаа анх өнгөрсөн зууны 40-50-иад онд АНУ-д бий болсон бөгөөд 1970-аад оноос өндөр хөгжилтэй улс орнуудын нийгмийн практикт нэвтэрч эхэлсэн ба харин 90-ээд оноос энэ үйл явц улам хурдтай явагдсан байна. Ингэхдээ том компани, корпораци, үйлдвэрийн газрууд буюу бизнесийн байгууллагын санаачлагаар тэдгээрийн үйл ажиллагаанд нийгмийн чиглэлийн, тухайлбал, ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, удирдлага, ажиллагсдын хоорондын харилцаа, компанийн нийгмийн хариуцлага, хүрээлэн буй орчныг хамгаалж байгаа байдал зэрэг нийгмийн асуудалд хяналт хийж нийгмийн тайлан гаргах байдлаар хэрэгжиж эхэлжээ.

Улмаар аудитын энэхүү хэлбэрийг нийгмийн бусад салбар түүний дотор төр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь харьцангуй шинэлэг үзэгдэл юм. Нийгмийн аудит "Social audit"-ын арга зүйг янз бүрийн байгууллага, олон янзын хэлбэрээр ашиглаж байна. Иймээс түүнийг шинж чанар, арга хэрэгсэл, үйл явц, үр дүн, бүтэц зэрэг олон талаас нь тодорхойлсон тодорхойлолт, томъёолол байдаг. Эдгээрийн зармыг авч үзье. Үүнд:

- Нийгмийн аудитад байгууллага нийгмийн гүйцэтгэлээ тодорхойлох, хэмжих, үнэлэх, тайлагнах үйл явцыг тодорхойлох, түүнийг удирдамжаар хангаж, дэмжихийг ойлгоно. Энэ нь засаглал, хариуцлагын тухай өргөн хэлэлцүүлэгт чухал шаардлагатай байдаг.
- Нийгмийн аудит гэж үйлчлүүлэгчид болон үйлчилгээг хангагч нараас мэдээлэл цуглуулах, үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн өөрчлөлтийг хийхэд үйлчлэгч, үйлчлүүлэгч талыг адил тэгш оролцуулах суурь болгон ашиглах хэлбэр юм. (СИЕТ-НҮБХХ)
- Нийгмийн аудит нь дүн шинжилгээ хийх (critical survey) судалгааны хэлбэр мөн бөгөөд энэ нь баталгаа шаардсан, нарийн шалгуур биш, харин сонирхогч талууд, иргэдийн тодорхойлсон энгийн шалгуураар хэмжигддэг. Нийгмийн

аудит нь байгууллагын тухайн үйл ажиллагаа явуулж буй орчин, олон нийтэд үзүүлж буй нөлөөллийг тодорхой асуулт, хариултаар тодорхойлно.

- Нийгмийн хариуцлага нь байгууллага үйл ажиллагаагаа хянаж, үнэлэх замаар хүрсэн амжилт, дутагдлаа шударгаар тайлагнах, ил тод төлөвлөгөө, чадварлаг удирдлагаар дамжуулан гүйцэтгэлээ сайжруулах үйл явц юм.
- Нийгмийн аудит нь байгууллага гүйцэтгэлээ сайжруулах, хариуцлагаа нэмэгдүүлэхийн тулд нийгмийн болон орчны нөлөөллийг үнэлэх, сонирхогч талуудыг оролцуулахад туслах асуудлыг багтаана. Энэ үйл явцад байгууллага алхам алхамаар суралцана.
- Нийгмийн аудит бол янз бүрийн хандлага бүхий сонирхогч талуудын байгууллагын гүйцэтгэлд хийж буй санхүүгийн бус шалгалт юм.

Дээрхи тодорхойлолтууд нь нийгмийн аудит нь арга хэрэгсэл, арга зүйгээс илүү өргөн хүрээний ойлголт болохыг нотолж байна. Нийгмийн аудит нь бусад үнэлгээний арга зүйгээс ялгагдах үндсэн ялгаа нь дотоод, гадаад сонирхогч талуудын идэвхитэй оролцоог хангахыг чухалчилдаг оршдог.

Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудаас хуулийн хүрээнд иргэдэд үйлчилгээг хүргэж, түүнийхээ үр дүнд өөрсдөө дотоод хяналт хийх удирдлагын хэв загварыг төрийн захиргааны уламжлалт арга гэх бөгөөд энэ арга зүйн хувьд иргэдийн эрх мэдэл, оролцоо бага байдаг.

Ийм арга зүйг ашиглаж байсан хөгжингүй орнуудад төрийн захиргааны байгууллагын төсвийн хомсдол, хүнд суртал үүсэж, тогтолцоо нь үр ашиггүй, нүсэр болохын хэрээр 1970 он гэхэд өөрчлөлт шинэчлэл хийхийг шаардаж эхэлсэн байна. Энэ хэрэгцээ шаардлагаас урган эдгээр орнуудад улсын салбарын шинэ удирдлагын онол, арга зүй хөгжсөн.

Улсын салбарын шинэ удирдлагын арга зүй нь бизнесийн салбарын бенчмаркинг, мэдээллийн технологийн ололтыг төрийн байгууллагын үр ашиг, чанарыг дээшлүүлэх, ардчиллыг гүнзгийрүүлэхэд ашиглахын зэрэгцээ төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэлд суурилсан арга зүйгээр удирдах үндсэн чиг үүргээс бусад үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, хувьчлах зэрэг удирдлагын шинэ хэв загваруудыг хөгжүүлжээ.

Дээр дурьдсанчлан бизнесийн байгууллагад ашиглаж байсан үйл ажиллагааныхаа нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох замаар нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлж, зах зээлд урт хугацаанд тогтвортой оршин байх арга зүйг төрийн захиргааны байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглахыг зорих болсон нь нийгмийн аудит юм. Үүнийг ерөнхийд нь олон нийтийн оролцоонд суурилсан төрийн удирдлага хэмээн ойлгох болжээ.

Бүдүүвч 1. **Олон нийтийн оролцоонд суурилсан төрийн удирдлага**



Төрийн байгууллагын үйл ажиллагаа нь иргэд, олон нийтэд хаалттай, тэдний оролцоо, идэвхи сул байх нь хүнд суртлыг өөгшүүлж, төрийн захиргааг үр ашиггүй, хяналтгүй болгож улмаар хуулийн болон засаглалын хямралыг бий болгодог ажээ. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагууд хөгжиж буй улс орнуудад улсын салбарын шинэ удирдлагын арга зүйг сайн засаглалын элементүүдтэй хослуулан хөгжүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжсэн бодлого явуулжээ. Нийгмийн хариуцлага нь төрийн болон хувийн байгууллага үйл ажиллагааныхаа нийгэмд үзүүлж байгаа үр нөлөөний төлөө хариуцлага хүлээх чадвартай байх, иргэд, олон нийттэй хамтран нийгмийн сайн сайхан байдлыг хангахад идэвхитэй, санаачлагатай байх чадавхийг бий болгох асуудал бөгөөд харин нийгмийн аудитийн тусламжтайгаар тухайн байгууллагын нийгмийн хариуцлагын байдлыг тодорхойлдог юм.

2. Нийгмийн аудитын зорилго, арга зүй, үндсэн зарчим

Байгууллагууд дараахь зорилгоор нийгмийн аудитыг гүйцэтгэдэг. Үүнд:

- Үйл ажиллагаандаа сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар гүйцэтгэлээ сайжруулах,
- Сонирхогч талуудтай холбоотой гүйцэтгэлийн шалгуурыг хөгжүүлж боловсронгуй болгох, байгууллагыг хөгжилд чиглүүлэх,
- Ил тод байдал болон тогтмол тайлагнах хариуцлагаа нэмэгдүүлэх зэрэг болно.

Нийгмийн аудит нь байгууллагын үйл ажиллагаан дахь гажуудал, байвал зохих норм хэм, хэмжээнээс зөрүүтэй алдаа, дутагдалд хүргэж буй хүчин зүйлүүдийг илрүүлэхэд чиглэдэг. Нийгмийн аудит нь санхүүгийн аудитын нэгэн адил “Ямар байна?”, “Ямар байх ёстой вэ?” гэсэн асуудалд хариулт өгөх замаар харьцуулан шинжилдэг бөгөөд харин түүнээс ялгаатай тал нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй, байх ёстой хэм хэмжээнээс зөрсөн алдаа, эрсдлийн үндсэн шалтгааныг илрүүлэн, оновчтой удирдлагын хөтөлбөрийг тодорхойлж “Юу хийх вэ?” гэсэн асуултанд хариулт өгдөг байна.

CIET /Building the community voice into planning/ гэдэг олон улсын байгууллага нь олон арван жилийн турш засаглалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт баримт нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд нь туслалцаа үзүүлж ирсэн ба нийгмийн аудитын арга зүйг боловсруулсан байна.

CIET нь нийгмийн аудитыг ардчиллын хэрэгсэл гэж үздэг бөгөөд энэ нь баримт нотолгоонд тулгуурласан төлөвлөлт хийхэд шаардагдах арга барил, чадавхи, олон нийтийн дуу хоолойг сонсох эрмэлзлэл зэргийг агуулсан үйл ажиллагааны хүрээ хэмээн тодорхойлжээ.

Нийгмийн аудитын үзэл санаа нь маш энгийн: нийтийн үйлчилгээг³⁹ хүртэгч хүмүүсээр нь үнэлүүлж, гарсан үр дүнг үйлчилгээ үзүүлэгч, олон нийтийн оролцоотойгоор уг үйлчилгээг сайжруулахад ашиглана.

CIET-ийн боловсруулсан нийгмийн арга зүй долоон бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- **Баримт нотолгоо олох:** Нийтийн үйлчилгээ тэр бүр хүсэн хүлээж байснаар хэрэгждэггүй. Үйлчилгээ үзүүлэхэд гардаг хамгийн энгийн алдаа бол үйлчилгээ хэрэгтэй байгаа учраас түүний хамралт, үр нөлөөг хангаж болно гэж үзэх явдал юм. Харин үйлчилгээ хэр хүртээмжтэй байна вэ, чухам яаж хэрэгжиж байна вэ гэдгийг мэдэхийн тулд баримт нотолгоо зайлшгүй хэрэгтэй.

³⁹ Нийтийн үйлчилгээ-public service

- **Иргэний нийгмийн оролцоо:** Иргэний нийгмийг мэдээллээр ханган үйл явцад оролцуулж, сайтар боловсруулсан харилцааны стратегийг ашиглан мэдээллийг хамтран бий болгож, ашиглавал нийтийн үйлчилгээ нь олон нийттэй холбогдсон засаглалын асуудлаархи сүлжээний нэг хэсэг болж чадна. Нийгмийн аудитын мөчлөг бүр олон нийтийн дунд жендер, насаар ангилагдсан бүлгээр хэлэлцэгдэж дараа нь эдгээр бүлэг үр дүнгээ олон нийтийн удирдагч, нутгийн захиргаанд мэдэгдэх замаар зохион байгуулагдана.
- **Төвийг сахисан байх:** Гуравдагч этгээдийн оролцоотойгоор хийгдэх олон нийтийн хяналт нь нийтийн үйлчилгээнд ил тод байдлын соёлыг хэвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.
- **Түншээсээ дэмжлэг авах:** Нутгийн захиргаа болон нийтийн үйлчилгээний салбарынхан аудитын үйл ажиллагаанд боловсруулалтын үе шатнаас нь эхлэн гарсан үр дүнд тулгуурлан олон нийтийн оролцоотойгоор шийдвэр гаргах хүртэл идэвхтэй оролцоно. Иргэний нийгмийн байгууллага нь нутгийн захиргааны нэгэн адил үйл явцын нэг гол түнш болж оролцоно.
- **Хэн нэгнийг нэр зааж буруутгахгүй байх:** Нийгмийн аудит нь системийн доголдлыг өөрчлөхөд анхаарлаа хандуулах, тухайн орон нутгийн түвшинд шийдлийг боловсруулах зорилготой байдаг. Энэ нь хэн нэгнийг буруутгана гэсэн үг огт биш юм. Нийгмийн аудитын явцад илэрсэн сөрөг зүйл ч гэсэн үйл ажиллагааг сайжруулах эхлэлийн цэг, үндсэн суурь болдог.
- **Нийгмийн аудитыг давтан хийх:** Нийтийн үйлчилгээний аудитыг давтан явуулсанаар нийгмийн аль салбар дахь хөрөнгө оруулалт үр дүнтэй явагдаж байгааг тодорхойлж болно. Энэ нь хөрөнгө оруулалтыг маш нарийн зохицуулж, тодорхой ахиц гарахгүй байгаа газраас хөрөнгө оруулалтыг татаж, өөр тийш чиглүүлэх боломж олгодог.
- **Гарсан үр дүнг түгээх, хэрэглэх:** Гарсан үр дүнг хуваалцах, түүнийгээ тайлбарлах чадвар нь хариуцлага ба ил тод байдлын хос зарчмын гол үзүүлэлт юм. Шинэ баримт нотолгоо олж авсанаар тухайн салбарын менежер нь ямар орчин нөхцөлд үйл ажиллагаа амжилттай явагдах вэ гэдгийг мэдэж авна. Бас нэг чухал зүйл нь гарсан ахицын талаар олон нийтэд мэдээлэх явдал юм.

Баримт нотолгоо олох давтан хийгдэх ажиллагаа нь гарсан өөрчлөлт болон түүний нөлөөг үнэлсэнээр нийгмийн аудитын нэг мөчлөг дуусна.

Нийгмийн аудитыг гүйцэтгэхэд дараах үндсэн зарчмыг баримталдаг байна. Үүнд:

1. **Тэгш хамралт**-Нийгмийн аудит нь байгууллагын байгаа болон нөлөөлж болох бүх талуудын хандлагыг заавал тусгасан байх ёстой. Бүх үндсэн сонирхогч талуудын дуу хоолойг тэдний тэнд байх эсэхээс үл хамааран сонсдог байх нь бүрхэг асуудлыг бүрэн тодруулах нөхцөл болно.
2. **Оролцоо**-Үр дүнтэй нийгмийн аудит нь бүх сонирхогч талыг нийгмийн аудитын загварыг бий болгох, түүний шалгууруудыг тодорхойлохоос эхлээд бүх үе шатанд оролцуулдаг байна. Байгууллагын нийгмийн гүйцэтгэл нь аудитын үр дүнд суурилсан төлөвлөлт, олон нийтийн шийдвэр гаргалтанд үндэслэдэг. “Сонирхогч талуудын оролцоо, хэлэлцүүлэг”-ийг нийгмийн аудитын арга зүйн зарчим гэж үздэг байна.

3. **Цогц уяалдаатай байдал**-Нийгмийн аудит нь байгууллагын нийгэм, байгаль орчин, соёл, олон нийт гүйцэтгэлийн бүхий л асуудлыг авч үзэхийг зорьдог. Иймээс ч үнэт зүйлс, зорилго, зорилт, эдгээрт хүрэхийн тулд юуг хийж байгаа талаар тодорхой нээлттэй байхыг шаарддаг. Байгаль орчны хувьд нийгмийн хариуцлага хүлээхгүйгээр ямар ч байгууллага оршин байх боломжгүй учир энэ асуудал ихээхэн чухал юм.
4. **Байнгын, цаг хугацаатай байх**-Нийгмийн аудит нь тохиолдлын эсвэл нэг удаагийн үйлдэл биш юм. Нийгмийн аудитыг жил эсвэл хоёр жил тутам гэх мэтээр тодорхой хугацаанд тогтмол хийх замаар байгууллагад төлөвшүүлэх нь нийгмийн хариуцлагыг бий болгоно. Нийгмийн аудитын тогтолцоог бий болгосноор сонирхогч талуудын байгууллагад нөлөөлөх чадвар хөгждөг байна.
5. **Харьцуулах боломж**-Нийгмийн аудит нь тухайн байгууллага гүйцэтгэлээ тодорхой хугацаанд бусадтай харьцуулах замаар шилдэг туршлагыг тодорхойлох хэрэгсэл болно. Сонирхогч талын хувьд тухайн байгууллагын үйл ажиллагааг бусадтай харьцуулах боломж олгодог.
6. **Үндэслэлтэй, үнэн бодитой байх**-Сонирхогч талын итгэлцэл, үнэмшлийг бий болгоход нийгмийн аудитад ашиглаж байгаа мэдээллийн чанар, найдвартай байдал ихээхэн чухал. Нийгмийн аудитыг оролцогч талуудын янз бүрийн нөлөөллөөс хамгаалахын тулд төвийг сахих тухайлбал, бие даасан аудитор болон ашиг сонирхлын зөрчилгүй бүлгүүдээр мэдээллийг шалгуулна.
7. **Нийцтэй байх**-Хамгийн үр дүнтэй арга зүй гэдэг нь байгууллагын нөхцөл байдалд тохирсон байх явдал юм. Нийгмийн аудитын зарим арга зүй ерөнхий байх эсвэл тодорхой байгууллага, сонирхогчдод зориулагдсан байх нь нийтлэг байдаг. Олон тохиолдолд дээрхи арга зүйг хосолсон байдлаар ашигладаг.
8. **Ач холбогдолтой байх**-Нийгмийн аудитын үйл явц ач холбогдолтой байх гэдэг нь бодлого, үндсэн үйл ажиллагаа, системийн уялдаа холбоог хангах асуудал юм.
9. **Ил, нээлттэй байх, мэдээллийг түгээдэг байх**-Ил нээлттэй байж, мэдээллийг түгээх, таниулан ойлгуулах зорилгоор олон нийт, сонирхогч талуудыг хамруулсан хэлэлцүүлгийг явуулна. Нийгмийн аудитын үр дүнг байгууллагын болон олон нийтийн бүх оролцогч нарт хүргэх эргэх холбоог бий болгох нь чухал. Байгууллагын гүйцэтгэл нь олон нийт, сонирхогч талуудын сонирхолтой давхцаж байх, мөн ил тод байдал, хариуцлага хүлээх чадварын зарчмуудад нийцүүлэх нь чухал юм.

3. Төрийн захиргаан дахь нийгмийн аудитын үйл явц

Ардчилсан улс бүр нийгэм болон иргэн бүрийн эрх ашиг, сонирхлыг хангах, улс орныхоо нийгэм-эдийн засгийн хөгжлийн таатай нөхцлийг бий болгоход чиглэсэн төрийн албаны тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэхийг зорьдог. Ийм зорилт нь төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх арга зүй, шалгуурыг боловсруулан, гүйцэтгэхгүйгээр биелэгдэхэд төвөгтэй болохыг гадаад орнуудын туршлага харуулжээ. Ингэхдээ үнэлгээний энэ арга зүй, шалгуур нь төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, төрийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүргийн шинж чанар, онцлогыг тооцож, харгалзан үзсэн байх шаардлагатай байдаг байна.

Төрийн албанд нийгмийн аудит хийхийн мөн чанар нь төрийн албыг нийгмийн үйлчилгээний байгууллага болохынх нь хувьд түүний чиг үүрэг, бүтцийг иж бүрэн шинжилж, тэдгээр нь төрийн албаны зорилго, чиг үүрэгт хэр зэрэг нийцэж байгааг тогтоон үнэлгээ хийнэ гэсэн үг юм.

Төрийн захиргаан дахь нийгмийн аудит нь дараах үе шатаар явагддаг байна⁴⁰. Үүнд:

1. Тухайн төлөөллийн орон нутагт (олон нийт) байгаа өрхүүдээс төрийн үйлчилгээний ашиглалт, туршлага, төсөөллийн талаархи мэдээллийг цуглуулна.
2. Эдгээр мэдээллийг тухайн үйлчилгээний талаархи албан ёсны мэдээлэлтэй холбоно.
3. Мэдээллийн үр дүнд тухайн асуудлуудыг хэрхэн сайжруулах вэ гэсэн дүн шинжилгээ хийнэ.
4. Олон нийтэд дүн шинжилгээний үр дүнг танилцуулж, нөхцөл байдлыг сайжруулах талаар санал бодлыг нь авна.
5. Үр дүн, санал бодлыг үйлчилгээг хангагч байгууллагууд, орон нутгийн бодлого төлөвлөх эрх бүхий хүмүүс, олон нийтийн төлөөлөлд танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна.

4. Нийгмийн аудитын үзүүлэх үр өгөөж

Нийгмийн аудитыг хэрэгжүүлсэнээр олон талын үр өгөөжийг бий болгоно. Эдгээрийн зармыг нь авч үзье. Үүнд:

- Байгууллагын сонирхогч талуудын өмнө хүлээсэн хариуцлагыг сайжруулна,
- Орон нутгийн иргэдийг чадваржуулж, улмаар иргэний оролцоог нэмэгдүүлнэ,
- Хариуцлагатай байдал, ил тод байдлыг дэмжинэ,
- Бодлого боловсруулагчид шийдвэр гаргагчдын хувьд иргэдтэй эргэх холбоог бий болгож, байгууллагын гүйцэтгэлийн болон нийгэм, ёс зүйн хяналтыг сайжруулна,
- Засгийн газрын төсөв, хөрөнгийг зориулагдсан хүмүүс, иргэд хүлээн авах нөхцөл баталгаажна,
- Нийгмийн хөтөлбөрүүдийн үр ашиг тодорхой болно,
- Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөллийг үнэлнэ,
- Удирдлагын сайн туршлагыг хөгжүүлэх, олон нийтийн оролцоотой төлөвлөлтийг хөгжүүлнэ,
- Нийгмийн эмзэг бүлэг, ядуучуудад зориулсан төлөвлөлтийг хөгжүүлнэ,
- Байгууллагын суралцах болон стратегийн төлөвлөлтийн чадавхийг бий болгоно,
- Байгууллагын бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлнэ,
- Байгууллагын стратеги, үйл ажиллагаа, үнэт зүйлсийн уялдааг хангана.

Түүнчлэн нийгмийн аудитын шинжилгээний дүнг хэрэглэгчид нь тухайн байгууллагаас гадна иргэний нийгмийн институцүүд, тухайлбал, улс төрийн намууд, ажил олгогчдын холбоод, үйлдвэрчний эвлэлүүд, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүд, төрийн бус байгууллагууд байдаг. Мөн нийгмийн аудитын бодитой, нээлттэй шинж чанар нь хоосон амлах, популист уриа, лоозон хэрэглэн олон нийтийг төөрөгдүүлэх боломжийг хязгаарлаж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа ил тод, тунгалаг байж, ардчилсан зарчмыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлдэг.

⁴⁰ Нийгмийн аудит. УБ., 2005 он. 17 дахь тал

5. Нийгмийн аудитын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлсэн зарим орны түршлага

Нийгмийн аудитын талаархи асуудлыг зохицуулсан олон улсын бие даасан эрх зүйн акт, баримт бичиг одоо хэр байдаггүй бөгөөд хүний эрх, эрх чөлөөг тунхагласан олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг энэ асуудлын эрх зүйн үндэс гэж үздэг байна. Тухайлбал, НҮБ-ын Дүрэм-1945 он, Хүний эрхийн түгээмэл тунхаглал-1948 он, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт-1966 он, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны тухай Зөвлөгөөний Төгсгөлийн баримт бичиг-1975 он зэрэг баримт бичиг болно.

Өндөр хөгжилтэй улс орнуудад нийгмийн аудитын эрх зүйн үндэс нь XX зууны 70-аад оны сүүлч 80-иад оны эхэн үеэс бий болсон бөгөөд ингэхдээ бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд нийгмийн аудитыг нэвтрүүлэх, пүүс компаниуд нийгмийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалж байгаа талаараа жил бүр нийгмийн тайлан гаргахыг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийг гаргажээ.

Гадаад орнуудын нийгмийн аудитын үндсэн шинж чанар нь нийгмийн хариуцлагаас үүдэн байгууллагын нийгмийн рейтингийг тогтоох, нийгмийн тайлан гаргах явдал бөгөөд эдгээрийг ерөнхийдөө олон улсын засгийн газрын бус байгууллагуудаас гаргасан олон улсын нийгмийн стандартын дагуу тогтоодог байна.

Энэ нь юуны өмнө олон улсын чанарын стандарттай холбоотой ба зах зээлийн орнуудад бизнесийн байгууллага цаг ямагт өрсөлдөөнтэй тулгарч уг өрсөлдөөнд тэсч үлдэн, даван гарах явдлыг тэргүүн зорилтоо болгодог ба өрсөлдөөнд үнэ, чанар, нийлүүлэх хугацаа гэсэн 3 үндэс байдаг билээ. 1950-иад оноос хэрэглэгчид үнэ, нийлүүлэх хугацааг гол болгон анхаардаг байсан бол 1990-ээд оноос чанарын асуудлыг нөгөө хоёроос дутуугүй анхаардаг болсон байна. Ийм учраас чанарын асуудлыг иж бүрнээр нь авч үзэх хандлага бий болж 1970-аад онд Европын хэд хэдэн оронд чанарыг хангах буюу удирдах тухай үндэсний стандартуудыг гарган (Жишээлбэл Их Британид 1979 онд BS 2570 стандарт) хэрэглэж эхэлжээ. Энэ түршлагыг олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор Олон улсын стандартчиллын байгууллага (ОУСБ) (ISO буюу International Organization for Standardization, заримдаа манайд кириллээр “ИСО” ч гэж ярьж, бичдэг)-ын хүрээнд чанарын удирдлагын асуудал эрхэлсэн 176 гэсэн дугаартай стандартчилын техникийн хороог (ISO/TC 176) байгуулсан байна.

Нийгмийн аудитыг төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх үйл явц нь аливаа байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавих шаардлагыг тогтоосон ISO 9000 бүлэг стандартыг хэрэглэн төрийн захиргааны байгууллагаас хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийнхээ зүгээс тавьсан шаардлагыг тогтвортой хангаж, түүний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд хэрхэн ажиллахыг тогтоох үйл явц юм.

ISO 9000 бүлэг стандарт гэдэг нь “Ямар хэлбэр, хэмжээтэй, ямар ч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг буюу үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хэрэглэж болох чанарын удирдлагын тогтолцоог тодорхойлсон түгээмэл багц стандарт юм. “Бүтээгдэхүүн нь дараахь аль нэг буюу хэд хэдэн төрлийн байж болно. Үүнд:

- Бүтээгдэхүүн буюу бүрдэл хэсэг үйлдвэрлэх (тоног төхөөрөмж, ширхэгийн бүтээгдэхүүн)
- Үйлчилгээ үзүүлэх
- Төр, засгийн чиг үүрэг гүйцэтгэх
- Программ хангамж гаргах
- Боловсруулсан материал үйлдвэрлэх зэрэг болно.

ISO 9000-ыг бүтээгдэхүүний стандарт мэтээр төсөөлөх тал байдаг, харин ISO 9000 нь аливаа байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавих шаардлагыг тогтоосон стандарт юм.

ISO 9000 бүлэг стандартад туссан чанарын удирдлагын тогтолцоо нь дараахь найман зарчимд тулгуурлана. Үүнд:

- *Хэрэглэгчид төвлөрүүлэх.* Энэ нь хэрэглэгчийн (өнөөгийн болон ирээдүйн) хэрэгцээг таньж мэдэн ойлгох, тэдний шаардлагыг хангах, улмаар хэрэглэгчийн санаснаас давуулах зорилгыг тодорхойлно,
- *Удирдлагын манлайлал.* Чанарын удирдлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхийн тулд дээд шатнаас эхлэн бүх шатны удирдлага нэгдмэл зорилго, чиглэлийг хангахад нийт ажиллагсадыг манлайлан бүрэн оролцох орчныг бүрдүүлэхэд оршино.
- *Ажиллагсадыг бүрэн татан оролцуулах.* Чанарын удирдлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд бүх шатны ажиллагсадыг татан оролцуулах нь байгууллагад ихээхэн ач тустай.
- *Хянаж удирдахдаа үйл явцын талаас нь хандах.* Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад уламжлалт арга нь эцсийн үр дүн буюу бэлэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд голлон анхаарч, тэдгээр нь шаардлагад тохироогүй бол залруулах арга хэмжээ авах явдал юм.
- *Удирдлагад тогтолцоотойгоор хандах.* Чанарын удирдлагын тогтолцооны хүрэн дэх харилцан уялдаа бүхий үйл явцыг нэгэн бүхэл бүтэн тогтолцоо байдлаар авч үзэж удирдах хэрэгтэй.
- *Байнгын сайжруулалт.* Чанарын удирдлагын тогтолцоо нь байнга сайжруулалт хийх ёстой. Энэ нь хяналт, залруулах, сэргийлэх арга хэмжээ, баримт бичгийн хяналт, чанарын аудит, удирдлагын дүн шинжилгээ, өгөгдлийн задлан шинжилгээ зэрэг арга механизмаар дамжин хэрэгжинэ.
- *Шийдвэр гаргахдаа бодитойгоор хандах.* Шийдвэр гаргахын тулд бүх төрлийн өгөгдлийг зөв ашиглах, өөрөөр хэлбэл, өгөгдлийг задлан шинжилсэний үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай байдаг.

Чанарын удирдлагын тогтолцоог олон улсын ISO 9000 стандартын дагуу төрийн байгууллага, албанд ашиглах боломжтой ба төрийн бодлого боловсруулахад оролцооны арга зүйг хэрхэн хэрэглэдэг, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг хэрхэн судалдаг талаар нэлээн олон оронд төсөл, хөтөлбөр хэрэгжсэн байна. Одоо зарим улсын туршлагаас авч үзье.

Онтариа хотын Гүйцэтгэлийг хэмжих хөтөлбөр

Канадын Онтариа хотын захиргаа Орон нутгийн гүйцэтгэлийг хэмжих хөтөлбөрөө (ОГХХ) 2000 онд эхэлжээ. Энэ хөтөлбөр нь мужийн хэмжээгээр үйлчилгээний үндсэн салбарын талаар тусгай тоо, баримт цуглуулах, цуглуулсан баримтаа мужийн захиргаанд танилцуулж, үр дүнг нь сонгогчдод уламжилдаг.

ОГХХ-ийг Онтариагийн хотын Дотоод хэрэг, Орон сууцны яам, Онтариогийн дагуул хотын холбоо болон бусад мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа байхаар боловсруулсан. ОГХХ нь ус, бохир ус, хатуу хог хаягдлын менежмент, газар ашиглалтын төлөвлөлт, нутгийн захиргааны удирдлага, зам, гал унтраах алба, цагдаагийн газар зэрэгтэй холбоотой 35 үзүүлэлтээр баримт цуглуулахыг шаарддаг байна. Мэдээллийн хувьсагч нь үйлчилгээний чанар, үнийг голлон анхаардаг. Мэдээлэл нь хотын танилцуулга, хотын шалгуур үзүүлэлт болон тайлбараас бүрдсэн, найдвартай

online систем маягаар хадгалагдана. Хэрэглэгч болон мэдээлэл цуглуулагчийн санал дээр үндэслэн системийг тасралтгүй сайжруулж байхад тайлбарын хэсэг нь их чухал нөлөөтэй.

Яваандаа хот өөрөө үйлчилгээний чанар, үнийн асуудал дээр бусад хот болон цаг хугацааны өөрчлөлттэй уялдуулан харьцуулалт хийхдээ ашиглах нэгдсэн үзүүлэлттэй болдог байна. Гэхдээ тоо баримтад гарч буй өөрчлөлт нь тухайн хотын нийгэм эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдлыг харуулж байгаа бөгөөд гүйцэтгэлийн хэмжээнээс шууд хамааралтай биш гэдгийг харгалзан үздэг юм.

Гүйцэтгэлийн үнэлгээний тэргүүн туршлагыг түгээх Онтариагийн төв нь тус яам болон мужийн хэмжээгээр ажилладаг бусад холбоодын хамтын ажиллагааны үр дүнд байгуулагдсан байна. Тус төвийн зорилт нь үйлчилгээ үзүүлэх талаар гарч буй тэргүүн туршлагыг түгээх, бусад хотууд хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Тус яам нь бүсийн зөвлөгч нартай бөгөөд тэдгээр нь дээрхи төв болон бусад хотод тэргүүн туршлагыг орон нутгийнхаа онцлогт тохируулан хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлж байна. ОГХХ-ийн энэ туршлагыг Филиппинд нэлээн амжилттай хэрэгжүүлсэн байна. Канадын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжүүлсэн Нутгийн захиргааг дэмжих төслөөр дамжуулан DILG LPPMS гүйцэтгэлийн хэмжээсийн арга хэрэгслийг сайжруулах анхдагч загвар болгон ашигласан байна. Энэ талаар Филиппинчүүд Канадад очиж илтгэл тавьсан ба Канадчууд тэдэнд газар дээр нь очиж зөвлөгөө өгчээ.

Малайзын төрийн үйлчилгээний ISO 9000 гэрчилгээ

Малайзын Удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох нэгж (УТББН) нь ISO 9000 олон улсын гүйцэтгэлийн удирдлагын стандартыг үндэсний төрийн албанд нэвтрүүлэх үүргийг Засгийн газраасаа авчээ. Энэ үйл явц 1996 оны дунд үеэс эхэлсэн бөгөөд Малайзын засгийн газрын 792 агентлаг (үүний дотор орон нутгийн 148 байгууллага), 600.0 мянга гаруй хүн хамрагдсан байна. 2000 он гэхэд агентлаг бүр наад зах нь ISO 9000-ын нэг гол үйл явцыг хэрэгжүүлсэн байхаар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах шаардлага тавьжээ.

Засгийн газрын бүх агентлагт ISO 9000-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, удирдамж гаргахаас энэ үйл явц эхэлсэн. Эдгээр баримт бичигт ISO 9000 стандартын шаардлагыг тайлбарласны зэрэгцээ улсын салбарт хэрэглэж байгаа жишээг оруулсан байна. Мөн Засгийн газар зөвшилцөх замаар хэрэгжүүлэх хуваарь, аудит хийх механизмыг тогтоосон нь агентлагын хувьд ойлгож хэрэгжүүлэхэд дөхөмтэй байжээ. Заавар, удирдамжийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар удирдлага, зохион байгуулалтын болон хүмүүсээ сургах талаар өргөн хүрээтэй ажил хийжээ.

Эхлээд Малайзын Засгийн газар ISO 9000-ыг улсын салбарт хэрэгжүүлэхийн тулд Их Британи, Австрали, Шинэ Зеландаас шинжээч зөвлөхийг урьжээ. Шинжээчид ISO 9000-ын 20 элементийг тодорхойлоход Засгийн газарт тусалжээ. Тэдгээр элемент нь улсын салбарын агентлагийг оролцуулаад аливаа чанарын удирдлагын системд тохирох нийтлэг элемент юм. Зааврын хэрэгжилтэнд агентлаг бүр өөрөө аудит хийх замаар хяналт-шинжилгээ хийхээс гадна бас УТББН аудит хийжээ. ISO 9000-ын шаардлагыг ханган биелүүлсэн агентлагт УТББН-ын баталсан Малайзын Төрийн албаны ISO 9000-ын гэрчилгээг олгоно. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Засгийн газрын зарим агентлаг гуравдагч талаар аудит хийлгэх нь бий. Хэрэглэгч болон гол сонирхогч талын сэтгэл ханамжтай байдлыг хангахуйц хэмжээнд агентлагын үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэхийн тулд Засгийн газар ISO 9000-ын хэрэгжилтэд байнга үнэлгээ хийж байгаа ажээ.

Энэ үйл ажиллагааны гол зорилго нь “ихэнхи төрийн албан хаагчдын үзэл бодлыг өөрчлөх, түүнчлэн шилдэг сайн ажиллагааны соёлыг төлөвшүүлэх”-ээр төлөвлөсөн байна. УТББН-ын үүрэг нь

аудит хийх явдал бөгөөд аудит хийгдсэний дараа Малайзын Төрийн албаны ISO 9000-ын гэрчилгээг олгох боломжтой болдог байна.

Гадаадын ISO 9000-ын шинжээч, зөвлөх нар УТББН-ын ажилтнуудад сургалт хийсний дараа Их Британи, Австрали, Шинэ Зеландад уг стандартыг улсын салбарт хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцах аялал хийсэн нь бүх төрийн албан хаагчдыг сургах, засгийн газрын бүх агентлагийн дарга нарыг удирдамжаар хангах нүсэр зорилтыг хөнгөвчилсөн байна.

Малайзын бий болгосон үзэл баримтлалаар бол төрийн албаны гол чиг үүрэг нь хувийн хэвшлийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх явдал юм. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлсэнээр хувийн салбарт өргөн хэрэглэж байгаа ISO 9000 чанарын стандартыг улсын салбарт хэрэглэхэд дөхөмтэй болох юм.

Аудитын тайланд байгууллагын бүхий л гүйцэтгэлийн үнэлгээний шалгууруудыг оруулна. Эцсийн шалгалт нь байгууллагын үйл ажиллагааны үр дүн сайжирсан эсэх, олон нийтийн санаа бодолд нийцэж байгаа эсэх, Хэрэглэгчийн дүрэмд (Засгийн газрын бүх байгууллага Дүрэмд тунхагласан чанарын стандартыг хангаж ажиллах талаар бичгээр үүрэг авсан байх) тусгагдсан зорилтод нийцэж байгаа эсэх зэргээс хамаарна. Энэ хэрэгжүүлсэн туршлага нь хэрэв засгийн газрын байгууллага бодлого, хөтөлбөрөө үр нөлөөтэй хэрэгжүүлж чадвал өөрийн хэрэглэгчид болон гол сонирхогч талуудынхаа шаардлагыг хангах болно гэдэг нь харагджээ.

ДҮГНЭЛТ:

- Нийгмийн аудитын тухай үзэл санаа, практикт нэвтэрсэн туршлага нь анх бизнесийн байгууллага, хувийн хэвшлийн салбарт хэрэгжсэн байна.
- ХХ зууны сүүл үеэс төрийн захиргааны шинэтгэлийн хүрээнд өндөр хөгжилтэй улс орнуудад төрийн үйлчилгээг боловсронгуй болгох, түүнийг хөгжүүлэхэд төрийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдаас гадна бусад сонирхогч талууд, иргэд, олон нийтийн оролцоог хангахад нийгмийн аудитыг нэг хэрэгсэл болгон хэрэглэсэн нь үр дүнтэй болсон байна.
- Цаашид төрийн албаны гүйцэтгэл, төрийн үйлчилгээг хөгжүүлэх, эдгээрт нийгмийн аудитын арга зүйг ашиглахад эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна түүнийг ашиглах улс төрийн хүсэл эрмэлзлэлийг бий болгох, нийгмийн аудитын шинэ арга зүй, түүнийг ашиглах тогтолцоо, механизмыг хөгжүүлэх зэрэг олон тулгамдсан асуудал байна.
- Нийгмийн аудитын туршлагын зорилго нь улс орнуудад төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэхэд оршино. Аль ч тохиолдолд үндэсний болон орон нутгийн түвшинд одоо байгаа чадавхи, чадварт түшиглэх хэрэгтэй бөгөөд улс орны нийгэм, соёлын нөхцөл байдалд тохирсон арга замаар хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Ашигласан материал

1. Нийгмийн аудит. УБ., 2005 он
2. Нийгмийн аудит (Гадаадын зарим орны туршлагаас). УБ., 2005 он
3. А.А. Шулус, Ю.Н. Попов Социальный аудит. М., 2008 г.
4. Ю.Н. Попов Концепция социального аудита. М., 2007 г.
5. Social audit of public services. www.ciet.org

**ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АСУУДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАНДЛАГА**
(Харьцуулсан судалгаа)

*Ц. Норовдондог (Ph.D), А.Пагма (МА, Б.Ариунжаргал (МА),
О.Нарантуяа, Т.Мягмаржав*

АГУУЛГА

Удирдтгал

Судалгааны дүгнэлт

I. Улсын салбарын шинэчлэлийн зорилго, мөн чанар, хандлага

ii. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэлбэрүүд

iii. Төрийн үйлчилгээг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлсэн зарим орны туршлага

- 3.1. Австрали улс
- 3.2. Их Британи
- 3.3. Канад улс
- 3.4. АНУ
- 3.5. ОХУ

Ашигласан материал

УДИРТГАЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Ө.Энхтүвшингийн захиалгаар “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх асуудал, бусад орнуудын туршлага, хандлага” сэдэвт судалгааны ажлыг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь төрийн байгууллагуудын гүйцэтгэж байгаа зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэлбэрийг тодорхойлох, зарим улс оронд энэ чиглэлээр төрийн салбарт шинэчлэл хийсэн туршлагыг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

Судалгааны зорилтууд:

- Төрийн салбарын шинэчлэлийн зорилго, мөн чанар, хандлагыг судлах
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэлбэрүүд, олон улсын хэмжээнд төлөвшин бий болсон арга зүйг тодруулах

- Төрийн удирдлагын үйл явцад аутсорсингийг ашиглах аргыг судлах
- Төрийн үйлчилгээг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлсэн зарим орны туршлагыг харьцуулан судлаж дүгнэлт хийх

Судалгааны аргачлал:

- Төрийн салбарын шинэчлэлийн агуулга, мөн чанар, онцлогын харьцуулалт,
- Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой материалыг судалж нэгтгэн дүгнэх,
- Бичиг баримтын судалгаа

Энэ хүрээнд:

- Төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх асуудалтай холбоотой ном, материал, судалгааны тайлангуудад анализ хийсэн
- Бусад орнуудын туршлага, цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны багийг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн референт-шинжээч А.Пагма ахлаж (I, II бүлэг, III.5) судлаач Б.Ариунжаргал (III.1), судлаач Т.Мягмаржав (III.2) судлаач О.Нарантуяа (III.3,4) нар гүйцэтгэв.

Судалгааны дүгнэлт:

1. Бидний судалгаандаа авч үзсэн гадаадын улсуудад төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл явц нь гол төлөв төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явагдсан ба Концесс, Тендер, Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоод, аутсорсингоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зэрэг олон янзын хэлбэрээр хэрэгжсэн байна. Манай улсад энэ чиглэлийн үйл ажиллагааны концесс, тендер, гэрээгээр гүйцэтгүүлэх эхлэл тавигдсан бөгөөд харин төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн гүйцэтгүүлэхэд аутсорсингийг ашиглах, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх хэлбэр төдийлэн нэвтрээгүй байна.
2. Гадаадын зарим орны туршлагаас харахад төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим үүргийг улсын бус секторт шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагааг олон янзын хэлбэрээр нэвтрүүлсэн нь үр дүнтэй болжээ. Үүнийг улс бүрээр нь нэгтгэн авч үзье:

а/ Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага нь 51 хувь нь хувийн салбарын пүүс компаниуд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг ба хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна. Түүнчлэн Их Британийн Төрийн үйлчилгээний Омбудсмен ажиллуулдаг ба төрийн үйлчилгээний стандартын дагуу түүний чанар хүртээмжийг шалгадаг байна.

б/Австрали улсын “Partnerships Victoria” бодлогын баримт бичиг нь хамтын хэлэлцээр хийхийн өмнөх шийдвэр гаргалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн менежмент,

мониторинг ба хяналтын хийх асуудлыг багтаасан цогц заавар журмуудыг анхлан тодорхойлжээ. Түүнээс хойш уг удирдамжийг байнга сайжруулан шинэчилж, хэрэгцээт жишээ хэв загваруудыг багтааснаараа цаг үетэйгээ нийцэж Австралийн бусад мужуудын хувьд төдийгүй олон улсын түвшинд стандарт, үлгэр дууриалал болон хэрэглэгддэг байна. Түүнчлэн Австралид төрийн зарим үүргийг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлэхэд аутсорсингийг ашиглаж байна.

в/ Канад улсын хувьд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчин нь нэлээн боловсронгуй ба Төрийн үйлчилгээний тухай хууль, Төрийн үйлчилгээг өөрчлөх болон үүргийг шилжүүлэх тухай акт, Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт зэрэг гол хуулиуд нь төрийн зарим үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн. Мөн дэд бүтэц, нийтийн тээвэр, ус болон хог хаягдлын байгууламж, эмнэлэг, сургууль, халамжийн байгууллага, олон нийтийн амралт соёлийн төвийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог өргөн ашиглаж байна.

г/ АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд цэвэр болон муу ус, хог хаягдлын үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээ, барилгын засвар үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, архитектур ба инженерингийн үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээ болон барилга байгууламжийн менежментийн удирдлага, ашиглалтыг голчлон гэрээгээр гүйцэтгүүлдэг нийтлэг жишиг эртнээс тогтжээ. Түүнчлэн АНУ-д өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нилээд туршлага солицож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг.

д/ ОХУ-д төрийн гүйцэтгэх байгууллагуудад аутсорсингийг өргөн ашиглаж, ялангуяа Холбооны субъектууд өөрийн засгийн газрын тогтоол, журмаар энэ үйл ажиллагааг зохицуулан амьдралд өргөн нэвтрүүлж байна. Бизнес холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллаж гэрээний үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх үйл ажиллагаа үндсэндээ эрх зүйн хувьд ч, практик дээр ч төлөвших шатандаа явж байна. Мөн нийгмийн үйлчилгээний салбар тухайлбал, нийгмийн халамж, өндөр настны эмчилгээ, үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог өргөн ашиглаж байна.

3. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох нь чухал ба энэ хүрээнд төр, засгаас иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоодын ажилд бодитой туслалцаа үзүүлэх, тэдгээрээс дэвшүүлсэн санал, санаачлагыг хүлээн авч дэмждэг, хэрхэн ажил хэрэг болгосноо эргэж тайлагнадаг хууль эрх зүйн орчныг мөн бүрдүүлэх шаардлагатай.
4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх үйл явц нь үндэслэлтэй эсэхийг тогтоох шалгуур, үзүүлэлтийг боловсруулах нь чухал бөгөөд энд зөвхөн төсвийн зардлыг багасгах явдал голлох шалгуур болж болохгүй юм. Харин төрийн зарим үүргийг төрийн бус байгууллага, хувийн секторт шилжүүлэх үйл явцын үндсэн шалгуурууд нь шилжүүлсэн үүргийг хэрэгжүүлэх үр ашиг нэмэгдэх, үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодог ажээ.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ:

I. Улсын салбарын шинэчлэлийн зорилго, мөн чанар, хандлага

XX зууны эцэс XXI зууны эхээр дэлхийн ихэнхи улс оронд улсын салбарын шинэчлэл явагдаж, төрийн удирдлагыг өөрчлөх цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэ удирдлагын тогтолцоонд шилжүүлэх өргөн цар хүрээтэй үйл явц явагдсан, одоо ч үргэлжилж байна. Энэхүү өөрчлөлт шинэчлэл нь төрийн байгууллагыг тогтолцооных нь хувьд үр ашгийг нь нэмэгдүүлэх, төрийг өндөр чадавхитай, мэргэшсэн боловсон хүчин бүхий, ингэхдээ эдгээр боловсон хүчинд зарцуулж буй зардлаа хянадаг, тооцдог чадвартай хүчирхэг ажил олгогч болгох, хувийн хэвшил, ард иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх цогц зорилтуудыг шийдвэрлэх шаардлагыг дэвшүүлжээ.

Улсын салбарын шинэчлэлийн голлох салбар, чиглэл нь нийгэмд төрийн үүрэг, төрийн удирдлагын байгууллагуудын бүтэц, төрийн аппаратын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн албаны удирдлага, санхүүгийн удирдлагын шинэчлэл, төрийн удирдлагын ил тод, тайлагнах байдал зэрэг болно.

Дэлхийн зарим улсад, тухайлбал, Австрали, Шинэ Зеланд, Их Британид улсын салбар, төрийн удирдлагыг бүхэлд нь, үндсээр нь шинэчлэх (New Public Management) байдлаар явагдсан бол Герман, Финлянд, Голланд зэрэг оронд аажмаар шинэчлэх, Канадад аль алийг нь хослуулах замаар энэ шинэчлэлийг хийж байна. Ингэхдээ энэ хоёр замын алиныг нь ч сонгосон хувийн секторын удирдлагын давуу талыг онцолж, түүний арга, загварыг хэсэгчлэн болон бүхэлд нь төрийн удирдлага, улсын салбарын удирдлагад нэвтрүүлэх, төрийн захиргааны шинэчлэл уламжлалт бюрократ тогтолцоонд бус, харин аж ахуй эрхлэх менежментэд суурилах, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, төрийн үйлчилгээг нийлүүлэхэд өрсөлдөөнийг дэмжих, гүйцэтгэлд үндэслэсэн үнэлгээ нэвтрүүлэх, төрийн зарим үүргийг хувийн хэвشلээр гүйцэтгүүлэх, хувьчлах явдлыг тэргүүлэх чиглэл болгожээ.

Төрийн удирдлага, захиргааны шинэчлэлийн нэг гол чиглэл нь төр, иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааны нэг үндсэн хэлбэр болох төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх явдал бөгөөд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх нэг чухал арга нь төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэх үйл ажиллагаа юм.

Төрийн зарим чиг үүргийг хувийн сектор, төрийн бус байгууллагад шилжүүлэх нь ардчилсан, өндөр хөгжилтэй улс орнуудын улсын салбарын хөгжлийн орчин үеийн хандлага бөгөөд төрийн зарим үүргийг гүйцэтгэхэд “гуравдугаар сектор” оролцох нь үйлчилгээг тодорхой, шуурхай болгох, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, захиргааны хүнд суртлыг халж, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээг нэн тэргүүнд тавих боломжийг олгодог байна.

Төрийн үйлчилгээ нь төрийн нийтийн чиг үүрэгтэй шууд холбоотой ба төрийн байгууллагууд эдгээр үүрэг дээр үндэслэн уг үйлчилгээг үзүүлдэг. Төрийн үйлчилгээ нь төрийн чухам ямар чиг үүрэгтэй холбогдон гарч ирдэг вэ гэдэг асуудлыг тодруулах үүднээс төрийн чиг үүргийн дараахь хоёр том бүлэг болгон авч үздэг. Үүнд:

1. Иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн төрийн чиг үүрэг
2. Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоогүй чиг үүрэг болно.

Төрийн гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлах, данслаж цэгцлэх үйл явцад (Inventory of function) эдгээр чиг үүргийг дараахь 3 бүлэг болгон хуваажээ. Үүнд:

1. Хууль, хэм хэмжээ тогтоох чиг үүрэг
2. Хууль хэрэглэх чиг үүрэг
3. Төрийн (нийтийн) үйлчилгээ үзүүлэх ба төрийн өмчийг удирдах чиг үүрэг болно.

Төрийн зарим чиг үүргийг улсын бус салбарт шилжүүлэн гүйцэтгүүлэх асуудал нь энэ 3 дугаар бүлэг чиг үүрэг буюу төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй холбоотой гэдэг нь ойлгомжтой юм. Төрийн буюу нийтийн үйлчилгээ нь бусад үйлчилгээнээс ялгарах дараах онцлог шинжтэй байдаг. Үүнд:

- Эдгээр нь бүх нийтийг хамарсан, нийтийн ач холбогдол бүхий үйл ажиллагааг хангадаг.
- Уг үйлчилгээг хүртдэг субъект нь хязгааргүй хүрээтэй байдаг.

- Нийтийн үйлчилгээг төр ба орон нутгийн байгууллага, аль эсхүл өөр бусад субъект үзүүлдэг.
- Нийтийн үйлчилгээ нь нийтийн болон хувийн өмч дээр суурилдаг.

Төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэх үйл ажиллагааг захиргааны журмаар (ихэвчлэн тусгайлан байгуулсан бүтцээр дамжуулан) ба гэрээний үндсэн дээр шилжүүлэх гэсэн замаар хэрэгжүүлдэг.

Төрийн үйлчилгээг хүргэх дэг журам, хэмжээ, нөхцөлд их, бага ямар нэгэн өөрчлөлт орох нь хэрэглэгчдэд шууд нөлөөлөх учраас нийтийн үйлчилгээг улсын бус секторт шилжүүлэх шийдвэрийг гаргахдаа нухацтай хандах, хэрэглэгчдийн хүсэл, сонирхлыг харгалзах нь чухал байдаг байна.

Түүнчлэн ийнхүү шилжүүлэх үйл явц нь үндэслэлтэй эсэхийг тогтоох шалгуур, үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай ба энд зөвхөн төсвийн зардлыг багасгах явдал голлох шалгуур болж болохгүй юм. Харин төрийн зарим үүргийг төрийн бус байгууллага, хувийн секторт шилжүүлэх үйл явцын үндсэн шалгуурууд нь шилжүүлсэн үүргийг хэрэгжүүлэх үр ашиг нэмэгдэх, үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодог ажээ.

Төрийн үйлчилгээний чиг үүргийг улсын бус салбарт шилжүүлэхийн тулд дараахь нөхцлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- Нийтийн үйлчилгээг улсын бус салбарт шилжүүлэх шалгуурыг тодорхойлох,
- Нийтийн үйлчилгээг шилжүүлэн гүйцэтгэх гэж буй төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагыг тодруулах шалгуурыг тодорхойлох,
- Нийтийн үйлчилгээг дээрхи байгууллагуудаар шилжүүлэн гүйцэтгүүлэх нөхцөлийг тодорхойлох зэрэг болно.

Мөн төрийн зарим чиг үүргийг шилжүүлж байгаа тодорхой тохиолдол бүрт ямар зорилтод хүрэх гэж буй, ийнхүү шилжүүлэхийн нийгмийн ач холбогдол бүхий үр дүн, урьд нь ямар сөрөг үр дүн гарч байсан, түүнийг хэрхэн арилгах арга зам зэргийг нарийн тооцож тодруулсан байх шаардлагатай байдаг байна.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх нэг чухал нөхцөл нь төрийн зүгээс эдгээр байгууллагын үзүүлж буй үйлчилгээний чанарт хяналт тавих явдал юм.

Ихэнхи улс оронд энэхүү хяналтыг “Төрийн үйлчилгээний стандарт”-ын (Public Service Standards)⁴¹ дагуу явуулдаг байна. Энэхүү стандартыг боловсруулахын тулд төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг (The register of Public Service)⁴² гаргадаг.

II. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэлбэрүүд, тэдгээрийн онцлог

Төрийн удирдлага, захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл явц нь ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явагддаг ба төрийн эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэх хэд хэдэн хэлбэрийг ангилж болохоор байна. Үүнд:

1. **Концессийн гэрээ** (Төрийн зүгээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах хэлбэр)
2. **Тендерийн гэрээ** (Төрийн хөрөнгөөр хувийн хэвшлээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх хэлбэр)
3. **Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоодоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх** (Зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллагын зарим чиг үүргээс зах зээлийн хяналт, зохицуулалтын зарим эрх, үүргийг

⁴¹ [Public Service Standards 2007-2008](http://www.nationalarchives.gov.uk). www.nationalarchives.gov.uk

⁴² [National Register of Public Service](http://www.nrpsi.co.uk). www.nrpsi.co.uk

Мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүдэд шилжүүлсэнээр зах зээлийн өөрөө өөрийгөө зохицуулах механизмыг төлөвшүүлэх, шаталсан хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх хэлбэр)

4. **Аутсорсинг** (Тухайн хэрэгцээт ажил үйлчилгээг нарийн мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэх хэлбэр) гэх мэтээр

Концесс нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр бөгөөд төр, концесс эзэмшигчид байгалийн баялаг, газар, дэд бүтцийн объектууд, үйлдвэрийн газар бусад аж ахуйн объектууд, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр харилцан ашигтай нөхцөлөөр ашиглуулахаар шилжүүлэх хэлбэр юм. Концессийн гэрээний зүйл буюу объект нь гол төлөв нийтийн шинж чанартай объектууд байдаг, тухайлбал, нисэх буудал, төмөр зам, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжууд мөн нийтийн тээврийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын объектууд зэрэг болно.

Түүнчлэн концессийн олон хэлбэр байдаг ба төсөл боловсруулах, барих ажлыг хувийн байгууллагад зөвшөөрч мөнгө, цаг хэмнэхийн зэрэгцээ гүйцэтгэлийн баталгаатай байдлыг хангах болон төслийн нэмэлт эрсдлийг хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвшлийн байгууллага үндэсний болон орон нутгийн засаг захиргааны захиалгаар тодорхой нэг үйлчилгээг (барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ) хүргэх, түүнтэй холбогдох засвар үйлчилгээ зэрэг өдөр тутмын үйл ажиллагаа, ашиглалтыг гэрээгээр гүйцэтгэн төрийн эрх бүхий байгууллага тухайн барилга байгууламж, системийг өмчилж ерөнхий удирдлагаар хангах зэрэг хэд хэдэн хэлбэртэй. Эдгээр хэлбэрүүд нь эрсдэл шилжүүлэх хэмжээ болон хувийн салбарын оролцооны хувьд харилцан адилгүй ба жишээ нь, Канад улс гэхэд урд нь төрийн хариуцаж байсан ажил үйлчилгээг хувийн хэвшилд бүхэлд нь концессоор гүйцэтгүүлэхийг түншлэлийн дээд хэлбэр гэж үздэг байна⁴³.

Тендер нь урьдчилсан уралдаанд шалгаруулалтын үндсэн дээр түншлэгчийг шалгаруулан гэрээ байгуулах хэлбэр юм. Тендер нь шударга, үр ашигтай байдал, өрсөлдөөний үндсэн дээр төрөөс бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гэрээт ажил, үйлчилгээ хийлгэх түншлэгчээ сонгон гэрээ байгуулах үйл явц болно.

Тендер нь нээлттэй, хаалттай, тусгай хаалттай, хоёр үе шаттай, үнэ тогтоох зэрэг төрөлтэй. Аливаа тендерийг шударга явуулах анхдагч нөхцөл нь сонирхогч талуудыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр жигд хангаж, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх явдал гэж үздэг.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх нь иргэний нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон төрийн бус байгууллагууд нь төсөв зардлыг хэмнэх, үйлчилгээг иргэдэд илүү ойртуулж, шуурхай үр дүнтэй хүргэх боломжтой байдгаараа давуу талтай байдаг байна. Төрийн бус байгууллагууд нь нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн хэв журам, хүний эрхтэй холбоотой асуудлууд, мэдээлэл, зар сурталчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг үзүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцдог.

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр болон хуулийн дагуу шилжүүлэн хэрэгжүүлэхэд **мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагууд** чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэхдээ мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагууд нь тухай салбарын харилцааг хянах, зохицуулах харилцааг хууль, журмын хүрээнд зохицуулахын зэрэгцээ хамгийн гол нь тухайн салбарын үйл ажиллагааны стандарт, журмыг боловсруулан тогтоох, түүний дагуу үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхийг тэдэнд хуулиар олгосон байдаг оршино. Тухайлбал, **Канадын радио нэвтрүүлгийн стандартын зөвлөл (CBSC)** - Canadian Broadcast Standards Council -Энэхүү зөвлөл нь Канадын хувийн салбарын нэвтрүүлэгчдийн өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага юм. Зөвлөл нь хэд хэдэн дүрэм журам (code)-ыг гарган

⁴³ Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. Захиалгат судалгааны тайлан. УБ., 2010, 14 дэх тал

мөрдүүлж байгаа бөгөөд тухайлбал: секс дүрийг дүрслэх журам (sex role portrayal code), хүчирхийлэлийн журам (violence code), ёс зүйн дүрэм (code of ethics), мөн радио телевизийн нэвтрүүлэгчдийн ёс зүйн дүрэм, радио телевизийн нэвтрүүлгийн программийн үнийн журам, сэтгүүлчийн ёс зүйн дүрэм гэх мэт дүрэм журмуудаар зохицуулагддаг байна.

Мөн үзэгч сонсогчдийн зүгээс нэвтрүүлэгтэй холбоотой санал хүсэлт, нэвтрүүлэгчдийн талаархи гомдолоо зөвлөлд гаргах бөгөөд зөвлөл уг асуудлыг 14 хоногт хариу өгдөг байна. Энэ нь нэвтрүүлэгчдийн хариуцлагын түвшин өсөхөд ихээхэн нөлөөлж байна гэж Зөвлөлийн олон нийтийн хэлэлцүүлгийн илтгэлд дурдсан байна. Энэхүү зөвлөл нь жил бүр олон нийтэд илтгэл тайлангаа тавьж хэлэлцүүлдэг байна.

Түүнчлэн хүүхдийн нэвтрүүлгийн стандарт, бусдыг доромжилсон нэвтрүүлгийн, хүчирхийлэлийн гэх мэтчилсэн нилээд олон стандартуудыг зөвлөлөөс батлан гаргаж мөрдүүлж байна.

Олон улсын үнэт цаасны хороо-IOSCO-АНУ-ын үнэт цаасны зах зээлд томоохон байр эзэлдэг байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг байна. Олон улсын үнэт цаасны хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж дүгнэх аргачлал, арга зүйг баталсан бөгөөд уг дүрмийн 6-д “Өөрөө өөрийгөө зохицуулахад хамаарах зарчим (Principles relating to Self-Regulation)-уудыг тодорхойлж зохицуулсан байна. Өөрөө өөрийгөө зохицуулагч энэхүү байгууллага нь бүхий л үйл ажиллагаагаа дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах болон хянах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Дэлхийн олон улс оронд явагдсан захиргааны шинэчлэлийн нэг зорилго нь төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа инновацийг нэвтрүүлэхэд бэлэн байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан бөгөөд төрийн удирдлагын хувийн хэвшил, эдийн засгийн салбарын тэргүүлэх туршлагаас нэвтрүүлсэн шинэ технологи нь аутсорсинг билээ.

“Аутсорсинг” гэдэг үг нь англи хэлний **“outsourcing”** буюу гадаад орчноос нөөц эрж хайх гэсэн утгатай үг. Эдийн засгийн салбарт аутсорсинг гэдэг бол тухайн компанийн үйл ажиллагаанд хэрэгтэй ямар нэг ажлыг тухайн ажлыг хийж мэргэшсэн өөр компаниар хийлгэхийг хэлнэ.

Сонгодог тодорхойлолтууд:

- “Байгууллага өөрийн түргэн хугацаанд гүйцэтгэх ёстой ажлуудыг гадны гүйцэтгэгчийг ашиглан гүйцэтгүүлэх үйл явц” (Филип А. Лапланте)
- “Бүтээгдэхүүн болон үйлчилгээгээ өөрийн боломжоор хийснээс илүү чанартай, хурдан хийлгэхийн тулд гадны гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг хэлнэ.” (Ранди Сойфер)⁴⁴

Харин захиргаа-удирдлагын үйл явцад аутсорсингийг хэрэглэх гэж төрийн үйлчилгээний тодорхой үүргийг шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, орон нутгийн байгууллага, бусад байгууллагаар гүйцэтгүүлэхийг хэлнэ⁴⁵.

Төрийн үйлчилгээнд аутсорсинг дараах үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, тухайлбал, мэдээллийн шинэ технологийг нэвтрүүлэх зэрэг үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх,
- Төрийн өмчийн барилга, байгууламжийн удирдлага, үйлчилгээг гүйцэтгэх,
- Боловсон хүчнийг шилж сонгох, холбооны үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн тооцоо, тооллого хийх,
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал, төсвийн хөрөнгийн хэмнэлтэд хяналт тавих,
- Төрийн удирдлага, захиргааны байгууллага үндсэн үйл ажиллагаандаа гол анхаарлаа хандуулах боломж олгох зэрэг болно.

⁴⁴ www.biznetwork.mn

⁴⁵ Административная реформа: решения и проблемы. www.adm.yar.ru

Аутсорсингийн хөгжлийн орчин үеийн хандлага нь олон улс оронд төрийн байгууллагын үйл ажиллагаанд энэ технологийг ашиглаж байгаа нь харагдаж байна⁴⁶.

Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй аутсорсингийн хөгжлийн дараах 4 хандлагыг онцолж болно. Үүнд:

- **Төрийн үйлчилгээнд гэрээний үндсэн дээр үүрэг шилжүүлэн үйлчилгээ үзүүлэх практикийг өргөн хүрээтэй болгосон:** Олон орны нийтийн үйлчилгээний⁴⁷ салбарт төрийн бус байгууллагууд зөвхөн техникийн болон тээврийн үйлчилгээ үзүүлэхэд оролцох бус харин хүн амд төрийн болон орон нутгийн үйлчилгээ, тухайлбал, татварын хуудсыг цуглуулж авах, хорих байгууллагыг удирдах, хувийн гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх болон бусад үйлчилгээ үзүүлдэг болсон байна.
- **Төрийн байгууллагын болон албан хаагчдын үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт орсон:** Төрийн байгууллагын үйл ажиллагаанд аутсорсингийг нэвтрүүлсэнээр улсын бус салбараар шилжүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг төрөлжүүлэх, данслах, жагсаалт гаргах, шилжүүлэх шалгуурыг боловсруулах, зарим төрлийн үйл ажиллагааны зардлыг тооцох ил тод, тунгалаг тогтолцоог бүрдүүлэх, аутсорсингийг ашиглах, хянах, гэрээний биелэлтэд мониторинг хийх журам боловсруулах, төрийн байгууллагуудыг аутсорсинг ашиглахад түлхэц үзүүлэхүйц механизм бий болгон хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийгдсэн.
- **Түншлэлийн харилцаа тогтоох:** Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нэг хэлбэр бөгөөд хувийн хэвшил нь аж ахуйн нэгж байгууллага байхаас гадна ашгийн бус байгууллага буюу төрийн бус байгууллага байж болно. Оролцогч тал бүр эзэн байх, өөрөөр хэлбэл, оролцогчид аль нэг эрх бүхий байгууллагаас үл хамааран өөрийн нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцээр хийх чадвартай байна. Түншлэл нь оролцогчдын хооронд удаан хугацаанд тогтвортой үргэлжлэх харилцааг байгуулна. Түншлэл нь үр дүн эсхүл үйл ажиллагааны төлөө хариуцлагаа хуваалцахыг илэрхийлнэ.
- **Төрийн болон орон нутгийн чанартай гэрээний агуулга өөрчлөгдсөн:** Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагын хооронд байгуулсан гэрээнд юун түрүүнд үйлчилгээний төлбөрийн төрөл, хэмжээ, гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага зэрэг эдийн засгийн агуулга бүхий заалтуудад ач холбогдол өгч, үүнд гэрээний эрх зүй онцгой байр суурь эзлэх болсон. Түүнчлэн захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан үндсэн гэрээний хамт үйлчилгээний түвшингийн (Service Level Agreements) тухай гэрээг мөн байгуулдаг. Энэ нэмэлт гэрээнд үйлчилгээний чанарт тавигдах шаардлага, үзүүлэлтийг нарийвчлан зааж, түүнд тавих хяналтын арга хэрэгслийг тодорхойлно.

III. Төрийн үйлчилгээг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлэх талаар зарим орны туршлага

3.1. Австрали улс

Австрали улс нь төрийн бүтцийн хувьд парламентын засаглалтай Холбооны Засгийн газар бүхий тогтолцоотой бөгөөд ТХХТ (Төр Хувийн Хэвшлийн Түншлэл) төсөл, хөтөлбөрүүд нь голчлон нэгдсэн Засгийн газар гэхээсээ илүү Холбооны муж улсаар дамжин, бие даан хэрэгжиж эхэлсэн.

Мужуудын засаг захиргаа нь эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийн асуудлыг хариуцан, хүн амын хэрэгцээнд нийлүүлэх ажлын тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

Бодлого, хууль эрх зүйн орчин

ТХХТ-ийг хэрэгжүүлэхдээ дараах бодлого, хууль эрх зүйн актын дагуу хэрэгжүүлдэг.

- **Хууль эрх зүй:** Австралийн Үндсэн хууль (Constitution), Төрийн үйлчилгээний тухай хууль (Public Service Act) 1999, Эрүүгийн хууль (Crimes Act) 1914, Хяналт шалгалтын

⁴⁶ Outsourcing of Public Services in Australia. www.inst-informatica.pt

⁴⁷ Public Service

ерөнхий хууль (Auditor-General Act) 1997, Санхүүжилтийн тухай хууль (Appropriation Acts), Иргэний түншлэлийн тухай хууль (Civil Partnership Act) 2004.

- **Бодлогын баримт бичиг:** Виктория хамтын ажиллагааны тухай (Partnerships Victoria) 2000, Нээлттэй өрсөлдөөний бодлого (Open Competition), Албан тайлангын баримтлах бодлого (Mandatory Reporting), Төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл (Public Works).
- **Санхүүгийн менежментийн хууль зүйн орчин:** Санхүүгийн удирдлага ба хариуцлагын тухай хууль (Financial Management and Accountability Act) 1997 болон хуультай холбогдож гарсан дүрэм, журам, тогтоолууд (Orders,), Хамтын нөхөрлөлийн орнуудын компани болон тэдгээрийн зохицуулалтын тухай хууль (Commonwealth Authorities and Companies Act) 1997, хуультай холбогдолтой гарсан тогтоолууд (Commonwealth Authorities and Companies Regulations).

Виктория мужид хувийн хэвшил дэд бүтцийн салбарт гар бие оролцож, бүтээн байгуулах болсон үеийг цаг хугацааны хувьд 2000 оноос өмнөх болон 2000 оны дараах үе гэж ерөнхийд нь хоёр хуваан авч үздэг байна.

1997 онд үндсэн дараах ажил үйлчилгээнд хуваагдаж байсан:

- Замын үйлчилгээ (зам, замын хажуу, явган хүний зам, ус зайлуулах үйлчилгээ, автомашины зогсоолын үйлчилгээ, замын хажуугийн тохижилт болон тэмдгийн үйлчилгээ, гудамжны цэвэрлэгээ)
- Талбайн үйлчилгээ (задгай талбай, далайн түрэлтийн үед усанд ордог эрэг хавийн бүс болон модны үйлчилгээ, оршуулгын газар)
- Барилгын үйлчилгээ (барилгын үзлэг болон дотоод үйлчилгээ)

2000 оноос хойш дараах ажил үйлчилгээ нэмэгдсэн байна:

- Замын үйлчилгээ (орон нутгийн замын энгийн техник үйлчилгээ, ус зайлуулах сувгийн засвар)
- Цэвэрлэгээ (бүх ус зайлуулах сувгийн дэд бүтэц, арилжааны болон олон нийтийн задгай талбай, ариун цэврийн газрууд /00/ зэргээс хог цуглуулах)
- Цэцэрлэгт хүрээлэн болон замын хажуугийн талбайн үйлчилгээ (бүх орон нутгийн /сүлжээ/ замын хажуу, тоглоомын талбай, амралтын бүс болон галын унтраах зэрэг үйлчилгээ)
- Тохижилт болон тэмдгийн үйлчилгээ (замын, цэцэрлэгт хүрээлэнгийн бүх тэмдэг, бүх тохижилт буюу тавилга, шат, явган хүний зам)
- Барилгын үйлчилгээ (төрийн өмчийн бүх барилгын дотоод үйлчилгээ болон цаг үеийн үйлчилгээ)⁴⁸

2000 оноос өмнөх үеийн үйл явцын онцлог нь балансын гаднах буюу төсвийн болон татварын бус санхүүжилтийн эх үүсвэрийг хайж олох, хувийн хэвшлийн байгууллагуудын өрсөлдөөнт болон үр ашигтай ажиллах чадварын итгэлцлийг бий болгоход анхаарсан байна. 2000 оноос хойш ТХХТ-ийн үе нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн “мөнгөний үнэ цэнэ”-ийг бий болгох баримжаатай, эрсдлийг эрчимжүүлэн шилжүүлэх тал дээр голчлон анхаарч ирсэн байна.

2000 онд гарсан “Partnerships Victoria” бодлогын баримт бичиг нь хамтын хэлэлцээр хийхийн өмнөх шийдвэр гаргалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн менежмент, мониторинг ба хяналтын хийх асуудлыг багтаасан цогц заавар журмуудыг анхлан тодорхойлжээ. Түүнээс хойш уг удирдамжийг байнга сайжруулан шинэчилж, хэрэгцээт жишээ хэв загваруудыг багтааснаараа цаг үетэйгээ нийцэж Австралийн бусад мужуудын хувьд төдийгүй олон улсын түвшинд стандарт, үлгэр дууриалал болон хэрэглэгддэг байна.

Виктория мужийн Хамтын Ажиллагааны арга барилын салшгүй гол санаа нь Засгийн газар актив хөрөнгө худалдан авч байгаа бус, харин зөвшөөрөгдсөн чанартай, тоо хэмжээтэй, тогтоосон

⁴⁸ www.econ.mq.edu.au

зардалтай болон заасан цаг хугацаатай ажил үйлчилгээг хувийн хэвшлээс худалдан авч байгаа явдал юм.

Уламжлалт улсын салбарын худалдан авалт ба Викториа Хамтын Ажиллагааны аргачлал хоёрын ялгаатай талыг дор харьцуулан үзүүлсэн болно.

Уламжлалт улсын салбарын худалдан авалт ба Викториа Хамтын Ажиллагааны аргачлалын харьцуулалт⁴⁹

Уламжлалт худалдан авалт	Викториа хамтын ажиллагаа
Дэд бүтцийн барилга, байгууламжийг төр худалдан авна	Дэд бүтцээр дамжин нийлүүлэгдэж буй үйлчилгээг төр худалдан авна
Зураг төсөл, барилга байгуулалтын богино-хугацаат гэрээ (2-4 жилийн)	Зураг төсөл, барилга байгуулалтыг бүхэлд нь хамарсан урт хугацааны гэрээ (20+жил)
Орцод суурилсан ажлын жагсаалт	Гарцад суурилсан ажлын жагсаалт
Барьж байгуулах болон ашиглах хугацааны бүх эрсдлийг төр хүлээнэ	Барьж байгуулах болон ашиглах хугацааны бүх эрсдлийг хувийн хэвшил хүлээнэ
Хөрөнгө оруулалтын эхний зардал өндөр, урсгал зардал бага байхаар төлбөр хийгддэг	Барилга байгууламж ашиглалтад ормогц төлбөр хийгдэнэ. Төлбөрийн хэмжээ урт хугацааны гэрээний туршид харьцангуй жигд байна
Барьж байгуулах цаг хугацаа болон зардлын хэтрэлтийг төр үүрэхэд хүрдэг	Хувийн гэрээлэгч барьж байгуулах цаг хугацаа болон зардлын хэтрэлтийг харуулна
Барилга байгууламжийг төр хариуцан ажиллуулна	Барилга байгууламжийг төр хариуцан ажиллуулах эсэх нь үйлчилгээний төрлөөс хамаарна
Байгууламжийг барих, ашиглах хугацааны туршид төрөөс олон тооны гэрээ, хэлэцээрийг байгуулна	Байгууламжийг барих, ашиглах хугацааны туршид төрөөс ганцхан тооны гэрээ хийдэг
Үйл явц дахь ажлын гүйцэтгэлээс хамаарсан стандарт байхгүй	Гүйцэтгэлийн стандарттай, үйлчилгээ гэрээнд заасны дагуу биелүүлээгүй нөхцөлд төлбөрийг бууруулах боломжтой
Ашиглалтын хугацаа тодорхой биш	Хүлээлгэн өгөх чанарын үзүүлэлт болон ашиглалтын хугацаа тодорхой

Дээрхи хүснэгтээс Викториа Хамтын Ажиллагааны гол элементүүд нь:

- Засгийн газар төрөөс үзүүлэх гол ажил үйлчилгээ, тухайлбал, улсын сургуулийн сургалт, улсын эмнэлгийн болон засан хүмүүжүүлэх үйлчилгээ гэх мэт хариуцлагыг өөртөө авч үлдсэн
- Хөрөнгийн хомсдол болон балансын хуудасны тоон харьцаанаас илүүтэйгээр мөнгөний үнэ цэнийг хөдөлгөгч хүчин зүйл болгосон
- Хамтын ажиллагааны төрөл бүрийн загваруудыг ашигласан
- Худалдан авалтын процессыг ил тод тендерээр явуулах зарчмыг хатуу баримталсан
- Олон нийтийн ашиг сонирхлын шалгуурыг давж байгаа эсэхийг шалгах тестыг шударга тэгш байдал, хэрэглэгчдийн эрх, олон нийтэд хүртээмжтэй байдал, аюулгүй байдал, хувийн нууцлал зэрэг шалгуураар боловсруулсан

⁴⁹ Partnerships Victoria. Guideline material. July 2006, Overviem, page 5

- Өрсөлдөөнт төвийг сахисан зохицуулалтаар засгийн газрын агентлагын өөрт нь ноогдсон ерөнхий өрсөлдөөнт давуу талыг халж байгаа зэргийг дурьдаж болно.⁵⁰

Бараа материал, үйлчилгээ авах удирдамж

Хамтын нөхөрлөлийн орнуудад (*Австрали, Шинэ Зеланд, Шотланд, Их Британи гм*) бараа материал, үйлчилгээ нийлүүлэхэд удирдах зарчим нь ижил байдаг. Сангийн яамнаас энэхүү "Бараа материал, үйлчилгээ авах удирдамж"-ийг гаргасан байна.

Удирдамжийг гарснаар Засгийн газрын бүх хэлтэс, агентлагын 1997 оны Санхүүгийн хуулиар Засгийн газрын хэлтэс, агентлагын чиг үүргийг тодорхойлж нарийвчлан зааж өгсөн байдаг.

Хамрах хүрээ

Удирдамжинд доорх зүйлс хамаарна. Тухайн бараа материал, ажил үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг Засгийн газрын агентлаг тодорхойлоод түүнийг сонгох, үйлчилгээг авах явцад гарах магадлалтай эрсдлийг тооцох, гэрээ байгуулах, бараа материал үйлчилгээний нийлүүлэлт, төлбөр, гэрээний явцад хяналт тавих үйл ажиллагаа хамаарна.

Энэ асуудалтай холбоотой үндсэн гурван баримт бичиг байдаг. Үүнд:

1. Сангийн яамнаас гарсан удирдамж нь тухайн бараа материал, үйлчилгээг үзүүлэх процедурыг тодорхойлох.
2. Санхүүгийн хөтөлбөр, ажил үйлчилгээ авах Засгийн газрын бодлогод өөр санхүү ба төрийн зохицуулалтын хэлтэсээс зөвлөгөө өгдөг.
3. Засгийн газрын бараа материал ажил үйлчилгээ авахад эдийн засгийн өсөлттэй холбогдуулан Засгийн газрын агентлагуудад дэмжлэг үзүүлэхээр гарч буй баримт бичгүүд зэрэг болно.

Aus Tender

Aus Tender нь Засгийн газрын агентлагуудын жил бүрийн бараа материал, үйлчилгээ худалдаж авах жагсаалтыг хэвлэн гаргах, ажил хэргийн боломжийг танилцуулах цахим хэлбэрийн системийг ашигладаг.

Aus Tender нь Австралийн Засгийн газрын өмнөөс Санхүү ба төрийн зохицуулалтын хяналтын хэлтэс удирдаж явуулдаг. Агентлаг нь цахим системээс гадна хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл болох сонин, сэтгүүл, телевизийг ашиглаж болдог байна.

Тендерийн үр дүн гарсан тохиолдолд шалгарсан газарт мэдэгдэнэ. Агентлаг нь тухайн үүрэг гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгчийг нээлттэй байлгах үүднээс хамтран гүйцэтгэгчийг тодруулна. Шалгарсан гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийнхээ мэдээллийг бүрэн гүйцэд өгч ил тод болгодог.

Шууд эх үүсвэр нь тухайн тендерийн гадаад, дотоодын нийлүүлэгчид уралдаан шалгаруулалт явуулахгүйгээр авах давуу эрх олгогдохгүй. Харин дараахь тохиолдолд агентлагууд шууд эх үүсвэрт шууд хандана.

- үнийн болон чанарын санал ирээгүй
- бичиг баримтын шаардлага хангаагүй
- оролцогч нар нь оролцох шаардлагыг хангаагүй (агентлаг өөрийн дүрэм журмыг өөрчлөөгүй мөн тендерийн нөхцөлийг хангаж чадаагүй тохиолдолд)
- яаралтай, хугацаа тулсан тохиолдолд
- хязгаарлагдмал хүрээнд бараа материал, үйлчилгээ авах тохиолдолд. Үүнд зохиогчийн эрх, патент, зэрэгт хамааралтай тохиолдолд ханддаг байна.⁵¹

Хугацаа

⁵⁰ Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. Судалгааны тайлан. Удирдлагын академи., 2010 он.

⁵¹ australia.gov.au

Бараа материал, үйлчилгээ зарласан өдөр цагаас хойш 25 хоногийн дотор бичиг баримтыг өгсөн байна. Зарим тохиолдолд явуулж байгаа агентлаг нь доод талын хугацаа нь 10-аас доош хоногоор тогтоож болдог байна.

Хариуцлага ба ил тод байдал

Ажил үйлчилгээг авахад хамгийн эхэнд тавигддаг асуудал нь хариуцлага, ил тод байдал юм. Агентлаг болон түүний албан тушаалтанууд бараа материал үйлчилгээг авах бүх үе шатанд нээлттэй, ил тод явуулах ёстой.

Хариуцлага гэдэг нь: тухайн бараа материал үйлчилгээг авахад гаргаж буй шийдвэр, үйлдлээ хариуцна.

Ил тод байдал, хариуцлага хоёрын суурь нь хууль эрх зүйн үүрэг, бодлого (баримт бичиг үнийн санал бусад зүйлийг багтаасан) юм. Агентлаг нь үйлчилгээ авах бүртээ ажлынхаа баримтуудыг тухай бүрт нь авч хадгалж байх ёстой.

Тухайн агентлаг нь өөрийн ажилтнууддаа дараахь байдлыг гаргуулахгүйн тулд доорхи шаардлагыг тавьдаг байна.

1. албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх,
2. шударга байх,
3. ямар нэгэн шударга бус байдал илэрвэл түүнийг шалгаж үзэх,
4. Австралийн Засгийн газраас баримтладаг бодлогын дагуу тухайн бараа материал, үйлчилгээг авах байгууллагын зохиож буй үйл ажиллагаа, хүлээн авалт зэрэгт оролцохгүй байх шаардлагыг тавьж дээр дурьдсан үйл ажиллагаануудыг хориглодог байна.

Үнэ ба чанар

Бараа материал авах үед үнэ болон чанар хоёр нийцэж байгаа талаар тус бүрд нь нарийн судалж үздэг байна.

Үнэ ба чанарын хоорондын зохилдолгоонд өртөг голлох үүрэг гүйцэтгэхгүй. Харин энэ зохилдолгоонд дараахь зүйлүүдийг авч үзнэ.

- тухайн бараа материал, үйлчилгээ шаардлагатай эсэх,
- тухайн бараа материал, үйлчилгээг авахад гүйцэтгэж байгаа талын чадвар, ажилласан хугацаа, туршлага
- тухайн саналын эрсдэл
- гэрээний хувилбарын дүгнэлт (гэрээний үнэлэлт хувилбаруудад үнэлэлт өгөх, өөрөөр хэлбэл, гэрээний хувилбарыг өргөтгөх, багасгах)

Жижиг, дунд үйлдвэрлэл

Засгийн газар бараа материал, үйлчилгээ авахдаа тухайн ажиллагааг хариуцсан хүмүүс жижиг, дунд үйлдвэрлэлүүдэд ижил тэгш эрх олгоно. Ямар нэг шалтгаанаар түрүүлж хасахгүй.

Бараа материал, ажил үйлчилгээний 10-аас доошгүй хувийг (квот) жижиг, дунд үйлдвэрлэлээс авдаг байна.

3.2. Их Британи Улс

Их Британи улсад XVIII зуунаас анх эхлэн орон нутгийн баян хүмүүс зээлийн сан бий болгон хувийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө мөнгө зээлж, эвдэрч муудсан зам засаж түүнийгээ ашиглуулахдаа хэрэглэгчийн хураамжийн шимтгэл авч зээлсэн өрөө буцаан төлдөг байжээ. XIX зууны дунд үед Лондон хотын гүүр барих засварлах ажлын санхүүжилтийг иймэрхүү байдлаар бүрдүүлсэн сангаас хийж байжээ. Энэ концессийн гэрээ нь цаг хугацааны хувьд хамгийн урт түүхтэй нь байсан байна.

Анх Лейборист намын засгийн газар 1997 онд иргэдэд өндөр чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратеги зорилт дэвшүүлэхдээ Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийг санаачилж,

улмаар 2000 онд Их Британи улсын ТХХТ-ийн төв болсон Их Британи Түншлэл /Partnerships UK-PUK/ байгууллага бий болж үйл ажиллагаагаа эхэлжээ.

Хууль эрх зүй орчин Их Британийн Төрийн үйлчилгээний тухай хууль 2009 онд шинэчлэгдсэн, Захиргааны байгууллагын шинэчлэлийн тухай хууль 2001, Төрийн зохицуулалтыг шинэчлэх болон харилцан тохиролцох гэрээ хийх тухай хууль 1994, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 2000, Төрийн үйлчилгээний гомдол шийдвэрлэх тухай хууль (Public Services Ombudsman /Wales/ Act) 2005, Иргэний түншлэлийн тухай хууль (Civil Partnership Act) 2004.

Бодлогын баримт бичиг Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага 2000, Засгийн газар болон иргэний секторын хоорондын хамтын ажиллагааны гэрээ Их Британийн дотоод хэргийн яам (Memorandum the civil partnership) 2004, Иргэний Харти (Cimizens charter) 1991.

Public Servises Ombudsman-Төрийн үйлчилгээний Омбудсмен

Их Британид зарим байгууллагад төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Ombudsman (гомдол шийдвэрлэх төрийн үйлчилгээний байгууллага) ажилладаг.

Төрийн албаны зарим үйлчилгээ хангалтгүй байгаагаас үйлчилгээний талаархи гомдол ирэх гол нөхцөл болдог. Их Британий Засгийн газрын Ассамблей бусад холбоодууд, эрүүл мэндийн байгууллагууд, Засгийн газрын талаархи гомдлуудыг Public Servises Ombudsman шалгах эрхтэй байдаг. Ombudsman эдгээр гомдлуудыг шалгахдаа: байгууллагуудыг хэсэг тус бүрээр бүрэн шалгадаг. Хэрэв тэнд төрийн албан хаагчийн талаар гомдол байвал Ombudsman нь хамгийн түрүүнд тухайн байгууллагын бүх гомдол саналыг хүлээн авч судалж ажиглалт хийж дахин шалгана. Харин ямар нэгэн гомдол гарчихаад шийдвэрлэгдэхгүй байгаа бол Ombudsman дахин нягтлан шалгаад эцсийн шийдвэрийг гаргадаг байна. Ombudsman-ны үүрэг нь төрийн үйлчилгээний чанарын талаар гарсан санал гомдлыг дэс дараалалтайгаар дамжуулан хянаж шийдвэрлэх явдал юм.

Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага

Дээр дурьдсан PUK байгууллага нь ашгийн бус статустай бөгөөд анх тус улсын Сангийн яамны бүтцийн нэг хэсэг (Treasury Taskforce) байсан бөгөөд өнөөдөр 51 хувь нь хувийн салбарын пүүс компанууд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг байна. Түүнийг Сангийн Яам болон төрийн салбарын бусад байгууллагууд бодлогын хүрээнд дэмжих үүрэгтэй ажилладаг байна.

PUK хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна.

PUK улсын салбарт гагцхүү доорхи 5 үндсэн салбарт ажлаа явуулахаар тогтжээ. Үүнд:

- Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих
- Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх
- Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах
- Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах
- Төсөл болон компаниудад хөрөнгө оруулах

PUK-ын ажлын албаны баг 80 орчим хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хувийн болон төрийн байгууллагын ажилтнууд багтдаг. Хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2003 онд анхны хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан. Мөн Төслийн мэдээллийн сан, Үйл ажиллагааны туслалцааны нэгж, (Operationa Maskforce) болон хэрэгжиж буй төслүүдийн хэрэглэгчдийг дэмжих үүрэгтэй “Мэдээллийн технологийн харилцааны туслах төв” нээгджээ.

Эрүүл мэндийн салбарт

Энэ салбарт хийгдсэн ТХХТ шинэчлэлийн гол хөтөлбөр нь Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээ (National Health Services) ба өндөр зэрэглэлийн эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэхэд үүрэг хүлээсэн улсын байгууллага юм. Энэхүү төсөл нь зүгээр нэг санхүүгийн хөрөнгө оруулалт бус хувийн салбарын менежмент, бизнесийн болон шинийг санаачлагч ур чадварыг эрүүл мэндийн үйлчилгээнд татан оролцуулах явдал бөгөөд D-B-F-O загварыг голдуу ашигладаг байна. Ингэснээр NHS нь, 25-40 жилийн хугацааны туршид жил бүр хувийн эзэмшлийн байгууламж болон тоног төхөөрөмжийг ашигласны төлөө төлбөр төлдөг. Мөн бүх төсөл нь мөнгөний үнэ цэнийг зарлага талдаа чухалчилсан байхыг NHS журмандаа зааж өгчээ.

Боловсролын салбарт

Энэ салбарт хийгдсэн ТХХТ-ийн томоохон төслийн нэг болох New Deal for Schools (NDS) нь тус улсын 220 сургуулийн PFI аргачлалын дор хувийн хэвшил нь сургуулийн барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг гэрээгээр нийлүүлэн үйл ажиллагааг нь хариуцаж, бизнесийн ашиг орлого бий болгох чадвартайгаар орон нутгийн боловсролын байгууллага болон сургуультай хамтарч ажилладаг байна.

Батлан Хамгаалах салбарт

Их Британийн ТХХТ-ийн түүхэн дахь хамгийн том төсөлд тус улсын Батлан Хамгаалах яамны захиалгаар ундны усны хангамж, хөрсний ус болон муу ус цэвэршүүлэх байгууламжийн актив хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагааг 25 жилийн хугацаатай хэрэгжүүлэх хувийн хэвшлийн 3 ханган нийлүүлэгчийн хамтарсан нэгдлээр гүйцэтгүүлэх хоёр тэрбум фунт стерлингийн өртөг бүхий Акватрины төсөл тооцогдож байгаа юм. Ингэснээр Батлан хамгаалах яам стратегийн бус үйл ажиллагааг аутсорсинг хийснээр зөвхөн үр ашигтай хэрэглээ, бага зардалтай худалдан авалт болон мөнгөний үнэ цэнийг бий болгож, хүрээлэн буй орчны зорилт, тулгамдсан асуудлыг давхар шийдсэн байна.

Төрийн үйлчилгээний стандарт (Public Service Standards) 2007-2008

Энэ стандартын гол зорилго нь хэрэглэгчдэд чанартай сайн үйлчилгээ хүргэх болон гүйцэтгэлийг нарийн тогтоох, зорилтот бүлэг болон стандартын дагуу байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагааг зохицуулдаг.

Түүнчлэн 2007-2008 онд хувь хүний зорилтот бүлэг нь ажлын хүрээнээс ангид тусад нь байлгах ба үндсэн бүрдүүлэгч гол ажлаас салангид авч үздэг. Хэрэглэгч дөрвөн долоо хоногоос багагүй хугацаанд түр зогсоох мэдээллийг өгч болно.

Мэдээллийн Эрх чөлөөний тухай болон Мэдээлэл Хамгаалах эсвэл Мэдээллийн Зохицуулалтын тухай хуулиудын дагуу нууц биш бол 98,5 хувь нь захидал бичиж бичгээр хариуг ажлын 10 хоногийн дотор өгнө.

Хуулиудын дагуу дараахь хэлбэрээр хариуг өгч болно. Үүнд:

Утсаар хариу өгөх: Шаардлагатай тохиолдолд нийт хэрэглэгчдийн 85 хувь нь 20 секундын дотор холбогдох албан тушаалтантай холбогдож мэдээлэх боломжийг бүрдүүлэх

Хэрэглэгчийн сэтгэл хангамж: Хэрэглэгчийн сэтгэл хангамж нь 90 хувь дээр нь нэмэх ба утасны үйлчилгээнд 80 хувь дээр нь нэмэх байна.

Үйлчилгээний ашигтай үйлчилгээ: Ажлын өдөр үйлчилгээний хугацаанд бизнес систем нь 99 хувь ашигтай гол түлхүүр бөгөөд онлайн түлхүүр үйлчилгээ нь 99 хувь нь ашигтай байдаг.

Уншлагын танхимд хэрэглэгчдэд зориулсан бичлэг үзүүлэх ба цаг гаргах:

Хэрэглэгчдэд зориулсан уншлагын танхимд 35 минут бичлэг үзүүлэх

Бичлэгийн хуулбар хийх хурд болон чанар: Тусгайлсан зорилтот бүлэгт захиалгын дагуу бичлэгийг хуулан нийлүүлэх хувь 98,5 байдаг. Үүнд дараахь стандартыг дагаж мөрдөнө.

Хар болон цагаанаар хуулах фото хуулбар:

- 200 хувь байвал ажлын 9 өдөрт

- 201-500 хувь бол ажлын 14 өдөрт

Хэвлэх болон микрофильм эсвэл цахим шууданг орлуулагч

- 200 хувь бол ажлын 7 өдөрт
- 201-500 хувь бол ажлын 14 өдөрт

Дижитал скайнараас хар, цагаан болон өнгөт хэвлэл хийх

- 20 хувь бол ажлын 14 өдөрт Электрон хувь
- Файл нь 20 хүртэл электрон шуудангаар ажлын 14 хоногт мөн нэмж 1 өдөрт нь CD-ROM-д бичнэ.
- Файлуудыг дижиталаар бол ажлын 1 өдөрт

Микрофильм буюу бичлэг хийх эсвэл хуулбар хийх

- Бичлэг болон хуулбар хийхэд хэрвээ 1,000 метр урттай бичлэг эсвэл 100 хуулбар ажлын 15 өдөрт
- Гэрчилгээ хувилах бол ажлын 2 өдөрт багтаан хийх

Үндэсний Архивт хэрэглэгчид шинэ, нээлттэй цаг гаргах ба түүний тодорхойлолт, ангилал гаргуулах эрх авах

2000 оны Мэдээллийн Эрх Чөлөөний хуулийн дор санал гаргасны дагуу үр дүнг шалгах ба олон нийтэд нээлттэй байх Үндэсний Архивын газарт нэмэлт хийх

- Өөрийнх нь хүсэлт ёсоор Хувь хүний тухай мэдээллийг Мэдээллийн Эрх чөлөөний хуулийн дагуу 30 хоногийн дотор 100 хувь гаргаж өгөх
- Үндэсний Архивын шилжүүлэг нээлттэй бол хувь хүний мэдээллийг хүсэлт хүлээж авснаас хойш ажлын 15 өдөрт гаргаж өгнө.
- Үндэсний Архивт шилжүүлсэн баримт бичиг хуулбараас тэмдэглэлийн 80 хувийг ажлын 60 хоногт гаргаж өгнө.

Үндэсний Архивын газар нь хүртээмжтэй үйлчлэх ба Мэдээллийн Эрх чөлөөний дагуу нээлттэй, чөлөөтэй байх нь 2007 оны 5 дугаар сараас хэрэгжсэн байна.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд:

1. Их Британи улс нь төр хувийн хэвшлийн харилцааг ХҮИИ зууны үеэс янз бүрийн хэлбэрээр хэрэгжүүлж ирсэн түүхтэй. 51 хувь нь хувийн салбарын пүүс компаниуд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг байна.

- Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих
- Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх
- Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах
- Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах
- Төсөл болон компаниудад хөрөнгө оруулах зэрэг

Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага нь улсын салбарт гагцхүү дээрхи 5 үндсэн салбарт ажлаа явуулдаг байна.

2. Эрүүл мэндийн, Боловсролын, Батлан хамгаалахын салбаруудад тоног төхөөрөмжүүдийг гэрээгээр нийлүүлэн үйл ажиллагааг нь хариуцах болон D-B-F-O загварыг голдуу ашиглан 25-40 жилийн хугацааны туршид жил бүр хувийн эзэмшлийг ашигласны төлөө төлбөр төлдөг байсан төдийгүй аутсорсинг хийснээр үр ашигтай хэрэглээ, бага зардалтай худалдан авалт болон мөнгөний үнэ цэнийг бий болгож тулгамдсан асуудлыг давхар шийдсэн.
3. Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой **Public Services Ombudsman** байгууллагыг ажиллуулдаг төдийгүй мөн хэрэглэгчдэд чанартай түргэн шуурхай сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд тодорхой стандартуудыг мөрддөг.

3.3. Канад улс

Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс тогтсон холбооны улс бөгөөд парламентын засаглалтай ардчилсан, үндсэн хуульт хаант улс юм. Төрийн тэргүүн нь Хатан хаан II Элизабет. Англи, Франц гэсэн албан ёсны хоёр хэлтэй бөгөөд олон үндэстэн угсаатан амьдардаг. Канад нь технологийн хувьд хөгжсөн, аж үйлдвэржсэн орон бөгөөд байгалийн баялаг, нарийн төвөгтэй харилцаатай орон болох АНУ-тай хийдэг худалдаан дээрээ тулгуурласан эдийн засагтай.

Канад улс нь Төр хувийн хэвшлийн түншлэлийг 1988 оноос эхлэн өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж байгаа орны нэг юм. 2000 оноос эхлэн ТХХТ-ийн үйл ажиллагаа өргөн далайцтай эрчимтэйгээр хөгжиж, орон нутгийн шинж чанартай хөтөлбөрүүд нь ихэнхи тохиолдолд Барих-санхүүжүүлэх болон Төсөл санаачлах-барих-санхүүжүүлэх-ажиллуулах загвараар хэрэгжиж байна.

Канадын ТХХТ-ийн Үндэсний зөвлөл (1998) ТХХТ-ийг төрийн болон хувийн хэвшлийн хооронд бие биенийхээ экспертиз дээр суурилсан, нөөцийн, эрсдлийн ба ашгийн зохистой хуваарилалтаар дамжуулан олон нийтийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах хамтарсан нэгдэл гэж тодорхойлдог байна. Үндэсний зөвлөл нь гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг жинхэнэ ТХХТ гэж үздэггүй. Канад улсад ТХХТ нь амжилттайгаар хэрэгжиж буй үндсэн хүчин зүйл нь:

- Олон улсын сонирхогч талыг татан оролцуулсан
- Хувийн салбарын хөрөнгө босгох бололцоо өндөр (тэтгэврийн сан, даатгалын сан, хувийн хөрөнгө)
- Засгийн газрын (нам бус) болон олон нийтийн дэмжлэг нэн өсч буй
- Төрийн салбар дахь холбоодын эерэг хандлага, эсэргүүцэл багассан байдал
- Дээд түвшний улс төрийн хатуу манлайлал зэрэг байна.

ТХХТ дэд бүтцийг шинэчлэхэд нэн хэрэгцээтэй арга болох хувийн хэвшлийн оролцоог Канадын иргэдийн дунд явуулсан судалгаагаар 88 хувь нь дэмжиж, дэд бүтцийн салбарын эрэлт хэрэгцээг Засгийн газар дангаараа хангаж гүйцэтгэх чадвар дутмаг байгааг дүгнэж, мөн 63 хувь нь хувийн хэвшил бүрэн байдлаар оролцох цаг нь болсон гэсэн дүгнэлт гарчээ. Үүний үндсэн дээр Канадын засгийн газар ТХХТ-ийг идэвхитэйгээр дэмжин ажиллаж байна. Энэхүү дэмжлэг нь дараахь үр дүнд хүрээд байна.

- Дэд бүтцийн салбарын хөгжлийн зогсонги байдлыг шийдвэрлэсэн
- Төсөл, хөтөлбөрүүд гэрээнд заасан цаг хугацаа болон тогтоосон төсөвтөө багтан хийгддэг болсон
- Эрсдлийг үлэмж хэмжээгээр хувийн хэвшилд шилжүүлсэн
- Байгууламжийн ашиглалын хугацааны зардал төсөвдөө багтдаг болсон
- Удаан хугацааны гүйцэтгэлийн чиг баримжаатай ажиллах болсон
- Хөрөнгө ашиглалтын болон үнэ цэнийг дээшлүүлсэн
- Засгийн газар өөрийн үндсэн чиг үүрэгтээ анхаарах боломж илүү болсон зэрэг юм.

Канадын Төр хувийн хэвшлийн түншлэлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа нь дараахь салбаруудад хуваагдан үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байна.

1. Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ
2. Сургууль
3. Тээврийн харилцаа
4. Цэвэр болон бохир ус гэсэн салбаруудад хувийн салбарын оролцоо хамгийн их байдаг байна. Өөрөөр хэлбэл төрийн зарим чиг үүргийг хувийн салбарын холбоо, нэгдлүүдээр гүйцэтгүүлж байна.

Канад улсад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хугацааг харахад урт хугацаатай байдаг бөгөөд хамгийн багадаа 25 жил болон түүнээс дээш хугацаатайгаар хэрэгжсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

- Эмнэлэгийн салбар-30 жил
- Сургууль-30 жил
- Зам байгуулах-30 жилийн хугацаатай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Хууль эрх зүйн орчин:

Хууль эрх зүйн хувьд Канадын холбооны хууль болон мужийн хуулиудаар зохицуулагддаг. Голлох хуулиудад:

1. Канадын стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хууль (2002) -Canada Strategic Infrastructure Fund Act

Хуульд стратегийн дэд бүтцийг тодорхойлж өгсөн. Үүнд:

- Авто зам болон төмөр зам
- Орон нутгийн тээврийн харилцаа
- Аялал жуулчлал болон хотын хөгжил
- Бохир ус цэвэршүүлэх
- Цэвэр ус салбарыг хуульчилсан байна.

Энэхүү хуулиар хувийн хэвшлийг хэрхэн оролцуулах болон гэрээ байгуулах талаар хуульчилсан байна. Төсөл хөтөлбөрийг шалгаруулах болон гэрээ байгуулах асуудлыг Канадын хатан хааны хувийн зөвлөлийн гишүүн сайд хариуцдаг.

2. Төрийн үйлчилгээг өөрчлөх болон үүргийг шилжүүлэх тухай акт (хууль)

1985 онд батлагдсан. (Public service rearrangement and transfer of duties act)

Хуулийн Р-34 дугаар бүлэгт Холбооны төрийн захиргааны байгууллагын сайд нь өөр сайдад, нэг хэлтсээс нөгөө хэлтэст, төрийн захиргааны байгууллагаас нөгөөд гүйцэтгэх үүрэг, удирдлага, хяналтын үүргээ бүрэн шилжүүлэх мөн нэг сайд болон шадар сайдад хамаарах 2 болон түүнээс дээш хэлтсийн үүргийг нэгдэл холбоонд шилжүүлэх тухай зохицуулсан байна.

3. Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт (Act respecting transport infrastructure partnerships)

Хуулиар гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн бөгөөд гэрээг дараахь байдлаар тодорхойлсон байна.

Түншлэлийн гэрээ гэж барилга байгууламж болон дэд бүтэц, зам тээврийн ажил болон завсар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Засгийн газар болон хувийн хэвшлийн хооронд түншлэлийн урт хугацааны хүсэлт гаргахыг хэлнэ. Гэрээнд оролцогч нь Засгийн газар болон сайд, эсвэл хотын захиргаа байж болно гэж заасан байна. Мөн түүнчлэн хуулинд төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон гэрээнд өөрчлөлт оруулах, эзэмшил, хариуцлагын талаар зохицуулсан байна.

- Төрийн үйлчилгээний тухай хууль-**Public service act** (1996)
- Усны тухай хууль-Canadian Water law
- Тээврийн тухай хууль- Canadian transportation act (1996)
- Зам тээврийн хөрөнгө оруулалтын тухай хууль (Transportation investment act-British Columbia) 1996
- Авто замын хууль- [Highway Act, 1998](#)

Канад нь гадаадын хөрөнгө оруулагчидтай зарим томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ Концессийн гэрээ байгуулан ажилладаг байна. Дэ Чо гүүрийг концессийн гэрээ байгуулсан байна.

Канад улсад төрийн зарим чиг үүргийг гэрээгээр болон хуулийн дагуу шилжүүлэн хэрэгжүүлдэг мэргэжлийн холбоод байдаг бөгөөд тэдгээр холбоод нь тухай салбарын харилцааг удирдах, зохицуулах, хяналт тавих бүхий л харилцааг хууль болон дүрэм, журмаар зохицуулдаг байна.

Канадын Үндсэн хуулийн эрх, эрх чөлөөний тунхаглал, радио нэвтрүүлгийн тухай хууль, Радиогийн журам, Телевиз радиогийн журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулдаг байна.

Канадын радио нэвтрүүлгийн стандартын зөвлөл (CBSC)-Canadian Broadcast Standards Council

Энэхүү зөвлөл нь Канадын хувийн салбарын нэвтрүүлэгчдийн өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага юм. Тус зөвлөл нь 1990 онд байгуулагдсан.

Зөвлөл нь Канадын 730 радио телевизийн станц болон 2 телевизийн сүлжээг багтаасан байгууллага юм. Программ нь англи, франц болон гуравдагч хэл дээр нэвтрүүлдэг ба Канадын нэвтрүүлэгчдийн холбооны гишүүн нэвтрүүлэгч 96% байдаг.

Зөвлөл нь хэд хэдэн дүрэм журам (code)-ыг гарган мөрдүүлж байгаа бөгөөд тухайлбал: секс дүрийг дүрслэх журам (sex role portrayal code), хүчирхийлэлийн журам (violence code), ёс зүйн дүрэм (code of ethics), мөн радио телевизийн нэвтрүүлэгчдийн ёс зүйн дүрэм, радио телевизийн нэвтрүүлгийн программийн үнийн журам, сэтгүүлчийн ёс зүйн дүрэм гэх мэт дүрэм журмуудаар зохицуулагддаг байна.

Мөн үзэгч сонсогчдийн зүгээс нэвтрүүлэгтэй холбоотой санал хүсэлт, нэвтрүүлэгчдийн талаарх гомдолоо зөвлөлд гаргах бөгөөд зөвлөл уг асуудлыг 14 хоногт хариу өгдөг байна. Энэ нь нэвтрүүлэгчдийн хариуцлагын түвшин өсөхөд ихээхэн нөлөөлж байна гэж Зөвлөлийн олон нийтийн хэлэлцүүлгийн илтгэлд дурдсан байна. Энэхүү зөвлөл нь жил бүр олон нийтэд илтгэл тайлангаа тавьж хэлэлцүүлдэг байна.

Мөн түүнчлэн хүүхдийн нэвтрүүлгийн стандарт, бусдыг доромжилсон нэвтрүүлгийн, хүчирхийлэлийн гэх мэтчилсэн нилээд олон стандартуудыг зөвлөлөөс батлан гаргаж мөрдүүлж байна.

3.4. Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь дэлхийн хамгийн том, технологийн хувьд хөгжсөн хүчирхэг эдийн засагтай орон юм. Тус улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны дагуу хувийн бизнес давамгайлах үүрэгтэй бөгөөд холбооны болон төрийн байгууллагууд шаардлагатай бараа, үйлчилгээг эдгээр хувийн үйлдвэрлэгчээс худалдан авдаг системтэй байна. Баруун Европ, Японы аж үйлдвэрлэгчидтэй харьцуулбал америкийн бизнес эрхлэгчид нь капитал болон үйл ажиллагааны хэмжээг өргөжүүлэх, ажиллах хүч нэмэгдүүлэх, шинэ бараа бүтээгдэхүүн боловсруулахад давуу талтай байна. АНУ-ын компаниуд нь компьютер, анагаах ухаан, сансар судлал, батлан хамгаалах зэрэг салбарын тоног төхөөрөмж боловсруулалтаараа дэлхийд тэргүүлдэг байна.

АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд дараах ажил үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлдэг байна. Тухайлбал:

1. Цэвэр болон бохир ус
2. Хог хаягдалын үйлчилгээ
3. Нийтийн аж ахуйн үйлчилгээ
4. Барилгын засвар үйлчилгээ
5. Хууль эрх зүйн зөвлөгөө
6. Архитектур ба инженерийн үйлчилгээ
7. Түргэн тусламжийн үйлчилгээ
8. Барилга, байгууламжийн менежментийн удирдлага ба ашиглалт гэх мэт

Мөн хувийн хэвшил дангаараа эсхүл улсын салбартай хамтарсан хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төлбөрт авто замын барилгын ажлууд орно.

Хувийн салбарын пүүс компаниуд бас нийгмийн салбар болох сургууль, халамжийн үйлчилгээний хөтөлбөр, хотын дотоод хөгжлийн дахин сайжруулалт болон төрийн барилга байшин барих зэрэг ажил үүргийг Төр хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтаар хийдэг. Төрөөс нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа биелүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд хэдэн зуун мянган улсын орон сууцыг ч мөн ТХХТ-ийн санхүүжилтээр барьжээ.

АНУ-д ТХХТ-ийн нэгдсэн бодлого зохицуулалтыг хангах үүрэг бүхий төрийн байгууллага байдаггүй хэдий ч, төр хувийн хэвшлийн салбарын хамтын ажиллагааг дэмжих зорилго бүхий Үндэсний ТХХТ-ийн зөвлөл хэмээх ашгийн бөгөөд нам бус байгууллага 1985 онд байгуулагдсанаар

түншлэлийн хүрээнд шинэлэг санаа дэвшүүлэх, түүнийгээ бодит ажил хэрэг болгоход чиглэсэн хувийн болон улсын салбарын гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний зөвлөл нь дэргэдээ Эрчим хүчний институт, Олон улсын институт, Үл хөдлөх хөрөнгийн институт, Тээврийн институт болон Усны институттай.

Хууль, эрх зүйн орчин

АНУ-ын хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн үйлчилгээний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар зохицуулагддаг байна.

Харин өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нилээд туршлага солилцож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн томоохон холбоо, нэгдлүүдээр болон өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор энэхүү үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг байна.

Олон улсын үнэт цаасны хороо-IOSCO

Олон улсын үнэт цаасны хороо нь АНУ-ын үнэт цаасны зах зээлд томоохон байр эзэлдэг байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг байна. Олон улсын үнэт цаасны хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж дүгнэх аргачлал, арга зүйг баталсан бөгөөд уг дүрмийн 6-д “Өөрөө өөрийгөө зохицуулахад хамаарах зарчим (Principles relating to Self-Regulation)-уудыг тодорхойлж зохицуулсан байна. Өөрөө өөрийгөө зохицуулагч энэхүү байгууллага нь бүхий л үйл ажиллагаагаа дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах болон хянах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Энэхүү дүрмээр хороо нь хууль болон дүрмэнд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх талаар нарийн зааж өгсөн байдаг байна.

Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага нь дараах ач холбогдолтой:

- Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага нь төрийн хууль тогтоомж болон өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм журмыг хэрэгжүүлэхэд болон хууль, болон бусад эрх зүйн актын зорилгуудыг биелүүлэх
- Тохируулагчийн алдаа гаргах боломжийг багасгадаг
- Зохицуулах харилцаануудын бүхэлд нь хамарч чаддаг байна.

Өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллага нь:

- Хууль тогтоомж болон өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын дүрэм журмыг холбоо, түүний гишүүд биелүүлэх чадвартай байх
- Өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын гишүүд болон гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах чадвартай байх
- Төслийн хөрөнгө оруулагчийн болон гишүүдийн баримтлах стандарт, журмуудыг боловсруулах
- Зохицуулагч нь өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын журам, бодлогын зааврууд болон хамтран ажиллагчийн дүрмэнд захирагдах ёстой.
- Дүрэм зөрчигчид хариуцлага хүлээлгэх
- Удирдах албан тушаалтан болон удирдах зөвлөлийг сонгоход гишүүдийн төлөөллийг тэгш оролцуулах зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой.

3.5. Оросын Холбооны Улс

ОХУ-д төрийн захиргааны шинэчлэлийг улсынхаа нийгэм эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд гаргах чухал нөхцлүүдийн нэг гэж үздэг. Энэ шинэчлэл хэд хэдэн үе шаттайгаар явагдаж байна. Үүнд, нэгдүгээр үе-1992-1993 он, хоёрдугаар үе- 1996-1998, гуравдугаар үе-1999-2000, дөрөвдүгээр үе-2001-2003, тавдугаар үе-2005 оноос эхлэсэн.

Бодлого, хууль эрх зүйн орчин

- **Хууль эрх зүй:** “Оросын Холбооны Улсын Үндсэн хууль” (1993), “Оросын Холбооны Улсын субъектүүдийн төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагуудын зохион байгуулалтын үндсэн зарчмуудын тухай” (1999), “Оросын Холбооны Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын зохион байгуулалтын үндсэн зарчмуудын тухай” (2004), “Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын тухай” (2007), “Төрийн үйлчилгээний стандартын тухай” хуулийн төсөл” (2007)
- **Бодлогын баримт бичиг:** “Захиргааны шинэчлэл 2005-2010” Үндэсний Хөтөлбөр“, “Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл” Холбооны хөтөлбөр (2003-2005), “Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл ба хөгжил” Холбооны хөтөлбөрт (2009-2013)

2003-2005 онуудад ОХУ-ын захиргааны шинэчлэлийг эрчимтэй хэрэгжүүлэх чухал шийдвэрүүд гарсан байна. ОХУ-ын Ерөнхийлөгчийн ОХУ-ын Холбооны Хуралд явуулсан 2003 оны **Илгээлтэд** улс орны эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтөнд саад болж буй хүчин зүйлүүдийн нэг нь төрийн аппаратын үйл ажиллагааны үр ашиг хангалтгүй байгаа болон эрх мэдлийн хэмжээндээ чанар нь хүрэхгүй байгаа байдал гэж тодорхойлжээ⁵².

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 7 дугаар сарын 23-ны N824 **“2003-2004 онуудад захиргааны шинэчлэл хийх арга хэмжээний тухай”** зарлигт захиргааны шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг заасан. Үүнд:

- Үйлдвэрлэл эрхлэгч субъектүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд төрийн оролцоог хязгаарлах, түүний дотор төрийн илүүдсэн зохицуулалтыг багасгах,
- Холбооны гүйцэтгэх байгууллагуудын давхардсан үүрэг, эрх мэдлийг хасах,
- Эдийн засгийн салбарт өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын тогтолцоог хөгжүүлэх,
- Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, төрийн өмчийг удирдах, иргэд, хуулийн этгээдэд төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлэх үүргийг зохион байгуулалтын хувьд хувааж, цэгцлэх зэрэг болно.

Эдгээр зорилтыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах үүргийг захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэх Засгийн газрын Комисс хүлээжээ.

Түүнчлэн 2005-2010 онд хэрэгжүүлэх **“Захиргааны шинэчлэл”**-ийн зорилтот хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдан гарч, түүнийг хэрэгжүүлж эхэлсэн нь улсын салбарын шинэчлэлийг эрчимжүүлэхэд их түлхэц болжээ.

“Захиргааны шинэчлэл”-ийн үзэл баримтлалд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлд үндэслэсэн үнэлгээ, төрийн болон орон нутгийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, захиргааны болон электрон захиргааны журмыг боловсруулж, нэвтрүүлэх, төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, авилгын эрсдэл бүхий салбарын удирдлагыг боловсронгуй болгох онцгой механизмыг бий болгож, хэрэгжүүлэх, захиргааны хэргийн шүүх, эрх зүйн механизмыг боловсронгуй болгох, гүйцэтгэх засаглалын эрх мэдэл, чиг үүргийн давхардлыг арилгах үйл ажиллагааг дуусгах, захиргаа-удирдлагын үйл явцад аутсорсингийн тогтолцоог хөгжүүлэх, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын харилцааны үр дүн, тунгалаг байдлыг хангах зэрэг цогц арга хэмжээг тодорхойлсон байна.

Захиргааны шинэчлэлийн явцад хийгдсэн нэг чухал арга хэмжээ бол захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүргийг шинжилж, ангилах ажил байжээ. Энэ үйл ажиллагааны дүнд агуулгыг нь шинээр тодорхойлох, аль эсхүл бүр мөсөн хүчингүй болгох, эсхүл өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагт шилжүүлэх шаардлагатай бүлэг чиг үүргийг тодруулсан байна. Засгийн газрын

⁵² Послание Президента Федеральному Собранию Российской Федерации 2003. www. kremlin.ru

комиссоос захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлсэн ажлын хүрээнд нийт 5634 чиг үүргийг шинжилж дүгнэлт хийснээс 1468 нь илүүдэл, 263 нь давхардсан, 868 нь өөрчлөх чиг үүрэг байжээ⁵³.

Мөн 2002 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарилгаар батлагдсан **“Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл”** Холбооны хөтөлбөрт (2003-2005) дэвшүүлсэн төрийн албаны шинэчлэлийн нэг чухал чиглэл нь дэлхийн стандартад нийцсэн төрийн цогц үйлчилгээг бий болгох явдал юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр төрийн албан хаагчид албан үүргээ чанартай сайн гүйцэтгэж иргэд, байгууллагад үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлсэн үр дүн гарна гэдгийг тодорхойлжээ⁵⁴.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2009 оны № 261 зарлигаар батлагдсан **“Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл ба хөгжил”** Холбооны хөтөлбөрт (2009-2013) төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлж дуусган, ОХУ-ын төрийн албаны нэгдсэн тогтолцоог бий болгон, төрийн албаны өндөр мэргэшсэн боловсон хүчнийг бүрдүүлж, төрийн удирдлагын үр ашиг, инновацит эдийн засаг, иргэний нийгмийн хөгжлийг хангах зорилго дэвшүүлжээ⁵⁵.

Түүнчлэн ОХУ-ын төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зарим чиг үүргийг төрийн бус салбарт шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн зарим хууль батлагдаж, зарим хуулийн төслүүд боловсруулагдсан байна. Тухайлбал, 2007 онд **“Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын тухай”** (Федеральный закон “О саморегулируемых организациях”) Холбооны хууль батлагдсан, гүйцэтгэх засаглалын байгууллагын захиргааны журмын тухай, төрийн үйлчилгээний стандартын тухай, санхүүгийн аудит болон үнэлгээний салбарын төрийн үйл ажиллагааг өөрийгөө зохицуулах байгууллагуудад шилжүүлэх тухай холбооны хуулиудын төсөл боловсруулагдаж, холбооны түвшиний төрийн үйлчилгээний жагсаалт, стандартыг боловсруулах ажил хийгдэж байгаа юм.

Дээрхи бодлогын баримт бичгүүдэд тодорхойлогдсон төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд ОХУ-ын субъектүүдэд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, тухайлбал, төрийн үйлчилгээг аутсорсингоор гүйцэтгүүлэх хэлбэр амжилттай хэрэгжиж, энэ асуудалд онцгой анхаарал хандуулж байна.

Жишээ нь, ОХУ-ын Пенза мужийн Засгийн газар 2008 онд **“Пенза мужийн төрийн гүйцэтгэх байгууллагууд аутсорсингийг хэрэглэх тухай”**⁵⁶ №274 дугаар тогтоолыг баталсан ба түүнд аль нэг чиг үүргийг шилжүүлэн аутсорсингоор гүйцэтгүүлэх нь оновчтой эсэхийг эрх бүхий албан тушаалтан тодорхойлох (тухайлбал, Пенза мужийн Засгийн газрын орлогч дарга) ба аутсорсингоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааны жагсаалт гаргах, төрийн гүйцэтгэх байгууллагын зарим үүргийг аутсорсингоор гүйцэтгүүлэх дүрэм боловсруулж батлуулахыг заажээ.

Түүнчлэн энэ ажлын хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийн байдалд анализ (аудит) хийх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны төрөлд анализ хийх, тодорхой шалгуурын дагуу аутсорсингоор хийлгэх үйл ажиллагааны төрөл, хугацааг тодорхойлох шаардлагатай байдаг.

ОХУ-ын субъектуудын төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага аутсорсингоор зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ дараах үндсэн хүчин зүйлүүдийг тооцож оноогоор үнэлдэг байна. Үүнд:

- Тухайн чиг үүргийн аль ангилалд хамаарч буй байдал (үндсэн эсхүл туслах) 1-5 оноо,
- Нөөцийн хүчин зүйл (боловсон хүчний болон санхүүгийн) 1-5 оноо,
- Үнэ, өртөгийн хүчин зүйл (тухайн үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө, санхүүгийн тооцоо) 1-3-5 оноо,

⁵³ Концепции административной реформы в РФ в 2006-2010 годах. www.adm.yar.ru

⁵⁴ Федеральная программа “Реформирование государственной службы службы Российской Федерации” www.uk.mos.ru

⁵⁵ Федеральная программа “Реформирование и развитие государственной службы службы Российской Федерации” www.rg.ru

⁵⁶ Постановление Правительства Пензенской обл. от 04.05.2008. №274 “Об использовании аутсорсинга исполнительными органами государственной власти Пензенской области” www.regionz.ru

- Цаг хугацааны хүчин зүйл,
- Чанарын асуудал, 1-3 оноо,
- Хязгаарлалтын хүчин зүйл (тухайн чиг үүргийг гүйцэтгэх эрх зүйн зохицуулатыг харгалзах) 1-5 оноо, зэрэг болно.

Дээрхи хүчин зүйл бүрийг оноогоор тооцон 6 хүчин зүйлээр нийт 18 онооноос доош үнэлгээ авсан тохиолдолд тухайн чиг үүргийг аутсорсингоор гүйцэтгүүлэхээр шилжүүлдэг байна.

Ийнхүү ОХУ-д захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, төр иргэний нийгмийн харилцааг шинэ түвшинд гаргах үйл ажиллагаа амжилттай хийгдэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. Судалгааны тайлан. Удирдлагын академи., 2010 он.
2. Partnerships Victoria. Guideline material. July 2006, Overviem, page 5, www.australia.gov.au
3. Outsourcing of public services in Australia: seven case studies. www.econ.mq.edu.au
4. [Public Service Standards 2007-2008. www.nationalarchives.gov.uk](http://www.nationalarchives.gov.uk)
5. [National Register of Public Service. www.nrpsi.co.uk](http://www.nrpsi.co.uk)
6. Civil Service Act 2005. www.parliament.uk
7. Civil Partnership Act. 2004. www.partnershipsuk.org.uk
8. Административная реформа: решения и проблемы. www.adm.yar.ru
9. Послание Президента Федеральному Собранию Российской Федерации 2003. www.kremlin.ru
10. Концепции административной реформы в РФ в 2006-2010 годах. www.adm.yar.ru
11. Федеральная программа "Реформирование государственной службы службы Российской Федерации" www.uk.mos.ru
12. Федеральная программа "Реформирование и развитие государственной службы службы Российской Федерации" www.rg.ru
13. Постановление Правительства Пензенской обл.от 04.05.2008. №274 "Об использовании аутсорсинга исполнительными органами государственной власти Пензенской области" www.regionz.ru
14. И.Н.Барциц Публичные услуги и административный регламент их оказания. М., 2008 г
15. <http://laws-lois.justice.gc.ca/eng/index.html>
16. <http://www.cbcs.ca/english/faqs/standards.php#content>
17. <http://www.infoc.gc.ca/ip-pi/csis-fcis/csis-fcis-eng.html>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН*/Тойм судалгаа/**Ц.Товуусүрэн, А.Пагма/МА/***СЭДВИЙН АГУУЛГА****Нэг. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагаа**

- 1.1. Нийгмийн даатгалын салбарын бодлогыг тодорхойлж буй баримт бичгүүд
- 1.2. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй Монгол улсын хуулиуд
- 1.3. Нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд

Хоёр. Нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ

- 2.1. Нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилтийн талаархи олон нийтийн үнэлгээ, санаа бодол
- 2.2. Судалгааны байгууллага, судлаачдын хийсэн үнэлгээ, санал, зөвлөмж

Гурав. Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн шинжилгээ

- 3.1. Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага, хөрөнгийн үлдэгдлийн судалгаа
- 3.2. Нийгмийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалтын талаархи судалгаа

Дөрөв. ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО**Тав. Нийгмийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудлууд, хэрхэн шийдвэрлэх талаархи санал, зөвлөмж**

- 5.1. Судалгааны дүгнэлт-нөхцөл байдлын үнэлгээ
- 5.2. Судалгааны санал, зөвлөмж

Ашигласан материалын жагсаалт**Хавсралт 1.** Гадаадын зарим орнуудын Нийгмийн Даатгалын сангийн бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа /БНБелУ, ОХУ, БНКазУ/

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

НЭГ. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагаа

Монгол улс 1990-ээд оноос улсын төсвөөс шууд хараат байсан тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын хуучин харилцааг халж нийгмийн хамгаалал, даатгалын цоо шинэ тогтолцоог бүрдүүлэн, түүний эрх зүйн орчинг бий болгох ажлыг эхлүүлсэн билээ. 1991 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай, 1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг тус тус батлан НД-ын биеэ даасан тогтолцоо бий болгох бодит угтвар нөхцөлийг бүрдүүлснээр 1994 онд НД-ын багц хуулиуд батлагдаж энэ чиглэлийн эрх зүйн орчин бий болжээ. Тэдгээрийг 1995 оноос мөрдөж эхэлсэн ба үүнээс хойш “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай”, “Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай” зэрэг хуулиуд шинээр батлагдан нийгмийн даатгалын харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжин орсон цагаас хойш төрөөс нийгмийн даатгалын харилцаатай холбоотой асуудлыг бодлогын түвшинд ямагт анхааран үзэж, холбогдох бодлогын баримт бичиг, шийдвэрийг цаг тухайд нь гарган хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй бодлогын баримт бичиг, хууль, эрх зүйн актууд, энэ чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл, хийгдсэн судалгааны ажлыг тоймлон үзүүлбэл:

1.1. Нийгмийн даатгалын салбарын бодлогыг тодорхойлж буй баримт бичгүүд

№	Бодлогын баримт бичгийн нэрс	Огноо	Зорилго
1.	Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг	ЗГ-2003-239	Нийгмийн хамгааллын салбарын урт хугацааны хөгжлийн ерөнхий чиглэл, холбогдох яам, агентлагуудын ойрын болон дунд хугацаанд явуулах үйл ажиллагаа, авах арга хэмжээг тодорхойлох
2.	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	УИХ-1996-26	Нийгмийн даатгалын бие даасан тогтолцоо бүрдүүлэх
3.	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр. 1999-2004, 2004-2008 он	ЗГ-1998-130 ЗГ-2003-271	Ахмад настны эрүүл мэнд нийгмийн хамгааллыг сайжруулах замаар тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгмийн дунд эрүүл, идэвхитэй амьдрах таатай орчин бүрдүүлэх
4.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл	УИХ-1999-38	Тэтгэврийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэх, бие даасан тэтгэврийн даатгалын сан бүрдүүлэх, хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх, тэтгэврийн нэрийн данс нээх зарчмыг тодорхойлох
5.	Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр	УИХ-2008-35	Тэтгэврийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгох, Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжүүлэх, малчин, албан бус секторт хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, жижиг аж ахуй эрхлэгчийг нийгмийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлүүлнэ.

1.2. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй Монгол улсын хуулиуд

№	НД-ын хуулиудын нэрс	Баталсан огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон байдал
1.	Нийгмийн даатгалын тухай хууль	1994-05-31	Нийт 20 гаруй удаа оруулсан ба сүүлийн удаа 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар оруулсан.
2.	НДСангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль	1994-06-07	1999, 2000, 2002, 2003 он ба 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар оруулсан.
3.	НДСангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай	1994-06-07	2000, 2004 он ба 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар оруулсан.
4.	Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай	1994-06-09	1996, 1997 он ба 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар оруулсан.
5.	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1994-06-13	1999, 2002, 2003, 2005 он ба 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар оруулсан.
6.	НДСангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай	1994-07-05	2002 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн хуулиар оруулсан.
7.	НДСангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай	1997-01-16	Нэмэлт, өөрчлөлт ороогүй
8.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай	1999-06-11	Нэмэлт, өөрчлөлт ороогүй
9.	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль	2002-04-25	2003, 2006, 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар оруулсан.
10.	Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай	2002-11-20	Нэмэлт, өөрчлөлт ороогүй

1.3. Нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлж буй газар	Хугацаа
1.	“Тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэх” төсөл	АХБ, Сангийн яам, НХХЯ	2007-2008
2.	“Нийгмийн хамгааллын салбарын хөтөлбөр”	НХХЯ	2002-2008
3.	“Монгол улсад нийгмийн эрүүл мэндийн даатгалыг сайжруулах талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, чадавхийг дээшлүүлэх”	ГТХАН, ОУХБ, ДЭМБ-ын консерциум, УНДЕГ	2009-2012

1.4. Нийгмийн даатгалын асуудлаар хийсэн судалгааны ажлын тойм

№	Судалгааны ажлын сэдэв	Гүйцэтгэсэн байгууллага, судлаачид	Гүйцэтгэсэн огноо
1.	Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, цаашид сайжруулах арга зам	УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төв	2008
2.	Эрүүл мэндийн санхүүжилтын тогтолцоог боловсронгуй болгох нь	Нээлттэй нийгэм хүрээлэн, Бодлогын шинжилгээний төсөл, судлаач Д.Чимиддамба	2007
3.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ ба чанарыг сайжруулах арга замууд	Нээлттэй нийгэм хүрээлэн, Бодлогын шинжилгээний төсөл, судлаач Л.Мөнх-Эрдэнэ	2007
4.	Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн менежментийг боловсронгуй болгох нь	Нээлттэй нийгэм хүрээлэн, Бодлогын шинжилгээний төсөл, судлаач Т. Одончимэг	2007

ХОЁР. Нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ**2.1. Нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилтийн талаархи олон нийтийн үнэлгээ, санаа бодол**

Уг асуудлыг авч үзэхдээ УИХ-ын Төсвийн Байнгын хорооны захиалгаар УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төвийн судлаачдын 2008 онд хийж гүйцэтгэсэн “Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, цаашид сайжруулах арга зам” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хийгдсэн олон нийтийн санал асуулгын судалгааны материалд тулгуурласан болно.

Өнөөгийн зах зээлийн харилцааны нөхцөлд ирээдүйн амьдралын түвшин, хүрэлцээ, хангамж харилцан адилгүй байдаг нь зүй ёсны хэрэг билээ. Энэ тохиолдолд иргэдийн ирээдүйн амьдралын баталгааг хангах, нийгмийн асуудлыг зохистой байдлаар шийдвэрлэх, тэднийг ажилгүйдэл, ядуурлаас хамгаалах цорын ганц найдвартай механизм нь нийгмийн даатгал болдог байна. Иймээс манай энэ удаагийн судалгааны нэг үндсэн зорилт нь олон нийтийн зүгээс Монголын НД-ын өнөөгийн тогтолцооны талаархи тэдний үнэлэлт, үнэлгээг тодруулан үзэх явдал байлаа.

Нийгмийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилтийн байдлыг тодруулах үүднээс санал асуулгын судалгааны анхаарлын төвд юуны өмнө өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоонд хандах **олон түмний хандлага, байр суурийн** асуудлыг тандан судлах шаардлагатай байлаа. Энэ дагуу “Өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоо таны санаанд хэр нийцдэг вэ?” гэсэн асуултад нийт судалгаанд хамрагсадын 38,1 хувь нь нийцдэг харин дийлэнх нь буюу 61,9 хувь нь нийцдэггүй гэж хариулсан байна. Энд сонирхол татсан нэг зүйл бол аль ч оролцогч хариулж мэдэхгүй байна гэсэн хариултыг сонгоогүй байдал юм.

Энэ нь олон нийт хэдийгээр нийгмийн даатгалын тогтолцооны талаар ямар нэг ойлголтой байдаг ч иргэдийн эрх ашиг, сонирхолд тэр бүр хүрч нийцэж ажиллахгүй байгааг харуулж буй баримт мөн.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл/НДҮЗ/ хэрхэн ажилладаг талаархи иргэдийн санал бодлыг тандаж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

Судалгаанд хамрагсдын хувьд НДҮЗ-ийн тухай сонсож байсан боловч түүний үйл ажиллагаа, бодлого, чиглэлийн талаар сайн мэдэхгүй байна гэж 54,7 хувь, огт мэдэхгүй, сонсоогүй юм байна гэж 34,3 хувь, ер нь мэднэ гэсэн 10,9 хувь нь тус тус хариулцаажээ.

Энэ нь нэг талаас НД-ын үйл ажиллагааг зохицуулах төв байгууллага болох Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа олон түмэнд ил тод биш, энэ талын мэдээ, мэдээлэл

хангалтгүй байгааг, нөгөө талаас тус байгууллагын үйл ажиллагаа ямар түвшинд байгааг илтгэн харуулж байна гэж үзэж болох юм.

НД-ын тогтолцоотой шууд хамааралтай **иргэдийн нийгмийн хамгааллын** тухай асуудал ч бидний анхаарлын гадна орхигдоогүй.

“Таны нийгмийн хамгаалал хэр баталгаатай вэ?” гэсэн асуултын санал асуулгын дүнг нэгтгэхэд дийлэнх олонхи буюу судалгаанд хамрагсдын 53,1 хувь нь баталгаагүй, 22,9 хувь нь баталгаатай, 24 хувь хариулж мэдэхгүй байна гэсэн үзүүлэлт харагдаж байна. Эндээс үзвэл иргэдийн талаас илүү хэсэг нь нийгмийн даатгалын үйл ажиллагаа, түүнээс үүдэн гарсан нийгмийн хамгааллын талаар сэтгэл дундуур байдаг нь харагдаж байна.

Нийгмийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилттэй холбоотой нэг чухал асуудал бол **иргэд, олон түмэн нийгмийн даатгалын үйлчилгээнд хэрхэн хамрагддаг байдлын тухай** асуудал юм. Энэ талаархи санал асуулгын судалгааны байдлыг манай иргэд нийгмийн даатгалын үйлчилгээнд хэрхэн хамрагддаг нь тодорхой байна.

Тухайлбал:

- Та нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагддаг уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 76,3 хувь нь “тийм”, харин 23,7 хувь нь “үгүй” гэж хариулцгаажээ.
- Та яагаад нийгмийн даатгалд хамрагдаагүй шалтгаанаа тодорхойлон бичнэ үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчид дараахь байдлаар хариулт өгсөн нь сонирхолтой байна. Үүнд:
 1. Мэдэхгүйн улмаас – 31,9
 2. Бичиг баримт бүрдээгүй – 16,3
 3. Шаардлага байхгүй – 14,8
 4. Зав чөлөө болж өгөхгүй – 13,3
 5. Шилжүүлэг хийгдээгүйгээс – 7,4
 6. Бусад шалтгаанаар – 16,3 хувиар тус тус хариулсан байна.

Эндээс иргэдийн НД-ын үйл ажиллагаанд хамрагдахад хамгийн их саад болж буй бэрхшээл нь даатгалын ач холбогдол, үр шимийн талаар **мэдлэг, мэдээлэл муутай** /31,9 хувь/, холбогдох **бичиг баримтаа бүрдүүлж чаддаггүй** /16,3 хувь/ байдал харагдаж байна. Тиймээс иргэдийг нийгмийн даатгалын үйл ажиллагаанд бүрэн хамруулахын тулд дээрх асуудал, бэрхшээлийг арилган зохицуулах талаар даатгалын байгууллагууд санаачлага гаргах нь чухал юм.

Цаашилбал, өнөөгийн нийгмийн даатгал, тэр дундаа **тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг** олон нийт хэрхэн үнэлж байгааг тодруулан мэдэхийг хичээсэн юм.

Үүнтэй холбоотойгоор “Өнөөдөр иргэдэд олгож буй нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ боломжийн гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуултанд санал асуулгын судалгаанд хамрагдагсад хариулсан байдлаас үзвэл дээрхи асуудлын талаар сэтгэл дундуур байдаг нь харагдаж байна. Тухайлбал, НД-ын нийт тогтолцоо нь санаанд нийцэхгүй гэж респондентүүдийн дийлэнх /61.9%/ үнэлсэн нь дээрхийг батлаж байгаа юм. Энэхүү доогуур үнэлгээнд ямар хүчин зүйл голлон нөлөөлж байгааг тандахад энд гол нь иргэдийн өнөөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэлээд хүчтэй нөлөөлдөг гэж үзэж болохоор байна. Үүнийг ч статистикийн дүн шинжилгээ давхар нотлож байгаа юм/Хүснэгт 1/. Эндээс үзвэл нийгмийн даатгалын тогтолцооны талаархи олон нийтийн үнэлгээ нь НДС-гийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээтэй шууд хамааралтай болох нь харагдаж байна гэсэн үг юм. Харин энд нас, хүйс, боловсрол зэрэг хүчин зүйлийн нөлөө бага байгаа юм.

Энэ удаагийн судалгааны явцад **нийгмийн даатгалын тогтолцооны чанар, хүртээмжийн** талаарх үнэлгээ даатгалын төрөл бүрээр дараах байдлаар гарсан нь сонирхол татаж байна. /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын дараахь төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг үнэлнэ үү?

	сайн	Дунд	муу	Мэдэхгүй
Өндөр насны тэтгэвэр	28.4%	44.0%	13.1%	14.4%
Тахир дутуугийн даатгал	16.0%	31.1%	21.7%	31.3%
Тэжээгчээ алдсны	14.8%	28.8%	19.1%	37.3%
Эрүүл мэндийн даатгал	22.4%	32.7%	33.8%	11.2%
Ажилгүйдлийн даатгал	12.2%	22.1%	23.7%	42.0%

Хүснэгтээс үзэхэд өндөр насны тэтгэврийн үйлчилгээний чанар, хүртээмж бусдаас харьцангуй илүү үнэлгээ авсан болно /Chi-Square=20.740; df=12; Sig.(2-sided)= .054/.

Харин эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи респондентүүдийн үнэлгээ нь үндсэндээ харилцан адилгүй байгаа ч сөрөг үнэлгээ /33.8%/ нь давамгайлж байгаа нь анхаарал татаж байна. Түүнээс гадна респондентүүд нийгмийн даатгалын үлдсэн бусад төрлүүдийг /тахир дутуугийн даатгал, тэжээгчээ алдсны даатгал, ажилгүйдлийн даатгал/ хангалттай хэмээн үнэлээгүй болно. /“Мэдэхгүй” гэсэн хариулт өндөр /31.3%-42.0% -ийн хооронд хэлбэлзэж байна/.

Нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд олгогдож байгаа тэтгэмжийн талаархи респондентүүдийн үнэлгээ нь ихэнхидээ энэ талын мэдлэг хангалтгүй байгаагаар тодорхойлогдож байгаа нь хүснэгт 3-аас харагдаж байна. Харин судалгаанд оролцогчдын ихэнх нь жирэмсэний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын бүх төрлүүдээс хамгийн эерэгээр үнэлсэн /32.6%/ нь сонирхолтой юм. Энэ нь нэг талаас тухайн тогтолцооноос олгож буй тэтгэмжийн төрлийн хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, мөн нөгөө талаас үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийг хуваарилан зарцуулах зарчим нь нийгмийн даатгалын тогтолцооны шинэтгэлийн нэг томоохон асуудал болж байдаг. Санал асуулгад оролцогчдын 72.0 хувь нь нас, хүйс, боловсрол зэргийг харгалзахгүйгээр НДС-гийн хуваарилан зарцуулж байгаа хэлбэрийг өөрийн амьдралд шууд хамаатай гэж хариулсан байна.

Энэ байдал энэ удаагийн судалгааны дараагийн асуултын хариултаар давхар нотлогдож байна. Респондентуудын 40.1 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийг одоо төлж байгаа хүнд олгох нь зүйтэй гэж үзэж байна /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. НД-ын шимтгэлийн хуримтлалыг хуваарилан зарцуулж байгаа нөхцлүүдийн алинтай Та санал нийлж байна вэ?

Нөхцөл	хувиар
1995 оноос өмнө гарсан хүнд олгох ёстой	15.0
Одоо төлж байгаа хүнд олгох ёстой	40.1
1960 оноос хойш төрсөн хүний дансанд хуримтлах ёстой	19.1
НД-ын зарим хэсгийн ЗГ зарцуулах ёстой	1.9
мэдэхгүй	23.9
Нийт	100.0

Хэдийгээр санал асуулгад оролцогчдын ихэнх нь нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалын хуваарилан зарцуулах асуудлын хүрээнд дэх өнөөгийн өөрчлөлтийг дэмжиж байгаа боловч хэрэгжүүлэх арга замын талаар хүмүүсийн санал харилцан адилгүй байгаа юм /Хүснэгт 6/.

Хүснэгт 6. НДС-аг ашигтай байдлаар өсгөх нь зүйтэй саналыг Та хэрхэн үзэж байна вэ?

Санал	хувь
Ашигтай бол зөв	38.1
Олны жишгийг дагана	10.5
Буруу	18.1
маш эрсдэлтэй	19.7
мэдэхгүй	13.6
Нийт	100.0

Хүснэгтээс үзвэл НДС-г ашигтай байдлаар өсгөх нь ерөнхийдөө зөв зүйтэй болохыг судалгаанд хамрагсдын дийлэнх /38.1%/ нь үзсэн нь сангийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх үүднээс түүнийг эргэлтэнд оруулах нь зах зээлийн эдийн засгийн утгаараа зөв гэж үзсэнтэй холбоотой юм. Нөгөө талаар үүнийг маш эрсдэлтэй, буруу алхам болох гэж үзэж байгаа респондентуудийн 37.8 хувь /нийлбэр дүнгээр/ үзсэн нь энэ асуудалд болгоомжтой хандаж байгаагийн илрэл юм.

Энэ бүхнийг дүгнэж үзвэл нийгмийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилтийн байдал манай хүмүүсийн хандах хандлага, үнэлэмж төдийлөн сайн биш байгаа нь харагдлаа. Энэ нь нийгмийн даатгалын талаархи хүмүүсийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаагийн зэрэгцээ хууль эрх зүйн орчин төдийлөн боловсронгуй бус, ялангуяа даатгуулагчдын эрх ашиг, сонирхлыг шууд хамгаалдаг, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг, хариуцлага тооцдог механизм эрх зүйн актуудад тусгалаа олоогүйтэй холбоотой байна гэж үзэх үндэс байна.

2.2. Судалгааны байгууллагууд, судлаачдын хийсэн үнэлгээ, санал, зөвлөмж

Дээр 1.1 дэх хэсэгт нийгмийн даатгалын асуудлаар хийсэн судалгааны ажлуудын жагсаалтыг гаргасан билээ. Энэ хэсэгт эдгээр судалгааны дүгнэлт, дэвшүүлсэн санал, зөвлөмжийг танилцуулах зорилго тавьсан болно.

УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төвөөс 2008 онд УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалгаар “Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, цаашид сайжруулах арга зам” сэдэвт судалгааг хийсэн бөгөөд дараахь санал, зөвлөмжийг тус судалгааны үр дүнд хийсэн байна. Үүнд:

- НДС-гийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зохистой тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох.
- Шаардлагатай тохиолдолд авч ашиглах НДС-ын эрсдэлийн болон нөөцийн сан бүрдүүлэх боломж нөхцөлийг судлан холбогдох хууль тогтоомжуудад энэ талын зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн НДС-ын зарим төрлийн үйлчилгээг боловсронгуй болгон сайжруулах, эрх зүйн орчинг шинэчлэх шаардлага ч зүй ёсоор тавигдаж байгаа болно. Тухайлбал:

- НДС-ын төрлүүд дотроос ихээхэн хүнд байдалд ороод байгаа тэтгэврийн даатгалын сангийн эрх зүйн орчны шинэтгэлийн асуудлыг онцгой анхаарах
- Тэтгэврийн нэрийн дансыг зохих ёсоор нь ажиллуулж түүний үйл ажиллагааг иргэдэд танилцуулах, мэдээлэл өгөх ажлыг эрчимжүүлэх.
- Тэтгэврийн даатгалын сангийн нийт орлогын 4.0 хувийг тусгай санд төвлөрүүлэх асуудлыг холбогдох хуульд өөрчлөлт оруулж шийдвэрлэх.
- Гадаад оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа монгол иргэдийг НДС-д даатгуулах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
- Хүн амын дундаж насжилттай уяалдуулан өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх бүхий насыг шинээр тогтоох.

- Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний хэмжээ, нэр төрлийг оновчтой болгох, гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн тууштай бодлого, эдийн засгийн хөшүүрэг байхгүй байгааг анхааран үзэж иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг боловсронгуй болгох.
- Гадаад орнуудын ижил мэргэжлийн байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлж, олон улсын НД-ын ололт, туршлагаас суралцаж, дэлхийн жишигт нийцсэн шинэ төрөл үйлчилгээг нэвтрүүлэх.
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн доод хэмжээг 50 хувьд хүргэх, тэтгэмж олгох хугацааг олон улсын стандартад хүргэх зэрэг өөрчлөлтүүдийг нэн даруй хийх нь зүйтэй гэсэн байна.

Нээлттэй нийгэм хүрээлэнгээс санхүүгийн тэтгэлэг олгон хэрэгжүүлдэг бодлогын судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн судлаач Д.Чимиддамба, Л.Мөнх-Эрдэнэ, Т.Одончимэг нар нийгмийн даатгалын асуудлаар хийсэн тус тусын судалгааны ажилдаа тодорхой санал, дүгнэлтийг дэвшүүлжээ. Одоо эдгээрийг тоймлон авч үзье.

Судлаач Д.Чимиддамба “Эрүүл мэндийн санхүүжилтын тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдэвт судалгааны ажилдаа эрүүл мэндийн даатгалын хэлбэр, зарчмыг авч үзэхийн зэрэгцээ улс орнуудад хэрэглэгддэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааны хоёр загвар, төлбөрийн аргуудыг тодорхойлсон байна.

Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилттэй холбоотой дараахь дүгнэлтүүдийг хийжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн санхүүжилт нь эрүүл мэндийн бодлоготойгоо уялдахгүй байна.
- Эрүүл мэндийн санхүүжилт нь тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүргэх боломжийг хязгаарлаж байна.
- Эрүүл мэндийн санхүүжилт нь тусламж үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулахад чиглэгдэхгүй байна.

Судлаач Л.Мөнх-Эрдэнэ “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ ба чанарыг сайжруулах арга замууд” сэдэвт судалгааны ажилдаа Монгол улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар ба санхүүжилт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг судалсан олон улсын туршлага зэрэг асуудлыг авч үзсэн байна. Иргэний эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ хүртэхэд нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардал чухал үзүүлэлт болдог бөгөөд манай улсын нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал нь иргэдэд эрүүл мэндийн чанартай, тусламж үйлчилгээ, тухайлбал, эмнэлгийн өндөр чанартай тусламжийг үзүүлэхэд санхүүжилтын хэмжээ хангалтгүй байна. Учир нь манай улсын нэг иргэнд ногдох эрүүл мэндийн зардал нь байх ёстой үзүүлэлтээсээ даруй 1,8 дахин бага байна⁵⁷.

Эмч, эмнэлгийн ажиллагсдын цалин хөлс харьцангуй бага, орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн хангамж хүрэлцээгүй байгаа зэрэг нь тусламж үйлчилгээний чанар тааруу байгаагийн нэг шалтгаан мөн гэж судлаач үзсэн байна.

Судлаач Т.Одончимэг “Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн менежментийг боловсронгуй болгох нь” сэдэвт судалгааны ажилдаа нийгмийн даатгалын салбарын бодлогын баримт бичигт бичиг баримтын судалгаа хийсэн байна.

⁵⁷ Л. Мөнх-Эрдэнэ “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ ба чанарыг сайжруулах арга замууд”, 2 дахь тал. www.openforum.mn

ГУРАВ. Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн шинжилгээ

3.1. Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага, хөрөнгийн үлдэгдлийн судалгаа

Нийгмийн даатгалын сангийн 2008 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2007 оноос ажил олгогчид 2,2 мянга, даатгуулагчид 143,3 мянгаар нэмэгдэж, 19,8 мянган ажил олгогч, 2 296,2 мянган иргэнийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулсан дүн гарчээ⁵⁸.

Даатгуулагчдын төрлөөр урд онтой харьцуулан харуулбал: /Мянга/

Даатгуулагчдын төрөл	2007 он	2008 он	Өөрчлөлтийн хувь
Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчид	484,8	539,7	11,3
Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч	51,1	62,5	22,3
Эрүүл мэндийн заавал болон сайн дурын даатгуулагчид	321,5	340,8	6,0
Эрүүл мэндийг төрөөс хариуцах даатгуулагчид	1 295,5	1 353,2	4,4
Дүн	2 152,9	2 296,2	6,7

2008 онд эрүүл мэндийн даатгалд 2.2 сая хүн хамрагдсанаас аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид 24.2 хувь, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэд 58.8 хувь, малчин, оюутан, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд 17.0 хувийг тус тус эзэлж байна.

2008 онд эрүүл мэндийн даатгалын хамралтыг 80.0-аас дээш хувьд хүргэх зорилт тавьж ажилласаны үр дүнд жилийн эцэст даатгалд шинээр 196.7 мянган хүн нэмэгдэж, хамралт нийтдээ 84.4 хувьд хүрч дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн 2008 оны орлогын төлөвлөгөө бодит боломжоос харьцангуй өндөр хэмжээгээр батлагдсан, нөгөө талаас шимтгэл төлөгчдийн санхүүгийн төлбөр гүйцэтгэх чадвар суларсан үед нийгмийн даатгалын системийн хэмжээгээр шимтгэлийн жилийн орлогын төлөвлөгөөг 94.1 хувиар биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сан тус бүрээр авч үзвэл тэтгэврийн даатгалын сан 91,0 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 90,4 хувиар, Эрүүл мэндийн даатгалын сан 92,7 хувиар, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан 158 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 87,9 хувиар тус тус биелэлттэй гарсан байна⁵⁹.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор албан бус секторт ажиллагч, малчин, оюутны “Шимтгэл ногдуулалтын төлөвлөгөө”-г оны эхнээс батлуулан хэрэгжүүлснээр эдгээр иргэдийн даатгалын хамралт өмнөх оныхоос 22.9 мянган хүнээр, сангийн орлого 382.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

⁵⁸ Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны 2008 оны санхүүгийн тайлан. УНДЕГ-ын Санхүү бүртгэлийн газар. Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны 2009 оны зөвлөлгөөний материал.

⁵⁹ Ч.Алтанхуяг. Нийгмийн даатгалын салбарын 2008 оны ажлын үр дүн, санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ, цаашдын зорилт. <http://www.ndaatgal.mn/>

Нийгмийн даатгалын шинэ тогтолцоо бий болсноос хойшхи 14 жилийн хугацаанд түүхэндээ хамгийн өндөр буюу 280.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого цуглуулж, даатгалын сангаас хамгийн их зарлага буюу 410.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, эмчилгээ, үйлчилгээний зардал, төлбөрийг санхүүжүүлсэн байна⁶⁰.

Тэтгэврийн даатгалын сангаас гурван төрлийн тэтгэвэр авч байгаа 293.4 мянган хүнд 327.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож, Засгийн газрын шийдвэрийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2008 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн 81000 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 54.0 мянган төгрөгөөр тогтоож, тэтгэврийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, тэтгэврийн нэмэгдэлд 56.5 тэрбум төгрөг зарцуулж, дундаж тэтгэвэр 96.4 мянгад хүрлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас 110,0 орчим мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний амаржсаны, оршуулгын тэтгэмжид 13,5 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 8,0 мянга орчим даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжид 3,2 тэрбум төгрөг, сургалтын зардалд 39,7 сая төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 7200 иргэний тэтгэвэрт 13,7 тэрбум төгрөг, 3000 гаруй хүний хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээх төлбөр, рашаан сувилалын зардалд зориулан 468,7 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний зардлын санхүүжилтийг хугацаанд нь шуурхай зохион байгуулж олгосны үр дүнд 1.6 сая хүний тусламж үйлчилгээний зардалд 50.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оныхоос 23.3 тэрбум төгрөгөөр буюу 84.7 хувиар өссөн байна. Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлсэн даатгуулагчийн тусламж үйлчилгээнд нийт зардлын 95.8 хувь буюу 46.0 тэрбум төгрөг, рашаан сувиллаар үйлчлүүлсэн даатгуулагчийн тусламж үйлчилгээнд 2.4 хувь буюу 1.2 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөнд 1.8 хувь буюу 884.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ⁶¹. Одоо НДС-ын 2004-2008 оны орлого, зарлага, үлдэгдлийн талаархи мэдээллийг доорхи хүснэгтээр үзүүлэе.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁶⁰ Мөн тэнд

⁶¹ Ч.Алтанхуяг. Нийгмийн даатгалын салбарын 2008 оны ажлын үр дүн, санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ, цаашдын зорилт. <http://www.ndaatgal.mn/>

Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага, үлдэгдлийн талаархи мэдээлэл /тэрбум төгрөгөөр/

	Тэтгэврийн даатгалын сан			Тэтгэмжийн даатгалын сан			Эрүүл мэндийн даатгалын сан			Үйлдвэрлэлийн осол, Мэр/Шалт/Өвчний даатгалын сан			Ажилгүйдлийн даатгалын сан			НДСангийн нийт дүн		
	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)	Орлого	Зарлага	Зөрүү (+,-)
2004	112, 4	106, 6	5, 8	6, 9	4, 5	2, 3	28, 1	20, 9	7, 2	5, 1	4, 0	1, 0	3, 4	1, 0	2, 3	155,9	137,0	18,6
2005	124, 5	121, 0	3, 5	8, 2	5, 0	3, 1	32, 2	23, 6	8, 5	6, 0	4, 7	1, 2	4, 1	1, 2	2, 8	175,0	155,5	19,1
2006	164, 9	158, 8	6, 1	10, 6	5, 7	4, 8	41, 6	26, 5	15, 1	7, 7	6, 7	1, 0	5, 3	1, 6	3, 7	230,1	199,3	30,7
2007	241, 6	232, 7	8, 8	14, 6	7, 5	7, 0	52, 6	26, 1	26, 4	10, 4	10, 7	- 0,3	7, 2	1, 9	5, 2	326,4	278,9	47,1
2008	336, 6	327, 3	9, 3	12, 8	13, 4	-0,6	64, 5	50, 8	13, 7	19, 9	14, 5	5, 4	12, 4	3, 2	9, 1	446,2	409,2	36,9
Нийт /өссөн дүнгээр/	980,0	946,4	33,5	53,1	36,1	16,6	219,0	147,9	70,9	49,1	40,6	8,3	32,4	8,9	23,1	1 333,6	1 179,9	153,7

Дээрхи хүснэгтээс үзэхэд 2004-2008 онуудад нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага тус тусдаа болон нийтдээ жилээс жилд өссөн дүн харагдаж байгаа ба зарлага гэдэгт нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээнд зарцуулсан зардлыг оруулсан байна. Эндээс 2004 оны орлого, зарлагын дүнг 2008 оны мөнхүү үзүүлэлттэй сан тус бүрээр нь харьцуулан авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого 224,2 тэрбум төгрөгөөр буюу 2,9 дахин, зарлага 220,7 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5,9 тэрбум төгрөгөөр буюу 1,8 дахин, зарлага нь 8,9 тэрбум төгрөгөөр буюу 2,9 дахин, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 36,4 тэрбум төгрөгөөр буюу 2,2 дахин, зарлага нь 29,9 тэрбум төгрөгөөр буюу 2,4 дахин, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого 14,8 тэрбум төгрөгөөр буюу 3,9 дахин, зарлага нь 10,5 тэрбум буюу 3,6 дахин, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 9 тэрбум төгрөгөөр буюу 3,6 дахин, зарлага нь 2,2 тэрбум төгрөгөөр буюу 3,2 дахин тус тус өссөн байна.

Даатгалын сангуудын орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийн дүнг харьцуулан үзэхэд 2004-2008 оны нийт дүнгээр эрүүл мэндийн даатгалын сан хамгийн их буюу 70,9 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй, тэтгэврийн даатгалын сан 33,5 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сан 23,1 тэрбум, тэтгэмжийн даатгалын сан 16,6 тэрбум, ҮОМШӨ-ний даатгалын сан 8,3 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй байгаа дүн гарчээ.

Нийгмийн даатгалын сангаас зөвхөн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээнд зарцуулсан зарлагыг тооцсон дээрхи хүснэгтээс харахад зарлага нь орлогоосоо давсан тохиолдол хоёр удаа гарсан байна. Ерөнхийдөө дээрхи хоёр тохиолдлыг эс тооцвол сангууд жил бүр үлдэгдэлтэй байдаг ба тухайлбал, 2008 онд тэтгэмжийн сангаас бусад сангууд 13,7-9,1 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй, харин тэтгэмжийн сан 600 сая төгрөгний алдагдалтай дүн гарсан байна.

НД-ын сангуудын орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийн дүнг авч үзэхэд хамгийн их үлдэгдэлтэй сан нь эрүүл мэндийн даатгалын сан, дараа нь тэтгэврийн даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний даатгалын сангууд орж байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн боловч эмнэлэгт үзүүлэх болгонд нэмэлт төлбөр төлдөг, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ хангалтгүй талаар даатгуулагчдын зүгээс шүүмжлэл байнга гардаг атал эрүүл мэндийн даатгалын сан хамгийн их үлдэгдэлтэй байгаа нь анхаарал татаж байна.

3.2. Нийгмийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалтын талаархи мэдээллийн дүгнэлт

Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалтын талаар хавсралт №1 хүснэгтэд ирүүлсэн /2008 оны эцсийн байдлаар/ тайлангаас харахад нийт орлого 446 465.0, зарлага 409 522.1, чөлөөт үлдэгдэл 164 728.3 байгаа нь тус санд тодорхой хэмжээний нөөц хөрөнгө хуримтлагдах бололцоо байгааг гэрчилж байна.

Нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалт

/2008 оны жилийн эцсийн байдлаар, сая төгрөгөөр/

		Орлого	Зарлага	Чөлөөт үлдэгдэл	Үүнээс		
					Арилжаан ы банкинд	ЗГ-ын бонд	МБанкны үнэт цаас

1	Тэтгэврийн даатгалын сан	336 692.1	327 385.6	29 124.3	1 995.2		
2	Тэтгэмжийн даатгалын сан	12 840.3	13 493.3	25 141.3	12 549.4		
3	Эрүүл мэндийн даатгалын сан	64 541.8	50 840.4	67 112.4	38 248.7		
4	Үйлдвэрлэлийн осол, м/ш/ө даатгалын сан	19 964.1	14 553.7	14 143.9	1 099.7		
5	Ажилгүйдлийн даатгалын сан	12 426.7	3 249.1	29 206.4	19 407.0		
	Нийт	446 465.0	409 522.1	164 728.3	73 300.0		

Эндээс харахад ялангуяа Эрүүл мэндийн даатгалын санд 67 112.4, Ажилгүйдлийн даатгалын санд 29 206.4 төгрөгийн чөлөөт үлдэгдэл байгаа нь бусад сангуудаас харьцангуй илүү байна. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагчдын зүгээс байнга шүүмжилж байхад Эрүүл мэндийн даатгалын сан ихээхэн үлдэгдэлтэй байгааг 2 чиглэлээр тайлбарлаж болохоор байна.

1. ЭМД-ын үйлчилгээ хүндээ хүрч үйлчлэхгүй байгаа

2. ЭМД-ын тухай хуулийн 12.5-д заасан 10-15 хувийн төлбөрийг даатгуулагч өөрөө хийх шаардлагагүй байна.

Ажилгүйдлийн даатгалын санд төвлөрсөн мөнгөний үлдэгдэл их байгаа нь ажилгүйдлийн даатгалын талаар сургалт сурталчилгаа хангалтгүй хийдэг, ажилд зуучлах талаар дорвитой ажил зохиохгүй байгаатай холбоотой гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр ажилгүй болсон хүмүүс Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлэх хугацаа богино байгаа болон ажил олгогчоос энэ тухай тайлбарлахгүй байгаатай холбоотой байна.

Чөлөөт үлдэгдлийн нийт дүн болох 164 728.3 төгрөгөөс 72 300.0 төг-ийг арилжааны нилээд олон банкинд харилцан адилгүй хугацаатай, янз бүрийн хувийн хүүтэй өсгөхөөр хадгалуулсан байна. Энэхүү хадгаламжийн хугацаа болон хүүний талаархи мэдээллийг УНДЕГ-аас ирүүлээгүй болно.

№	Хадгалагч банк	Хадгаламжийн хэмжээ	Хугацаа	Хүү
1	Улаанбаатар хотын банк	9 000 000 000.00		
2	Капитал банк	14 000 000 000.00		
	Зоос банк	12 000 000 000.00		
	Анод банк	2 000 000 000.00		
	Монгол шуудан банк	5 100 000 000.00		
	Капитрон банк	6 000 000 000.00		
	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	3 000 000 000.00		
	Хаан банк	15 000 000 000.00		
	Хадгаламж банк	3 000 000 000.00		
	Худалдаа хөгжлийн банк	3 000 000 000.00		
	Нийт	72 300 000 000.00		

Тайлбар: Зоос банкны хадгаламжийн данснаас 1 тэрбум төгрөгийг 2009 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Төв төрийн сан банкны 900090003 тоот тэтгэмжийн даатгалын сангийн харилцах дансанд оруулсан болно.

Хуримтлалын сан байгуулаагүй ба Монгол банкны үнэт цаас болон Засгийн Газрын бонд худалдан аваагүй байна.

ДӨРӨВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР

4.1. ЯПОН УЛС

Японд 1961 оны 4 сараас эхлэн мөрдөгдсөн Үндэсний тэтгэврийн тухай хуулиар суурь тэтгэвэр, нэмэгдэл тэтгэвэр гэсэн 2 шатлалтай байхаар зааж хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн бүх иргэдийг хамарсан үндэсний суурь тэтгэврийн даатгал, хувийн компанид ажиллагчдыг хамарсан ажиллагчдын тэтгэврийн даатгал, төрийн үйлчилгээний болон зарим салбарын ажиллагчдыг хамарсан харилцан туслалцааны /хоёр талын/ тэтгэврийн даатгал гэсэн 3 хэсэгтэй тэтгэврийн даатгалын систем үйлчилж байна.

Нэгдүгээр хэсэгт: хувиараа хөдөлмөр эрхлэгчид, фермер, оюутан, ажилгүйчүүд гэх мэт 2, 3 дугаар хэсэгт хамрагддаггүй бүх хүмүүс хамрагддаг бөгөөд тэдгээр нь тэтгэврийн даатгалд 20-60 нас хүртэл сар бүр 13300 иен /2000оныхоор/ төлдөг.

Хоёрдугаар хэсэгт: 5-аас дээш ажлын байртай хувийн секторын бүх ажиллагчид, төрийн үйлчилгээний ажилтнууд хамрагдана. Энэ бүлгийн хүмүүс үндэсний тэтгэврийн даатгалд тусгайлан шимтгэл төлдөггүй, харин хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн дагуу ажиллагчдын тэтгэврийн даатгалд тусгай журмын дагуу цалингийн сүлжээнээс хамааралтайгаар 8,675% /уурхайчид, далайчид 9,575%/ийн шимтгэл төлнө.

Гуравдугаар хэсэгт: 2 дугаар хэсэгт хамрагдагчдын ар гэрийн ажил хийдэггүй хүмүүс хамрагдана. Эдгээр хүмүүс шимтгэл төлөхгүй, ажил олгогч, ажиллагчдын шимтгэл төлөх нөхцөл хангагдсан нөхцөлд тэтгэвэр авах эрх нээгдэнэ.

Японы тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгодог нь манайхтай адил байна. Японд Үндэсний суурь тэтгэвэр /65 наснаас сард 67000 иен/, Ажиллагчдын өндөр насны тэтгэвэр, Ажиллагчдын гэр бүлийн хүний /жилд 231400 иен, бусад хүүхэд бүрт 77100 иен/ тэтгэвэр, хувийн тэтгэвэр ба орлогын хамгаалалтын бусад хэлбэрүүд үйлчилж байна.

Эрүүл мэндийн даатгал Японд төрийн эрүүл мэндийн даатгалын систем үйлчилдэг. Одоо 1994 онд батлагдсан эрүүл мэндийн даатгалын хуулиар энэ харилцааг зохицуулж байна. Үндэсний эрүүл мэндийн даатгал, ажиллагчдын эрүүл мэндийн даатгал гэсэн 2 хэсэгтэй.

Үндэсний эрүүл мэндийн даатгалд ажиллагчдын болон байгууллага, хот, тосгодын орон нутгийн тусгай хөтөлбөрт хамрагдаагүй бүх иргэд хамрагдана. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамардаг үндэсний эрүүл мэндийн даатгалын тусгай систем ч энд багтана. Жирийн даатгуулагчдын жилийн шимтгэлийн дундаж хэмжээ 80202 иен, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 166608 иен байдаг. Бага орлоготой иргэдийн шимтгэлийн 30-70%-ийг хөнгөлөх хөтөлбөрт хамруулдаг. Энэ төрөлд ажил олгогч шимтгэл төлөхгүй, харин Засгийн газар эмнэлгийн зардлын 50%, захиргааны зардлыг бүрэн хариуцдаг. Үндэсний эрүүл мэндийн даатгалаас зөвхөн эмчилгээний зардлын зарим хэсгийг олгодог. Эмчилгээний зардлын 30%-ийг иргэн өөрөө хариуцах бөгөөд дээд хэмжээ нь 63800 иен, бага орлоготой бол 34400 иен байдаг. Даатгуулагч эмнэлгийн хоолны зардлаа /хоногт 760 иен/ өөрөө хариуцна.

Ажиллагчдын эрүүл мэндийн даатгалд 5-аас дээш ажлын байртай хувийн компанийн ажиллагчид заавал бусад нь сайн дураар хамрагдана.

4.2. ФРАНЦ УЛС

Францад хөдөлмөр эрхэлдэг бүх хүмүүс даатгалд хамрагддаг. Гэхдээ хөдөө аж ахуй, уул уурхай, төмөр зам, нийтийн аж ахуй, төрийн албан хаагчид, далайчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид тусгай системээр даатгуулна. Даатгуулагч орлогоосоо 6,55% тэтгэврийн даатгалд, гэрбүлийн хүний тэтгэмжийн даатгалд 0,1%-ийн шимтгэл төлнө. Ажил олгогч ажиллагчдын шимтгэл төлөх орлогоос 8,2%-ийн шимтгэл төлдөг. Шимтгэл төлөх ордлогын дээд хэмжээг тогтоодог байна.

Өндөр насны тэтгэвэр тэтгэмжийг 60 нас хүрсэн, 150-иас дээш улиралд шимтгэл төлсөн даатгуулагчид хамгийн их орлоготой ажилласан 25 жилийн дундаж цалингаас 25-50%-иар тогтоон олгодог. Өндөр насны үндсэн тэтгэвэр дээр тогтмол болон гэр бүлийн нэмэгдэл тэтгэврийг 65-аас дээш насны ханд олгодог.

Бага тэтгэвэртэй иргэдийн орлогыг өсгөх зорилгоор 65 насанд хүрсэн тэтгэвэр авагчдын жилийн орлого нь 6997,74 /гэр бүлтэй бол 12257,01/ еврогоос доош орлоготой тэтгэвэр авагчид жилд 2807,72 еврогийн тэтгэмж олгоно.

Бага орлоготой тэтгэвэр авагчид жилд 4024,86 /гэр бүлтэй бол 6641,57/ еврогийн нэмэгдэл тэтгэврийг тусгай нөхцөл /иргэний харъяалал г.м./- ийн дагуу олгоно.

Эрүүл мэндийн даатгал: Францад 1999 онд батлагдсан эрүүл мэндийн даатгалын хуулиар энэ харилцааг зохицуулж байна. Ажил эрхэлдэг бүх хүмүүс, тэтгэврийнхэн, зарим ажил эрхэлдэггүй хүмүүс хамрагддаг. Хөдөө аж ахуй, уул уурхай, төмөр зам, нийтийн аж ахуй, төрийн албан хаагчид, далайчид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүст тусгай систем үйлчилдэг. Хөдөлмөрийн чадвартай ажил эрхэлдэггүй хүмүүс сайн дураараа даатгалд хамрагдана. Ажиллагчид орлогоосоо 6,8%-иар, тэтгэврээс 1,4%-иар, ажилгүйчүүд доод орлогын хэмжээнээс 2%-иар, ажил олгогч цалингийн сангаасаа 12,8%-иар шимтгэл төлнө. Эрүүл мэндийн даатгалын сангаас өвчлөлийн, эхчүүдийн эмнэлгийн тэтгэмжийг санхүүжүүлдэг. Эмчилгээний зардлын 70-80%-ийг гаргана.

4.3. БНСУ-с

БНСУ-д Үндэсний тэтгэврийн даатгалд 18-59 насны бүх иргэд хамрагддаг. Төрийн албан хаагчид, ажиллагчид, хувийн сургуулийн багш, цэргийн бие бүрэлдэхүүнд тэтгэврийн тусгай тогтолцоо үйлчилдэг байна. Ажиллагчид сарын орлогоосоо 4,5%, ардын аж ахуйтан, загасчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид сарын орлогоосоо 6%, Ажил олгогч даатгуулагчийн орлогын дүнгээс 4,5%-ийн шимтгэл төлнө. Суурь тэтгэвэр тогтоох үнэлгээ нь даатгуулагчийн сүүлийн 3 жилийн сарын дундаж орлого буюу даатгуулсан бүх хугацаанд төлсөн шимтгэлийн дүнг 1,8 дахин нэмгдүүлсэнтэй тэнцэнэ. Засгийн газар захиргааны зардлын зарим хэсэг, загасчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шимтгэлийн хагасыг хариуцдаг.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн, 60 нас хүрсэн даатгуулагч өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй. 2033 онд тэтгэвэр тогтоох насыг 65-д хүргэхээр төлөвлөж байгаа.

Тэтгэврийн хэмжээг суурь тэтгэвэр тогтоох үнэлгээний 47,5 %-иар тогтоох бөгөөд даатгалд хамрагдсан 10 жилээс дээшхи жил тутамд суурь тэтгэвэр тогтоох үнэлгээний 5 %-иар бодож нэмэгдэл олгодог байна.

Эрүүл мэндийн даатгал.

БНСУ-д 2002 онд батлагдсан хуулиар энэ харилцааг зохицуулж байна. Эрүүл мэндийн даатгалд бүх иргэд хамрагдах бөгөөд бага орлоготой иргэдийг тусгай хөтөлбөрт хамруулдаг байна. Даатгуулагч сарын цалингаасаа 1,815%-иар, ажил олгогч сарын цалингийн нормативт сангаас 1,815%-иар, Засгийн газар төрийн албан хаагчдын 1,815%-иар, хувийн сургуулийн ажиллагчдын төлөө 0,726%-иар, сургууль ажиллагчдынхаа төлөө 1,095%-иар шимтгэл төлнө. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэмжийн 40%-ийг төсвөөс, 10%-ийг тамхины татвараас улс төлнө. Зардлын хуваарилалтыг хийхдээ эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол 20%, гадуур нарийн мэргэжлийн эмнэлгээр

үйлчлүүлсэн бол 50%, мэргэжлийн эмнэлгээр үйлчлүүлсэн бол 45%, ердийн эмнэлгээр үйлчлүүлсэн бол 40%, клиникээр үйлчлүүлсэн бол 30%-ийн зардлыг даатгуулагч болон ар гэрийнхэнд нь олгодог байна. Нэг үгээр хэлбэл өрхийн эрүүл мэндийн даатгалын систем үйлчилж байна.

4.4. ШВЕД УЛС

Швед улс нь нийгмийн хамгааллын талаар иргэдийн амьдралын баталгааг хангаж, сэтгэл хангалуун аж төрөх бололцоог бүрдүүлсэн орнуудын нэг. 1999 оноос нийгмийн даатгалын шинэчлэл хийж байгаа юм. Тэтгэврийн систем гэхэд хуучин-хуваарилалтын систем, шинэ буюу хуваарилалт-хуримтлалын систем хосолсон 5 төрөл хэлбэртэй байна.

Шведийн нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл нь 1937 оноос өмнө төрсөн хүмүүсийн хуучин системээр, 1938-1953 онд төрсөн хүмүүс хуучин системээс шинэ системд аажмаар шилжих механизмаар, 1954 оноос хойш төрсөн хүмүүс шинэ системээр тэтгэврийнхээ асуудлыг шийдвэрлүүлж байна.

Тэтгэврийн даатгал: Шведэд иргэд төрсөн оноосоо шалтгаалан хуучин системийн бүх нийтийн тэтгэвэр, орлогын тэтгэвэр, шинэ системийн орлогын тэтгэвэр, шимтгэлийн тэтгэвэр, баталгаат тэтгэвэрт хамрагддаг. Эдгээр 5 төрлийн тэтгэвэр нь бүх нийтийг хамарсан 2 шатлалтай. Эхнийх нь бүх иргэдэд адил хэмжээний суурь тэтгэвэр олгодог бол дараагийнх нь хувь хүний даатгалд хамрагдсан нөхцөл, төлсөн шимтгэлийн хэмжээнээс хамаарч нэмэгдэл орлого бий болгох зорилготой.

Тэтгэврийн даатгалын санг бүрдүүлэхэд ажилтан үнэлгээт орлогын 7%-иар шимтгэл төлдөг бол хувиараа хөдөлмөр эрхлэгчид 10,21 %-иар мөн орлогоос шимтгэл төлнө. Үнэлгээт орлого гэдэг нь суурь /доод/ орлогыг 7,5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцдэг. Ажил олгогч цалингийн сангаасаа 10,21 %-иар шимтгэл төлнө. Ажил олгогч ба даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 16%-ыг орлогын тэтгэвэрт, 2,5%-ийг шимтгэлийн тэтгэвэрт зарцуулдаг байна.

Засгийн газар шинэ системийн баталгаат тэтгэвэр, хуучин системийн бүх нийтийн тэтгэврийн хагас зардлыг хариуцдаг. Тэтгэврийн даатгалын төрөл нь манайхтай адил боловч шинэ системийн үед тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн тусгай журмаар зохицуулж байна.

Өндөр насны тэтгэвэр: Мөн л 5 төрөлтэй байна.

Хуучин системийн бүх нийтийн тэтгэвэрт 16-64 насандаа 40 жил Шведийн иргэн байсан, эсвэл 30 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 3-аас доошгүй жил Шведийн иргэн байсан иргэн хамрагдана. Тэтгэвэр тогтоох насны хязгаар нь 60-70 нас байх бөгөөд 60-64 насанд бууруулах, 65-70 насанд өсгөх механизмтай.

Хуучин системийн орлогын тэтгэвэрт 3-аас дээш жил шимтгэл төлсөн 65 насанд хүрсэн иргэн хамрагдах бөгөөд Бүрэн тэтгэвэр авах нөхцөл нь 30 жил шимтгэл төлсөн байх ёстой. Мөн 60-64 насанд бууруулах, 65-70 насанд өсгөх механизм үйлчилдэг.

Шинэ ситемийн орлогын тэтгэвэрийг 16 наснаасаа орлогоо тайлагнах системд хамрагдсан байх нөхцөлтэй. Төлсөн нийт шимтгэлийн дүнг амьжиргааны өртгийн өсөлт зэрэг бусад хүчин зүйлээс хамаарах орлогын нэмэгдэх хэмжээг цалингийн дундажийн ирээдүйн өсөлтийн "норм"-ыг үндэслэн нэмэгдүүлж тооцох журамтай.

Шинэ системийн шимтгэлийн тэтгэвэрт 16 наснаасаа орлогоо тайлагнах системд хамрагдсан /шимтгэл төлсөн/ хүмүүс хамаарна. Тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн төлсөн шимтгэл дээр хувийн, хамтарсан, тогтмол зэрэг бусад хэлбэрээр нэмэгдсэн шимтгэлийн орлогыг нэмэгдүүлж тооцох журамтай.

Шинэ системийн баталгаат тэтгэвэрт 3 жилээс дээш хугацаанд Шведийн иргэн байсан бүх иргэн хамрагдана. Шведийн бүх нийтийн болон орлогын тэтгэврийн аль аль нь 61-64 насандаа тогтоолсон бол 0,5%-иар буурах, 65-70 насандаа тогтоолгосон бол 0,7 %-иар сард нэмэгдэх механизмаар дамжиж тэтгэвэр тогтоолгох насыг зохицуулдаг онцлогтой.

4.5. МОНГОЛ УЛС

Монгол улс 1995 оноос нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжихдээ эв санааны нэгдлийн буюу хуваарилалтын тогтолцоог сонгосон бөгөөд 1999 онд батлагдсан тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай хуулиар хуваарилалт, хуримтлал хосолсон тогтолцоонд аажмаар шилжих эрх зүйн үндсийг тавьж, 1960 оны 1дүгээр сарын 1-нээс хойш төрсөн хүмүүсийн хувьд 2000 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэрийн дансыг хөтөлж эхэлсэн байна. Харин малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд нэрийн данс нээхэд зарим бэрхшээл тулгарч байгаа юм. Даатгуулагчийн нэрийн дансны тогтолцоонд шилжихэд дор дурдсан ажилбаруудыг гүйцэтгэх ёстой:

- 1960 оноос хойш төрсөн даатгуулагч бүрт хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нэрийн данс нээх

- 2000 оноос өмнө хөдөлмөр эрхэлж байсан хүний хувьд нэрийн дансны эхний үлдэгдлийг хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу тооцож гаргах

- Даатгуулагч тус бүрийн өөрийнх нь болон түүний нэрийн өмнөөс ажил олгогчынх нь төлсөн бүх шимтгэлийг дансанд бүртгэх

- Нэрийн дансны эхний үлдэгдэл ба түүний орлогод жилд нэг удаа хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хүү тооцож өсгөх

- Жил бүрийн эцэст өнгөрсөн онуудын болон тухайн жилийн шимтгэлийн орлогыг инфляци болон цалингийн бодит өсөлттэй уялдуулан индексжүүлэх

- Даатгуулагчид Нийгмийн даатгалын төв байгууллагаас баталсан журмын дагуу нэрийн дансны орлого, зарлагын талаархи мэдээллийг хүргэх

- Тэтгэврийг хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тооцож зарлагыг бүртгэх

- Тэтгэврийн индекслэлийг бүртгэх

Нэрийн дансны үндсэн зарчим нь иргэдийн авах тэтгэврийн хэмжээ нь түүний төлсөн шимтгэл, нэмэгдсэн орлогын хэмжээтэй нь дүйж байх явдал юм. Харин даатгуулагч хэд наслахаас үл хамааран тэтгэвэр авах ёстой гэсэн зарчим бол хэвээр үлдэнэ. Хуваарилалт-хуримтлалын тогтолцоонд шилжсэн үед хөтөлбөрийн дагуу хуримтлагдсан шимтгэлийн орлогын зарим хэсгийг /3%/ 2005 оноос эхлэн үнэт цаасны хөрөнгө оруулалтад зарцуулахаар зохицуулсан байна. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэлд зааснаар 2005 оноос шинэ тогтолцоонд шилжиж, нэрийн данснаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг олгохоор зохицуулсан.

Тэтгэврийн даатгалын хуримтлалын тогтолцоо нь улс орнуудад бүрэн хэрэгжиж үр ашиг нь мэдрэгдэж нотлогдоогүй, Швед, Латви, Литви зэрэг орнуудад манай нэгэн адил нэврүүлж эхэлж байгаа шинэ тогтолцоо юм.

Манай улсын хувьд шинээр нэвтрүүлж эхэлсэн тогтолцооныхоо нэр хүндийг унагахгүй байхын тулд анхаарвал зохих цөөнгүй асуудал тулгарч байгаа нь энгийн даатгуулагчийн хувьд ч улам бүр тод мэдрэгдэх боллоо. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны мэдээллийг даатгуулагчид хүргүүлэх, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулж өсгөх үйл ажиллагааны журам нь шаардлага хангахгүй байгаа, орлогод тооцсон хүү ил тод бус байгаа зэрэг дутагдал үргэлжилсээр байна. Нөгөө талаар Тэтгэврийн даатгалын хуваарилалтын болон хуваарилалт-хуримтлалын тогтолцоонд шилжих зааг үед ижил орлого, адил нөхцөлтэй даатгуулагчдын тогтоолгох тэтгэврийн хэмжээ нь хоорондоо эрс ялгаатай байж болох төлөв ажиглагдаж байна. Манайд хэрэгжүүлж байгаа тэтгэврийн даатгалын шинэ, хуучин тогтолцооны зарчим, тэтгэвэр тогтоох аргачлалын ялгаатай холбогдон хэдхэн хоногийн зөрүүтэй төрсөн даатгуулагчийн тогтоолгох тэтгэврийн хэмжээ нь хоорондоо ихээхэн зөрүүтэй байж болохыг Дэлхийн банкны шинжээч Ларри Томсон “2014 оны 12 дугаар сарын 31-нд 55 нас хүрэх даатгуулагчийн тогтоолгох тэтгэвэр, 2015 оны 1 дүгээр сарын 1-нд 55 нас хүрэх даатгуулагчийн тогтоолгох тэтгэвэр хоорондоо асар их зөрүүтэй байна” гэж тэмдэглэжээ. Энэ нь тэтгэврийн даатгалын шинэ тогтолцооны үзэл баримтлал, санхүүгийн тооцоо нь хэр зэрэг үндэслэлтэй болохыг дахин хянаж үзэхийг шаардаж байна. Ингэж тэтгэврийн даатгалын

хуваарилалт-хуримтлалын шинэ тогтолцооны нэр хүндийг унагах нөхцлийг бүрдүүлэхэд сонгуулийн амлалтаар хэрэгжүүлсэн, даатгуулагчид ихээхэн таалагдаж байгаа шимтгэлийн хувь хэмжээг бууруулж тогтоосон шийдвэр ч жинтэй нөлөө үзүүлсэн нь харагдаж байна.

Дээр дурдсанаас үндэслэн шинэ тогтолцоонд шилжих үеийн шинэ, хуучин аргачлалаар тогтоосон тэтгэврийн зөрүүг багасгах арга хэмжээг төрөөс авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Эс тэгвэл тэтгэврийн шинэ тогтолцооны нэр хүнд нэг мөсөн унахад хүрч болзошгүй байна.

ТАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ГАРЧ БУЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААРХИ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

5.1. Судалгааны дүгнэлт- Нөхцөл байдлын үнэлгээ

Монгол улс төрийн нийгмийн хамгааллын тогтолцоо, үйлчилгээнээс зах зээлийн үеийн нийгмийн даатгалын тогтолцоо, үйлчилгээний хэлбэрт тууштай шилжин орж энэхүү шинэ тогтолцооны эрх зүйн үндэс тавигдсан ба улмаар түүнийг дэлхийн зарим улсын жишгийн дагуу улам боловсронгуй болгох үйл ажиллагаа эхлүүлээд байна.

“Нийгмийн даатгалын тогтолцоо, эрх зүйн орчин” сэдэвт судалгааны хүрээнд судалж үзсэн баримт материал, мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. Өнөөдөр нийгмийн даатгалын шинэ тогтолцооны баттай үндэс бүрэлдэн бий болсон боловч түүнийг өнөөгийн цаг үеийн байнга өөрчлөгдөж буй орчин, зах зээлийн эдийн засгийн харилцааны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсронгуй болгох зайлшгүй нөхцөл, тулгамдсан асуудлууд байсаар байна.
2. Нийгмийн даатгалын тухай багц хуульд 2008 онд нэлээд томоохон нэмэлт, өөрчлөлт орж нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг НД-ын сангийн төсвийн тухай хуулиар баталж байх болсноор сангийн бие даасан байдлыг хангах нөхцөл бүрдэж, даатгалын хамралтыг өргөтгөх, даатгалын сангаас нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн орчин бий болсон хэдий ч УНДЕГ-аас НД-ын сангуудын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалтын талаар 2008 оны эцсийн байдлаар гаргасан мэдээллээс үзэхэд нийт 164 728,3 сая төгрөгний чөлөөт үлдэгдлээс 73300,0 сая төгрөгийг арилжааны банкинд байршуулсанаас өөрөөр хуримтлалын хэмжээг нэмэгдүүлэх бусад арга хэлбэрийг ашиглаж эхлээгүй байна.
3. НД-ын хамралтын хүрээг өргөжүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна. Тухайлбал, олон тооны малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторынхон НД-д хамрагдахгүй хоцорч байгаа ба малчид, албан бус секторт ажиллагчдын ажил хөдөлмөрийн онцлог болон орлогын тогтворгүй байдлаас шалтгаалж НД-д хамруулах ажил үр дүнд хүрэхгүй байна.
4. Тэтгэвэрийн даатгалын хүрээнд шийдвэрлэвэл зохих тулгамдсан олон асуудал бий болжээ. Тэтгэвэр авагчдын орлогыг нэмэгдүүлэх, даатгалын шинэ төрөл, тогтолцоог нэвтрүүлэх, шимтгэлийн хэмжээ, тэтгэвэр тогтоолгох нас, хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг сайжруулах зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүй тогтолд нийцсэн олон асуудлыг харгалзан шинэчлэл өөрчлөлт хийх шаардлагатай болсон байна.
5. Тэтгэврийн нэрийн дансанд хуримтлагдаж буй шимтгэл үнэгүйдлээс бүрэн хамгаалагдаагүй, даатгуулагч нь нэрийн дансан дахь хуримтлалаа бүрэн захиран зарцуулах, гэрээслэлийн дагуу өв залгамжлагчдаа шилжүүлэх эрх зүйн орчин гүйцэд бүрдээгүй байна.
6. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар олон нийтийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний

талаар хамгийн олон буюу санал асуулгад оролцогчдын 33,8 хувь нь хангалтгүй муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Энэ нь өнөөдөр эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний хэмжээ, нэр төрлийг оновчтой болгох гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн тууштай бодлого, эдийн засгийн хөшүүрэг байхгүй байгаатай ямар нэгэн байдлаар холбоотой гэж үзэх үндэслэл байна.

7. Түүнчлэн олон нийтийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд даатгуулагч иргэд НД-ын талаар мэдлэг, мэдээлэл муутай, эрх ашгаа хамгаалж мэддэггүй, нийгмийн даатгалын асуудлыг сонирхдоггүй, энэ талаар эрх зүйн зөвлөгөө авч сураагүй байна. Иймд НД-ын тогтолцооны талаар иргэд, олон нийтэд сурталчилгаа явуулж, тэдэнд мэдлэг, мэдээлэл олгох явдал чухал байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.
8. **НДҮЗ** хэрхэн ажилладаг талаархи иргэдийн санал бодлыг тандаж үзэхэд судалгаанд хамрагсдын хувьд НДҮЗ-ийн тухай сонсож байсан боловч түүний үйл ажиллагаа, бодлого, чиглэлийн талаар сайн мэдэхгүй байна гэж 54,7 хувь, огт мэдэхгүй, сонсоогүй юм байна гэж 34,3 хувь, ер нь мэднэ гэсэн 10,9 хувь нь тус тус хариулцаажээ. Энэ нь нэг талаас НД-ын үйл ажиллагааг зохицуулах төв байгууллага болох Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа олон түмэнд ил тод биш, энэ талын мэдээ, мэдээлэл хангалтгүй байгааг, нөгөө талаас тус байгууллагын үйл ажиллагаа хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу чиг үүргээ төдийлөн сайн биелүүлэхгүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.
9. Эрх зүйн орчны зохицуулалтын талаар манайхтай ижил төстэй буюу шилжилт хийж буй улс орнуудын нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй хуулиудтай манай хуулиудыг харьцуулсан шинжилгээний аргаар шинжилж үзэхэд ерөнхий үзэл баримтлалын хувьд эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан ижил төстэй байна. Гэсэн хэдий ч эдгээр хуулинд даатгагч, даатгуулагч, даатгалын шимтгэл төлөгч, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг болон НД-ын удирдлага, санхүүжилтын зарчмыг тодорхой зүйл заалтаар зохицуулсан зэрэг тусгаж авууштай зохицуулалт олон байгааг анхаарах нь зүйтэй.

5.2. Судалгааны санал, зөвлөмж

“Нийгмийн даатгалын тогтолцоо, эрх зүйн орчин” гэсэн сэдвийн хүрээнд хийгдсэн энэхүү судалгаанд авагдсан материалаас дүгнэлт хийхэд дор дурдсан асуудлыг цаашид гарах бодлогын шийдвэр, хууль тогтоомжид тусгах талаар шийдвэр гаргах түвшинд анхаарахыг санал болгож байна. Үүнд:

1. Судлаачдын зүгээс дэлхийн улс орнуудад тэтгэврийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг харьцуулан авч үзсэний үндсэн дээр Японд олгодог суурь тэтгэвэр, Францад олгодог нэмэлт тэтгэвэр, Шведийн хуримтлал-хуваарилалтын системийн үед олгох баталгаат тэтгэврийн хэлбэрийн аль нэгийг манай улсын онцлог /амьжиргааны түвшин, санхүүгийн боломж г.м./-т тохируулан нэвтрүүлэх шаардлага тавигдаж байна. Ингэхдээ саяхан байгуулсан “Хүний хөгжил сан”-гийн хөрөнгөөс нэгдүгээрт нийгмийн даатгалд хамрагдах хүрээг өргөжүүлэхийн тулд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зэрэг албан бус секторт ажиллагчдыг заавал даатгалд хамруулан хураамжийн зарим хэсгийг уг сангаас санхүүжүүлэх, хоёрдугаарт тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг ахиулах зорилгоор Шведийн туршлагаар тэтгэврийнхэнд тодорхой нас /тухайлбал 65 нас/-аас эхлэн тэтгэврийн болзол хангасан эсэхийг үл харгалзан бүх нийтийн нэмэгдэл /суурь/ тэтгэвэр тогтоон олгох системийг нэвтрүүлж, мөн сангаас эх үүсвэрийг нь шийдэж болох юм. Нэмэлт /суурь/ тэтгэврийн санг ямар, ямар эх үүсвэрээс бүрдүүлэхийг хуулиар журамлаж хэрэгтэй. Ингэвэл Монгол улс тэтгэврийн даатгалын давхар тогтолцоонд шилжих, шинэ тогтолцооныхоо нэр хүндийг хамгаалан үлдэх боломж бүрдэнэ. Энэ тохиолдолд “Хүний хөгжил сан”-гийн хөрөнгө улс төрчдийн сонгуулийн амлалтыг хэрэгжүүлэхээс ангид байх шаардлагатай болно.

2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний талаар хэрэглэгчдийн /33,8%/ сэтгэл дундуур байдаг үндсэн шалтгааны нэг нь энэ төрлийн даатгалд хамрагдаж зохих үйлчилгээг авч чадахгүй үлдэж байгаа иргэн хэт олон байгаатай холбоотой байж болох юм. Иймд өрхийн даатгалын хэлбэрийг БНСУ-ын туршлагаар нэвтрүүлэх боломжтой юм. Гэхдээ БНСУ-ын өрхийг хамарсан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь нь бага байгааг манайд тэр хэвээр нь авах бололцоо муутай гэдэг нь ойлгомжтой. Өрхийн эрүүл мэндийн даатгалын хэлбэрт шилжихийн тулд энэхүү даатгалын үйлчилгээг хүртээмжтэй, үйлчлүүлэгчийн хувьд сэтгэл хангалуун байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлж болохоор байна:

а/ Эрүүл мэндийн даатгалын хураамжийг одоогийнхоос хэт ихээр биш гэхдээ нэмэгдүүлэх, өрхийн нэг даатгуулагчид оногдох хүний тоог тодорхой байлгах.

б/ Төрөөс даатгалын төлбөрийг нь хариуцахаар хуульчлагдсан хүүхэд, тэтгэврийнхэн, тахир дутуу хүмүүс, хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ 2 нас хүртэл асарч буй эх г.м./ даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалд хуваарилж байгаа мөнгөний хэмжээг нэмэгдүүлж, нэг даатгуулагчид оногдох мөнгөний хэмжээг цагийн баталгаат хөлстэй холбон хуульд тодорхой зааж өгөх.

в/ Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид зэрэг албан бус секторт ажиллагчдыг эрүүл мэндийн заавал даатгалд хамруулан даатгалын хураамжийн тодорхой хэсгийг “Хүний хөгжил сан”-гаас санхүүжүүлэх аваас эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүрээ өргөжиж, сангийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэх эерэг сайн талтай болно.

г/ Ажилгүйчүүдыг эрүүл мэндийн даатгалд хамруулж, ажилгүйдлын тэтгэмжээс шимтгэл авдаг журамд шилжих.

3. Даатгагч, даатгуулагч, даатгалын шимтгэл төлөгч, эрүүл мэндийн байгууллагын **эрх, үүргийг** Нийгмийн даатгалын болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар зохицуулах;

4. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулиар зохицуулж байгаа нэрийн дансны эхний үлдэгдлийг тогтоох, даатгуулагчийн нэрийн дансанд хүү тооцох, тэтгэврийн доод хэмжээ, тэтгэврийг индекслэх, нэрийн данснаас тэтгэвэр авах эрх, тэтгэвэр олгохтой холбогдсон харилцааг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулиар зохицуулах;

5. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-ийг тэтгэврийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тухай мэдээлэл, шимтгэлийн тооцоог хөтлөх зарчим, эрх зүйн үндсийг дагнан зохицуулахаар тооцож шинэчлэн найруулах;

6. Одоогийн мөрдөж байгаа Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулиар Засгийн газрын байгууллагуудад эрх шилжүүлж зохицуулахаар заасан журам заавруудыг нэг мөр хуульчлан тогтоох;

7. Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зарчмыг тухайн жилийн орлогын тодорхой хувиар тогтоох;

8. Нийгмийн даатгалын сангийн активын хөрөнгө оруулалтын удирдлагын бүхий л үйл ажиллагаа, тооцоог эрхлэх банкныг Казахстан зэрэг улсын туршлагаар нэр заан тогтоох, эсвэл уг банкныг уралдаант шалгаруулалтаар тодруулахаар хуульд өөрчлөлт оруулах;

9. Нийгмийн даатгалын сангийн актив болон Нийгмийн даатгалын байгууллага, Үндэсний ба салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийг тус тусад нь хийхээр хуульд нэмэлт оруулах;

10. Сангийн хөрөнгөөр дор дурдсан үйл ажиллагааг эрхлэхийг хориглохоор хуульд нэмэлт оруулах; Үүнд:

а\ нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг барьцаанд тавих

б\ Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр шинээр хуулийн этгээд үүсгэн байгуулах

Ашигласан материал**Хууль, эрх зүйн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Нийгмийн даатгалын тухай хууль. 1994 он.
3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль. 1994 он.
4. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай. 1994 он.
5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай. 1994 он.
6. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль. 2002 он.
7. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль. 2002 он.
8. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль. 2002 он.
9. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай. 1994 он.
10. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай. 2002 он.
11. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай. 1999 он.
12. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай. 1994 он.
13. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай. 1997 он.

Бодлогын баримт бичиг, судалгаа

1. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг. УБ хот, 2003 он.
2. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл. УБ хот, 1999 оны УИХ-ын 38-р тогтоол
3. Тэтгэврийн тогтолцоог бэхжүүлэх-Тэтгэврийн бодлогын зорилтыг тодорхойлох нь /семинар/. УБ хот, 2007 он.
4. Нийгмийн даатгалын ажилтнуудын улсын анхдугаар зөвлөлгөөний баримт бичиг. УБ хот. 2008 он.
5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2006 оны ажлын тайлан. УБ хот. 2007 он
6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2007 оны ажлын тайлан. УБ хот. 2008 он
7. Тэтгэврийн үндсэн сургалт-2007. УБ хот

Ном, гарын авлага

1. Д. Ванданмагсар. Нийгмийн даатгалын үүсэл, хөгжил, шинэчлэл, УБ., 2002 он
2. Ч. Дагвадорж. Нийгмийн хамгаалал: онол-арга зүй, туршлага, харьцуулалт, УБ., 2004 он
3. П. Бямбацэрэн, Ч.Дагвадорж. Нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд, УБ., 2000 он
4. Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхтгэл, УБ., 2000 он
5. С. Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2007 он

Электрон мэдээллийн эх сурвалж

1. Ч.Алтанхуяг : Нийгмийн даатгалын салбарын 2008 оны ажлын үр дүн, санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ, цаашдын зорилт. www.ndaatgal.mn
2. Т. Одончимэг “Нийгмийн даатгалын тэтгэврийн сангийн менежментийг боловсронгуй болгох нь”. www.openforum.mn
3. Л. Мөнх-Эрдэнэ “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ ба чанарыг сайжруулах арга замууд”. www.openforum.mn
4. Д. Чимиддамба “Эрүүл мэндийн санхүүжилтын тогтолцоог боловсронгуй болгох нь”. www.openforum.mn

Хавсралт 1. Гадаадын зарим орнуудын Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг харьцуулсан судалгаа

№	Хууль тогтоомжийн нэр, огноо	Хуулийн зохицуулалт	
		Нийгмийн даатгалын сан бүрдүүлэх журам	Нийгмийн даатгалын санг захиран зарцуулах журам
1	2	3	4
	БНБелУ-ын хууль “Беларусь улсын хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүн амын нийгмийн хамгааллын санд заавал төлөх даатгалын шимтгэлийн тухай”	<p>3 дугаар зүйл. Заавал даатгалын шимтгэлийн хэмжээ.</p> <p>Тэтгэврийн даатгалын шимтгэл:</p> <p>Ажил олгогч-28%</p> <p>ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл нийт бүтээгдэхүүнийх нь 50-иас дээш хувь эзэлдэг ажил олгогч-24%</p> <p>Хэрэглэгчийн хоршоо, нөхөрлөл...-5%</p> <p>Белгосстрахад сайн дураараа даатгуулагч-29%</p> <p>Ажил эрхэлж байгаа хүмүүс-1%</p> <p>Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон төрөлтийн, шинээр төрсөн хүүхдийн, хүүхдээ 3 нас хүртэл асарсаны, даатгуулагчийн нас нөгчсөний тэтгэвэр тэтгэмжийн даатгалын тохиолдлын заавал төлөх даатгалын шимтгэл- 6%</p> <p>Мэргэжлийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг Беларусь улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн зарлигийн хавсралтад зааснаар ажил, үйлчилгээний нөхцлийн онцлогоос хамаарч 1,5 – 4,8% байхаар тогтоосон</p> <p>БНБелУ-ын Дээд Зөвлөлийн тогтоол № 2367-ХП 1993:01.10</p> <p>Белорусь улсын “Хүн амын нийгмийн хамгааллын сан”ийн тухай</p> <p>1...Белорусь улсын “Хүн амын нийгмийн хамгааллын сан” нь Беларусь улсын Сайд нарын Зөвлөлийн шууд удирдлага дор санхүү,</p>	<p>БНБелУ-ын “Хүн амын нийгмийн хамгааллын сан”ийн дүрэм</p> <p>1. Ерөнхий зүйл</p> <p>Белорусь улсын “Хүн амын нийгмийн хамгааллын сан” нь нийгмийн даатгалын санхүүгийн төрийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд санхүү-зээлийн үйл ажиллагаа явуулж, Беларусь улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа зохион байгуулна.</p> <p>Сангийн мөнгөн хөрөнгө нь улсын төсвийн бүрэлдэхүүнд орохгүй. Дайчлан хурааж авч болохгүй бөгөөд банкны байгууллагад хадгалагдана.</p> <p>2. Сангийн бодлого, чиг үүрэг</p> <p>Сангийн бодлого нь:</p> <p>Төрөл бүрийн тэтгэвэр, тэтгэмж, бусад нийгмийн төлбөрийн зардлыг Беларусь улсын нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид нийцүүлэн санхүүжүүлэх:</p> <p>Тэтгэвэр тэтгэмж, бусад зардалд зориулсан даатгалын шимтгэлийг цуглуулж хуримтлуулах:</p> <p>Өөрийгөө санхүүжүүлэх зарчмын үндсэн дээр сангийн хөрөнгийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах:</p> <p>3. Сангийн төсвийг боловсруулах батлах зарцуулах журам</p> <p>Сан нь сангийн төсвийн орлогын төслийг Сангийн</p>

		<p>зээлийн бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага мөн.</p> <p>Энэхүү сангийн хөрөнгө нь улсын төсвийн бүрэлдэхүүнд орохгүй бөгөөд ажил олгогч, эзэд, иргэний төлсөн заавал даатгалын шимтгэл, улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс орсон мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.</p> <p>1. Беларусь улсын “Нийгмийн хамгааллын сангийн дүрмийг хавралтын ёсоор баталсугай</p>	<p>ям, Төлөвлөгөө эдийн засгийн хороотой зөвшилцөн орлогын эх үүсвэр тус бүрээр, Белорусь улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, үйлдвэрчний эвлэлүүдтэй зөвшилцөн тэтгэвэр тэтгэмж, эрүүлжүүлэх арга хэмжээнд зайлшгүй шаардлагатай гэж тооцсон арга хэмжээний зардлыг статья бүрээр боловсруулж, түүнийг СнЗ батална.</p> <p>Сангийн гүйцэтгэлийн тайланг СнЗ батална.</p> <p>Сан улирал бүр сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ.</p> <p>Мужийн болон Минск хотын Сангийн удирдах газрын Сангийн хөрөнгийн орлого, зарлагын хуваарилалтын тооцоог холбогдох санхүүгийн болон Нийгмийн хамгааллын байгууллагын санхүүгийн нэгжүүдтэй хамтран боловсруулж түүнийг Сангийн удирдах зөвлөл батална.</p>
<p>ОХУ-ын Холбооны хууль</p> <p>ОХУ-ын тэтгэврийн заавал даатгалын тухай</p>	<p>17 дугаар зүйл ОХУ-ын Тэтгэврийн сангийн төсөв бүрдүүлэх</p> <p>1.ОХУ-ын Тэтгэврийн сангийн төсөв нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>Даатгалын шимтгэлийн орлого;</p> <p>Холбооны төсвийн хөрөнгө;</p> <p>Алданги, санхүүгийн бусад ногдол;</p> <p>Нийгмийн заавал даатгалын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг түр хугацаагаар байршуулсан \хөрөнгө оруулалт\ -ы орлого</p> <p>Даатгуулагч хувь хүмүүс, байгууллагаас оруулсан сайн дурын даатгалын шимтгэл</p> <p>Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр;</p> <p>22 дугаар зүйл. Даатгалын шимтгэлийн тариф</p> <p>1. Даатгалын шимтгэлийн тариф нь шимтгэл ногдуулах суурь нэгжид ногдох шимтгэлийн хэмжээ мөн.</p>	<p>18 дугаар зүйл. Тэтгэврийн сангийн хөрөнгийг зарцуулах</p> <p>ОХУ-ын Тэтгэврийн сангийн хөрөнгийг дор дурдсан чиглэлээр зориулалтын дагуу зарцуулна:</p> <p>Хөдөлмөрийн тэтгэврийн талаархи ОХУ-ын хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн тэтгэвэр, тэтгэмж, тэтгэвэр авагчийн оршуулгын болон нас нөгчисдөд зориулсан зардал;</p> <p>ОХУ-ын Тэтгэврийн сангийн төсвөөс олгодог бусад тэтгэвэр;</p> <p>Даатгагчийн үйл ажиллагааны \төв болон орон нутгийн байгууллагын\ санхүү, материал техникийн урсгал зардал;</p> <p>ОХУ-ын нийгмийн заавал даатгалын тухай хууль тогтоомжийн актад заасан бусад зардал;</p> <p>ОХУ-ын Тэтгэврийн сангийн тухайн жилийн төсөвт тусгаагүй зардлыг холбооны хуулиар</p>	

2. Хэрэв энэ зүйлийн 3-т зааснаас өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан даатгуулагчийн хувьд дор дурдсан даатгалын шимтгэлийн тарифыг хэрэглэнэ:

1\ аж ахуйн уламжлалт салбар болох газар тариалан \фермер\-ийн аж ахуй эрхэлдэг умарт хязгаарын үндэсний цөөнхийн гэр бүл төрөл төрөгсдийн хамтын аж ахуйн ажил олгогчоос бусад ажил олгогч-даатгуулагчийн хувьд:

Хүснэгт 1

Жилийн эхнээс өссөн дүнгээр тооцсон ажиллагч тус бүрийн даатгалын шимтгэл төлөх суурь хөдөлмөрийн хөлс	1966 оноос өмнө төрсөн хүн		1967 оноос хойш төрсөн бүх хүн	
	Тэтгэврийн даатгалын санхүүжилтэд	Тэтгэврийн хуримтлалд	-“-	-“-
280000 рув. хүртэл	14,0%	0,0%	8,0 %	6,0 %
280001-3600000 рув	39200 рув+ 280000 рув.-с дээш дүнд 5,5 %	0,0%	22400 Рув+ 280000 Рув.-с Дээш Дүнд 3,1%	16800 Рув+ 280000 Рув.-с Дээш Дүнд 2,4%

тогтоосон журмын дагуу энэхүү төсөвт өөрчлөлт оруулсаны дараа санхүүжүүлнэ.

19 дүгээр зүйл. ОХУ-ын Тэтгэврийн сангийн нөөц ...нөөцийн хэмжээ, түүнийг бүрдүүлэх, зарцуулах журмыг ОХУ-ын Тэтгэврийн сангийн төсвийн тухай хуулиар тогтооно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

		600000 рув.-с дээш	56800 рув.	-	32320 рув.	24480 рув.	
	<div>Казахстан улсын хууль №405П</div> <div>Нийгмийн даатгалын тухай</div> <div>заавал үндэсийн</div>	<div>31 дүгээр зүйл. Улсын Нийгмийн даатгалын сангийн активыг бүрдүүлэх</div> <div>1. Сангийн актив дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: 1\ нийгмийн даатгалын шимтгэл, хугацаа хэтрүүлсэний алданги болон хөрөнгө оруулалтын орлогоос сангийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулсан хувьд ногдох хэсгийг хассан дүн; 2\ Казахстан улсын хууль тогтоомжоор тогтоосон бусад эх үүсвэр; 2. Сангийн активын хөрөнгийг зөвхөн дараахь зориулалтаар ашиглана; 1\ энэ хуулиар тогтоосон нийгмийн арга хэмжээний төлбөр хийх; 2\ Засгийн газраас тогтоосон жагсаалтад хамаарах санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах 3\ илүү төлсөн төлбөрийг буцаах, алдаа гаргасаны улмаас эргэж орсон орлого</div> <div>21 дүгээр зүйл. Хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдлоор нийгмийн төлбөр ногдуулах, түүний хэмжээ</div> <div>4. Хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн түүнийг тогтоосон бүх хугацаанд нийгмийн төлбөрийг олгоно.</div> <div>5. Хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдлоор олгох сарын төлбөрийн хэмжээ нь даатгуулагчийн сүүлийн 24 сарын хөдөлмөрийн хөлсний дундажаас Казахстан улсын хуулиар тогтоосон</div>				<div>7 дугаар зүйл. Нийгмийн арга хэмжээнд зориулсан хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах</div> <div>1. Улсын нийгмийн даатгалын сангийн нийгмийн арга хэмжээнд зориулсан хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, бүрэн байлгах асуудлыг төр баталгаажуулна.</div> <div>2. Нийгмийн арга хэмжээнд зориулсан хөрөнгийг дараахь журмаар бүрэн бүтэн байдлыг нь хангана: 1\ сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Казахстан улсын Засгийн газраас холбогдох норм, хязгаарлалтыг тогтоож өгөх; 2\ сангаас хөрөнгө оруулалтын арга хэмжээг зөвхөн Үндэсний банкаар дамжуулан хэрэгжүүлэх; 3\ сангийн активын хөрөнгө оруулалтын удирдлагын бүхий л үйл ажиллагаа, тооцоог Казахстан улсын Үндэсний банк үйлдэх. 4\ сангийн актив ба өөрийн хөрөнгийн тооцоог тус тусд нь хийх; 5\ сангийн үйл ажиллагааны зардалд хязгаар тогтоох; 6\ аудитын шалгалтыг жил тутамд заавал хийх; 7\ Казахстан улсын хууль тогтоомжийн дагуу сангийн санхүү, статистикийн тайлан мэдээг тогтмол гаргах; 8\ сангийн активаас хөрөнгө оруулалт хийх санхүүгийн хэрэгслийн жагсаалтыг Казахстан улсын Засгийн газар батлах; 29 дүгээр зүйл. Сангийн эрх үүрэг</div>	

	<p>хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 80%-ийг хассан ялгаврыг орлого орлуулах, хөдөлмөрийн чадвараа алдалтын болон даатгалд хамрагдсан хугацааны тохирох итгэлцүүрээр үржүүлсэн үржвэрээр тодорхойлогдоно.</p>	<p>1. Сан дор дурдсан эрхтэй:</p> <p>1\ нийгмийн заавал даатгалын шимтгэлийг цуглуулах;</p> <p>2\ Засгийн газраас тогтоосон журмын хүрээнд үнэт цаас, бусад санхүүгийн хэрэгсэлтэй холбогдол бүхий үйл ажиллагаа явуулах;</p> <p>3\ сангийн үйл ажиллагааг эрхэлсэний төлөө хувь хүртэх;</p> <p>4\ төвүүдээс хөрөнгийн хөдөлгөөний мэдээлэл авах;</p> <p>5\ нийгмийн даатгалын оролцогчдоос сангийн үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдол бүхий Казахстан улсын хуулиар хориглоогүй мэдээ, мэдээлэл гаргуулж авах;</p> <p>2. Сан дор дурдсан үүрэгтэй:</p> <p>1\Төвүүдийн нийгмийн төлбөрт шаардагдах хөрөнгийг хугацаанд нь шилжүүлэх</p> <p>2\түр хугацаанд чөлөөтэй байгаа сангийн хөрөнгийг Казахстан улсын Үндэсний банкаар дамжуулж санхүүгийн хэрэгсэлд түр хугацаагаар байршуулах;</p> <p>3\жил бүр Аудитын шалгалтад хамрагдах;</p> <p>4\Казахстан улсын хууль тогтоомжид заасан бусад үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>3. Сан дор дурдсан эрх эдлэхгүй:</p> <p>1\ сангийн активыг барьцаанд тавих;</p> <p>2\ хуулийн этгээд үүсгэн байгуулах, энэ хуульд заагаагүй бусад үйл ажиллагаа эрхлэх;</p> <p>30 дугаар зүйл. Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</p> <p>1. Сан нь Казахстан улсын Үндэсний банктэй гэрээ байгуулж, түүгээр дамжуулан сангийн активын хөрөнгийг санхүүгийн хэрэгслүүдэд байршуулах замаар хөрөнгө оруулалтын үйл</p>
--	---	--

			<p>ажиллагаа явуулна.</p> <p>2. Казахстан улсын Үндэсний банк сангийн хөрөнгийн бүрдэлт, сангийн активын байршил, хөрөнгө оруулалтын орлоготой холбоотой бүхий л үйл ажиллагааны тооцоог хийж, данснуудын болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тайланг санд улирал тутам гаргаж өгнө.</p>
--	--	--	---

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР
ХИЙГДСЭН СУДАЛГААНУУДЫН ҮР ДҮН**
/Харьцуулсан мэдээлэл/

*Ц.Товуусүрэн, А.Пагма, Б.Мөнхцэцэг,
Т.Мягмаржав, Б.Ариунжаргал, Б.Хатантуул*

УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагвын захиалгаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн судалгаануудын үр дүнд хийсэн шинжилгээ, харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажлыг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, яам, агентлаг, нийслэл, дүүрэг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудаас гаргасан судалгаа шинжилгээний мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж, бодлогын баримт бичгүүдийг харьцуулан дүн шинжилгээ хийж, цаашид энэ чиглэлийн бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас гаргасан бодлогын баримт бичгийг судлах,
- Судалгааны сэдвээр Засгийн газар, олон улсын байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан судалгааны тайлан, материалд шинжилгээ хийх,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар ТББ-аас хийсэн судалгааны тайлан, материалыг судлах

Судалгааны аргачлал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн судалгааны дүгнэлт, зөвлөмжийн харьцуулалт,
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэх,
- Бичиг баримтын судалгаа

Судалгааны үр дүн:

- Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх асуудалтай холбоотой бодлогын баримт бичиг, тайлан, материалд анализ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн.

Бидний судалгаанд авагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр 2000 оноос хойш хийгдсэн нийт 33 судалгааны ажлаас 16 нь хөдөлмөр эрхлэлтийн талаар, 9 нь ядуурлын талаар, 6 нь ажлын байрыг нэмэгдүүлэх талаар хийгдсэн байна. Эл асуудлаар маш олон судалгааны ажил хийгдсэн бөгөөд “Мэргэжилтэй ажилчин

бэлтгэх асуудлын талаархи мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн байдалд хийх шинжлэл”, “Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь 2004”, “Хөдөлмөрийн зах зээлд тахир дутуу иргэдийн оролцоо”, “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт 2006”, “Цагийн ажлын байрны эрэлтийн судалгаа” зэрэг олон судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмжийн дагуу УИХ, Засгийн газар тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж байна. Бусад судалгааны дүгнэлт, зөвлөмжүүд ч бодлогын баримт бичгүүдэд зохих тусгалаа олсон байна.

Судалгааны дүгнэлт:

1. Судалгааны ажлуудын дүгнэлт, зөвлөмжийг багцлан харахад олонх тохиолдолд тухайн чиглэлээр хөтөлбөр, дэд хөтөлбөр баталж хэрэгжүүлэх, эсвэл зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, эрх зүйн зохицуулалт буй болгох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гарчээ.
2. 1991 оноос хойш хөдөлмөрийн салбарт 9, нийгмийн хамгааллын салбарт 23 бодлогын баримт бичгийг Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар батлан мөрдөж байгаагийн дотор 15 нь хөтөлбөр, дэд хөтөлбөр, 8 нь үндсэн чиглэл байна. Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар хангалттай олон судалгаа шинжилгээний ажлыг холбогдох байгууллагууд, олон улсын байгууллагын төслөөр гүйцэтгэж, олон тооны бодлогын баримт бичиг (хөтөлбөр, төлөвлөгөө, үндсэн чиглэл, үзэл баримтлал, бодлого, стратеги, мастер төлөвлөгөө) баталж хэрэгжүүлсээр атал ядуурал, ажилгүйдэл буурахгүй, зарим талаар өсч байгаад л гол анхаарлаа хандуулах шаардлагатай байна.
3. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээ, түүний мөрөөр хийгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, үндсэн чиглэл, стратеги, үзэл баримтлал, бодлого, мастер төлөвлөгөө хангалттай байгаа ч бодит амьдрал дээр ажилгүйдэл, ядуурал мэдэгдэхүйц буурахгүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийж байгаа ажлын эхлэл нь ажилгүйдэл, ядуурлын өсөлтийн хурдыг гүйцэхгүй байгаа дүр зураг Засгийн газар, яам, агентлаг, олон улсын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллагаас сүүлийн жилүүдэд хийж гүйцэтгэсэн судалгааны дүгнэлтээс тодорхой байна.
4. Эмзэг байдал, ядуурлыг бууруулах аливаа арга хэмжээний богино хугацаанд үзүүлэх нөлөө сул, харин дунд болон урт хугацаанд тогтвортой хэрэгжиж байж үр дүн өгдөг болохыг судалгааны үр дүн харуулж байна.
5. Сүүлийн үед НХХЯ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллага болон Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкны хамтарсан судалгаагаар ядуу амьдралтай хүмүүс (өрх)-ийн дотор ажил эрхэлж байгаа хүмүүс 2007 оны байдлаар 66.2%-ийг эзэлж байгаа нь ажил эрхэлж байгаа хүмүүсийнхээ цалин орлогыг нэмэгдүүлэх дохио болж байна гэж үзэх үндэстэй.

Судалгааны зөвлөмж:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгаалын чиглэл (бусад салбарт мөн адил)-ээр гаргасан бүх бодлогын баримт бичиг (хөтөлбөр, төлөвлөгөө, үзэл баримтлал, бодлого, үндсэн чиглэл, стратеги, мастер төлөвлөгөө)-үүдийг нэгтгэн урт хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөр болгон баталж, харин цаашид хийгдэх судалгааны ажлуудыг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх нь илүү үр дүнтэй болов уу.
2. Ядуурлыг бууруулах бодлогыг эдийн засгийн өсөлттэй нягт уялдуулсан бодлогын стратеги боловсруулж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.
3. Хөдөлмөр зуучлалын байгууллагууд болон бүх төрлийн сургалтын аж ахуйн нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулж иргэдийг хөдөлмөр эрхлэх суурь ур чадвар болон мэргэжлийн чадвар эзэмшүүлэхэд анхаарах нь зүйтэй.

4. Ядуурлыг бууруулах нь ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг хөхүүлэн дэмжих (боломжийн орлоготой байх)-ээс шууд шалтгаалах бөгөөд энэ ажлыг уул уурхайн хэдэн олборлох үйлдвэрээр бүрэн шийдвэрлэх боломжгүй юм. Иймд аялал жуулчлал, үйлчилгээний салбар, жижиг дунд бизнесийг богино хугацаанд дэмжин хөгжүүлж, тэнд ажиллагчдын тоог үлэмж нэмэгдүүлэх нь зөвхөн ядуурлыг бууруулаад зогсохгүй, улс орны эдийн засгийн хөгжил зөвхөн уул уурхайгаас хараат болохоос ч сэргийлэх боломжтойг анхаарах нь чухал юм.
5. Хөдөөнөөс шилжин ирэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор нийслэлийн дагуул гэр хорооллыг бий болгох замаар хөдөө аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэдийн амьдралын туршлагад тулгуурлан өрхийн аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэх боломжтой.
6. Төрийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжээс барьцаа шаардахгүй, зээлийн хүү бага, боломжийн хугацаатай банкны зээлийг олгох нөхцлийг бүрдүүлэх нь энэ асуудлыг шийдвэрлэхэд чухал болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.
7. Төрөөс хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд хандуулж буй анхаарлаа нэмэгдүүлэх чухал юм.

2009 оны сүүлчээр батлагдсан “Зөгийн үүр” хөтөлбөрийн тухайд тусгайлан хэрэгжилтийг нь эрчимтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр гарсан судалгаа, шинжилгээний тойм

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХИ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД	
1.	<p>ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (ЗГ-1994) 1994-2000 Хөтөлбөрийн гол зорилго: Нийгмийн амьдралд шилжилтийн үеийн сөрөг үр дагавар болж гарч ирсэн ядуурлын асуудлыг бодлогын хэмжээнд тодорхойлж, чиглэсэн зорилго зорилт бүхий үйл ажиллагааг явуулах, ядуу хүмүүсийн гутранги сэтгэл зүйг өөрчилж, хийж бүтээснээрээ амьдралаа өөрөө өөд нь татах үзэл бодлыг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, ядуурлын хамралтын хүрээг өргөжүүлэхгүй байх, улмаар ядуурлыг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн анхаарал хүчийг төвлөрүүлэх зорилготой.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилт: Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт дэд бүтцийг хөгжүүлэх замаар ажлын байр түр бий болгох, сургуулийн өмнөх болон суурь боловсролыг дэмжих, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн суурь үйлчилгээг сайжруулах, насанд хүрсэн тахир дутуу иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, тэдний орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд хамруулах болон тахир дутуу хүүхдэд боловсрол олгох зэрэг 12 мянга гаруй жижиг төсөл хэрэгжсэн байна.</p>
2.	<p>ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (ЗГ-2001-108) Хөтөлбөрийн гол зорилго: Хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, нийгмийн зайлшгүй үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар нэн ядуу болон ядуу өрхийг ядуурлаас гаргах, ядуу бус, бага орлоготой өрхийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх.</p> <p>I үе шат: 2001-200 Зон II үе шат: 2004-2006 он</p> <p>Хэрэгжилтийн байдал: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өрхийн үйлдвэрлэлийг дэмжих идэвхитэй бодлого, үйл ажиллагаа нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай ажилгүй иргэдийн өөрсдийнх нь хүсэлтээр төрийн байгууллагын анхан шат болох хорооны оролцоотойгоор ажиллаж амьдрах орчинг бий болгох, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж амьдралын түвшингээ дээшлүүлж хөдөлмөр эрхлүүлэхэд чиглэгдсэн сарын 2 хувийн хүүтэй, 1 жил хүртэл хугацаатай, 1.0 сая хүртэл төгрөгийн зээлийг олгож байна.</p>
3.	<p>ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2001-153/ Хөтөлбөрийн зорилго: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, гарч болзошгүй аюул, осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, үйлдвэрлэлийн орчноос үүсэх таагүй нөлөөллийн шалтгааныг тогтоон арилгах, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч болон ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх</p> <p>2001-2004 он хүртэл</p>
4.	<p>ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2005-75/ Хөтөлбөрийн гол зорилго: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах бүх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтныг мэргэжлийн эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, нийгмийн түншлэлийн механизмыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.</p> <p>I үе шат: 2005-2007 он II үе шат: 2008-2009 он</p> <p>Хэрэгжилтийн байдал: 1-р шатанд: 2005 онд 70%, 2006 онд 86.6%, 2007 онд 90% явцын биелэлт нь 82.2 хувьтай байна. 2-р шатанд: 2008 онд 50.2%, 2009 онд 84.7% явцын биелэлт 63.6 хувьтай байна.</p>

	<p>Хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаархи мэдээлэл (2009 он)</p> <p>Ажлын байрны аттестатчлалын хоёрдахь шатыг 2009 онд барилга, барилга угсралтын үйлдвэр болон уул уурхайн салбарт зохион байгуулав. Аттестатчлалыг зохион байгуулахтай холбогдуулан “Аттестатчлалын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 122 дугаар тогтоол гаргаж, барилга, уул уурхайн салбар хоёрдахь үзлэг, шалгалтыг хийлээ. Тогтоолд тусгагдсан заалтууд нь:</p> <ul style="list-style-type: none"> • Үзлэг, шалгалтын үед илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт, үнэлгээ хийх байгууллагын чадавхийг бэхжүүлэх, • эрүүл, аюулгүй ажлын байр бий болгох, • аттестатчилалд амжилттай сайн дүн үзүүлсэн байгууллага, хамт олны туршлага, санаачлагыг мэдээлэх, сурталчлахад чиглэсэн болно. <p>Барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрүүдэд 2009 оны 4-р сарын 1-ээс 6-р сарын 1-ний хооронд 2 сарын хугацаанд аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид аттестатчлалыг хийсэн байна. Нийт 20 аймаг, 6 дүүргийн 620 байгууллага, 770 цех тасаг, 17910 ажиллагсад хамрагдсан. Уул уурхайн салбарт 2009 оны 8-р сарын 1-ээс 10-р сарын 1-нд мөн 2 сарын хугацаанд зохион байгуулж, 21 аймаг, 8 дүүргийн 402 байгууллага, 772 цех тасаг, 22794 хүн хамрагдав.</p> <p>ХӨНМӨСҮТөөвөс мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн шалтгаан нөхцөлийг сүүлийн 35 жилээр судлан дүгнэлт хийсэн байна.</p> <p>“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг 2009 оны 1-р сарын 14-нд Засгийн газрын 14 дүгээр тогтоолоор батлан мөрдөж байна. Энэ дүрэмд зааснаар үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх орон тооны бус байнгын комисс судлан бүртгэж, сум, дүүргийн комисст мэдээлэх, энэ комисс нь аймаг, нийслэлийн комисст мэдээлэх, улмаар МХЕГазарт ирж нэгтгэгддэг тогтолцоо өнөөдөр мөрдөгдөж байна. 2009 онд үйлдвэрлэлийн осол 366, осолд өртөгсөд 410, нас барагсад 54 байгаа нь өмнөх онтой харьцуулахад буурсан байна.</p> <p>2009 онд 66 аж ахуйн нэгж байгууллагад 20 удаа WISE сургалтыг зохион байгуулж, 529 хүнийг хамруулсан байна. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн Үндэсний хороо 2009 оны 4 дүгээр сарын 2-нд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд байгуулагдан ажиллаж байна.</p>
5.	<p>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2002-92/</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Монгол улсын иргэдийг өөрийн мэргэжил, ур чадварын дагуу хүссэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдан дэмжлэг авах, өөрсдийн боломж, чадавхийг хөгжүүлэх замаар амьжиргаагаа дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийн бодлого болон бүс нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан хөгжүүлэх.</p> <p>2002-2010 он хүртэл</p> <p>Хэрэгжилтийн байдал:</p> <p>Дэлхийн банкны 7,5 сая долларын хөнгөлөлттэй зээл, бусад эх үүсвэрээр “Малын индексжүүлсэн даатгал” төслийг Баянхонгор, Хэнтий, Увс аймгуудад хэрэгжүүлж эхлээд байна. Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаар Үндэсний дээд хэмжээний чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж шилжих хөдөлгөөний сөрөг нөлөөг бууруулах, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, гэр бүлийн хамтын ажиллагааг бүх талаар сайжруулан иргэнд ээлтэй, үндэсний аюулгүй байдлыг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авах нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсныг онцлон тэмдэглээд зөвлөмж гаргасан байна. 2005 онд 53105 ажлын байр шинээр бий болж, 44955 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6510 хүнээр буюу 16.9 пунктээр нэмэгдсэн байна. Ажилгүйдлийн түвшин /ХХҮГ-ын тооцооноор/ 3.3 хувь болов.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2005 онд нийт 3879.6 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлэн жижиг зээл олгох журмын дагуу банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг зээл олгож 2005 онд хөрөнгийн хэмжээ 2480.0 сая төгрөг болж өссөн байна. 1156 иргэн, 39 аж ахуйн нэгжид 206 өрх, 17 малчин өрхүүдийн бүлэгт 1 тэрбум 930.6 сая төгрөгийн зээлийг олгосноор 2689 ажлын байр бий болгожээ. 2005 онд нийт 17877 ажилгүй иргэдийг үүнээс 17408 нь бүртгэлтэй ажилгүйчүүдийг нийтийг хамарсан зохион байгуулалттай ажилд</p>

	<p>хамруулж, түр ажлын байраар хангасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 95.5 хувьтай байна.</p> <p>Хяналт шинжилгээ, үнэлгээ:</p> <p>Хөтөлбөр нь хоёр зорилтын хүрээнд тус бүр 5 үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. 2009 оны хувьд 96,0 хувийн биелэлттэй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2002-2009 оны хугацаанд нийт 64,0 тэрбум төгрөг зарцуулсан байна.</p> <p>I үе шат: 2002 онд 55%, 2003 онд 64%, 2004 онд 68%, 2005 онд 82% -аар биелэсэн байна. Явцын биелэлт нь 67.2% байсан. II шат: 2006 онд 95%, 2007 онд 90%, 2008 онд 84%, 2009 онд 96% хувийн биелэлттэй байсан. Явцын биелэлт нь 70,1 хувь байсан байна.</p>
6.	<p>ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2005-75/</p> <p>Хөтөлбөрийн зорилго: Хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах бүх нөхцлийг бүрдүүлэх, ажилтныг мэргэжлийн эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, нийгмийн түншлэлийн механизмыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.</p> <p>I үе шат: 2005-2007 он II үе шат: 2007-2010 он</p> <p>Хэрэгжилтийн байдал:</p> <p>Хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд хийгдсэн ажлуудыг НХХЯ-аас гаргасан тайланд дэлгэрэнгүй дурьдсан бөгөөд тус хөтөлбөрийн гол үр дүн нь Хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд ажилтны ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхийг эрмэлздэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь сайшаалтай байна. Гэвч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин төдийлөн буурахгүй ялангуяа барилга, уул уурхайн салбарт осол гарч, ажилчид амь насаа алдах явдал гарсаар байна. Үүний гол шалтгаан нь ажил олгогчдын ажлын зохион байгуулалт, ажлын сахилга, дэг журам сул байгаагийн зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэг ажилчдын дунд хангалтгүй, энэ талын зан үйл хэвшил болоогүйтэй холбоотой байна. Иймээс ажил олгогч, ажилтны сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах, осол, аварггүй, эрүүл ажиллах зан үйлийг бүх шатанд төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааг байнга тасралтгүй системтэй явуулах шаардлагатай байгаа болно.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн /ХААЭА/ менежментийг системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэрүүд цөөн бөгөөд эдгээр үйлдвэрүүд дээр ч осол гарсаар байна. Иймээс энэхүү системийг жижиг, дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэх талаар далайцтай ажил зохион байгуулах шаардлагатай. ХААЭА-н асуудал нь салбар дундын цогц зохицуулалт шаардаж байгаа учраас салбар хоорондын уялдааг сайн хангах шаардлагатай байна. Мөн ХААЭА-н хууль тогтоомж, дүрэм журмыг өөрчлөх шинэчлэх ажил нилээд хийгдэж байгаа боловч тэдгээрийг ажил хэрэг болгох талаар эрчимтэй ажиллах явдал дутагдаж байна. Энэ асуудал нь Засгийн газрын зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогын нэг бүрэлдэхүүн хэсэг учраас цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны I үе шат хэрэгжиж дууссан бөгөөд II дах шатны төлөвлөгөөг боловсруулахдаа хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, цаг хугацааны боломжоо бүрэн тооцох шаардлагатай байна.</p> <p>Хөтөлбөрийн үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи ажил олгогч, ажилтны хүлээх үүрэг хариуцлагын эрх зүйн зохицуулалт бий болсон байна. • Хөдөлмөрийн нөхцөл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнийг зохион байгуулах арга хэмжээний санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт бий болж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурсан, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжирсан байна. • Засгийн газар, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, ажил олгогчид болон хөдөлмөрчдийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлого, үйл ажиллагаа уялдсан, тэдгээрийн чиг үүрэг, хариуцлага, эрх хэмжээг тогтоосон удирдлагын нэгдсэн тогтолцоо бий болсон байна. • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийг нэвтрүүлсэн аж ахуйн

	<p>нэгж, байгууллагыг дэмжин туслах хөтөлбөр хэрэгжиж, зохих үр дүнд хүрсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжлийн болон олон нийтийн хяналтыг зохистой хослуулсан хөдөлмөрийн хяналтын үр ашигтай, уян хатан тогтолцоо бүрдсэн байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдолтой статистикийн мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа болон олон нийтийн оролцоонд тулгуурлан гаргадаг болж, статистик мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулан, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааны үндсэн илтгэлийг жил бүр гаргадаг болсон байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдолтой сургалт болон судалгаа, шинжилгээний ажлын эхлэл тавигдсан, судалгааны байгууллагын чадавхи нь бэхжсэн байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажилд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо өргөжиж, сургалтын танхим, мэргэжлийн боловсон хүчний нөөц бий болсон байна. <p>Хөтөлбөрийн хяналт- шинжилгээ, үнэлгээ:</p> <ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр оролцуулж байна. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг санхүүжүүлэгчдэд тайлагнах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
7.	<p>ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР (ЗГ-2005-64)</p> <p>Хөтөлбөрийн гол зорилго: Хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>I үе шат: 2005-2006 он II үе шат: 2007-2008 он III үе шат: 2009-2010 он</p> <p>Хэрэгжилтийн байдал:</p> <p>Нийт шаардагдах зардал 19410.0 сая төг. (Үүнээс 15 000.0 сая төгрөг нь Мянганы сорилтын сан, Японы Засгийн газрын 2 үе шаттай зээл, бусад) Үүнээс гүйцэтгэл 2006, 2007 оны нийт эх үүсвэрээс олгосон зээлийн байдлаар авч үзвэл 249 төсөл хүлээн авснаас 241 төсөл банкинд шилжүүлж, 110 орчим төсөлд 2603.9 сая төгрөгийн зээл олгосон байна.</p> <p>Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны 2005-2006 оны биелэлт 90 хувь, хоёрдугаар үе шатны 2007 оны жилийн төлөвлөгөөний биелэлт нь өссөн дүнгийн дунджаар 70 хувьтай байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдсэн. Жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжих арга хэмжээг сайн хэрэгжүүлж байна. ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох талаар тодорхой ажил хийгдэж байна. Хөтөлбөрт заагдсан дараахь ажлуудын хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Хяналт, шалгалтын тогтолцоог хялбаршуулах, Технологи дамжуулах төв байгуулах, Гаалийн жишиг болон хэлцлийн үнэ бүрдүүлэх нээлттэй механизмийг бий болгоход тарифын зөвлөл, импортлогчдийн оролцоог нэмэгдүүлэх, ... мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих зэрэг арга хэмжээнүүд орж байна. Төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн хуралдаанаас ЖДҮ эрхлэгчдийн зээлийн дэмжлэг хүсэн ирүүлсэн төслүүдийн 96 орчим хувийг банк шилжүүлсэн боловч дөнгөж 45 хувьд зээл олгогдсон байна. <p>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал</p> <ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүй байгаа, ЖДҮ-ийг дэмжих зээлийн эх үүсвэр урт хугацаат хөнгөлөлттэй

	<p>зээлийн асуудлын шийдвэрлэгдэх хугацаа удаашралтай, ЖДҮ-ийн мэдлэг боловсрол, чадвар дутмаг, үйлдвэрлэлийн технологийн мэргэшлийн ажилчны бэлтгэл зэргээс хамаарч уг хөтөлбөрийн зарим арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх хандлага ажиглагдаж байна.</p> <ul style="list-style-type: none"> Олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас Монгол улсын Засгийн газрын шугамаар ирж буй ЖДҮ, бизнесийг дэмжих төслийн зээл"-ийн хүүг нь манай Арилжааны банкаар дамжуулж зээл олгох явцад өсгөхгүй байхад анхаарах. <p>Эдгээрээс гарах арга зам. Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Татварын болон бусад хууль тогтоомжид оруулан баталсан нэмэлт, өөрчлөлт, бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах, хураамжийн ачааллыг багасгах талаар хийгдсэн ажлуудын үр дүнг тогтоосон судалгаа явуулж, танилцуулж байх; ЖДҮ-д олгох зээлийн баталгааны асуудалд анхаарах, зээл олгогч банкуудын зээл олголт, эргэн төлөлтийн байдалд дүгнэлт өгөн, хамтын ажиллагааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Японы 2 үе шаттай зээлийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох талаар арга хэмжээ авах, Хот, орон нутагт байгуулсан бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, ХШ хийж, үнэлгээ өгөх, удирдамж, зөвлөмжөөр хангах, ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх. <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ Энэ хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яамд, банк санхүү, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хоршоод, их дээд сургуулийн хамтын ажиллагааг улам сайжруулах.</p> <p>Хөтөлбөрийн талаархи яамны санал</p> <ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, төлөвлөсөн цаг хугацаатай хамааралтай асуудлыг шуурхай шийдвэрлэх. <p>"Технологи дамжуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төслийг боловсруулан батлуулах асуудлыг шийдвэрлэх, хөрөнгийн асуудал шийдэгдэх хэмжээгээр технологи дамжуулах төв байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим бэрхшээлтэй асуудлыг Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтарч шийдвэрлэх, мөн Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх.</p>
8.	<p>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР /ЗГ-2006-283/ Хөтөлбөрийн зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг нь үнэлж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хамт олон, гэр бүл иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх I үе шат: 2006-2008 он II үе шат: 2009-2012 он</p> <p>Хэрэгжилтийн байдал: Тус хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи нэг жилийн хугацаанд тавьсан зорилтууд нь 16.6 хувийн биелэлттэй байна гэж НХХЯ-аас гаргасан 2007 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын тайланд тусгажээ. Хөтөлбөр 6 жилийн хугацаанд хэрэгжих учраас жилд 16.6 хувийн ахицтай байвал 6 жилийн дараа нийт дүнгээрээ 100 хувийн биелэлттэй байх ёстой. Иймд 2007 оны байдлаар тус хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь байна гэж үзжээ. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хийгдсэн ажлуудыг дурьдвал:</p> <p>Зорилт 1: ХБИ-ийн оролцоог дэмжих, дэд хөтөлбөрүүдийг аймаг орон нутагт Засаг даргын шийдвэрээр бий болгон хэрэгжүүлж байгаа юм байна. Нийгмийн халамжийн сангаас 2007 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарсаны нөхцөлт мөнгөн тэтгэмжинд нийт 6278 иргэн хамрагдаж 924.0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй 538 хүүхдэд 24.6 сая төгрөг тус тус олгожээ.</p> <p>Зорилт 2: "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД-31-101-04-т заасан норм нормативыг шинээр баригдаж буй барилгуудад мөрдүүлэх ажлыг БХБЯ, УМХГ-тай хамтран зохион байгуулж байна.</p> <p>Зорилт 3: Хөдөлмөрийн бэрхшээлийн төрөл, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан тэднийг мэргэжлийн сургалтанд хамруулах, эзэмшсэн мэргэжлээсээ өөр чиглэлээр мэргэших, хос мэргэжил эзэмших, давтан сурахад зориулан ХЭДСангаас дэмжлэг үзүүлж холбогдох</p>

	<p>сургалтуудыг зохион байгуулжээ.</p> <p>Зорилт 4: Сэргээн засалтын үндэсний төвд /СЗҮТ/ 2007 оны хичээлийн жилд үндсэн ангид 104 хөгжлийн бэрхшээлтэй оюутан элсүүлснээс 8 оюутан эрүүл мэндийн байдал болон бусад шалтгаанаар завсардан, нийт 96 оюутан 9 мэргэжилээр 1 жилийн хугацаатай амжилттай суралцан төгсчээ.</p> <p>Зорилт 5: “Тэгш дүүрэн” төслийн хүрээнд нийслэлийн ЕБС, СӨБ, МСҮТ-ийн 80 гаруй багш оролцсон “ХБИ-тэй ажиллах арга зүй” сэдэвт 3 хоногийн сургалт зохион байгуулжээ. СЗҮТ болон ХХҮГ хамтран хүнд болон дунд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй нийт 117 иргэдийн дунд богино хугацааны сургалт явуулж чадамжийн гэрчилгээ олгожээ.</p> <p>Зорилт 6: 2007 онд СЗҮТ-д 1263 хүнд 50.0 сая төгрөгийн протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэсний 34.2 сая нь нийгмийн халамжийн сангаас, 5.7 сая нь НДС-аас тус тус санхүүжүүлсэн. Нийтдээ 1436 ХБИ-г үзлэгт хамруулж, 460 өвчтөн хэвтүүлэн эмчилжээ.</p>
9.	<p>ТӨРӨӨС АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО (УИХ-2006-01)</p> <p>Хөтөлбөрийн гол зорилго: Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн үйлчилгээгээр дамжуулан албан хэлбэрт шилжүүлэх, аливаа эрсдэлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгож, улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>I үе шат: 2006-2008 он II үе шат: 2009-2011 он III үе шат: 2012-2015 он</p> <p>Баримтлах зарчим</p> <ul style="list-style-type: none"> ❖ Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд аливаа дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно. ❖ Хувь хүн, өрх, хамтлагийн аж ахуй эрхлэх эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ. ❖ Албан бус хөдөлмөр эрхлэлтээс албан хэлбэрт шилжих санаачлага, үйл ажиллагааг дэмжинэ. ❖ Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлана. ❖ Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх эдийн засгийн бодлоготой хослуулна. ❖ Албадан болон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, нийгэм, эдийн засгийн талаар ялгаварлан гадуурхах явдлыг устгах зорилттой уялдуулна. ❖ Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг нь тэдний үйл ажиллагааны хэлбэр, бүс нутгийн онцлогоос үл хамааран тэгш, хүртээмжтэй байна. <p>Хэрэгжүүлэх арга зам</p> <ul style="list-style-type: none"> • Албан бус хөдөлмөр эрхлэлтийг макро эдийн засгийн бодлоготой уялдуулж, газрын шинэчлэл, хөрөнгө оруулалт, технологи, татвар, санхүү, зээл, бүртгэл, мэдээллийн бодлогоор дамжуулан зохион байгуулалтад орох боломжийг өргөжүүлнэ. Энэ зорилгоор: • хувь хүн, өрх, хамтлагийн ажил, үйлчилгээ эрхлэх, хөдөлмөрөө оновчтой хорших, үйл ажиллагаагаа албан хэлбэрт шилжүүлэх сонирхлыг газар эзэмших, ашиглах, өмчлөх бодлогоор дэмжих; • зээлийн үйлчилгээний төрлийг өргөжүүлэх, зээл авах боломжийг нэмэгдүүлэх замаар хувь хүн, өрх, хамтлагийн хадгаламж, хуримтлалаа өсгөх сонирхлыг бий болгох; • эд хөрөнгийн болон зээлийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлж, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах; • татварын уян хатан бодлогоор дамжуулан хувь хүн, өрх, хамтлагийн ажил, үйлчилгээгээ албан хэлбэрт шилжүүлэх боломжийг дээшлүүлэх; • нийгмийн даатгалын хувь хэмжээг үе шаттайгаар бууруулах, цалин, хөлсний тогтолцоог боловсронгуй болгох замаар албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх; • албан бус хөдөлмөр эрхлэлтийг үндэсний статистикийн бүртгэл, тооцооны системд хамруулж, мэдээлэл, судалгааг боловсронгуй болгох; • албан бус хөдөлмөр эрхлэгчдийг техник, технологийн дэвшил, хөрөнгө оруулалтаар дэмжиж, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх. <p>Албан бус хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчныг сайжруулан энэхүү хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрлөх эрхийн баталгааг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн хангахад анхаарна. Энэ зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> • хөдөлмөрийн хууль тогтоомжийн хамрах хүрээг өргөжүүлэн, албан бус хөдөлмөр

	<p>эрхлэгчдийг албан хөдөлмөр эрхлэгчдийн нэг адил хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> • албан бус хөдөлмөр эрхлэгчдэд ажил, үйлчилгээний чиглэл болон бизнесийн сонирхлоороо нэгдэх, төлөөллөө бий болгоход нь дэмжлэг үзүүлэх; • хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг, хүртээмжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өргөжүүлж, хөдөлмөрийн харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх; • өндөр эрсдэлтэй ажил, үйлчилгээ эрхэлж байгаа албан бус хөдөлмөр эрхлэгчдийг зохион байгуулалтын оновчтой хэлбэрт оруулах чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх. <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлоготой уялдуулан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ. Энэ зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> • хөдөлмөр эрхлэлтийн олон хэв шинж, бүс нутгийн онцлогт нийцсэн уян хатан бодлого хэрэгжүүлэх; • хөдөлмөр эрхлэлтийн талаархи төсөл, тусламжид ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах • албан бус хөдөлмөр эрхлэгчдэд аж ахуй эрхлэх ур чадвар олгох, түүнийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг сайжруулж, нийгмийн эмзэг хэсгийг түлхүү хамруулах арга хэлбэрийг дэмжих; • албан бус хөдөлмөр эрхлэгчид мэдээлэл, харилцааны технологийг ашиглан зах зээлийн талаархи шинэ мэдлэг олж авах боломжийг бүрдүүлэхэд анхаарах; • бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, зуучлалыг өргөжүүлж, бизнесийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг хөгжүүлэх. <p>Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, ашиг сонирхол, орлогын байдалтай уялдуулан тэдгээрийн нийгмийн хамгааллыг сайжруулна. Энэ зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> • албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөлийг үе шаттай сайжруулахад чиглэсэн менежментийг нэвтрүүлж, энэ чиглэлээр Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техник, арга зүйн дэмжлэг авах; • нийгмийн даатгалын үйлчлэх хүрээ, нэр төрлийг өргөжүүлж, тэдгээрт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулах талаар төсөл боловсруулж хэрэгжүүлэх; • албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын талаархи мэдлэгийг дээшлүүлж, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах; • албан бус хөдөлмөр эрхлэгчдийг олон улсын жишигт нийцсэн нийгмийн хамгааллын сайн дурын бүтэц, бичил сүлжээнд хамруулах талаар гарч байгаа санал, санаачлагыг дэмжих. <p>Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэн албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэхэд нийгмийн түншлэлийн болон олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, тэдний чадавхийг бэхжүүлнэ. Энэ зорилгоор:</p> <ul style="list-style-type: none"> • албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах талаар ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн болон бусад байгууллагаас гаргаж байгаа санаачлагыг дэмжих; • нийгмийн зөвшлийг хангах гурван талт хэлэлцээр, үндэсний хороо, зөвлөл зэрэг хамтын ажиллагааны хэлбэрт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг оролцуулах боломжийг бүрдүүлэх; • албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, тэдгээрт үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авах.
10.	<p>МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО (УИХ-2008-12)</p> <p>Хөтөлбөрийн гол зорилго:</p> <p>Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, гэр бүлийг бэхжүүлэх, хүний амьжиргааны чадамжийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог эрс шинэчлэх үндсэн дээр ядуурлыг бууруулж Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэх бодлого баримтална.</p> <p>I үе шат: 2007-2015 он II үе шат: 2016-2021 он</p> <p>Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого. Нэгдүгээр үе шат 2007-2015 онд:</p> <p>Стратегийн зорилт 1. Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх</p>

эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна:

- эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх зорилтуудтай уялдуулан хоёр жилд нэг удаа шинэчлэн сайжруулж, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх;
- эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3 хувиас ихгүй байлгах;
- өрх, хүн ам, амьжиргааны түвшний талаархи үндэсний хэмжээний мэдээллийн сан байгуулна. Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох.

Хоёрдугаар үе шат 2016-2021 онд:

Стратегийн зорилт-1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгож, ядуурлын түвшинг эрчимтэй бууруулна:

- ядуурлыг бууруулах асуудлаар салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизмыг боловсронгуй болгох;
- ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зориулсан сан байгуулж, хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
- ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг иргэдийн хэрэгцээ, чадавхид тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого.

Хүн амын орлого багатай эмзэг хэсэгт түлхүү хандсан нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ. Нийгмийн хамгаалалд оруулж байгаа хөрөнгө бол хойч үедээ оруулж байгаа хөрөнгө оруулалт гэж үзнэ. Нийгмийн хөгжлийн оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, монгол хүний аж амьдралын чанарыг сайжруулна.

Бүх үе шат 2007-202 онд:

Стратегийн зорилт 1.

Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ:

- нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор хүргэх тогтолцоог бүрдүүлэх;
- хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг хөгжүүлэх.

Стратегийн зорилт 2.

Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, үр чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:

- хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах;
- хөдөлмөрийн гадаад болон дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх замаар гадаадад ажиллах хүч гаргах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;
- хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг сайжруулах, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн бизнес инкубаторыг байгуулан ажиллуулж, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;
- мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хувийн хэвшлийн оролцоог дэмжих замаар бэлтгэгдэж байгаа боловсон хүчний чадавхийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх.

Стратегийн зорилт 3.

Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ:

- эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, өөрийн мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгох санал санаачлагыг хөхүүлэн дэмжих;
- албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх;
- албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, бизнесийн дэмжлэгийг өргөжүүлэх;
- хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, эцэг, эх, гэр бүлийн гишүүдийг нь ажлын байраар хангах зэргээр залуучуудын ажил эрхлэлттэй уялдуулан цогц байдлаар хэрэгжүүлэх.

Стратегийн зорилт 4.

Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно:

- олон давхаргат болон олон сонголтот тэтгэврийн тогтолцоо бүрдүүлэх;
- хуулийн этгээдэд ажиллаж байгаа хүн бүр нийгмийн даатгалд заавал хамрагдах зарчимд шилжих;
- цэргийн албан хаагчдын болон бүх нийтийн тэтгэврийн даатгалын оновчтой бодлогыг хэрэгжүүлж, даатгалын сангийн бүрэн хуримтлалын тогтолцоог бий болгох угтвар нөхцөлийг бүрдүүлэх;
- нийгмийн даатгалын системийг зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн хөгжүүлж, нийгмийн даатгалын сангуудад хөрөнгө бүрдүүлэх механизмыг боловсронгуй болгож, бүрдсэн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг төлөвшүүлэх.

Тайлагнах, хянах тогтолцоо, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх

1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтын жил бүрийн хэрэгжилтийг Засгийн газар дараа жилийн эхний улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд тайлагнана.
2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хяналт тавина.
3. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэн дүгнэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад мониторинг хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх. Хугацаа: 2010.06.30-ны өдөр

II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх. Хугацаа: 2015.06.30-ны өдөр

III үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх. Хугацаа: 2020.06.30-ны өдөр

Хяналт, шинжилгээ, үнэлгээг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна.

11.	<p>ТӨРӨӨС МАЛЧДЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /УИХ-2009-39/ Хөтөлбөрийн зорилго: Малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг, орлогыг нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэх. I үе шат: 2009-2015 он II үе шат: 2016-2020 он</p> <p>Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, шалгуур үзүүлэлт: <i>Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат /2009-2015 он /-нд дараахь үр дүнд хүрнэ.</i></p> <ul style="list-style-type: none"> • малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ; • малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно; • малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг тусалцааг үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ; • мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна; • мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ; • малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ; • эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50 хувиар өснө; • эхний үе шатанд эрүүл мэндийн даатгалд малчдын 70-аас доошгүй хувийг, нийгмийн даатгалд малчдын 50-аас доошгүй хувийг хамруулсан байна. <p><i>Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хоёрдахь үе шат /2016-2020 он/-нд дараахь үр дүнд хүрнэ.</i></p> <ul style="list-style-type: none"> • малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно; • малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна; • хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 80 хувиар өснө. <p>Хэрэгжилтийн байдал: Мал аж ахуйн чиглэлээр малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба 2009 онд 10 аймгийн 244 малчин өрх хөтөлбөрт хамрагдан, малчдын дунд туршлага солилцох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, мал аж ахуйн эрсдэлээс хамгаалах, бизнес инкубацийн үйлчилгээ, нийтийг хамарсан ажилд хамруулах бүлэг зохион байгуулалтанд оруулах, эрүүл мэнд нийгмийн даатгалд хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна. Мөн малчдын хөдөлмөр эрхлэлтийн талаархи нэгдсэн бүртгэл судалгааг хийсэн байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд Архангай, Булган, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Өвөрхангай аймгийн сонгогдсон сумдын 80 малчин өрхийг хамруулсан байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчдад зориулсан мал маллагааны технологийн сургалтын хөтөлбөрийг мал эмнэлэг үржлийн газрын мэргэжилтэнүүдтэй хамтран боловсруулж сургалтын хөтөлбөрийн удирдамжийг боловсруулжээ. Малчдад аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах мэргэшсэн зөвлөхүүдийг Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн бизнесийн хөгжлийн төвүүдэд бэлтгэж, малчдад зориулсан 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт залуу малчин өрхийг илүүтэй дэмжин хөтөлбөрт хамруулж байгаа ба хөтөлбөрт нийт 380.0 сая төгрөг зарцуулсан байна.</p>
12.	<p>ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР <i>/НХХСайд, БСШУСайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа/</i></p> <p>Хөтөлбөрийн зорилго: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын дэд хөтөлбөр” батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрөөр оюутан залуучуудыг ажилд зуучлах, тэднийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөрийн хүмүүжил олгох</p>

	<p>сургалтад хамруулах, ажил хөдөлмөр эрхлэх дадал олгох, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл зөвлөгөө өгөх, цагийн ажилд зуучлах, зэрэг үйл ажиллагаа багтаж байна.</p> <p>Хэрэгжилтийн байдал:</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд 12 мянга гаруй оюутан залуучууд хамрагдаж 4210 оюутан цагийн болон түр ажлын байранд зуучлагдсан байна.</p> <p>Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд цагийн ажлын эрэлтийн судалгаа, ажлын байрны захиалга авч оюутныг ажилд зуучлах, вэб сайт ажиллуулах, нийтийг хамарсан ажилд хамруулах, бүтээлийн бирж ажиллуулах, төгсөгчдийн хөдөлмөрийн яармаг зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 5 их дээд сургуулийн дэргэд “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулсан. Оюутны цагийн хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд 12160 оюутан бүртгэгдэж, 4210 оюутан цагийн ажлын байранд зуучлагдсан байна. Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд нийт 224,2 сая төгрөг зарцуулсан байна.</p>
13.	<p>УУЛ УУРХАЙ, ЗАМ БАРИЛГЫН САЛБАРТ МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧИН БЭЛТГЭХ ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭЭРХИ СУРГАЛТЫН ТУРШИЛТЫН ДЭД ХӨТӨЛБӨР <i>/НХХСайд, ЗТБХБСайд, ЭБЭХСайдын хамтарсан тушаалаар/</i></p> <p>Хөтөлбөрийн гол зорилго:</p> <p>Шинэ техник технологийг ажлын байран дээрхи сургалтаар эзэмшүүлэх, мэргэжлийн сургалтаар бэлтгэх боломжгүй шинэ мэргэжлээр ажилчдыг дагалдуулан сургахад чиглэгдсэн ба сургалтын дараа суралцагчдыг ажлын байраар хангах нөхцлийг ажил олгогчид бүрдүүлэх</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилт:</p> <p>Хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын 87% нь сургалтын дараа тухайн аж ахуйн нэгж болон бусад байгууллагад тогтвортой ажлын байраар хангагдаж ажиллаж байна. Сургалтад хамрагдсан иргэдийн 90 хувь нь мэргэжлийн ур чадварын шалгалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх, зэргийг авсан байна. 2009 онд дэд хөтөлбөрийн хүрээнд 93 аж ахуй нэгжид 3536 хүн сургасан байна. Үүнд: Барилгын 68 аж ахуй нэгжид 2407 хүн сургаж 1077.5 сая төгрөг, замын 14 аж ахуй нэгжид 560 хүн сургаж 269.0 сая төгрөг, уул уурхайн 11 аж ахуй нэгжид 569 хүн сургаж 318.9 сая төгрөгийг нийт 1665,4 сая төгрөг зарцуулсан байна.</p>
14.	<p>“ЗӨГИЙН ҮҮР” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР</p> <p>Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороон даргын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 119 дугаар тушаал</p> <p>Хөтөлбөрийн гол зорилго:</p> <p>Хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч буй өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэдийг эх орондоо буцаж ирж ажиллах болон хилийн чанадаас мэдлэг, туршлага, боломжоо улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглүүлэн ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, бүх шатанд нийгмийн түншлэлийн механизмыг бүрдүүлж, хамтран ажиллах нөхцөл бий болгох.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилт:</p> <p>“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гадаадад хөдөлмөр эрхлээд буцаж ирж байгаа иргэдэд чиглэсэн төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, тэд буцаж ирэхдээ тоног төхөөрөмж авчрах тохиолдолд гаалийн татвараас хөнгөлж, чөлөөлөх тухай зэрэг заалтуудыг тусгаад байна.</p> <p>Хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн мэдлэг, туршлага, боломжийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд ашиглах, тэдгээрийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулахад чиглэсэн хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан 2009 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ажлын хэсгийн анхдугаар хурлыг зохион байгуулсан байна.</p>
<p>ЗАСГИЙН ГАЗАР, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААС ХИЙСЭН СУДАЛГАА</p>	
15.	<p>МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУ-ын Засгийн Газар, НҮБХХ. 2000 он</p> <p>Зорилго: Нийгмийн үйлчилгээний олон асуудлууд шилжилтийн үед ямар хүндрэл бэрхшээлтэй тулгарч, одоо ямар түвшинд байгаа, цаашид шийдвэрлэх арга замын талаар.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>1998 онд явуулсан АТТС (ажилгүйдлийн түвшний түүвэр судалгаа)-аар ажилгүйдлийн түвшин</p>

	<p>19% гэж гарсан нь хөдөөд 12%, хот сууринд 30% тус тус болж байжээ. Үйлдвэрийн газрууд хаагдсан, хөдөө орон нутгаас хүмүүс шилжин суурьших явдал ихэссэнээс шалтгаалан хот суурин газарт ядуурал хамгийн их байна.</p> <p>Зах зээлийн эдийн засагт шаардагдах ур чадварыг олгоход чиглэсэн боловсрол /мэргэжлийн сургалтын салбарт цаашид өөрчлөлт хийж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.</p>
16.	<p>АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУ-ын Засгийн Газар, НҮБХХ. 2002-2003 он</p> <p>Зорилго: АХС-г ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг судлах зорилго тавьсан байна.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>2002-2003 оны 4 улирлыг хамруулан хоёр шатлалт, санамсаргүй түүврийн аргыг ашиглаж Улаанбаатар хот болон 4 бүс нутгаар (хот, хөдөөгөөр) бүлэглэлт хийж, нийт 9 бүлгээр үр дүнг тооцжээ.</p>
17.	<p>ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ДАХЬ ХАНДИВЛАГЧДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН ЖЕНДЕРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Санхүү, эдийн засгийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Жендерийн мэдрэмжтэй төсөв боловсруулах чадавхийг бэхжүүлэх төсөл. 2004 он</p> <p>Зорилго: Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар дахь хандивлагчдын зээл, тусламжийн зарцуулалтад хийсэн жендерийн дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Ядуурлыг бууруулах талаар Сүүлийн жилүүдэд эдийн засгийн байдал тогтворжиж, зарим өсөлт гарч, улмаар ядуурлыг бууруулах нөхцлийг бүрдүүлж байгаа хэдий ч ядуурал буураагүй, энэ талаар авч буй арга хэмжээ мэдэгдэхүйц үр дүн өгөхгүй байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Монгол улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр боловч эрэгтэйчүүдийн хэмжээнээс нэлээд доогуур байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд НХХЯ-ны харьяалалд бүгд байхгүй байгаагаас үр дүнг нэгтгэн тооцох, судалгаа явуулах, дүгнэлт гаргахад бэрхшээлтэй байгаа тул зээл, тусламжийн төслийг тухайн асуудал хариуцсан яам нь хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг ч тэр яам хариуцдаг байх.</p>
18.	<p>МАЛЖУУЛАЛТААР МАЛЧИН ӨРХҮҮДИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, АМЬЖИРГААГ БАТАЛГААЖУУЛАХ СТРАТЕГИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ НЬ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУ-ын ЗГ, UNDP, Санхүү эдийн засгийн яам ядуурлын судалгааны нэгж (НҮБ-ын ХХ/ШОУХА “Ядуурлын Судалгаа, Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих”, МОН(01) Ю01 төсөл. 2004 он</p> <p>Зорилго: Сүүлийн жилүүдэд дараалан болсон ган, зуд болон нийгмийн бусад олон хүчин зүйлүүдээс шалтгаалж малгүй болсон малчин өрхүүдийг малжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг судлаж, цаашид тэдний амьдралыг дээшлүүлэх арга зам, малжуулах арга, хэлбэрийг тодорхойлсон зөвлөмж гаргах.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар. Малжуулалтын үр дүнд ядуу малчин өрхийн малын тоо, бүтээмж, өрхийн орлого, хэрэглээ, хөрөнгө нэмэгдэж, цөөн малтай өрхийн тоог бууруулж, ядуурлыг арилгахад нөлөөлсөн тул Монголд явуулсан малжуулах арга хэмжээ нь малчдын амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн чухал арга хэмжээ болжээ. Гэвч өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн малжуулах арга хэмжээнүүд нь зохион байгуулсан арга хэлбэр, хугацаа, малчин өрхийн сонголт зэрэг менежментийн алдаанаас болж, олон тохиолдолд хүлээсэн үр дүнд хүрээгүй байна. Малжуулах арга хэмжээг боловсронгуй болгохын тулд малжуулах өрхийг зөв сонгон шалгаруулах, өрхийн хэрэгцээг харгалзан өгөх малын тоог оновчтой тогтоох, сайн чанарын буюу өндөр ашиг шимийн малаар малжуулах зэрэг асуудлуудад илүү анхаарал тавих хэрэгтэй байжээ.</p> <p>Малчин өрхийн Амьжиргааг дээшлүүлэхэд өрхийн туслах аж ахуй хөгжүүлэх, малчдын хөдөлмөр, хөрөнгийг хорших замаар хагас эрчимжсэн мал аж ахуй, өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж олгохуйц санхүү, эрх зүйн нөхцлийг бүрдүүлж өгөх нь чухал байна.</p> <p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар Малжуулах стратегийг хэрэгжүүлэхдээ бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн амьжиргааны болон орон нутгийн өвөрмөц онцлогуудыг зайлшгүй харгалзан иж бүрэн хандах, төслийн хэрэгжилт, үр дүнд нь байнга хяналт тавих замаар нийтэд хүртээмжтэй болгох зарчмыг мөрдөх нь зүйтэй.</p> <p>Малжуулалтаар малчин өрхийн амьжиргааг сайжруулахад малжуулалттай зэрэгцүүлэн дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:</p>

	<ul style="list-style-type: none"> • ядуу малчин өрхийг малжуулахдаа бэлчээр, худаг, усаар хангагдах боломж олгох, • эрсдэлээс хамгаалах, даван туулах тогтолцоог бүрдүүлэх, • малын чанарыг сайжруулж, өндөр ашиг шимтэй, шилмэл малаар малжуулах, • малчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах, • өрхийн нэмэлт орлогын эх үүсвэртэй болгох.
19.	<p>АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Монгол Улсын Үндэсний Аудитын Газар УИХ-ын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан. 2006 он</p> <p>Зорилго: Ажиллах хүч гадаадад гаргаж буй байдал, Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй байдал, Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг хэрэгжүүлж буй байдал, НХХЯ, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газар ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх, үүргээ хэрэгжүүлж ажилласан байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Засгийн газар гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоохдоо өөрийн орны ажилгүйдлийн түвшинг харгалзан аль улсын хичнээн иргэнийг авч ажиллуулах шаардлагыг нарийн судалж, тооцоолохгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох • Гадаадын иргэдэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох ажилд тавих дотоод хяналтыг сайжруулах • Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч буй ААНБ-ын нийт ажиллагсдын тоог тогтоохдоо нийгмийн даатгалын байгууллагатай хамтарч ажиллах • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиудын зөрчилтэй заалтуудыг нэг мөр болгох асуудлыг боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
20.	<p>МОНГОЛЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2007 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЯДУУРАЛ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУ-ын Засгийн Газар, UNDP, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO), Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг (SIDA) 2007 он</p> <p>Зорилго: Хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлыг хэрхэн бууруулж болох тухай.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Төр засгийн бодлого оновчтой байх явдал маш чухал. Төрийн аливаа бодлого, хөтөлбөр дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд багагүй хэмжээний нөлөө үзүүлж, улмаар зохистой ажил хөдөлмөр эрхлэх, хүний хөгжлийг эрчимжүүлэх боломж бүрдэхэд нөлөөлнө.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг тойрсон бодлогын 14 зөвлөмжүүдийг нэгтгэн гаргасан байна.</p> <p>1. Хөдөлмөр эрхлэлтийн тухай стратегийг Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын нэг гол бүрэлдэхүүн хэсэг болгох талаар</p> <ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүд, залуучуудыг оролцуулан иргэн бүрийг бүтээмж өндөр, зохистой бүрэн хөдөлмөр эрхлэлтээр хангах тухай Үндэсний хөгжлийн бодлого, стратегид тусган, улмаар ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэрэгсэл болгох, • Илүү олон, зохистой ажлын байр, ялангуяа ядуу хүмүүс амьдарч буй газар, нутагт бий болгох, мөн шинээр бий болсон ажлын байранд нийцэхүйц мэдлэг, чадварыг Монголын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд адил тэгшээр олгоход чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн тухай Үндэсний стратеги боловсруулах, • Макро эдийн засгийн болон салбарын бодлого, хөтөлбөрүүд ажлын байр илүү олноор бий болгоход чиглэсэн байхыг баталгаажуулах шаардлагатай. <p>2. Хүний хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар</p> <p>3. Хөдөлмөрийн зах зээл дэхь ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүүг арилгах талаар</p> <p>4. Архидалтыг багасгах талаар</p> <p>5. Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийг боловсронгуй болгох талаар</p> <p>6. Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар</p> <p>7. Уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих бусад салбарын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх талаар</p> <p>8. Хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сумдын эдийн засгийг сэргээн</p>

	<p>бэжжүүлэх талаар</p> <p>9. Албан бус салбарыг албан болгох талаар</p> <p>10. Залуучуудад зориулсан зохистой, бүтээмжтэй ажил эрхлэлтийг дэмжих талаар</p> <p>11. Хөдөлмөрийн зах зээлийн жөндөрийн тэгш бус байдлыг халах талаар</p> <p>12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох бололцоог өргөжүүлэх талаар</p> <p>13. Шилжих хөдөлгөөнд оролцогчдын хөдөлмөр эрхлэх бололцоог өргөжүүлэх, тэднийг хамгаалах талаар</p> <p>14. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах талаар</p>
21.	<p>МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ МОНГОЛД</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Монгол Улсын Сангийн яам. 2007 он</p> <p>Зорилго: Ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын эзлэх хувийг 2015 он гэхэд 2 дахин бууруулах.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Ядуурлын түвшин хот, суурин газартай харьцуулахад хөдөөд илүү байна, хөдөөгийн хүн ам зах зээлээс алдагдсаны зэрэгцээ дэд бүтэц хөгжөөгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарагдмал, ажлын байр хомс, мэдээлэл түргэн шуурхай хүртэх боломж сул байгаа нь тэдний амьдралын түвшин доройтоход нөлөөлж байна, байгал цаг уурын нөлөөллөөс аж ахуй, амьдралын хэв маяг шууд хараат байгаа нь хөдөөгийн хөгжлийн гол хүндрэл болж байгаа. Хотын ядуурлын хэмжээ 2003-2006 онд 30.3 хувиас 27.0, хөдөөгийн ядуурал 43.4 хувиас 37 хувь хүртэл буурчээ. Улаанбаатар хотын хүн амын тавны нэг орчим нь ядуу байна.</p> <p>Шинээр ажлын байр бий болгох, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, нийгмийн эмзэг бүлэг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөөгийн хөдөлмөр эрхлэлтийг хэрэгжүүлэх, ажиллах хүч гадаадад гаргах мөн гадаадаас авах мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, гадаадад ажиллаж байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээг иргэдэд хүргэх, мөн ядуурлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүдийн уялдааг хангах.</p>
22.	<p>45-ААС ДЭЭШ НАСНЫ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар. 2008 он</p> <p>Зорилго: Судалгааг ахимаг насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ОУХБ болон бусад оронд хийсэн судалгаануудын аргачлал, туршлага, арга зүйн хандлагыг харгалзан үзэж, түүнийг Монгол Улсын 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, баримт бичиг, бодлого, хөтөлбөр боловсруулах тулгуур материал байдлаар боловсруулах зорилго тавьсан.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Иргэдийг ажилд хөлсөлж авах, сонгох, үнээх, сургаж хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, цалин хөлс тогтоох, ажлаас халах талаар шийдвэр гаргах үед нас болон настай холбогдох шалгуур хэрэглэхээс аль болох зайлсхийх;</p> <p>Насны ямар нэг бүлэгт хамаарах хүмүүс, ажиллагчид үнэхээр ялгаварлан гадуурхагдаж байгаа эсэх талаар үр өгөөжтэй, байнгын хяналт, үнэлгээ хийж байх;</p> <p>Хөдөлмөр, боловсрол, сургалтын хүрээнд, ялангуяа ажилд орох, сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэх үед ялгаварлан гадуурхагдаж буй холбогдох насны хүмүүсийг дэмжих үйл ажиллагаа явуулах.</p> <p>Ажлын байрны тодорхойлолт, заавар, бусад баримт бичгийг “насаар шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхах” зүйл, заалтгүй болгох;</p> <p>Цалин хөлс, шагнал урамшууллын дүрэм, журам дахь насаар ялгасан, ангилсан зүйл, заалтуудыг арилгах;</p> <p>Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан зохицуулах комиссийг байгуулах, маргаан зохицуулах дэгийг хамтын болон дэг журам тогтоосон гэрээгээр тогтоох.</p>
23.	<p>АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа:</p> <p>Үндэсний статистикийн хороо 2006 оны 7 дугаар сараас эхлэн “Ажиллах хүчний судалгаа”-г тогтмол явуулж байна.</p> <p>Зорилго: Хүн амын ажил эрхлэлтийн байдлыг тодорхойлон, хөдөлмөр эрхлэлт,</p>

	<p>ажилгүйдлийн холбогдолтой үзүүлэлтүүдийг бүс нутаг, хот, хөдөө, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, ажил эрхлэлтийн байдлаар улирлын нөлөөллийг тусган тооцох.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Олон улсын нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн, сүүлийн 12 сараар буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцдог байна.</p>
24.	<p>МОНГОЛ УЛС ДАХЬ ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ (Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүн)</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУ-ын ҮСХ, Дэлхийн банк. 2007 оны 7 сараас эхлүүлсэн. 2009 он</p> <p>Зорилго: Сүүлийн таван жилд ядуурлын байдал хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг харах, хүн амын өнөөгийн амьжиргааны түвшинг үнэлэх, ядуурлыг бууруулах цаашдын үйл ажиллагаанд тулгарах сорилтуудын талаар бодлого боловсруулагчдад мэдээлэл өгөх.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Ядуурлын өнөөгийн түвшин болон сүүлийн таван жилд гарсан өөрчлөлтүүдийг, хүн амын хэрэглээний хэв шинжийг шалган үзэж ядуурал нь өрхийн тэргүүний шинж байдал, өрхийн эзэмшиж буй хөрөнгө, амьдарч буй сууцны төрөл, болон хүн амын авч буй нийгмийн хамгаалалтай хэрхэн холбогдож буйг харуулж ядуурлын дүр төрхийг дэлгэрэнгүйгээр харуулсан байна.</p> <p>Ажил эрхэлж байгаа мөртлөө ядуу амьдралтай хүмүүс, гэр бүлийн нийт ядуучуудад эзлэх хувийн жин 60 гаруй %-тай байгааг анхаарах.</p>
25.	<p>ЖЕНДЕРИЙН АСУУДАЛ МОНГОЛ УЛСАД</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны тайлан. 2004 он</p> <p>Зорилго: Ядуурлын үр нөлөө эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөрөөр тусдаг гэдгийг даяарчлал улам ойлгуулж байгаа ба нийгэм, эдийн засгийн хөгжлийн олон салбарт байгаа жендерийн зөрүү нь ядуурлыг бууруулах хүчин чармайлтыг сулруулахад хүргэдэг байна. Бодлогын хэрэгжилтийн үр нөлөөний жендерийн зөрүүг багасгаснаар эдийн засгийн өсөлтийг төдийгүй эрх тэгш байх зорилтыг хангах.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Тодорхой зорилтот бүлэгтэй, жендерийн мэдрэмжтэй хөтөлбөр.</p> <ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүдийн цагийн хомсдолоос үүдсэн ядуурал • Хөдөлмөрийн зах зээл дэх жендер дээр суурилсан гажуудал • Албан бус хэвшил дэх эмэгтэйчүүдийн бүтээмжийг дээшлүүлэх, • Эмэгтэйчүүдийн өөрсөддөө туслах байгууллага байгуулах, • Нийгмийн хамгааллын шинэчлэлийг жендерийн мэдрэмжтэй болгох, • Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, • Жендерийн тэгш байдлыг сайжруулах талаар хуримтлуулсан туршлагаа солилцох
26.	<p>ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, Хүүхдийн Хөдөлмөрийг устгах ОУБ. 2006 он</p> <p>Зорилго: Улаанбаатар хот болон сонгосон аймгийн төв, сумдын албан бус хэвшилд хөдөлмөр эрхлэж буй хүүхдийн тоо, тэдний эрхлэж буй хөдөлмөрийн шинж байдал, боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгааг цогц байдлаар судлан судалгааны үндсэн дээр бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль сахиулах • Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, орлогыг тогтворжуулах, • Иргэдийн хандлагыг өөрчлөх, ойлголтыг нэмэгдүүлэх, • Боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх.
27.	<p>МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БҮТЭЦ ДЭХ ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА</p> <p>Ажиллах хүчний оролцооны түвшин судалгаа (тухайн насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр) 2006-2007 он</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Үндэсний Статистикийн газар, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны тоо баримт, мэдээллийг ашигласан.</p>

45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага болон олон улсын бусад байгууллагуудаас гаргасан шийдвэр, чиглэл, зөвлөмж зэрэг албан ёсны баримт бичгүүдэд тулгуурлан харьцуулалт, тойм судалгаа, шинжилгээ

Зорилго: Энэхүү судалгаанд “45-аас дээш насны иргэд”-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг судалсан. Олон улсын түвшинд ахимаг насны ажиллагчид (“Older workers”) гэсэн нэр томъёо хэрэглэгддэг бөгөөд үүнд хамруулах насны хязгаар улс орон бүрт өөр өөр онцлогтой байдаг байна. Ахимаг насны ажиллагсдад хамруулах насны дээд хязгаар нь тухайн улсын ажиллагсдын өндөр насны тэтгэвэрт гарах нас байдаг бол доод хязгаар нь 40, 45, 50, 55 гэх мэт янз бүр байдаг байна.

45-аас дээш нас монгол хүний хувьд хөдөлмөрийн идэвхитэй үе боловч тэд хөдөлмөр эрхлэх үедээ ноцтой бэрхшээлтэй тулгарсаар байна. Хэдийгээр 45 ба түүнээс дээш насныхны ажилгүйдлийн түвшин бусад насны бүлгийнхнээс доогуур байгаа бөгөөд жилээс жилд буурч байна. Энэ судалгаанд ахимаг насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ОУХБ болон бусад оронд хийсэн судалгаануудын аргачлал, туршлага, арга зүйн хандлагыг харгалзан үзэж, түүнийг Монгол Улсын 45-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, баримт бичиг, бодлого, хөтөлбөр боловсруулах тулгуур материал байдлаар боловсруулах зорилго тавьсан болно.

Дүгнэлт, зөвлөмж:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

- Нас ахисан ажиллагсдад зориулсан таван жилийн хугацаатай Үндэсний Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг Финландын туршлага;
- Герман, Дани, Нидерланд, Ирландын ажил олгогчдын нийгэмлэгүүдийн хамтарсан “Ахимаг нас” хэмээх төсөл;
- Насан туршийн мэргэжлийн сургалтыг дэмжих зорилготой Германы Засгийн газар ажил олгогчдын байгууллагууд болон үйлдвэрчний эвлэлүүдийн “Ажлын байрны төлөө Эвсэл”;
- Японы гурван “багана”-т бодлого, хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах буюу Тэйнэн хууль (Бүтэн нэр нь “Ахимаг насны хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах тухай хууль”), Хүний Мөнгөн Нөөцийн Төвүүд (Silver Human Resources Centers);
- Нидерландын “тэтгэврийн өмнөх” тогтолцоо, ажил олгогчдын нийгэмлэгүүд, үйлдвэрчний эвлэлүүд, хүн амын цөөнхийн бүлэг, ахмадын байгууллагын төлөөлөгчид, судлаачид, парламентын гишүүд, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид орсон “Ахимаг насны ажиллагчдын асуудлыг шийдвэрлэх бүлэг”, Нидерландын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбооны “Getting Older While Working” хэмээх илтгэл;
- Их Британийн “Хялбар дөхөм, Аюулгүй байдал, Сонголт: Өндөр насны тэтгэвэрт гарахын тулд ажиллаж хадгалах нь” хэмээх баримт бичиг (“Ногоон ном”), Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомж-2006;
- АНУ-ын Хөдөлмөр эрхлэлт дэх Насаар Ялгаварлан гадуурхалтын тухай хууль (Age Discrimination in Employment Act - ADEA), Хөдөлмөр Эрхлэлтийн Адил Тэгш Боломжийн Комисс, Ахимаг насныхны Үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн Хөтөлбөр (Senior Community Service Employment Program-“SCSEP”), Ахимаг Насны Ажиллагчдын Байгаль Орчныг Хамгаалах Хөдөлмөр Эрхлэлтийн Хөтөлбөр, АНУ-ын Хөдөлмөрийн яамны 21 дүгээр зууны ажиллах хүчний Газар (Office of the 21st Century Work Force).

28. ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА ТӨСӨЛ

Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Дэлхийн банк. **2007 он**

Зорилго: Сүүлийн үеийн өрхийн судалгаагаар 2002 онд ядуурал 36 хувь болж 1998 онд 43 хувь байснаас буурчээ. Энэ хандлага 2002 оноос хойш үргэлжлэх буюу 2055 онд ядуурлын хэмжээ 32 хувь болох магадлалтай бөгөөд хөдөөд ядуурлын илрэл илүү их буюу 43 хувь (хотод 30 хувь) байна. Нүүдлийн малчин өрхүүд ядуучуудын дийлэнхийг эзэлж байгаа төдийгүй боловсролын түвшин бага байна.


Дүгнэлт, зөвлөмж:

Төсвийн төвлөрлийг сааруулахыг дэмжсэн бүтцийн өөрчлөлтүүд нь цаг хугацаа болон төр, засгийн бүх түвшний дэмжлэг чармайлт их шаардана. Төслийн хүрээнд санхүүгийн үйлчилгээ ерөнхийдөө өргөжсөн хэдий ч зээл авах боломж хүн амын зарим хэсгийн хувьд хязгаарлагдмал байна.

29.	<p>МОНГОЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, ЗАЛУУЧУУДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ОЙЛГОХУЙ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ). 2009 он НҮБ-ын Хүүхдийн сан /НҮБХС/, Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлж буй Хүүхдийн хөдөлмөрийг ойлгохуй сэдэвт хөтөлбөрийн тайлан 2009 оны 12 дугаар сар Б.Дарьханд-НҮБХС-ийн Хүүхэд хамгааллын мэргэжилтэн, Н.Монголмаа-ОУХБ-ын Үндсэний хөтөлбөрийн зохицуулагч, Ж.Азжаргал-Хөтөлбөрийн ажилтан. Зорилго: Хөдөө орон нутагт хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг өөрчлөхийн тулд энэ салбарыг зөвхөн малчин айл өрхийн амьдралыг залгуулах хэмжээнд биш илүү ашиг орлоготой үйлдвэрлэл болгон хөгжүүлэхэд улс төрийн болон эдийн засгийн дэмжлэг шаардлагатайг харуулахад оршино. Дүгнэлт, зөвлөмж: Тайланд дурьдсанаар 2006 оны байдлаар Монголд 7-14 насны 36000 хүүхэд хөдөлмөр эрхэлж байсан. Энэ нь мөн насны нийт хүүхдийн 10 хувьтай тэнцэж байгаа юм. 2002-2003 онд энэ үзүүлэлт 7 хувьтай байжээ. Хөдөлмөр эрхэлж буй 5-14 насны хүүхдүүдийн 90 гаруй хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 5 орчим хувь нь үйлчилгээний салбарт, 1 хүрэхгүй хувь нь үйлдвэрлэл дээр ажиллаж байна.</p>
30.	<p>ХҮН АМЫН ТООЛЛОГЫН ТОО МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр НҮБХХ, Үндэсний Статистикийн Хороо ҮСХ. 2009 он Зорилго: Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, 2002/2003 оны амжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг ашиглан хийсэн ядуурлын зураглалын гол үр дүнг үзүүлэх, ядуурлын үзүүлэлтүүдийг тухайн улсын засаг захиргааны буюу суурьшлын хамгийн доод боломжит түвшинд тооцож болох бөгөөд монгол улсын тухайд аймаг, сумын түвшинд тооцох. Дүгнэлт, зөвлөмж: Ядуурлын үзүүлэлтүүдийн тооцооны найдвартай байдлыг хамгийн дээд түвшинд байлгах үүднээс амжиргааны түвшин судалгааны тоо мэдээллийн төлөөлөх чадвар сайн байх засаг захиргааны буюу суурьшлийн хамгийн доод түвшинд загварчлал ашигласан бөгөөд түүвэрлэлтийн загвартаа Улаанбаатар, Аймгийн төв, Сумын төв, хөдөө гэсэн суурьшлын дөрвөн шатлалтай, өрхийн түвшингийн зарлагын загварыг амжиргааны түвшний судалгаа, хүн ам, орон сууцны тооллогын аль алинд нь байгаа ижил үзүүлэлтүүдийг ашиглан суурьшлийн шатлал бүрээр хийгдсэн.</p>
31.	<p>МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ӨСГӨХТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНТАЙ АСУУДЛУУД Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO). 2010 он Зорилго: Монгол Улсын эдийн засгийн хөгжилд судалгаа дүгнэлт хийж хөдөлмөр эрхлэлтийн тоог өсгөх. Дүгнэлт, зөвлөмж: Макро эдийн засгийн бодлого, Аж ахуй нэгж болон аж ахуй эрхлэгч нарт тогтсон нийтлэг хэв маяг, дүрэм журам Эдийн засагт оролцогчдийн ерөнхий орчин Шаардлага хангасан боловсрол мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн хомсдол зэрэг нь хөдөлмөр эрхлэлтийн тоог нэмэхэд хүндрэлтэй байна.</p>
32.	<p>УЛААНБААТАР ХОТЫН ЯДУУРАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Санхүү, эдийн засгийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн ам сургалт, судалгааны төв. 2004 он Зорилго: Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшинг орлого, хэрэглээнд үндэслэн тооцож, ядуурал, шилжих хөдөлгөөний асуудлыг цогц байдлаар судлах. Дүгнэлт, зөвлөмж: <ul style="list-style-type: none"> Шилжин ирэгчдийн дийлэнх нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, суралцах болон зах зээлд ойртох зорилгоор шилжин иржээ. Шилжин ирсний дараа ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх болон зах зээлд ойртох гэсэн зорилгууд нь биелж байгаа боловч боловсролын байдалд нь ахиц гарсангүй. Шилжигчид нь шилжих хөдөлгөөнд оролцсон учраас ядуу байгаа биш, тухайлбал, боловсролын түвшин доогуур байгаагаас ядууралд өртөж байна. </p>

	<ul style="list-style-type: none"> Шилжигчид шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай адил боломжтой нь харагдаж байгаа бөгөөд тэдний гол бэрхшээл нь мэргэжил, боловсролын байдлаараа шилжигч бус хүн амынхаас бага зэрэг дутмаг байгаа явдал юм. Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засгийн байдал болон боловсролын чанарыг сайжруулах асуудал хамгийн чухал юм. <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар</p> <ul style="list-style-type: none"> Анхаарал хандуулах зорилтот бүлэг нь өрхийн олон гишүүдтэй гэр хорооллын өрхүүд байна. Мөн өрхийн тэргүүлэгч нь бүрэн бус дунд боловсролтой өрхүүдэд анхаарах нь зүйтэй. Засгийн газраас гэр хороололд амьдарч буй хүн амд зориулан “нэг өрөө сууц”-ны барилга бариулах ажлыг зохион байгуулж болох юм. Хүн амын орлогын түвшинг дээшлүүлэх үндсэн хөшүүрэг бол ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх явдал юм. Үүнтэй холбоотойгоор нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг гэр хороололд оршин суугчдад түлхүү хандуулах, ялангуяа, албан бус секторыг зүй зохистой зохион байгуулах нь зүйтэй. Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн хөдөлгөөн, ухуулга сурталчилгааны ажлыг өрнүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд хөдөө, орон нутгийн амьдралын нөхцлийг сайжруулах, амьдрах сонирхлыг татах хөдөөгийн хөгжлийн нарийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
33.	<p>ДУНД ОРЛОГОТОЙ ХҮМҮҮСИЙГ ЭМЗЭГ БҮЛГИЙН ЭГНЭЭНД ОРОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Санхүү, эдийн засгийн яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл. 2004 он</p> <p>Зорилго: Хүн амын дунд орлоготой хэсгийг өнөөгийн нөхцөл байдал, эмзэг байдалд орж болзошгүй нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замууд, хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлыг судалж, бодлогын зөвлөмж боловсруулах.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Судалгаанаас үзэхэд өнөөгийн дунд орлоготны эмзэг хэсэгт Улаанбаатар хотод:</p> <ul style="list-style-type: none"> Социализмын үед үйлдвэрлэл, ажил мэргэжил, амьдралын тодорхой туршлага хуримтлуулсан, зохих түвшиний мэргэжил, мэргэшил, боловсролтой, одоо нас нь нилээд хэвийсэн буюу 45-55 орчим насны албан хаагчид, мэргэжилтнүүд, тэтгэврийн хүмүүс; Төрийн захиргааны болон төсвийн байгууллагууд (эмч сувилагчид, бүх шатны сургуулийн багш ажилтнууд, төрийн захиргааны байгууллагын ажилтан, мэргэжилтнүүд, хүчний байгууллагуудад ажиллагчид, армийн ажилтан, цагдаа г.м)-ын бага, дунд тушаалын ажилтан, албан хаагчид; Хувийн хэвшлийн байгууллагууд, албан бус хэвшилд ажиллагч бага дунд тушаалынхан, хөлсний ажилчид; Сургууль төгсөөд дөнгөж ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж байгаа залуучууд; жижиг бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид; 1990-ээд оноос хойшхи хугацаанд Засгийн газраас ядуурлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр төслүүд нь манай орны хүн амын ядуурлыг бууруулж, дунд орлоготны эгнээг өргөжүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн ч үр дүн нь төдийлөн хангалттай бус байна. Монгол улсын дунд орлоготны амьжиргааны түвшинг дээшлүүлэх үндсэн зорилго, стратегийг тодорхойлон хэрэгжүүлэх; Бүсүүдийн дунд орлоготны амьжиргааны түвшин, ахуй амьдралын нөхцөл байдал харилцан адилгүй байгаатай холбогдуулан уг бодлогод бүсийн давуу тал онцлогийг тусгах, Хөдөөгөөс хот суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжиж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд зарим талаар сөрөг нөлөө үзүүлэх түвшинд нэгэнт хүрээд байгаа өнөөгийн нөхцөлд хот, хөдөөгийн хөгжлийн түвшинг ойртуулах, хөдөө орон нутагт хөгжлийн таатай орчинг бүрдүүлэхэд түлхүү анхаарах, хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилтийг бүх талаар урамшуулан дэмжих;

34.	<p>ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: УИХ-ын дэргэдэх бодлогын шинжилгээний Төв. 2007 он Зорилго: Их, дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар <ul style="list-style-type: none"> ИДС төгсөгчдийн ажил мэргэжлийн чадварыг дээшлүүлэх Дээд боловсролын тогтолцоог зах зээлийн шаардлагад нийцүүлэн эрс шинэчлэх “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-т суурилсан “Их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг боловсруулан, батлаж хэрэгжүүлэх ИДС-иар эзэмшүүлэх мэргэжлийн бүтцийг өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөгөөтэй зохицуулах Ажлын байр нэмэгдүүлэх талаар Төгсөгчдийг ажлын байраар хангах талаархи Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шинэ шатанд гаргах Төгсөгчдийн ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэж чадсан гадаад улс орнуудын туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн бүтээлчээр хэрэглэх. </p>
35.	<p>МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧИН БЭЛТГЭХ АСУУДЛЫН ТАЛААРХИ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВҮҮДИЙН БАЙДАЛД ХИЙХ ШИНЖЛЭЛ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: УИХ-ын дэргэдэх бодлогын шинжилгээний Төв. 2007 он Зорилго: Өнөөгийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ)-ийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, бодлого хуулийн хэрэгжилтийн явцад тохиолдож буй тулгамдсан асуудлуудыг тодруулах, энэ талаар цаашид хэрэгжүүлэх бодлогын болон эрх зүйн шинэтгэлийн явц, үр дүнгийн талаар санал зөвлөмж боловсруулан гаргах. Дүгнэлт, зөвлөмж: <ul style="list-style-type: none"> МСҮТ-үүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, мэргэжлийн боловсролын асуудлыг Боловсролын яам гартаа авч, мэргэжлийн сургалтын заах арга зүйн төвийн чадамж, эрх мэдлийг нэмэгдүүлэх. Мэргэжлийн сургалтаар олгож буй ажил, мэргэжлийн ангилалыг хөдөлмөрийн зах, зээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэхийн зэрэгцээ, аль мэргэжлээр ямар сургууль илүү чанартай, нарийн мэргэжил олгох боломжтой талаар шалгуур тогтоож, зарим мэргэжлийг тодорхой МСҮТ-үүд дээр төвлөрүүлэн (тэргүүлэх чиглэл болгон) олгодог тогтолцоо бий болгох мэргэжлийн индекс, зөвшөөрлийн журмыг шинэчлэх. МСҮТ-ийн багш нарын хөдөлмөрийн онцлогт нийцсэн цалин, урамшуулал, ажлын үнэлгээний өвөрмөц тогтолцоог бий болгох. </p>
36.	<p>ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ БА НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхимийн судлаачдын баг. 2009 он Зорилго: Дэлхийн эдийн засгийн хямрал хөдөлмөрийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгаа байдлыг тандах. Дүгнэлт, зөвлөмж: <ul style="list-style-type: none"> Ажил эрхлэлтийг дэмжсэнээр ядуурлыг бууруулах. Хотын ядуурлыг бууруулахад гэр хороололд ядуурал, ажилгүйдэл өндөр байгаад үндэслэн гэр хорооллын ядуучуудыг зорилтот бүлэг болгон сонгон авч цогц арга хэмжээг бодлогод тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай юм. Хөдөөд ядуурлыг бууруулах. Хөдөө аж ахуйн салбарт бүтээмжийг нэмэгдүүлэх, сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлэх, улмаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж ажиллагсдын чадвар чадавхийг сайжруулах шаардлагатай байна. Ажлын байр нэмэгдүүлэх <ul style="list-style-type: none"> Хямралын улмаас бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх, ажлын байрны захиалга буурах, ажиллах хүчний гадаад руу шилжих хөдөлгөөн буурах, эсрэгээр гадаадаас буцаж ирэх, гадаадад ажиллагсдаас ирэх мөнгөн гуйвуулгын хэмжээ багасах зэрэг байдлаар нөлөөлж байна. Албан ёсны ажилгүйдлийн түвшинг тооцож байгаа өнөөгийн аргачлал нь зөвхөн бүртгүүлсэн ажилгүйдлийн хувьд тооцогддог учраас хөдөлмөрийн зах зээлийн </p>

	<p>бодит байдлыг илэрхийлж чадахгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> Нийгмийн эмзэг байдал, ядуурлыг бууруулахад тогтвортой орлогыг бий болгох ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн стратеги чухал байгаагийн дээр иргэд бизнес эрхэлж орлогоо өсгөхөд чиглэсэн боломжийг нэмэгдүүлэх үүнд төрийн зүгээс хууль эрх зүйн болон үйл ажиллагаагаа эрхлэн явуулах таатай нөхцөлийг хангахад нэн тэргүүнд анхааран ажиллах шаардлагатай байна.
37.	<p>ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ БА НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛЭГ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхимийн судлаачдын баг. 2009 он Зорилго: Нийгмийн эмзэг бүлэгт үзүүлж буй хямралын нөлөө, нийгмийн хамгааллын бодлого, түүний үр дүн, цаашдын хандлагыг тодорхойлох</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Ядуурлыг бууруулах талаар</p> <ul style="list-style-type: none"> Ядуурлыг бууруулах бодлогыг эдийн засгийн өсөлттэй нягт уялдуулсан бодлогын стратеги боловсруулж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна. Монголын өрхүүдийн ядуурах эмзэг байдлын судалгааг үндэсний хэмжээнд хийх шаардлагатай байгаа бөгөөд ийм судалгааг хийснээр ядуурлыг бууруулах, ядуурлаас урьдчилан сэргийлэх бодлогыг оновчтой, боловсронгуй болгоход ач холбогдолтой. <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар</p> <ul style="list-style-type: none"> Дэлхийн санхүүгийн хямралын улмаас 2008 оны 11 дүгээр сараас 2009 оны 6 дугаар сарын хооронд Монголын хөдөлмөрийн зах зээл дээр бүртгэлтэй ажилгүйчүүд огцом нэмэгдэж, албан ёсны секторт шинээр ажилд авах нь зогсонги байдалд орж, гадаад улс орон дахь эдийн засгийн хүндрэл бэрхшээлээс шалтгаалан гадаад руу шилжих ажиллах хүчний хөдөлгөөн бууран, ажиллагсад гадаадаас буцаж ирэх, гадаадад ажиллагсдаас ирэх мөнгөн гуйвуулгын хэмжээ багассан зэрэг байдлаар хямралын нөлөө илэрсэн. Эмзэг байдал, ядуурлыг бууруулах аливаа арга хэмжээний богино хугацаанд үзүүлэх нөлөө сул, харин дунд болон урт хугацаанд тогтвортой хэрэгжиж байж үр дүнгээ өгдөг болохыг онцлон тэмдэглэж байна.
38.	<p>УЛААНБААТАР ХОТЫН ЯДУУРАЛ ИХТЭЙ ХОРООДЫН ИРГЭДИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ЯВУУЛСАН СУДАЛГАА Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Нийслэлийн хөдөлмөр хамгаалалын газар. Б.Батбаатар, Ш.Галсан-дулам. 2006 он Зорилго: Энэхүү судалгаагаар амьжиргааны түвшин тогтоох аргачлал яагаад шаардлага хангахгүй байгаа, чухам ямар үзүүлэлтээр, ямар асуултаар авч үзснээс болохгүй байгааг судлан шинжлэх, санал гаргахаар зорьсон.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр зуучлалын байгууллагууд болон бүх төрлийн сургалтын аж ахуйн нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулж иргэдийг хөдөлмөр эрхлэх суурь ур чадвар болон мэргэжлийн чадвар эзэмшүүлэхэд анхаарах Нийслэлийн дагуул гэр хорооллыг бий болгох замаар хөдөө аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэдийн амьдралын туршлагад тулгуурлан өрхийн аж ахуй эрхлэх боломжийг бүрлүүлэх.</p>
39.	<p>ИХ ДЭЭД БОЛОН МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬ ТӨГСӨГЧ МЭРГЭЖИЛТЭЙ БОЛОВСОН ХҮЧНИЙ АЖЛЫН БАЙРНЫ ХАНГАЛТЫН СУДАЛГАА Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Нийслэлийн хөдөлмөр хамгаалалын газар. Б.Батбаатар, Ш.Галсандулам. 2008 он Зорилго: Мэргэжилтэй боловсон хүчин ажлын байраар хэрхэн хангагдаж байгаа, эзэмшсэн мэргэжил нь тухайн салбартаа аль зэрэг хэрэгцээтэй байгаа, хөдөлмөрийн зах зээлийг эрэлтийг хангаж байгаа эсэхэд Тандалт хийхэд энэ судалгааны зорилго оршино.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Төрөөс хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд анхаарах Үүнд:  Салбарын болон ажил олгогчийн ажиллах хүчний хэрэгцээг тодорхойлох систем бий</p>

	<p>болгох</p> <ul style="list-style-type: none"> Залуучуудын амьдралын болон хөдөлмөрийн чиглэлийг олгох анхан, дунд, дээд шатны сургалтын байгууллагаар бэлтгүүлэх оновчтой бүтэц, үндэслэлийн тогтолцоог бий болгох Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, ирээдүйтэй мэргэжлийн боловсрол олгох Залуучууд ажилгүй иргэд, сургалтын байгууллага, ажил олгогчид тогтмол мэдээлэл өгөх Мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ судалгаатай байх Сургалтын байгууллага, ажил олгогчийн ажлыг уялдуулан суралцагчдыг дадлагажуулж, ажлын байран дахь сургалтанд хамруулснаар ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлэх Залуучуудын хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, сэдлийг бий болгон өдөөж өгөх Давтан сургалт мэргэжил дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлэх Мэргэжил сонголтын урамшуулал бий болгох. <p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар</p> <p>Мэргэжилтэй боловсон хүчний ажил эрхлэлтийн байдалд хийсэн судалгаагаар эдийн засгийн хөгжилд нийцсэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн боловсон хүчнээр хангаж байгаа бэрхшээл нь:</p> <ul style="list-style-type: none"> Ажиллах хүчний хэрэгцээ тодорхойгүй Сургалтын байгууллагуудад сургах захиалгыг шаардлагатай мэргэжлээр нь бус тоогоор өгдгөөс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн хэрэгцээнд тохирдоггүй Ажлын хөлс хэт бага Мэргэжилтэй боловсон хүчний өрсөлдөх, хөрвөх, ур чадварын түвшин хөдөлмөрийн зах зээлийн шаардлагыг хангадаггүй Залуучууд залхуурах бэлэнчлэх сэтгэлгээнд автах хандалга бий болсон.
40.	<p>ИРГЭДИЙН АМЖИРГААНЫ ТҮВШИН ТОГТООХ АРГАЧЛАЛ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Нийслэлийн хөдөлмөр хамгааллын газар. 2008 он</p> <p>Зорилго: МУ-ын “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлд “нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнийг нийгмийн халамжинд хамруулахаар тодорхойлох шийдвэр гаргах үүрэг бүхий “Амжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл сум, хооронд ажиллуулах” тухай заалт засаг захиргааны анхан шатны нэгж болох хороодод хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэхэд ололттой ба дутагдалтай асуудлыг судалгаагаар гаргахыг зорьсон.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Амжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг асуудлын ихэнхи 71% нь асаргаанд хамрагдах иргэний хүсэлт байдаг. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа гол шалтгаан нь амжиргааны түвшин тогтоох аргачлал боловсронгуй бус Амжиргааг дэмжих зөвлөлийн ажлыг сайжруулах шаардлагатай гэж иргэд үздэг Амжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар орох иргэнийг өөрийн хүсэлтээр нь сонгоход иргэд, хэсгийн ахлагчийн санал нийлсэн боловч, зөвлөлөөс санал нийлэхгүй байна. Амжиргааг дэмжих зөвлөлийн талаар иргэдэд мэдээлэл муу хүрдэг, сургалт сурталчилгаа сул байдаг. Амжиргааг дэмжих зөвлөлийн ажилд иргэдийн 90% орчим нь дунд муу гэсэн үнэлгээ өгсөн байна.
41.	<p>ЦАГИЙН АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТИЙН СУДАЛГАА</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Нийслэлийн хөдөлмөрийн газар. 2009 он</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар</p> <p>Цагийн ажлын байрны цагийн хөлс нь 800-1200 төгрөгийн хооронд байвал хамгийн тохиромжтойг харуулж байна.</p>

	<ul style="list-style-type: none"> • Байгууллагууд хүний нөөцийн төлөвлөлтөндөө цагийн ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх талаар өөрчлөлт оруулах эсэхийг нь судлахад 32.3% нь оруулна гэж хариулсан цагийн ажилын байрны эрэлт нэмэгдэж буйг илтгэж байна. • Ажлын байранд дадлагажиж буй оюутны хөдөлмөрийн хөлсний хэмжээг байгууллагууд оюутантай харилцан тохиролцсоны үндсэн дээр эсвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан цалинг тогтоож байна. • Ажил олгогчдоос оюутан залууст тавигдах гол шаардлага нь хариуцлага хүлээх чадвар ба харилцааны соёл. <p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар Байгууллагууд цагийн ажлын байрыг дэмждэг ба шинээр ажлын байр бий болгож байна. Ихэнхи байгууллагуудад байнгын орон тооны ажилтан авч ажиллуулах шаардлагагүй ажлын байр гардаг.</p> <ul style="list-style-type: none"> • Дийлэнх байгууллага нь шинээр цагийн ажилын байр бий болгож байгаа нь цагийн ажлын байрны эрэлт нэмэгдэж оюутан залуус чөлөөт цагаараа ажиллах боломжтой болж байна. • Ихэнх байгууллагууд цагийн ажлын тогтоосон хэмжээ мөн тохиролцон дадлагажиж буй оюутны хөлсөө тогтоодог байна. • Ихэнх цагийн ажлын байр сар буюу түүнээс дээш хугацаанд гардаг байна.
	<p align="center">ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС ХИЙСЭН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ</p>
42.	<p>МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ 2002 онд</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Монголын хүн ам ба Хөгжил нийгэмлэг, Хүн амын сургалт судалгааны төв, НҮБ-ын Хүн амын сан, Зохистой хөгжлийн жендер төвтэй хамтран хийсэн. Б.Даваахүү ҮСГ-ын Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах мэргэжилтэн. 2002 он</p> <p>Зорилго: Энэхүү судалгаанд Монгол Улсын хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагсад, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, ажиллах хүчин, ажилгүйдлийн түвшний нийт эдийн засаг, үйлдвэрлэлийн түвшинд нөлөөлөлх нөлөөллийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгөхийг зорилго.</p> <p>Энэ судалгааны гол зорилго нь: эдийн засгийн идэвхитэй хүн амыг тодорхойлж, түүнээсээ ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшинг тооцож олон улсын түвшинтэй зэрэгцүүлэхэд оршино.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг нь харагдаж байна. Өндөр боловсролтой, ажиллах ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл бөгөөд тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг байна. Ажиллагсдын хүйсийн бүтцийг харахад эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 2002 оны байдлаар эрэгтэйчүүдийнхтэй бараг адил юм. Нийт ажиллагсдын 44.9 хувь нь хөдөө аж ахуйн, 11.4 хувь нь аж үйлдвэрийн, 12 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт ажиллаж байсан байна. Эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, зоогийн газар, худалдаа боловсруулах үйлдвэрт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байхад уул уурхай, цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэл, усан хангамж, тээвэр холбоо, барилга, батлан хамгаалахын салбарт эрэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.</p> <p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар Хүн ам зүйн ачаалал хэт өндөр байх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх улмаар ард түмний аж байдлыг дээшлүүлэхэд зарим сөрөг нөлөөтэй байдаг тул аливаа улс орны хүн ам зүйн бодлогын гол асуудлуудын нэг нь энэхүү ачааллыг зохицуулах явдал байдаг. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшинг хүйс, насны бүлгээр нь авч үзэхэд: 16-25 насанд эмэгтэйчүүдийн түвшин эрэгтэйчүүдийнхээс ихээхэн доогуур байгаа нь энэ насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй олноороо суралцаж байгаатай холбоотой юм. Нийт тэтгэвэрт гарсан хүмүүсийн 42.1хувь нь 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, 23.4хувь нь ажиллсан жилээрээ, 34.5хувь нь хөдөлмөрийн нөхцөл болон цэргийн байгууллагад ажиллсан</p>

	жилээрээ тэтгэвэрт гарагчид байна.
43.	<p>ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД ТАХИР ДУТУУ ИРГЭДИЙН ОРОЛЦОО Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: НХХЯ, Азийн хөгжлийн банкны Тахир дутуу хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх төсөл, “МЭ Консалтинг” ХХК. 2004 он Зорилго: Улаанбаатар хот болон ТДИХЭНТ хэрэгжиж буй аймгуудад оршин суугаа тахир дутуу иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцож байгаа байдал, хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, боловсрол, мэргэжил эзэмшсэн байдлыг цогц байдлаар судлахад оршино. Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Сүүлийн жилүүдэд эдийн засгийн байдал тогтворжиж, зарим өсөлт гарч, улмаар ядуурлыг бууруулах нөхцлийг бүрдүүлж байгаа хэдий ч ядуурал буураагүй, энэ талаар авч буй арга хэмжээ мэдэгдэхүйц үр дүн өгөхгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> Монгол улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр боловч эрэгтэйчүүдийн хэмжээнээс нэлээд доогуур байна. Төр, засгаас эмэгтэйчүүдийн талаар авч буй арга хэмжээний үр дүн хангалтгүй, жендэрийн ялгаатай байдал байсаар байгаа бөгөөд эдийн засгийн боломжийн хүртээмж, төрийн үйлчилгээг хүртэх чадвар, эдийн засаг болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөх байдал, улс төрийн хүч чадлаар эмэгтэйчүүд ялгаатай байна. <p>Ажлын байр нэмэгдүүлэх талаар</p> <ul style="list-style-type: none"> Хөдөлмөрийн хуулийн 111.1-ийг дараах хэлбэрээр өөрчлөх: “... 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа зургаа, түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулна; Тахир дутуу иргэдэд хөдөлмөр эрхлэхэд зориулан тусгайлан тоноглогсон, татварын болон бусад төрлийн хөнгөлөлт эдэлдэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. Улаанбаатар хотод тэргэнцэртэй хүнд зориулсан нийтийн хөсөг байхгүй байгаа нь тахир дутуу иргэдийн боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг хязгаарлаж буй нэгэн хүчин зүйлс болж байна. Тахир дутуу иргэдийн амьдралын төвшин, чанарыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тэдэнд зориулсан дэд бүтэц бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Хувиараа бизнес эрхлэх сонирхолтой тахир дутуу иргэдэд зах зээлийн судалгаа хийх аргачлал, санхүүгийн бүртгэл, тайлан хөтлөх, боловсруулах мэдлэг, менежмент, маркетингийн анхан шатны мэдлэг олгох сургалт зайлшгүй шаардлагатай. Тахир дутуу иргэний мэргэжил эзэмших сургалтыг тухайн хүний эрүүл мэндийн байдал, бэрхшээлийн хэлбэр, чадварыг харгалзан сургалтын ганцаарчилсан хөтөлбөрийн боловсруулж явуулах шаардлагатай болно.
44.	<p>ЯДУУРЛЫН АСУУДЛУУД БА ЯДУУРЛЫН СУДАЛГААНЫ НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Үндэсний Статистикийн Хороо ҮСХ. 2004 он Зорилго: Ядуурлын тухай ойлголт, түүнийг тодорхойлох хандлагууд, хэмжүүр. Дүгнэлт, зөвлөмж: 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор гэр бүлийн бизнест цалингүй оролцогч эрэгтэйчүүд 59,0 мянга байхад эмэгтэйчүүд 138,5 мянга буюу 2,3 дахин олон бөгөөд ажил эрхэлж байсан нийт хүний 17,8 хувьтай тэнцэх тооны эмэгтэйчүүд ямар нэгэн цалин хөлсгүйгээр гэр бүлийн бизнес мал аж ахуйд ажилдаг байна, мөн ажил эрхэлж буй эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин эмэгтэйчүүдийнхнээс байнга илүү, түүний зөрүү нь нэмэгдэж ирсэн.</p>
45.	<p>МОНГОЛЫН ХҮН АМЫН СЭТГҮҮЛ Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Монголын хүн ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн амын сургалт судалгааны төв, НҮБ-ын Хүн Ам Сан. 2008 он Зорилго: Сумуудын ажил эрхлэлтийн байдлыг салбараар нь авч үзэх. Дүгнэлт, зөвлөмж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Сумдын ажиллагсдын ихэнх хувийг малчид эзэлж байна, 2005 онд ихэнх сумын хувьд ажил эрхлэлт өндөр түвшинд байсна 2006 оноос буурах хандлага илэрч байна. Хөдөө орон нутагт ажиллагсдын 70 орчим хувь нь тусгай дунд боловсролтой 20 хувь нь дээд боловсролтой, харин 6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 4 хувь нь бага боловсролтой байна. Завхан аймгийн ажилгүйдлийн түвшин 4.4 хувьтай байна.</p>

	Ажлын байр нэмэгдүүлэх талаар Цаашид сумдад байгаа бүртгэлгүй ажилгүйчүүдийн тоог нарийн сайн тооцон гаргаж эдийн засгийн ачааллыг нь тооцоолох шаардлагатай байна.
46.	<p>“АЖЛЫН БАЙР- 2010” ХАВРЫН НЭГДСЭН ХӨДӨЛМӨРИЙН ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГИЙН ҮЕЭР ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮГНЭЛТ</p> <p>Гүйцэтгэсэн байгууллага, хугацаа: Ажил Олгогч Эздийн Нэдгсэн Холбоо. 2010 он</p> <p>Зорилго: Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг авахтай холбогдсон эрэлт, хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаархи үнэлэлт дүгнэлтийг тодруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аливаа арга хэмжээ, үйл ажиллагааны талаархи мэдээллийг ажил хайгч иргэдэд хүргэх хамгийн боломжит, дөт сувгийг тодорхойлоход оршино.</p> <p>Дүгнэлт, зөвлөмж:</p> <p>Санал асуулганд оролцогчдын 50 орчим хувийг эзлэх иргэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг дунд болон хангалтгүй гэж дүгнэсэн байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний байгууллага нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллийн хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийг хамарсан өдөрлөг яармагийн үйл ажиллагаагаар сайн сурталчилж байх нь зүйтэй гэсэн байна. Оролцогчдын 51,4 хувь нь тус газраас хэрэгжүүлж буй Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр болон цагийн ажил эрхэлж орлогоо нэмэгдүүлэх боломжийн талаар ямар нэгэн мэдээлэл аваагүй буюу асуултанд хариулаагүй байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрийн үйлчилгээний байгууллага нь хөдөлмөрийн зах зээлд ард иргэдийн эзэмшсэн мэргэжил дадлага туршлагыг нь харгалзан тэдэнд дэмжлэг үзүүлж санал асуулга явуулаад орхих биш шуурхай ажил зохион байгуулж ажиллах нь чухал юм.</p>

МОНГОЛ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

(Лавалгаа, мэдээлэл)

*Р.Хатанбаатар***1. Түүхэн товчоо**

Өнөөгийн Монголын нутагт Хүннүгийн үеэс Богд хаант улсын үе шувтаргал хоёр мянгаад жил (МЭӨ 209 оноос 1924 он) оршин тогтнож байсан феодалын хаант улсуудад төрийн хэргийг хэлэлцэх, хааны эрх мэдлийг зарим талаар хязгаарлах, зөвлөх үүрэг бүхий байгууллагууд байсан түүхэн уламжлал бий. Жишээлбэл, Их Монгол улсын (1206-1368) Их хуралдай нь хааныг сонгож, төр улсын тулгамдсан асуудлыг магадлан хэлэлцсэний үндсэн дээр хаанд зөвлөх эрх, үүрэг бүхий төрийн байгууллага байсан. Дундад эртний энэ үеийн Монголын улсуудын Хуралдай нь ард түмний дундаас сонгогдсон төлөөлөгчдийн байгууллага бус, язгуур угсаа, албан тушаалын зарчмыг баримтлан байгуулагдсан, хууль тогтоох эрх мэдлийг эдэлдэггүй зөвлөх үүрэгтэй байгууллагууд байлаа.

Мөн Богд хаант Монгол улсын (1911-1919) үед улс төрийн аливаа хэргийг бүгдээрээ нийлэн шүүмжлэн хэлэлцэж, олны бодлыг нийлүүлэх зорилго бүхий Улсын дээд, доод хурлыг байгуулж байв. Улсын хурал нь уламжлалын дагуу Хуралдайтай адилаар байгуулагдсан, сонгуулийн бус, зөвлөх эрх бүхий байсан боловч өмнөх үеэс ялгаатай нь Улсын доод хуралд язгууртан угсаагүй бичиг, цэргийн түшмэд орсон, төрийн хэргийг шийдэхэд олны саналыг авахын тулд төлөөлөгчдийн байгууллагаар хэлэлцдэг парламентат ёсыг Монголд анх нэвтрүүлж эхэлсэн онцлогтой.

1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа төрийн шинэ тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар үзэл бодлын ялгаа болон олон улсын тухайн цагийн нөхцөл байдлаас шалтгаалан нэгдүгээрт, эртний төрт ёсны уламжлал дээр суурилан төрөө цаг үеийн бодит байдалд зохицуулан хөгжүүлэх; хоёрдугаарт, үндсэн хуульт хаант засаг байгуулах; гуравдугаарт, социалист хэлбэрийн төр буюу пролетарийн диктатур байгуулах гэсэн үндсэн сонголтуудтай тулгарсан юм. Түүхэн баримтаас үзэхэд тэр үеийн Монголын удирдагчдын ихэнхи нь үндэсний ардчилсан үзлийг баримтлан, парламентат ёсыг тогтоохыг эрмэлзэж байсан байдаг. Монгол улсын Их хурал 1924 онд анхны үндсэн хууль баталж, уг хуулиар Монгол улсыг Бүгд найрамдах улс болгон тунхагласан юм.

Анхдугаар Үндсэн хуулиар Улсын их хурал бол төрийн эрхийг барих дээд байгууллага бөгөөд хурлын чөлөө цагт Улсын бага хурал төрийн эрхийг барина гэж заасан. Ийнхүү парламентат ёс Монгол оронд төлөвших эхлэл тавигдсан боловч тухайн цаг үеийн байдал, гаднын улс орны шахалтаар хууль ёс гажуудан, Улсын их хурал ёс төдий байгууллага болон хувирчээ.

1940 онд батлагдсан хоёр дахь Үндсэн хууль нь нэг намыг улс төрийн тогтолцооны цөм болгон баталгаажуулсан хууль байсан боловч амьдралд хэрэгжсэн ардчилсан шинжтэй зарим хэм хэмжээ, тухайлбал, төлөөллийн ардчилалын үндсэн зарчмыг хуульчилсан байдаг. 1944 онд сонгогчдын хувьд тавьж байсан элдэв хязгаарлалтыг хүчингүй болгож, сонгуулийн эрх нь хасагдсан хүмүүст сонгуулийн эрх олгож, 1949 онд сонгуулийн тогтолцоог ардчилах томоохон алхам хийн УИХ-ын сонгуулийг шууд, тэгш, саналаа нууцаар хураах үндсэн дээр сонгуулийн тойргоор явуулж байхаар болсон. Ийнхүү парламентат ёсыг Монголд төлөвшүүлэх чухал алхам хийгдсэн юм. Гэхдээ 1990 он хүртэл тухайн үеийн социалист системийн бусад орнуудын адилаар манай улсын АИХ нь хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэх болон сонгогдон байгуулагдах байдлаараа өнөөгийн ардчилсан нийгмийн үеийн парламент болон бүрэн төлөвшиж чадаагүй юм.

2. Парламентат ёсны төлөвшил

1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хувьсгал иргэдийн хувийн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс төрийн системийн ардчилсан тогтолцоо, өмчийн олон хэлбэр, зах зээлийн эдийн засгийг бий болгосон юм. 1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын чуулганаар “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-ийг баталж, төрийн эрх барих байгууллагыг шинэчлэхдээ нам, төрийн үүргийг зааглах, улс төрийн тогтолцооны гол цөм нь төр байх, парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчилалыг хөгжүүлэх бодлого баримталжээ. Төрийн эрх барих уламжлалт дээд байгууллага-Ардын их хурал, парламентат ёсны шинэ байгууллага-Улсын бага хурал, төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институцийг бий болгож, тэдгээрийн хооронд эрх мэдлийн харилцан хамаарал, зөв тэнцэлтэй хуваарилах зарчмыг гол болгосон.

Монгол оронд 1990 оны 6 дугаар сард анх удаа олон намын оролцоотой, нэг тойрогт олон нэр дэвшигч бүхий сонгууль явагдаж, парламентат ёсны шинэ төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын бага хурлыг улс төрийн намуудын төлөө сонгогчдын өгсөн саналыг үндэслэн байгуулсан юм. Ийнхүү Монгол улс ард иргэдээсээ эх үүсвэртэй төртэй байх бололцоо анх удаа бүрджээ. 1990-1992 он бол Монгол улсын хувьд нийгмийн байгуулал, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн төдийгүй Үндсэн хуулийн шилжилтийн үе байсан юм.

Энэ шилжилтийн үеийн парламентат ёсны тогтолцоонд АИХ-аас байгуулагдсан, АИХ-д үйл ажиллагаагаа тайлагнадаг Улсын бага хурал онцгой байр эзэлнэ. Хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага УБХ парламентат ёсыг жинхэнэ утгаар нь бүрдүүлэн тогтооход чухал үүрэг гүйцэтгэж, энэхүү төлөвшилтийн явц түгээмэл утгаараа хуулийн хүрээнд өрнөсөн. УБХ бол Монгол улсын анхны байнгын ажиллагаатай парламент байлаа.

АИХ-аас даалгаснаар УБХ Монгол улсын шинэ Үндсэн хуулийн төслийг хүн төрлөхтний түгээмэл үнэт зүйлсийн зарчмуудад тулгуурлан боловсруулж, АИХ-д өргөн барьсан юм. 1992 онд АИХ шинэ Үндсэн хуулийг баталснаар Монгол улс ардчиллын замаар эргэлтгүй замнасан, парламентын Бүгд найрамдах улс боллоо.

Шинэ Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүхэд тэнцвэржүүлэн хуваарилаж, парламентыг нэг танхимтай, 76 гишүүнтэй байхаар тогтоон, үйл ажиллагааных нь эрх зүйн үндсийг тодорхойлжээ. Үндсэн хуульд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан юм.

Ингэснээр хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тэнцвэрт байдлыг хангаж байх тэргүүлэх үүрэгтэй байгууллага нь Улсын Их Хурал болжээ. УИХ хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ төрийн гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож өгнө. УИХ хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачлах эрх бүхий субъектүүд болох Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөл, улс орны нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалтын ямарч асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Шинэ Үндсэн хууль үйлчилж эхэлснээс хойш 1992, 1996, 2000, 2004, 2008 онуудад нийт таван удаа парламентын сонгууль болоод байна. Монгол улсын хувьд 1990-1992 онд байгуулагдсан анхны байнгын ажиллагаатай парламент болох УБХ парламентын уламжлалт үеэс парламентат ёсонд шилжих замыг туулсан юм. 1992 оноос УИХ хууль тогтоох эрх мэдлийг дангаар хадгалсан ард

түмний төлөөлөгчдийн байгууллага болж Монгол оронд парламентат ёсны хөгжлийн төлөвшил дараагийн шатандаа орлоо.

Монгол улсын парламентат ёсны хөгжил нь нэгд, парламентын хэлбэр, дотоод болон үндсэн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь улам боловсронгуй болсноор, хоёрт, парламентыг бүрдүүлэх, түүний үйл ажиллагаанд олон түмний хяналт оролцоо идэвхижиж буйгаар, гуравт, парламент өөрийн зорилго, мөн чанараараа улам бүр төгөлдөршиж буйгаар тодорхойлогдож байна.

1992-1996 оны УИХ-ын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоог шинээр батлагдаад байсан Үндсэн хууль, түүний хавсралт хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх, шинэчлэх асуудал байлаа. Үүний зэрэгцээ УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа нь улс орны нийгэм-эдийн засгийн шилжилтийн үеийн тулгамдсан асуудал, зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байв. Шилжилтийн ээдрээ, бэрхшээлтэй энэ үед нийгмийн олон талт харилцааг хуулиар зохицуулах, улс орон, иргэдээ хууль зүйт ардчилсан нийгэмд зохицон амьдардаг болоход энэ удаагийн УИХ их үүрэг гүйцэтгэж, үүгээрээ парламентын хөгжлийн нэг чухал үеийг туулжээ.

1996-2000 онд УИХ-ын үйл ажиллагааны гол зорилго нь эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, ардчилсан төрийн тогтолцоог боловсронгуй болгох, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахтай холбоотой харилцааг сайжруулахад чиглэгдэж байв. Засгийн газраас эдийн засгийн нилээд зоримог гэж хэлж болох арга хэмжээнүүдийг авч явуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан, Засгийн газар, парламентын харилцааны ээдрээтэй асуудлуудтай тулгарч, шийдэж байсан нь парламентын төлөвшлийн явцад ихээхэн туршлага, сургамж болсон юм.

2000-2004, 2004-2008 онуудын УИХ ардчилсан төрийн тогтолцоог хөгжүүлэн, төрийн эрх мэдлийн хуваарилалтын механизмыг зүгшрүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлж хэрэгжүүлэх томоохон алхамуудыг хийсэн юм. Ардчилсан, чөлөөт сонгуулийн үндсэн дээр ард иргэдээсээ сонгогдсон парламентын хувьд үйл ажиллагаагаа иргэд сонгогчдод ил тод, нээлттэй байлгах талаар энэ хугацаанд УИХ ихээхэн анхааран ажилласан юм.

Улсын их хурлын гишүүний болон парламентын олонхи, цөөнхийн эрх зүйн байдал, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гишүүдэд тавих ёс зүйн шаардлагыг өндөржүүлэх, хуулийн төсөл боловсруулах, санаачлах, хэлэлцэх зэрэг хууль тогтоох үйл явцын үндэслэл, журмыг УИХ бүх л үйл ажиллагааныхаа явцад боловсронгуй болгож иржээ.

Ийнхүү улс орны өмнө тулгарсан төрийн байгуулалт, улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэн даван туулахын хирээр парламент өөрөө хөгжин төлөвшиж ирлээ.

Ашигласан материал

1. Монгол Улсын анхны байнгын парламент 1990-1992, эмхтгэсэн: Н.Жанцан, Улаанбаатар, 2007
2. Монгол Улсын Их Хурал 2000-2004, эмхтгэсэн: Х.Дамдинсүрэн, Улаанбаатар, 2004
3. Монгол Улсын Их Хурал 2004-2008, эмхтгэсэн: Ж.Нарантуяа, Улаанбаатар, 2008
4. Л.Өлзийсайхан: Парламент, Улаанбаатар, 2001
5. Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан: Парламентат ёс, Улаанбаатар, 2005

**ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНӨӨС ҮҮДЭН, УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН
СУУРЬШИЛТАД БИЙ БОЛСОН ХҮНДРЭЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ***/Лавлагаа-мэдээлэл/**Б.Буяндэлгэр, О.Нарантуяа*

Бүс нутгийн хөгжлийн ялгавартай байдал, нөөц, бололцоо, үйлчилгээний тэгш бус хүртээмжийн улмаас төвийн бүсийн аймаг, хотууд, ялангуяа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн сүүлийн 10 гаруй жилд эрчимтэй явагдаж, Монгол Улсын газар нутгийн 0,3 хувийг эзэлдэг нийслэл Улаанбаатар хотод манай орны нийт хүн амын 40 хувь нь оршин сууж байна.

Гэтэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн даац судалгаагаар 500 мянган хүн байх тооцоо байдаг атал өнөөдрийн байдлаар 2 дахин олон хүн ам оршин сууж байна.

Улаанбаатарт шилжин ирэгсдийн дунд явуулсан асуумжийн дүнгээр тэдний 41 хувь нь ажил эрхлэх, 38 хувь нь амьжиргаагаа дээшлүүлэх, 28 хувь нь зах зээлд ойртох зорилготой гэсэн хариулт өгчээ. Өрхийн орлого зарлага, амьжиргааны төвийн түүвэр судалгааны дүнгээс үзэхэд нийт хүн амын 36.1 хувь нь ядуурлын шугамаас доогуур орлоготой байхад хотын хүн амын 27.3 хувь, аймгийн төвийн хүн амын 33,9 хувь, сумын төвд амьдрагчдын 44.5 хувь, хөдөөд амьдрагчдын 42.7 хувь нь ядуурлын шугамаас доогуур орлоготой аж төрдөг ажээ. Энэ нь сумын төвийн хүн амын ядуурлын түвшин хотынхоос даруй 17.2 пунктээр, улсын дундажаас 8.4 пунктээр өндөр байна гэсэн үг.

Улаанбаатарын хүн амын механик өсөлт нь хот төлөвлөлт, газар ашиглалт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамж, байгаль орчны тэнцвэрт байдлыг илт алдагдуулах боллоо.

Улаанбаатар хотод 2000-2008 онуудад шилжин ирэгсдийн 30,2 хувь нь буюу 67,9 мянга нь сургуулийн насны хүүхэд, 7 хувь нь буюу 15,7 мянга нь тэтгэврийн насны хүмүүс байгаа нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 1996 онд 126 мянга, 2000 онд 162 мянга, 2007-2008 оны хичээлийн жилд 184,3 мянга болжээ.

БСШУЯ-наас батлагдсан нормативаар анги дүүргэлт 35 сурагч байдаг бол зарим сургуулийн нэг ангид 60 хүүхэд сурч байна. Анги дүүргэлт хэт их байгаа нь сурагчдын эрүүл мэнд, сургалтын чанарт нөлөөлөөд зогсохгүй багш нарын хүүхэдтэйгээ ажиллах боломжийг хязгаарладгаас сургууль завсардалтанд нөлөөлдөг.

Харин хөдөө орон нутагт байдал эсрэгээрээ байна. Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийг нэг сурагчид ногдох нормативт зардлаар санхүүжүүлж байгаа нь 10 жилийн сургуулийн хувьд 500-аас доош хүүхэдтэй, 8 жилийн сургуулийн хувьд 300-аас доош суралцагчидтай тохиолдолд эдийн засгийн хувьд оршин тогтноход хүндрэлтэй байгаа юм. Гэтэл шилжих хөдөлгөөнөөс үүдэн энэ хичээлийн жилийн байдлаар 500-аас доош хүүхэдтэй 10 жилийн сургууль 42, 300-аас доош хүүхэдтэй 8 жилийн сургууль 98 байна.

Манай орны ихэнх сургуулиуд 320 хүүхдийн хүчин чадалтай баригдсанаас хөдөөгийн сумдын сургуулийн хувьд байрны хүчин чадлыг гүйцэд ашиглаж чадахгүй байгаагаас гадна зардлын ихэнхийг халаалтад зарцуулж сургалтын материаллаг орчинг сайжруулах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх ямар ч боломжгүйд хүрч байна

Нийслэлийн эмнэлгийн байгууллагуудын ачаалал эрс нэмэгдлээ. Тухайлбал, Улаанбаатар хотын хоёрдахь шатлалын эмнэлгийн орны тоо 1998 онд 1937 байсан бол 2008 онд 1822 болж, эмнэлгийн нэг оронд ногдох хүний тоо 1998 онд 292 байсан бол 2008 онд 515 болсон байна.

Улаанбаатар хотын хүн амын механик өсөлтөөс шууд шалтгаалан тээврийн хэрэгсэлийн тоо эрс нэмэгдсэн, нөгөө талаас авто замын сүлжээ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалалыг даахгүй байна. Автозамын хөдөлгөөний түгжрэлийн улмаас нийтийн тээврийн хэрэгслийн дундаж хурд 15-18 км/цаг (зохистой хурд 25 км/цаг) болж буурч, үйлчилгээний хуваарь зөрчигдөж, зорчигчдын тав тух алдагдан, автобус хоорондын хүлээлтийн хугацаа нэмэгдэв. /Хүлээлтийн дундаж хугацаа том оврын автобусны хувьд 4-5 минут, цахилгаан тээврийнх 6-7 минут, микро автобусных 3-4 минут орчим байна./

427 км урттай автозамаар Улаанбаатар хотын иргэд өдөрт 3,4 сая зорчилт хийдэг бөгөөд үүнээс 2,4 саяыг нь нийтийн тээврийн хэрэгслэлээр зорчдог байна.

Төрийн өмчийн 3, хувийн хэвшлийн 98 аж ахуйн нэгж, байгууллага нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж, 2008 онд өдөр тутамд их багтаамжийн автобус, троллейбусны 2 чиглэлд 486, бага багтаамжийн автобусны 65 чиглэлд 1100 гаруй бүгд 1603 автобус, троллейбус шугаманд ажиллаж байгаагийн зэрэгцээ таксийн 21 байгууллагын 645, нийт 248 тээврийн хэрэгслээр зорчигчдыг тээвэрлэж байгаа боловч нийтийн тээврийн автобусны тоог 400-аар нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн тооцоо байгаа юм.

Нэг иргэний өдрийн зундаж зорчилт-3,4 удаа, дундаж зорчилтын зай - 3,4 км, зарцуулдаг хугацаа нь 29 минут, дундаж хурд 8 км/цаг байна.

Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн хомсдол, бохирдол ихэсч, Туул голын усны бохирдолт Гачууртаас эхлэн доошлох тутам нэмэгдсээр Биокомбинатын орчим хамгийн ихээр ажиглагдаж, Улиастай, Дунд голын ус өөрийгөө цэвэршүүлэх чадваргүй, азотын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 3,2-3,9 дахин ихэссэн нь шинжилгээгээр тогтоогдов. Дамбадаржаа, Сэлбэ, Сэлх голын дагуух эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд хөдөөнөөс нүүж ирсэн айлууд зөвшөөрөлгүй суурьшах болсноор голын ай сав бохирдож, Сэлхийн гол ширгэж, Сэлбийн гол ундрагагүй болжээ. Ийнхүү 2010 оноос хойш эх үүсвэрүүдээс олборлох усны хэмжээ дутагдах төлөв бий болоод байна.

Нийслэлийн хүн амыг сийрэгжүүлэхийн тулд хөдөө орон нутагтаа иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөдөөд ажиллагсдыг түлхүү урамшуулах болон бусад арга хэмжээний эрх зүйн орчинг бий болгох шаардлага чухлаар шаардагдаж байна.

Монгол улсад хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаанд 11 хүн туттын нэг нь шилжилт хөдөлгөөнд оролцож, шилжин буй 10 хүний 8 нь Улаанбаатар хотод ирж суурьшиж байгаа хэмээн бүртгэгджээ. Тэнцвэргүй шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан олон сөрөг нөлөө гарч байна. Нэн тэргүүнд нийгмийн салбарт ихээхэн хүндрэл учирч байгаа. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний газруудын хүртээмж багассанаас үйлчилгээ муудаж, сургуулт завсардалт, халдварт өвчин ихсэж байна.

Өрхийн орлого зарлага, амьжиргааны төвийн түүвэр судалгааны дүнгээс үзэхэд нийт хүн амын 36.1 хувь нь ядуурлын шугамаас доогуур орлоготой байхад хотын хүн амын 27.3 хувь, аймгийн төвийн хүн амын 33,9 хувь, сумын төвд амьдрагчдын 44.5 хувь, хөдөөд амьдрагчдын 42.7 хувь нь ядуурлын шугамаас доогуур орлоготой аж төрдөг ажээ. Энэ нь сумын төвийн хүн амын ядуурлын түвшин хотынхоос даруй 17.2 пунктээр, улсын дундажаас 8.4 пунктээр өндөр байна гэсэн үг.

Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийг нэг сурагчид ногдох нормативт зардлаар санхүүжүүлж байгаа нь 10 жилийн сургуулийн хувьд 500-аас доош хүүхэдтэй, 8 жилийн сургуулийн хувьд 300-аас доош суралцагчидтай тохиолдолд эдийн засгийн хувьд оршин тогтноход хүндрэлтэй байгаа юм. Гэтэл шилжих хөдөлгөөнөөс үүдэн энэ хичээлийн жилийн байдлаар 500-аас доош хүүхэдтэй 10 жилийн сургууль 42, 300-аас доош хүүхэдтэй 8 жилийн сургууль 98 байна.

Манай орны ихэнхи сургуулиуд 320 хүүхдийн хүчин чадалтай баригдсанаас хөдөөгийн сумдын сургуулийн хувьд байрны хүчин чадлыг гүйцэд ашиглаж чадахгүй байгаагаас гадна зардлын ихэнхийг халаалтад зарцуулж сургалтын материаллаг орчинг сайжруулах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх ямар ч боломжгүйд хүрч байна.

Боловсролын үйлчилгээнд үзүүлж байгаа хамгийн хүндрэлтэй асуудал бол анги дүүргэлт юм. БСШУЯ-наас батлагдсан нормативаар анги дүүргэлт 35 сурагч байдаг бол зарим сургуулийн нэг ангид 60 хүүхэд сурч байна. Анги дүүргэлт хэт их байгаа нь сурагчдын эрүүл мэнд, сургалтын чанарт нөлөөлөөд зогсохгүй багш нарын хүүхэдтэйгээ ажиллах боломжийг хязгаарладагаас сургууль завсардалтанд нөлөөлдөг.

Сургуулийн хүүхдийн тоо хэт ихэссэнээс зарим сургуулиуд гурван ээлжээр хичээллэж байна. Өнгөрсөн оны байдлаар 32 сургуулийн 162 бүлгийн 5700 сурагч 3 дугаар ээлжинд хичээллэсний ихэнхи нь хотын хүүхдүүд байна.

Эмнэлгийн хувьд ч орны хүчин чадлын ашиглалт буурсан боловч, эмч, эмнэлгийн ажилтны тоо цөөрч, мэргэжлийн туслалцаа үзүүлэх боломж багасаж байна. Өнөөгийн байдлаар хөдөөгийн 8 сум их эмчгүй, 121 суманд 144 эмч, дутагдалтай байна.

Шилжин ирэгсдийн дунд ядуу, орлогогүй өрх их байгаа учраас 5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд тураал 2.4 дахин их, заавал хийх дархлаажуулалтанд хамрагдалт улсын дундажаас харьцангуй бага байна.

Нэг. Шилжих хөдөлгөөнийг зогсоох бодлогын хүрээнд зарим хаалттай болгох, зөвшөөрөлгүй суурьшигчдыг хотоос хүчээр нүүлгэх, паспортын хууль гаргах, ажил эрхлэлтэд хяналт тавих, орон сууцтай болох боломжийг хязгаарлах, хүнсний норм тогтоох зэргээр шилжин ирэгчдэд янз бүрийн тавих арга хэмжээг хамруулж ирсэн байна. Энэ бодлогыг Вьетнамын Х Мин, Индонезийн Жакарта, Кубын Гавана, Хятадын Бээжин зэрэг хотуудад 1970-аад онуудад хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Хятад улсад хот, суурин газрын хөгжлийн хэт ялгаанаас үүдэн хөдөөгийн тосгоны иргэд олноор шилжих болсонтой холбогдуулан иргэдийг хөдөө рүү шилжүүлэх бодлого явуулж, картын систем нэвтрүүлэх, хотоос түр хугацаагаар иргэдийг хөдөө рүү шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Энэ арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг боомилсон арга хэмжээ болсон хэдий ч иргэдийн шилжих хөдөлгөөнийг багасгахад тодорхой үр дүн авчраагүй гэж үздэг байна. Бодлогын энэ зарим хувилбар социализмын үед манай оронд хэрэглэгдэж байсан гэж болно.

Хоёр. Шилжих хөдөлгөөнийг удирдан чиглүүлэх хүрээнд шилжих хөдөлгөөн зайлшгүй байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч, шилжих хөдөлгөөний эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээг хамааруулдаг байна. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөний урсгалыг өөр шаардлагатай гэж үзсэн газар нутаг руугаа чиглүүлэн, шилжигчдэд ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах болон бусад хэрэгцээт боломжийг бий болгох, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, хөдөөгийн боловсролтой, эдийн засгийн идэвхитэй хэсэг нь хот руу шилжин ирж байгаа байдлыг засах зорилгоор ирээдүйд томхон хот болгохоор төлөвлөж буй суурин газар луу шилжүүлэх, түүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байсан байна. Энэ бодлого Мексик, Өмнөд Солонгос зэрэг улсуудад амжилттай хэрэгжсэн хэдий ч шилжих хөдөлгөөний гол төвлөрөл эдийн засгийн хувьд илүү

хөгжилтэй бүсүүдийг сонгож бусад хэсэгт төдийлөн суурьших сонирхол иргэдэд бага болох нь ажиглагджээ.

Бидний үзэж байгаагаар манай улсын хувьд дээрхи бодлогын хүрээнд хүн амын уламжлалт нүүдлийн болон эрчимжиж буй суурин хэвшлийн зохистой харьцааг хадгалах зорилгоор нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг тэтгэх чадвар бүхий эдийн засгийн бүсүүд, тэдгээрийн тулгуур төв, дагуул хотуудыг хөгжүүлэх, энэ чиглэлд хамрагдаж байгаа бүсийн төвүүдийг түшиглүүлэн бүх шатны боловсрол, эрүүл мэнд соёлын иж бүрэн цогцолборуудыг байгуулж, үйлдвэрлэл үйлчилгээний сүлжээг өргөтгөх замаар ажлын байр бий болгох нь иргэдийн шилжих хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэх нэг хувилбар гэж үзэж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН